



МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА САНДАГИЙН  
БЯМБАЦОГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.01 № 3Г-1/37  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

「Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай」

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264001917



УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.05.01 № ХЭГ/1428  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл,  
2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй  
холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар  
хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох  
материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт 10 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Б.ЭНХБАЯР

000265005952

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“1.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР  
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН САЙД**

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж 11,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 33 33,  
Цахим шуудан: info@med.gov.mn

2026.04.30 № 01/1226

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН  
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА Б.ЭНХБАЯР ТАНАА

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан дагалдах хуулийн төслүүдийг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.



Б.ЭНХБАЯР

152604000183



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.04.29 № 112139

танай 2026.04.24 -ны № 0111135 -т

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН  
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД  
Ж.ЭНХБАЯР ТАНАА**

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



**С.АМАРСАЙХАН**

ХЗДХЯ-ны А5  
152843883



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn


2026.04.28 № 01/4169

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН  
ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН  
ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД Ж.ЭНХБАЯР  
ТАНАА**


Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай” хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрлийг олгож байна.

Хүндэтгэсэн,



З.МЭНДСАЙХАН

9761000687



## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төслийг боловсруулах үндэслэл, шаардлага

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх” гэж, 8.1.3-т “Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 06 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасан нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

### Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг хүснэгтээр батлах тухай гэсэн нэг зүйлтэй байна.

### Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2027 оны төсвийн зарлагын хязгаар, 2028-2029 оны дунд хугацааны зарлагын

төсөөлөл болон Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгосонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

## **МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-т “эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх” гэж, 8.1.3-т “Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасныг үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах бодлогыг баримталж, холбогдох хууль тогтоомж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, судалгаа, тооцоонд үндэслэн боловсруулсан болно.

Түүнчлэн хуулийн төслийг боловсруулах явцад Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасны дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусган хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно. Мөн энэ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төв”-өөр дамжуулан санал авах үйл ажиллагааг зохион байгуулж, цахим орчинд нээлттэй санал асуулга явуулан ирүүлсэн саналуудыг нэгтгэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан болно.

Манай улс сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт болон макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг харьцангуй тогтвортой түвшинд хадгалж ирсэн хэдий ч гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, шинэ сорилтууд нэмэгдсээр байна. Геополитикийн нөхцөл байдал хурцдаж, ялангуяа Ойрх Дорнодын бүс нутаг дахь тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь олон улсын санхүүгийн зах зээл, тээвэр, логистик, хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж, нийлүүлэлтийн сүлжээ, импортын үнийн дарамт, экспортын орлого, валютын ханш, инфляцад эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Ийм нөхцөлд төсвийн бодлогын тэлэлтийг хэт нэмэгдүүлэх нь инфляц, зээлийн хүү, валютын ханшид ирэх дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Эдгээр хүчин зүйлсийг харгалзан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028–2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг оновчтой удирдах, цаашид үүсэж болзошгүй хүндрэлүүдэд урьдчилан бэлтгэх бодлогын хүрээнд боловсруулсан болно.

Эдийн засгийн өсөлт 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд ойролцоогоор 6.3 хувийн түвшинд хүрэх хүлээлттэй байна. Нүүрсний олборлолт тогтвортой өсөж, дэлхийн зах зээл дээрх бусад түүхий эдийн үнэ өсөх, экспорт тогтвортой нэмэгдэх төлөвтэй байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжихээр байна. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд үргэлжилж, салбарын өсөлтөд эергээр нөлөөлөх хүлээлттэй байгаа бөгөөд мөн боловсруулах үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай байна.

Нөгөө талаас Ойрх Дорнодод үүсээд буй нөхцөл байдлын улмаас шатахууны үнэ өсөж, улмаар үйлдвэрлэлийн зардал нэмэгдэн, аж ахуйн нэгжүүдийн ашиг буурч, дунд хугацаанд хөрөнгө оруулалтын идэвх саарах төлөвтэй байна. Иймд үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах боломжийг бүрдүүлнэ.

Эдийн засгийн өрсөлдөх чадвар болон өрхийн бодит орлогын өсөлтийг дэмжих зорилгоор инфляцыг тогтвортой, зорилтот түвшинд бууруулах бодлого баримталж байна. Энэ хүрээнд 2027 онд 7.0 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд 5.0 хувьд хадгалагдахаар тооцоолсон. Инфляцыг бууруулахад хөдөө аж ахуйн салбарт шинэчлэл хийж хүнсний нийлүүлэлтийг сайжруулах, экспорт, импорттой холбоотой зохицуулалтыг оновчтой хийж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган боловсрууллаа. Тухайлбал:

- **Тэнцвэржүүлсэн орлого:** Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.
- **Нэгдсэн төсвийн суурь тэнцэл:** Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг ДНБ-ий хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байна гэж заасан. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь 2027-2029 онуудад дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.
- **Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ:** Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байна гэж заасан. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ ДНБ-ний 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагыг хангаж байна.

- **Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг 2027-2028 онд 50.0 хувь, 2029 онд 45.0 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн хуулийн шаардлагыг хангаж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2027 оны төсвийн зарлагын хязгаар, 2028-2029 оны дунд хугацааны зарлагын хязгаар төсөөлөл болон Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм. Мөн дээр дурдсан үндэслэл, нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр төсвийн бодлогын уялдаа, тогтвортой байдлыг хангах, түүнийг дагалдах эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагын хүрээнд энэхүү хуулийн төсөлтэй холбогдуулан бусад хуулийн төслийг боловсруулсан болно. Ингэснээр татвар, төсвийн бодлогын шинэчлэлийг цогцоор нь хэрэгжүүлэх, хууль хоорондын уялдаа холбоог хангах, эдийн засгийн бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх юм.

---o0o---

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН  
2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,  
2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА**

**УЛААНБААТАР ХОТ**

**2026 ОН**

## АГУУЛГА

<b>ХУРААНГУЙ</b> .....	<b>8</b>
<b>1. НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТӨСӨӨЛӨЛ</b> .....	<b>1</b>
1.1 Монгол Улсын эдийн засгийн 2024 оны гүйцэтгэл, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл, 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл.....	1
1.1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн.....	1
1.1.2 Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт .....	7
1.1.3 Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин.....	9
1.1.4 Гадаад худалдааны тэнцэл.....	10
1.1.5 Төлбөрийн тэнцэл .....	13
1.2 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2027-2029 оны төсөөлөл .....	15
1.2.1 Дэлхийн эдийн засгийн төлөв .....	15
1.2.2 Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага .....	16
1.2.3 Дотоодын нийт бүтээгдэхүүн.....	18
1.2.4 Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт .....	19
1.2.5 Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин.....	20
1.2.6 Гадаад худалдааны тэнцэл.....	21
1.2.7 Төлбөрийн тэнцэл .....	22
1.3 Макро эдийн засгийн төлөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцсон арга зүй, тооцооны үндэслэл .....	27
<b>2. ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТӨСӨӨЛӨЛ</b> .....	<b>29</b>
2.1 Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2024 оны гүйцэтгэл, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл, 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл. ....	29
2.1.1 Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл .....	29
2.1.2 Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт.....	30
2.1.3 Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ.....	32
2.1.4 Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл .....	33
2.1.5 Улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалт .....	34
2.1.6 Засгийн газрын болзошгүй өр төлбөр .....	38
2.1.7 Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөөг гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан байдал .....	39
2.2 Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2027-2029 оны төсөөлөл.....	40
2.2.1 Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2027-2029 оны төсөөлөл .....	40
2.2.2 Төсвийн нийт зарлагын 2027-2029 оны төсөөлөл .....	43
2.2.3 Нэгдсэн төсвийн суурь зарлагын 2027-2029 оны төсөөлөл .....	43
2.2.4 Засгийн газрын нийт өрийн 2027-2029 оны төсөөлөл.....	46
2.2.5 Гадаад зээл, үнэт цаасаар санхүүжих.....	46
2.2.6 Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт .....	47

2.3	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн тоог ашиглаагүй бол үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлсон тайлбар .	48
<b>3.</b>	<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ</b>	<b>51</b>
3.1	Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, стратегийн зорилт	52
3.2	Төсвийн тусгай шаардлага хангасан байдал	54
3.3	Макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ	56
3.4	Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл	58
<b>4.</b>	<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ</b>	<b>59</b>
<b>5.</b>	<b>ТАВДУГААР БҮЛЭГ. ХАВСРАЛТ</b>	<b>62</b>
5.1	Салбаруудын төсөөлөлд туссан төслүүдийн талаар	62
5.2	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	66

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1.1	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл .....	15
Хүснэгт 1.2	Цагаан алт хөдөлгөөний зорилт .....	23
Хүснэгт 1.3	Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны зорилт .....	24
Хүснэгт 2.1	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	29
Хүснэгт 2.2.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2025 оны төлөвлөгөө, урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	30
Хүснэгт 2.3.	Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт (тэрбум төгрөг).....	31
Хүснэгт 2.4.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны төлөвлөгөө, тэрбум төгрөг.....	33
Хүснэгт 2.5.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, түүний гүйцэтгэл (ДНБ-нд эзлэх хувь) .....	34
Хүснэгт 2.6.	Засгийн газрын өрийн үлдэгдэл, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг) .....	35
Хүснэгт 2.7	Гадаад үнэт цаас, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	35
Хүснэгт 2.8	Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд, түүний гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	39
Хүснэгт 2.9.	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл (тэрбум төгрөг) .....	40
Хүснэгт 2.10	Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг) .....	43
Хүснэгт 2.11	Нэгдсэн төсвийн суурь зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг).....	43
Хүснэгт 2.12	Нэгдсэн төсвийн урсгал зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг).....	44
Хүснэгт 2.13	Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (тэрбум төгрөг).....	46
Хүснэгт 2.14	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь) .....	47
Хүснэгт 2.15.	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийн төсөөлөл.....	48
Хүснэгт 3.1	Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь) .....	54
Хүснэгт 3.2	Нэгдсэн төсвийн урсгал зарлагын төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь).....	55
Хүснэгт 3.3	Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь) .....	55
Хүснэгт 3.4	Гол нэр төрлийн эрдэс баялгийн татварын орлогын нийт төсвийн орлогод эзлэх хувь	56
Хүснэгт 3.5	Тэнцвэржүүлсэн үнийн тооцоолол .....	56
Хүснэгт 3.6	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт .....	58

## **ЗУРАГ**

Зураг 1.1 Эдийн засгийн өсөлтийн бүтэц.....	5
Зураг 1.2 Инфляц, мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл .....	8
Зураг 1.3 Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд.....	9
Зураг 1.4 Хүн амын насны суварга, 2025 он.....	10
Зураг 1.5 Гадаад худалдааны үзүүлэлт .....	12
Зураг 1.6 Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц.....	14
Зураг 1.7 Дэлхийн тодорхой бус байдлын индекс.....	15
Зураг 1.8 Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	17
Зураг 1.9 Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц) .....	17
Зураг 1.10 Төмрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	17
Зураг 1.11 Коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн) .....	17
Зураг 1.12 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель).....	18
Зураг 1.13 Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл .....	18
Зураг 1.14 Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл .....	21
Зураг 2.1. Улсын нийт гадаад өрийн статистик, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум ам.доллар) .....	34
Зураг 2.2. Гадаад үнэт цаасны олон улсын зах зээл дээрх өгөөж.....	36
Зураг 2.3 Улс орнуудын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ .....	45
Зураг 2.4 Улс орнуудын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ .....	45
Зураг 3.1 Төсвийн бодлогын төлөв .....	57

## **ШИГТГЭЭ**

Шигтгээ 1.1. Хөдөө аж ахуйн салбарт дунд хугацаанд хэрэгжих хөтөлбөрүүдийн зорилт .....	23
Шигтгээ 1.2. Монгол улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр .....	25
Шигтгээ 2.1. Хөгжиж буй улс орнуудын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ, түүний харьцуулалт .....	45
Шигтгээ 3.1. Тэнцвэржүүлсэн үнэ.....	56

## ХУРААНГУЙ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Стратегийн баримт бичгийн төслийг, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт хүргүүлэх” гэж, 8.1.3-т “Засгийн газар Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэн жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, 8.1.4-т “Улсын Их Хурал Стратегийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хэлэлцэж, батлах”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг энэ хуулийн 11.1.3-т заасны дагуу тооцсон гол нэр төрлийн эрдэс баялгийн үнийг тусгаж тодорхойлсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ, төсвийн тусгай шаардлагад нийцүүлж хуульчлан батлах” гэж тус тус заасныг үндэслэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах бодлогыг баримталж, холбогдох хууль тогтоомж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, судалгаа, тооцоонд үндэслэн боловсруулсан болно.

Түүнчлэн хуулийн төслийг боловсруулах явцад Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасны дагуу төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоог хангах зорилгоор олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусган хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулсан болно. Мөн энэ хүрээнд Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төв”-өөр дамжуулан санал авах үйл ажиллагааг зохион байгуулж, цахим орчинд нээлттэй санал асуулга явуулан ирүүлсэн саналуудыг нэгтгэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан болно.

Манай улс сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт болон макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг харьцангуй тогтвортой түвшинд хадгалж ирсэн хэдий ч гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, шинэ сорилтууд нэмэгдсээр байна. Геополитикийн нөхцөл байдал хурцдаж, ялангуяа Ойрх Дорнодын бүс нутаг дахь тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь олон улсын санхүүгийн зах зээл, тээвэр, логистик, хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж, нийлүүлэлтийн сүлжээ, импортын үнийн дарамт, экспортын орлого, валютын ханш, инфляцад эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Ийм нөхцөлд төсвийн бодлогын тэлэлтийг хэт нэмэгдүүлэх нь инфляц, зээлийн хүү, валютын ханшид ирэх дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна. Эдгээр хүчин

зүйлсийг харгалзан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028–2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг оновчтой удирдах, цаашид үүсэж болзошгүй хүндрэлүүдэд урьдчилан бэлтгэх бодлогын хүрээнд боловсруулсан болно.

Эдийн засгийн өсөлт 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд ойролцоогоор 6.3 хувийн түвшинд хүрэх хүлээлттэй байна. Нүүрсний олборлолт тогтвортой өсөж, дэлхийн зах зээл дээрх бусад түүхий эдийн үнэ өсөх, экспорт тогтвортой нэмэгдэх төлөвтэй байгаа нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжихээр байна. Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд үргэлжилж, салбарын өсөлтөд эергээр нөлөөлөх хүлээлттэй байгаа бөгөөд мөн боловсруулах үйлдвэрлэл нэмэгдэх хандлагатай байна.

Нөгөө талаас Ойрх Дорнодод үүсээд буй нөхцөл байдлын улмаас шатахууны үнэ өсөж, улмаар үйлдвэрлэлийн зардал нэмэгдэн, аж ахуйн нэгжүүдийн ашиг буурч, дунд хугацаанд хөрөнгө оруулалтын идэвх саарах төлөвтэй байна. Иймд үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх нь эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалах боломжийг бүрдүүлнэ.

Эдийн засгийн өрсөлдөх чадвар болон өрхийн бодит орлогын өсөлтийг дэмжих зорилгоор инфляцыг тогтвортой, зорилтот түвшинд бууруулах бодлого баримталж байна. Энэ хүрээнд 2027 онд 7.0 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд 5.0 хувьд хадгалагдахаар тооцоолсон. Инфляцыг бууруулахад хүнсний нийлүүлэлт, экспорт, импорттой холбоотой зохицуулалтыг оновчтой хийж, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагуудыг ханган боловсрууллаа. Тухайлбал:

**Тэнцвэржүүлсэн орлого:** Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг олон улсын санхүүгийн мэдээллийн байгууллагуудаас гаргасан үнийн төсөөлөлд үндэслэхээс гадна макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон.

**Нэгдсэн төсвийн суурь тэнцэл:** Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг ДНБ-ий хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байна гэж заасан. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь 2027-2029 онуудад дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тус тус тэнцэж байгаа нь хуулийн шаардлагыг хангаж байна.

**Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ:** Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байна гэж заасан. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх тусгай шаардлагыг хангаж байна.

**Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг 2027-2028 онд 50.0 хувь, 2029 онд 45.0 хувь байхаар тооцсон нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн

үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх гэсэн хуулийн шаардлагыг хангаж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын 2027 оны төсвийн зарлагын хязгаар, 2028-2029 оны дунд хугацааны зарлагын хязгаар төсөөлөл болон Монгол Улсын 2027 оны төсвийн тухай хуулийн төсөл, холбогдох тооцоо, судалгааны үндсэн суурь үзүүлэлт болж, тэдгээрийг боловсруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

# 1. НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТӨСӨӨЛӨЛ<sup>1</sup>

Макро эдийн засгийн нөхцөл байдлыг Монгол Улсын эдийн засгийн 2024 он болон 2025 оны гүйцэтгэл, Монгол Улсын эдийн засгийн 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл гэсэн агуулгаар боловсруулж бэлтгэлээ.

## 1.1 Монгол Улсын эдийн засгийн 2024 оны гүйцэтгэл, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл, 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл

Энэ дэд бүлэгт макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөхцөл байдлыг хамгийн сүүлийн үеийн албан статистик тоон мэдээлэлд үндэслэн боловсруулж бэлтгэв.

### 1.1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн

**2024 оны гүйцэтгэл:** Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2024 онд нэрлэсэн дүнгээр 80.7 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 14.5 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит дүнгээр 32.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 5.1 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуй, боловсруулах салбараас бусад салбарууд эерэг нөлөө үзүүлэв.

Уул уурхайн салбар 2024 онд 10.8 хувиар өсөж нийт эдийн засгийн өсөлтийн 1.4 нэгж хувийг бүрдүүлсэн байна. Үүнд нүүрс олборлолт голлон нөлөөлсөн бөгөөд олборлолтын хэмжээ 103.4 сая тоннд хүрч, өмнөх оноос 21 хувиар өсжээ.

Түүнчлэн Оюу толгойн гүний уурхайн үйлдвэрлэл 2024 оны дөрөвдүгээр улиралд эрчимжиж, хүдрийн агууламж нэмэгдсэнээр Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл 25 хувиар нэмэгдэв. Үүний үр дүнд нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 1,562 мянган тоннд хүрч, өмнөх оноос 12 хувиар өссөн байна. Төмрийн хүдэр болон баяжмал үйлдвэрлэл мөн 10.1 сая тоннд хүрч, өмнөх оноос 32 хувиар нэмэгджээ.

Харин газрын тосны олборлолт 2024 онд өмнөх оноос 14 хувиар буурч, 4.2 сая баррельд хүрсэн, алт олборлолт 12.6 тоннд хүрч, төсөөллөөс доогуур гүйцэтгэлтэй гарсан нь уул уурхайн салбарын нийт өсөлтөд сөргөөр нөлөөллөө.

Хөдөө аж ахуйгаас бусад уул уурхайн бус салбаруудын өсөлт өндөр хадгалагдлаа. Уул уурхайн бус салбар 2024 онд 4.3 хувиар (хөдөө аж ахуйгаас бусад уул уурхайн бус салбарын өсөлт 9.9 хувь) тэлэв. Тухайлбал, үйлчилгээний салбарууд, барилга, цэвэр татварын орлогын гүйцэтгэл 2024 онд сайн байсан нь өсөлтийг дэмжсэн бол хөдөө аж ахуй, боловсруулах салбарын үйлдвэрлэл өмнөх оноос буурсан байна.

Сүүлийн хоёр жил дараалсан зудын хүндрэлийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарын уналт гүнзгийрэв. 2023-2024 оны өвөл нийт нутгийн 90 гаруй хувьд цасан бүрхүүлтэй, өвлийн туршид огцом дулаарал болон хүйтрэл ажиглагдсаны улмаас 14 аймагт мөсөн (төмөр) зуд, харин говийн аймгийн зарим сумдын нутгаар зундаа

---

<sup>1</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.4. Өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүн, хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт, ажил эрхлэлт болон ажилгүйдлийн түвшин, төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны урсгал тэнцлийн талаарх макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд;”

гантай байснаас харын зудын нөхцөл үүссэн. Он дамнасан зудын хүндрэлийн нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл сүүлийн хоёр жил дараалан буурснаар 2024 онд хөдөө аж ахуйн салбар 28.7 хувиар агшиж, эдийн засгийн өсөлтийг 3.6 нэгж хувиар хязгаарлалаа. Тодруулбал, улсын хэмжээнд 9.4 сая толгой том мал хорогдож, төл бойжилт өмнөх оноос 2.1 сая толгой малаар буурч 16.2 сая толгойд хүрснээр нийт малын тоо толгой 57.6 сая болж буурсан байна. Мөн 2024 онд нийт тариалсан талбай өнгөрсөн оноос 1.5 хувиар, нийт тариалсан талбайн 60 орчим хувийг бүрдүүлдэг улаан буудайн тариалсан талбай 5.4 хувиар тус тус буурснаар хураасан улаан буудайн хэмжээ өмнөх оноос 10.4 хувиар буурч, хөдөө аж ахуйн салбарын өсөлтийг хязгаарлав.

Хөдөө аж ахуйн салбарын уналтыг даган боловсруулах салбар 4.3 хувиар агшлаа. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, боловсруулах салбарын 20 орчим хувийг бүрдүүлдэг гурил, мах, самнасан ноолуур, ноолууран сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэл буурч боловсруулах салбарын өсөлтийг хязгаарлав. Тухайлбал, үхрийн махны үйлдвэрлэл 5.8 мянган тонн болж өмнөх оноос 33 хувиар, гурилын үйлдвэрлэл 144.5 мянган тонн болж 25 хувиар, самнасан ноолуур 626 тонн болж 46 хувиар, ноолууран сүлжмэл эдлэл 368 мянган ширхэг болж өмнөх оноос 26 хувиар тус тус буурсан байна. Харин дотоод эдийн засгийн идэвхийг даган боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг бүх төрлийн ундааны үйлдвэрлэл тэлж, уул уурхайн салбарын эрчимжилтийг даган тус салбарын 4 орчим хувийг бүрдүүлдэг тэсэлгээний зориулалттай химийн бодис үйлдвэрлэл өссөнөөр боловсруулах салбарын уналтыг саарууллаа. Түүнчлэн катодын зэсийн үйлдвэрлэл өмнөх оноос 28 хувиар буурч металл үйлдвэрлэлийн өсөлтийг сааруулав.

Инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт барилгын салбарын өсөлтийг дэмжив. Барилгын салбарын үйлдвэрлэлийг орон сууц, орон сууцны бус болон инженерийн барилга байгууламж, их засварын ажил гэсэн ангиллаар тооцон гаргадаг. Барилгын салбар 2024 онд эрчим хүч, далан суваг, шугам сүлжээ, авто зам зэрэг инженерийн барилга байгууламжийн өсөлтийн голлох нөлөөгөөр 14 хувиар өсөж, эдийн засгийн нийт өсөлтийг 0.1 нэгж хувиар дэмжлээ. Тухайлбал, Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 50 МВт хүчин чадалтай, 200 МВт/цагийн багтаамжтай батарей хуримтлуурын станц, Төв аймагт 150 МВт хүчин чадалтай Бөөрөлжүүтийн ЦС, Завхан аймагт 22 МВт хүчин чадалтай Тосон ДЦС ашиглалтад орж, Сэлэнгэ аймагт 50 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станцын ажил эхэлж эрчим хүчний барилга байгууламж нэмэгдсэн байна. Түүнчлэн Улаанбаатар-Дархан-Уул чиглэлийн авто замын бүтээн байгуулалт, Өмнөговь, Ховд, Сэлэнгэ аймгийн авто замын шинэчлэл, бүтээн байгуулалтууд болон Улаанбаатар хотын авто зам, гүүр, гүүрэн гарц, далан суваг, шугам сүлжээний бүтээн байгуулалтын ажил барилгын салбарын өсөлтийг голлон дэмжлээ. Харин их засварын ажил, орон сууц болон орон сууцны бус барилгын өсөлтийн хурд өнгөрсөн оны түвшнээс саарсан байна.

Тээврийн салбар 2024 онд 16.4 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 1.0 нэгж хувийг бүрдүүлэв. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэр, тэр дундаа нүүрсний экспортын биет хэмжээ 20 хувиар нэмэгдэж, дотоодын ачаа тээвэр 55 хувиар өссөнөөр тээврийн салбарын ачаа эргэлт нэмэгдсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад авто замаар 87.8 сая тонн ачаа тээвэрлэж 23.3 хувиар, төмөр

замаар 45.9 сая тонн ачаа тээвэрлэж 26 хувиар нэмэгдсэн байна. Мөн бүх төрлийн тээвэрээр зорчсон зорчигчдын тоо өмнөх оны түвшнээс 4.6 хувиар өсжээ.

Эрчим хүчний салбар 2024 онд 5.0 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.1 нэгж хувийг бүрдүүлэв. Монгол Улс 2024 онд 8,754.7 сая кВт.ц цахилгаан эрчим хүч (үүнээс сэргээгдэх эрчим хүч 726.6 сая кВт.ц) үйлдвэрлэж 5.5 хувиар, 16.0 сая Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж 4.0 хувиар өмнөх оноос өссөн байна.

Хүнсний болон хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа өссөнөөр бөөний болон жижиглэнгийн худалдааны салбар 2024 онд 11.9 хувиар тэлэв. Тус салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон ажиллагчдын тоо нэмэгдэж, шинээр олгосон зээл бусад салбаруудтай харьцуулахад хамгийн ихээр өссөнөөр 2024 онд дотоодын худалдааны салбарын идэвх хадгалагдав.

Нэмэгдсэн өртгийн албан татвар болон импортын барааны татварын нөлөөгөөр цэвэр татвар 14.7 хувиар өсөж эдийн засгийн өсөлтийг 1.8 нэгж хувиар нэмэгдүүлэв. Үүнд дотоодын эдийн засаг идэвхжиж дотоодын бараа үйлчилгээний НӨАТ-ын орлого 26 хувиар, импорт өсөж импортын барааны НӨАТ-ын орлого 25 хувиар, суудлын автомашины онцгой албан татварын орлого 55 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөллөө.

Эрэлт талаас тооцсон бодит ДНБ 2024 онд 5.1 хувиар өслөө. 2024 онд эцсийн хэрэглээ 11.5 хувиар, хөрөнгийн хуримтлал 9.7 хувиар тус тус нэмэгдэж, эдийн засгийн өсөлтөд 21.2 нэгж хувийн эерэг хувь нэмэр оруулав. Том малын зүй бус хорогдол 2024 онд 9.4 сая толгойд хүрч, биологийн өсөж үрждэг хөрөнгө буурсан ч машин тоног төхөөрөмжийн нөөц 30.7 хувиар, төмөр зам, авто замын барилга угсралтын ажлууд эрчимжин орон сууц болон бусад барилга байгууламжийн нөөц 26.0 хувиар тус тус нэмэгдсэнээр нийт хөрөнгө оруулалт эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Дотоодын эдийн засгийн идэвхжил, эрэлтийн өсөлтийг даган 2024 онд бараа, үйлчилгээний импорт 17.5 хувиар өссөнөөр цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг буруулах нөлөө үзүүлэв.

**2025 оны урьдчилсан гүйцэтгэл:** ДНБ 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэрлэсэн дүнгээр 89.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 11.5 хувиар, бодит дүнгээр 34.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 6.8 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд худалдаа болон үйлчилгээний зарим салбараас бусад эдийн засгийн салбаруудын өсөлт эергээр нөлөөллөө.

Уул уурхайн салбарын өсөлт жилийн хоёрдугаар хагаст сэргэснээр 10.6 хувьд хүрч, нийт эдийн засгийн өсөлтийн 1.4 хувийг бүрдүүлэв. Уул уурхайн салбар оны эхний хагаст 1.1 хувийн өсөлттэй байсан бол нүүрсний экспортын хэмжээ нэмэгдсэнээр сэргэж 4 дүгээр улиралд 95.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.4 хувиар өслөө. Түүнчлэн зэсийн баяжмал үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 36 хувиар, тухайлбал, Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр оны эхний гурван улиралд 42.2 хувиар өссөн нь уул уурхайн салбарын өсөлтийг дэмжив. Мөн төмрийн хүдрийн үйлдвэрлэлийн өсөлт хадгалагдаж 8.8 сая тоннд хүрснээр өмнөх оны мөн үеэс 31.8 хувиар өслөө. Алтны олборлолт 11 улирал дараалан буурч байснаас сэргэж 2025 оны 4 дүгээр улиралд 13.1 тоннд хүрч, 4.1 хувиар өсөв. Харин газрын тос олборлолт 8 улирал дараалан буурч 3.8 сая тонн болсноор уул уурхайн салбарын өсөлтийг сааруулсан байна.

Хөдөө аж ахуйн салбар 33.2 хувиар өсөж нийт эдийн засгийн өсөлтийн 2.9 хувийг бүрдүүллээ. Бойжсон төлийн тоо толгой 21.7 саяд хүрч (төл бойжилт 96.5 хувь) өмнөх оны мөн үеэс 5.5 сая толгой малаар нэмэгдэж, том малын зүй бус хорогдол 359 мянга болж, өмнөх оны мөн үеэс 9 сая толгой малаар буурснаар хөдөө аж ахуйн салбарын 90 орчим хувийг бүрдүүлдэг мал аж ахуйн салбарын өсөлт өндөр гарлаа. Харин газар тариалангийн салбарын хувьд оны эхний хагаст тариалангийн гол бүс нутгаар олон жилийн дунджаас бага хур тунадас унаснаар нийт хураасан үр тариа өмнөх оноос 148.6 мянган тонн, төмс 137.3 мянган тонн, хүнсний ногоо 42.5 мянган тонн, тэжээлийн ургамал 61 мянган тонноор тус тус буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын өсөлт эрчимжлээ. Боловсруулах салбарын өсөлт эрчимжиж, 2025 онд 10 хувиар өслөө. Үүнд төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл боловсруулах салбарын өсөлтийг голлон дэмжсэн байна. Эрчим хүчний салбар 2025 онд 10.2 хувиар өсөж, нийт эдийн засгийн өсөлтийн 0.2 нэгж хувийг бүрдүүлэв. Цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл 9.6 тэрбум кВт цагт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар, дулааны эрчим хүч үйлдвэрлэл 17.3 сая Гкалд хүрч, 8.5 хувиар нэмэгдэн эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн өсөлт тогтвортой хадгалагдлаа. Үүнд, шинээр ашиглалтад орсон Тосон, Бөөрөлжүүт зэрэг ДЦС-уудын үйлдвэрлэлийн өсөлт голлон нөлөөллөө. Барилгын салбарын өсөлтийг Улаанбаатар хот дахь эмнэлэг, сургууль, цэцэрлэгийн барилга, байгууламж болон Багахангай-Хөшгийн хөндий чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд, Сэлэнгэ аймаг дахь 70 МВт хүчин чадал бүхий дулааны цахилгаан станц, Дорнод аймгийн авто замын бүтээн байгуулалтын ажлууд зэрэг нь үргэлжлүүлэн тэтгэснээр 2025 онд 15.9 хувиар өслөө.


Тээврийн салбар 2025 онд 4.8 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийн 0.3 нэгж хувийг бүрдүүлэв. Зам, тээврийн салбар 2025 онд бүх төрлийн тээврээр нийт 146.4 сая тонн ачаа тээвэрлэж өмнөх оноос 10.3 хувиар нэмэгдсэн бөгөөд төмөр замын ачаа тээвэр 50 сая тоннд хүрч 8.7 хувиар, авто замын ачаа тээвэр 96.5 сая тоннд хүрч 10 хувиар, агаарын тээврийн ачаа 12.5 мянган тоннд хүрч 20 хувиар тус тус нэмэгдсэн нь өсөлтөд нөлөөллөө. Нийт ачаа тээврийн 65.9 хувийг авто тээвэр, 34.1 хувийг төмөр замын тээвэр, 0.01 хувийг агаарын тээврийн ачаа эзэлж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбар 2025 онд 4.6 хувиар агшиж, нийт эдийн засгийн өсөлтийг 0.6 нэгж хувиар саарууллаа. Худалдааны салбарын нэрлэсэн борлуулалтын орлого 69.3 их наяд болж 0.6 хувиар өссөн бол бодит орлого 34.3 их наяд болж 4.4 хувиар удаашрав. 2025 оны байдлаар салбарын 27.2 хувийг хүнсний бүтээгдэхүүн бүрдүүлж байгаа бол 73 орчим хувийг хүнсний бус бүтээгдэхүүн бүрдүүлж байна. Хүнсний бүтээгдэхүүний борлуулалт 2025 онд 15 их наяд төгрөгт хүрч 5.3 хувиар нэмэгдсэн бол хүнсний бус бүтээгдэхүүний борлуулалт 40 их наяд төгрөг болж өмнөх оноос 26.2 хувиар буурсан нь иргэдийн удаан эдэлгээт бараа бүтээгдэхүүний эрэлт буурч байгааг харуулж байна. Хүнсний бус бүтээгдэхүүний худалдан авалт буурахад машин тоног төхөөрөмж, мотоцикл, моторт тээврийн хэрэгсэл, тэдгээрийн сэлбэгийн худалдааны бууралт голлон нөлөөлөв. Дотоодын худалдаа эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлэх худалдан авалтын

менежерийн индекс<sup>2</sup> (ХМИ) 2025 оны төгсгөлд 46 хувь гарсан бөгөөд сүүлийн 4 улирал дараалан өсөж байна.

Дотоодын бараа, үйлчилгээ болон импортын бараанаас төвлөрсөн НӨАТ-ын орлого 2024 оны гүйцэтгэлээр 5.8 хувиар буюу өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өсөв. Уг өсөлтөд НӨАТ-ын 60 гаруй хувийг бүрдүүлдэг импортын барааны НӨАТ-ын орлого 793.7 тэрбумаар төгрөгөөр өсөж, голлох нөлөөг үзүүллээ. Мөн дотоодын НӨАТ-ын орлого 513.3 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оны мөн үеэс 26 хувиар өссөн байна.

Зураг 1.1 Эдийн засгийн өсөлтийн бүтэц



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо  
\*2025 оны урьдчилсан гүйцэтгэл

Эдийн засгийн хэмжээ эцсийн ашиглалт талаас 2025 онд 6.9 хувиар өсөв. Уул уурхайн салбарын үйл ажиллагааны идэвх хадгалагдаж, экспорт нэмэгдсэний зэрэгцээ импортын хэмжээ буурснаар цэвэр экспорт 2025 онд 12 хувиар өсөж, эдийн засгийн өсөлтийг голлон дэмжлээ. Мөн эцсийн хэрэглээ 5.7 хувиар өсөж, нийт өсөлтийг дэмжсэн байна. Үүнд, төрийн хэрэглээ буурсан хэдий ч өрхийн бодит орлогын өсөлт оны турш тогтвортой хадгалагдсанаар өрхийн хэрэглээ 2025 онд 9.2 хувиар өсөж, эцсийн хэрэглээг дэмжсэн байна. Төрийн албан хаагчийн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн инфляцын түвшинтэй уялдуулж нэмэгдүүлэх шийдвэрийн голлох нөлөөгөөр өрхийн цалин хөлсний орлого 2024 оны улирлын дунджаар 4 хувьд тогтвортой хадгалагдаж, өрхийн бодит орлогын өсөлт оны турш тогтвортой хадгалагдлаа. Түүнчлэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний орлого нэмэгдэж, өрхийн орлогыг дэмжив.

<sup>2</sup> ХМИ 50-аас дээш байвал тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ өсөх хандлагатай байгааг харуулдаг бол 50-аас доош бол ерөнхийдөө буурах буюу уруудах хандлагатайг харуулдаг. Харин яг 50 бол ямар нэг өөрчлөлт, хөдөлгөөн гараагүй байгааг илтгэдэг бөгөөд өнгөрсөн дөрвөн улирлын туршид агших мужид буюу 50-аас доош түвшинд байна.

Харин орон сууцны барилгын бүтээн байгуулалт болон биологийн өсөж үрждэг хөрөнгийн өсөлтийн хурд эрчимжиж үндсэн хөрөнгийн хуримтлалыг дэмжсэн боловч машин, тоног төхөөрөмжийн хуримтлалын өмнөх оны өндөр суурийн нөлөө болон тайлант онд материаллаг эргэлтийн хөрөнгө буурснаар хөрөнгийн нийт хуримтлал 2025 онд 7.2 хувиар агшиж, нийт өсөлтийг 3.6 нэгж хувиар хязгаарлалаа.

**2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:** Эдийн засгийн өсөлт 2026 оны эцэст 5.8 орчим хувь байхаар тооцоолж байна. Салбарын бүтцийн хувьд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, тээвэр, үйлчилгээний салбаруудын өсөлт тогтвортой үргэлжлэхээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг дэмжинэ. Харин уул уурхайн салбарын өсөлтийн хурд саарах хандлагатай байна.

“Хүнсний хувьсгал”, “Цагаан алт”, “Атар-4” зэрэг хөтөлбөр, аяны хэрэгжилт хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын өсөлтийг дэмжих нөлөөтэй байна. “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хүрээнд 2022-2025 онд нийт 1,261 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл, “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд 2025 онд эргэлтийн хөрөнгийн 23.7 тэрбум төгрөг, хөрөнгө оруулалтын 15.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг аж ахуйн нэгжүүдэд олгосон ба 2026 онд 29.6 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийг олгохоор төлөвлөсөн байна. “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хүрээнд 2026 онд 8.3 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор төлөвлөсөн байна. “Цагаан алт” хөтөлбөрийн хүрээнд ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 20-40 хувь, ноосны боловсруулалтын түвшнийг 25-55 хувь, арьс, ширний боловсруулалтын түвшнийг 30-50 хувь хүртэл нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Эдгээр зорилтууд нь үйлдвэрлэлийн түвшин, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар салбарын тогтвортой өсөлтийг дэмжих юм. Мөн Засгийн газрын 2025 оны 46 дугаар тогтоолоор ноолуурыг самнаж экспортлохоор шийдвэрлэсэн нь ноолуурын нэмүү өртгийг нэмэгдүүлж, боловсруулах салбарын өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Газар тариалангийн талбайг нэмэгдүүлж, нэгжээс авах ургацын хэмжээг өсгөх зорилт дэвшүүлээд буй “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ы хэрэгжилт хөдөө аж ахуй болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжихээр байна.

Барилгын салбарт томоохон бүтээн байгуулалтын төслүүд салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байна. Тухайлбал, Эрдэнэбүрэнгийн УЦС, Дулааны V цахилгаан станц, Төв аймгийн Баян суманд баригдах 660МВт ДЦС-ын бүтээн байгуулалтын ажил эрчимжихийн зэрэгцээ, орон сууцны зориулалттай зээлийн эрэлтийг дагаж орон сууцны барилгын хөрөнгө оруулалт нэмэгдэж, бүтээн байгуулалтын ажлыг дэмжсэнээр салбарын өсөлтийг дэмжихээр байна.

Уул уурхайн салбарт нүүрс болон төмрийн хүдрийн олборлолт өмнөх оноос нэмэгдэж, Оюу толгойн гүний уурхайн нөлөөгөөр баяжмал дахь зэс, алтны агуулга өсөх нь салбарын өсөлтөд томоохон нөлөөг үзүүлэхээр байна. Гэсэн хэдий ч, Оюутолгойн бусад алтны хэмжээ буурах төлөвтэй байгаагаас үүдэн 3 жил дараалан 10 орчим хувиар өссөн уул уурхайн салбарын өсөлт суурийн нөлөө болон алтны бууралтын нөлөөгөөр удаашрах төлөвтэй байна.

Үйлчилгээний салбарын хувьд тээврийн салбарын орлогын дийлэнхийг бүрдүүлдэг нүүрс, зэс, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүний экспортын нөлөөгөөр тээврийн салбарын өсөлт нэмэгдэхээр байна. Бөөний болон жижиглэн худалдааны салбарын 2025 онд агшилттай байсан суурийн нөлөө, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурал (COP17), аялал жуулчлалын салбарын

өсөлт болон эдийн засгийн дотоод эрэлт нэмэгдэх хүлээлттэй байгаагаас үүдэн худалдаа, үйлчилгээний салбарууд эдийн засгийн өсөлтөд 3.0 нэгж хувийн нөлөө үзүүлэхээр байна.

Эрчим хүчний салбарт Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд баригдаж буй 70 МВт станц болон Бөөрөлжүүтийн цахилгаан станцын 150 МВт хүчин чадал бүхий 2 дугаар блок ашиглалтад орсон нь салбарын үйлдвэрлэл, эдийн засгийн потенциалыг дэмжихээр байна.

Мөн Ойрх Дорнодын бүс нутагт үүсээд буй нөхцөл байдлаас үүдэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өсөх эрсдэлтэй байна. Газрын тосны үнэ өсөх нь богино хугацаанд инфляцыг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн өртгийг өсгөж нийт гарцын хэмжээг бууруулах эрсдэлтэй байгаа бол дунд хугацаанд аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт, судалгааны зардлаа бууруулах эрсдэлтэй байгаа нь эдийн засгийн өсөлтийн хурдыг сааруулах нөлөөтэй.

Эрэлт талаас уул уурхайн бүтээгдэхүүний экспорт өсөж, импортын түвшин өмнөх оны мөн үеийн орчимд хадгалагдсанаар, цэвэр экспорт эдийн засгийн өсөлтийг голлон дэмжих хүлээлтэй байна. Түүнчлэн, орон сууцны барилгын бүтээн байгуулалтын өсөлтийн эрчим өнгөрсөн оны түвшинд байж, Эрдэнэбүрэнгийн УЦС, газрын тос боловсруулах үйлдвэр зэрэг томоохон үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлууд нийт хөрөнгийн хуримтлалыг дэмжинэ. Харин зээл олголтын хэмжээ өнгөрсөн оны түвшинд байж эдийн засгийн үйл ажиллагааны дотоод идэвхийг дэмжих хэдий ч инфляцын түвшин нэмэгдсэнээр эцсийн хэрэглээний өсөлт саарах төлөвтэй байна.

### **1.1.2 Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт**

**2024 оны гүйцэтгэл:** Инфляц 2024 онд дунджаар 6.8 хувь, оны эцэст 9.0 хувь гарлаа. Эдийн засгийн дотоод идэвхжилээс үүдэлтэйгээр эрэлтийн шалтгаантай инфляц өссөний зэрэгцээ импортын болон үйлчилгээний инфляц эрчимжсэн байна. Инфляц оны эцэст өмнөх оны мөн үеэс өсөхөд өрхийн цахилгааны төлбөр, орон сууцны түрээсийн зардал болон хувцасны үнийн өсөлт голчлон нөлөөлсөн байна. Төв банк 2023 оны турш 13 хувьд хадгалсан бодлогын хүүг 2024 онд 10 хувьд хүргэж буурууллаа. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2024 оны эцэст 36.8 их наяд төгрөгт хүрч, зээлийн өсөлт 35.5 хувьд хүрч эрчимжсэн нь сүүлийн 10 жилийн хамгийн өндөр өсөлт болов. Зээлийн өсөлтөд цалин, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа болон уул уурхайн салбарын зээлийн өсөлт голлон нөлөөлсөн байна.

Мөнгөний нийлүүлэлт 2024 оны эцэст 42.6 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар өслөө. Эх үүсвэр талаас төгрөгийн эх үүсвэр нэмэгдсэн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлон нөлөөлөв. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 18.0 нэгж хувийг төгрөгийн харилцах, хадгаламж, -2.7 нэгж хувийг гадаад валютын харилцах, хадгаламж, 0.2 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө тус тус бүрдүүлсэн байна.

**2025 оны гүйцэтгэл:** Инфляц 2025 оны дунджаар 8.6 хувь, оны эцэст 7.5 хувь гарсан байна. 2025 оны эхний улиралд эрэлтийн гаралтай инфляц өндөр хэвээр хадгалагдаж, инфляцыг голлон тайлбарлаж байсан бол 2 дугаар улирлаас эхлэн аажмаар саарсан байна. Эрэлтийн инфляц саарахад 2025 оны төсөвт тодотгол хийж, төсвийн урсгал зардлыг бууруулсан, ханшийн зах зээл тогтворжсон, хэрэглээний зээлд зохицуулалт хийсэн, бодлогын хүүг 12 хувьд хадгалсан зэрэг

бодлогын арга хэмжээнүүд авч хэрэгжүүлсэн нь голлон нөлөөллөө. Харин нийлүүлэлтийн гаралтай үнийн өсөлт оны сүүлийн хагаст хүнсний үнийн өсөлтөөс үүдэлтэйгээр эрчимжсэн байна. Тухайлбал, махны үнэ улирлын хандлагаар буураагүй, 2025 оны зун ган болж ургац алдсанаар хүнсний ногооны нийлүүлэлт багасаж, үнэ өссөн нь нөлөөлсөн байна.

Төв банкнаас 2025 оны 3 дугаар сард мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж, 12 хувьд хүргэсэн байна. Арилжааны банкнуудын зээлийн үлдэгдэл 2025 оны эцэст 43.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар өсөж, өсөлтийн хурд өмнөх онтой харьцуулахад 16.5 нэгж хувиар саарсан байна. Зээлийн өсөлтөд бөөний болон жижиглэн худалдаа, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, тэтгэврийн зээл болон барилгын салбарын зээл голлон нөлөөлсөн байна.

Мөнгөний нийлүүлэлт 2025 оны эцэст 47.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 10.6 хувиар өслөө. Эх үүсвэр бүтцээр авч үзвэл, төгрөгийн хадгаламж мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн 9.4 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 2.1 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.2 нэгж хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлсэн бол төгрөгийн харилцах -1.1 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ. Байршуулалт талаас авч үзвэл, мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг дотоод цэвэр активын өсөлт голчлон бүрдүүлж байна. Дотоод цэвэр актив нэмэгдэхэд дотоодын зээлийн өсөлт нөлөөлсөн байна.

**2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:** Инфляц 2026 оны 3 дугаар сард 7.4 хувь гарч, төв банкны зорилтот түвшинд байна. Гэвч 2026 оны эхний хагаст хүнсний инфляц өндөр хэвээр хадгалагдах, нийлүүлэлтийн шалтгаантай хүчин зүйлсийн нөлөө давамгайлахын зэрэгцээ шатахууны үнэ нэмэгдэх, дам нөлөөгөөр бусад, бараа үйлчилгээний үнийн өсөлтийг эрчимжих эрсдэл нэмэгдэж байна. Тодруулбал, Ойрх Дорнод дахь геополитикийн хурцадмал байдал дэлхийн газрын тосны зах зээлд хүчтэй нөлөөлж, үнийг богино хугацаанд огцом өсгөсөн нь дотоодын шатахууны үнийн дарамтыг нэмэгдүүлж байна. Мөн шатахууны үнийн өсөлт эдийн засгийн салбаруудын үйлдвэрлэлийн өртгийг нэмэгдүүлж, цаашлаад үнэ өсөх эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн геополитикийн эрсдэл, тодорхой бус байдал өндөр хэвээр байгаа нь гадаад инфляц болон импортын инфляц өсөх дарамтыг нэмэгдүүлж, инфляцыг суурь төсөөллөөс өсгөх эрсдэлтэй байна.

Зураг 1.2 Инфляц, мөнгөний нийлүүлэлт, зээлийн үлдэгдэл



### 1.1.3 Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин

**2024 оны гүйцэтгэл:** Ажилчдын тоо 2024 оны байдлаар өмнөх оноос 60 мянган хүнээр өсөж 1 сая 355 мянгад хүрсэн байна. Дотоодын эдийн засаг идэвхжиж, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн тоо, экспорт нэмэгдэж өрхийн хэрэглээ сэргэснээр салбаруудын өсөлтийн нөлөөгөөр худалдаа, барилга, тээвэр, уул уурхайн салбарын ажилчид өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. Харин хөдөө аж ахуй, боловсруулах салбарын ажилчид буурсан нь ажилчдын тооны өсөлтийг саарууллаа.

Ажилгүй иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс 13 мянгаар буюу 17 хувиар өсөж 85 мянгад хүрснээр ажилгүйдлийн түвшин өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар өсөж 5.9 хувьд хүрсэн байна. Ажилчид болон ажилгүй иргэдийн тоо зэрэг өссөн нь ажиллах хүчийг өмнөх оны мөн үеэс 74 мянгаар өсгөж 1 сая 441 мянгад хүрсэн. Ингэснээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 1.8 нэгж хувиар өсөж 61.3 хувьд хүрчээ.


**2025 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:**<sup>3</sup> Эдийн засгийн өсөлтийн нөлөөгөөр аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа идэвхжиж, хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд сайжирч, хөдөө аж ахуй, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл болон барилгын салбарын тэлэлттэй уялдан ажилчдын тоо 34 мянгаар буюу 2.5 хувиар өсөж 1 сая 389 мянгад хүрч нэмэгдэх төлөвтэй байна. Гэсэн хэдий ч худалдааны салбарын уналт нь ажил эрхлэлтийн өсөлтийг сааруулахаар байна.

Зураг 1.3 Ажил эрхлэлтийн үзүүлэлтүүд

1. Ажиллагчид, ажилгүй хүний тоо (мянган хүн)



2. Ажиллах хүчний оролцооны түвшин, ажилгүйдлийн түвшин (хувь)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, ЭЗХЯ-ны тооцоолол  
Тэмдэглэл: 2025\* оны хүлээгдэж буй гүйцэтгэл.

Түүнчлэн ажиллах хүчнээс гадуур байсан иргэдийн хөдөлмөр эрхлэх сонирхол, боломж нэмэгдсэнээр хөдөлмөрийн нийлүүлэлт өсөж ажиллах хүч өмнөх оноос 28 мянган хүнээр буюу 2 хувиар тэлж 1 сая 468 мянгад хүрнэ гэж үзэж байна. Энэ нь ажиллах хүчний оролцооны түвшнийг 1.2 нэгж хувиар нэмэгдүүлж, 62.4 хувьд хүргэх хүлээлтийг бий болгож байна. Нөгөөтээгүүр ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 6.4 мянгаар буюу 7 хувиар буурч 79 мянгад хүрэх төлөвтэй байна. Ингэснээр

<sup>3</sup> Хөдөлмөрийн зах зээлийн 2025 оны үзүүлэлтүүд 2026 оны 7 дугаар сард зарлагдана.

ажилгүйдлийн түвшин 5.4 нэгж хувьд хүрч өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурах хүлээлттэй байна.

Зураг 1.4 Хүн амын насны суварга, 2025 он



**2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:**

Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд цаашид өсөлтөө хадгалагдах төлөвтэй байх хэдий ч 1990-2005 онд төрөлтийн түвшин бага байснаас одоо үеийн залуу боловсон хүчин болох 20-34 насны залуучуудын тоонд нөлөө үзүүлж байгаа нь (Зураг 1.4) хөдөлмөрийн нийлүүлэлтийн өсөлтийг сааруулах хүчин зүйл болж байна. Үүний улмаас ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийн өсөлтийн хурд буурах хандлагатай байна. Энэхүү хүн ам зүйн шалтгааны талаар Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн дунд хугацааны эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд<sup>4</sup> мөн дурдсан байдаг.

Ажиллагчдын тоо 2026 онд 20 мянгаар буюу 1.5 орчим хувиар нэмэгдэж 1 сая 409 мянга орчимд хүрэх төлөвтэй байна. Уг өсөлтөд боловсрол, эрчим хүч, ус хангамжийн салбаруудын идэвхжил голлон нөлөөлөх бол нөгөө талаас хөдөө аж ахуй, уул уурхай, барилгын салбарын огцом өсөлт саарч тогтворжихоор байгаа нь нийт ажил эрхлэлтийн өсөлтийн хурдыг сааруулахаар байна.

Түүнчлэн хөдөлмөрийн эрэлтийн өсөлт, хөдөлмөр эрхлэх сонирхол нэмэгдсэнтэй холбоотойгоор ажиллах хүч 20 гаруй мянган хүнээр буюу 1 орчим хувиар нэмэгдэж 1 сая 490 мянга гаруй хүнд хүрэх төлөвтэй байна. Үүний үр дүнд ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос 0.1 нэгж хувиар өсөж, 2026 онд 62.5 хувь буюу цар тахлаас өмнөх үеийн түвшинд хүрэх төлөвтэй байна.

Нөгөө талаас ажилгүй иргэдийн тоо өмнөх оноос 1.2 мянгаар өсөж, 80 мянгад хүрэх хандлагатай байна. Ингэснээр ажилгүйдлийн түвшин 5.4 хувь болж өмнөх оны түвшинд хадгалагдахаар байна.

**1.1.4 Гадаад худалдааны тэнцэл**

**2024 оны гүйцэтгэл:** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 онд 27.4 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 12.1 хувиар өссөн бол гадаад худалдааны тэнцэл 4.2 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт 2024 онд 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 3.9 хувиар өслөө. Өсөлтөд зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ нэмэгдсэн, алтны дэлхийн зах зээл дэх үнэ өссөн зэрэг нь голлон нөлөөллөө.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 14.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 5.6 хувиар өссөн байна. Хилийн голлох боомтуудын тээвэр зохион байгуулалт

<sup>4</sup> ГБХННЯ, ХНХСҮСИ болон Эм-Эм-Си-Жи ХХК хамтран боловсруулсан 2024 оны судалгааны тайлан

сайжирч, ажиллах цагийн хуваарь уртассанаар нүүрсний экспорт 83.8 сая тоннд хүрч, өмнөх оноос 20 хувиар нэмэгдлээ. Оюу толгойн далд уурхайн нөлөөгөөр зэсийн баяжмалын экспорт 2024 онд 1,695 мянган тоннд хүрч өмнөх оноос 11 хувиар, олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 7,511 мянган тоннд хүрч, өмнөх оноос 31 хувиар тус тус өслөө.

Харин уул уурхайн бус экспорт 1.1 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 13.9 хувиар буурлаа. Тухайлбал, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 493 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 33.6 хувиар буурсан байна. Нийт нутгийн ихэнх хэсэгт өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн экспортод сөргөөр нөлөөлж, 2024 оны эцсийн байдлаар малын махны экспорт 14 хувиар, ноолуурын экспорт 11 хувиар, арьс ширний экспорт 5 хувиар тус тус буурсан байна.

Эдийн засгийн өсөлт 11 улирал дараалан хадгалагдаж, дотоод идэвхжил өндөр байснаар бараа, бүтээгдэхүүний импорт 2024 онд 11.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 2.4 тэрбум ам.доллараар буюу 26 хувиар өслөө. Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл нийт өсөлтийн 11.6 нэгж хувийг хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик, тоног төхөөрөмж, барилгын материал, 10.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 3.3 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

Уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, нүүрсний олборлолт 23 хувиар, экспортын биет хэмжээ 20 хувиар тус тус өссөн нь уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүллээ. Тухайлбал, экскаватор, шанагт ухагчийн импорт 362 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 2 дахин, ачаа бараа тээвэрлэх тээврийн хэрэгслийн импорт 722 сая ам.долларт хүрч 67 хувиар, дизель түлшний импорт 1,296 сая ам.долларт хүрч 17 хувиар тус тус өссөн байна.

Өрхийн орлого сайжирч, хэрэглээний зээл нэмэгдсэн нь хэрэглээний бүтээгдэхүүн, тэр дундаа суудлын автомашины импортыг өдөөлөө. Тухайлбал, иргэдэд шинээр олгосон зээл 2024 онд 34 хувиар өсөж, суудлын автомашины импорт өмнөх оноос 67 хувиар өссөн байна. Суудлын автомашины импорт нэмэгдэж, аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээний тоо өссөнтэй холбоотойгоор авто бензиний импорт 643 сая ам.долларт хүрч, 23 хувиар өслөө.

Импортын дүн өмнөх оноос 2.4 тэрбум ам.доллараар өссөний 90 орчим хувийг тоо хэмжээ, 10 орчим хувийг үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Худалдааны гол түнш орнуудад үнийн өсөлт саарсан нь импортын барааны үнийн өсөлт бага түвшинд хадгалагдахад нөлөөлөв.

**2025 оны гүйцэтгэл:** Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2025 онд 27.0 тэрбум ам.долларт хүрсэн бол гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт 2025 онд 15.8 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны түвшинд хадгалагдав. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ өссөн нь нүүрсний үнийн бууралтаас шалтгаалсан экспортын орлогын алдагдлыг нөхлөө.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 14.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны түвшинд байна. Уул уурхайн биржээр арилжаалсан бүтээгдэхүүнийг хилийн боомтоор саадгүй нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, хил, гаалийн үйл ажиллагааг цахимжуулснаар нүүрсний экспорт 90.0 сая тоннд хүрч, өмнөх оноос 7 хувиар өссөн байна. Түүнчлэн далд уурхайн олборлолт нэмэгдэж, тээвэр зохион байгуулалт

сайжирсантай холбоотойгоор зэсийн баяжмалын экспортын хэмжээ өмнөх оноос 35 хувиар, төмрийн хүдрийн экспорт 17 хувиар тус тус өсөж, нүүрсний үнийн бууралтаас үүдэлтэй орлогын алдагдлыг нөхсөн байна.

Уул уурхайн бус экспорт 1.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 5.3 хувиар өсөв. Үүнээс хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 705 сая ам.долларт хүрч 9 хувиар, аж үйлдвэрийн салбарын экспорт 378 сая ам.долларт хүрч 5 хувиар тус тус нэмэгдсэн байна. Боловсруулах салбарын өсөлтийн нөлөөгөөр ноолуур, мах болон аж үйлдвэрийн зарим бүтээгдэхүүний экспорт нэмэгдсэн. Түүнчлэн түүхий ноолуурын экспортод хязгаарлалт тавьж, самнасан ноолуурын үйлдвэрлэлийг дэмжсэн бодлогын үр дүнд ноолуурын экспортын орлого өсөхөд эерэг нөлөө үзүүлжээ.

**Зураг 1.5 Гадаад худалдааны үзүүлэлт**



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Тэмдэглэл: Импортын бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний зориулалтаар ангилла.

Импорт 2025 онд 11.3 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оноос 303 сая ам.доллороор буюу 2.6 хувиар буурлаа. Импортын өөрчлөлтийг барааны бүлгээр авч үзвэл нийт бууралтын 1.8 нэгж хувийг хөрөнгө оруулалтын машин механик, тоног төхөөрөмж, 0.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 0.1 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна.

2024 онд уул уурхайн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн импорт өндөр байсан суурийн нөлөөгөөр 2025 онд уул уурхайн салбарт ашиглагддаг завсрын болон хөрөнгө оруулалтын барааны импорт саарчээ. Тухайлбал, экскаватор, шанагат ухагчийн импорт 298 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 18 орчим хувиар, ачаа бараа тээвэрлэх зориулалттай тээврийн хэрэгслийн импорт 505 сая ам.доллар болж, 30 гаруй хувиар тус тус буурсан байна. Харин уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээний экспорт өссөнтэй холбоотойгоор дизель түлшний импорт 1,337 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 3 орчим хувиар өсөв.

Суудлын автомашин, түүний сэлбэг хэрэгслийн импорт буурсан нь хэрэглээний бүтээгдэхүүний импортыг буурууллаа. Нийслэл хотод 10-аас дээш жилийн насжилттай суудлын автомашинд тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаар олгохгүй гэж шийдвэрлэсэнтэй холбоотойгоор суудлын автомашины импорт өмнөх оноос 6 орчим хувиар буурсан байна. Суудлын автомашины импортыг даган

автобензиний импорт 602 сая ам.долларт хүрч, мөн 6 хувиар буурав. Харин хүнс, эм тариа зэрэг өрхийн зайлшгүй хэрэгцээт бүтээгдэхүүний импорт харьцангуй тогтвортой хадгалагдлаа.

**2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:** 2026 оны эхний 3 сарын байдлаар экспорт 4.9 тэрбум ам.доллар, импорт 2.5 тэрбум ам.долларт тус тус хүрч, худалдааны тэнцэл 2.4 тэрбум ам.долларын ашигтай байна.

Нийт экспорт 2026 онд 18.3 тэрбум ам.долларт хүрэхээр хүлээгдэж байна. Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 17.0 тэрбум ам.долларт, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 1.3 тэрбум ам.доллар, тэр дундаа хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспорт 750 сая ам.долларт тус тус хүрэхээр байна.

Оюу толгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга нэмэгдэх төлөвтэй байгаагаас гадна дэлхийн зах зээл дэх цэвэр зэс, алтны үнэ өсөх хандлагатай байна. Үүнтэй холбоотойгоор зэсийн баяжмалын экспорт 2,195 мянган тоннд хүрч, зэсийн баяжмалын экспортын орлого 6.9 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Түүнчлэн, өмнөх жилүүдэд хийгдсэн хилийн боомтын хүчин чадал, тээвэр зохион байгуулалтын сайжруулалтын үр дүнд нүүрсний экспорт 95 сая тоннд хүрч нэмэгдэхээр байна. Харин нүүрсний хилийн үнэ ойрын хугацаанд сэргэх төлөвгүй байна. Олборлолт болон тээвэр зохион байгуулалт сайжирсантай холбоотойгоор төмрийн хүдрийн экспорт 9.2 сая тоннд хүрч нэмэгдэхээр байна.

Ойрх Дорнодод үүсээд буй геополитикийн хурцадмал байдал, түүнээс үүдсэн дизель түлшний үнийн өсөлтийн нөлөөгөөр 2026 онд импорт 12.5 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС, Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам зэрэг томоохон төслүүдийн бүтээн байгуулалт энэ онд эхлэх нөлөөгөөр тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өсөхөөр байна.

#### **1.1.5 Төлбөрийн тэнцэл**


**2024 оны гүйцэтгэл:** Импортын өсөлтийн нөлөөгөөр барааны худалдааны ашиг 2024 онд өмнөх оноос 1.6 тэрбум ам.доллараар буурснаар урсгал дансны тэнцэл 2.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Урсгал данс алдагдалтай гарсан ч санхүүгийн дансны ашиг нэмэгдсэнээр 2024 онд төлбөрийн тэнцэл 622 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын нөөц оны эцэст 5.5 тэрбум ам.долларт хүрч нэмэгдлээ.

Монголбанк 2024 оны 2 дугаар улиралд Хятадын Ардын Банктай байгуулсан своп хэлцлийн 4.5 тэрбум юань буюу 620 сая ам.долларын эргэн төлөлтийг хийсэн нь гадаад валютын гарах урсгалыг нэмэгдүүллээ. Нөгөө талаас хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар гадаад зах зээлд шинэ бондууд гаргаснаар гадаад валютын орох урсгал нэмэгдэж, санхүүгийн дансны ашиг 2024 онд 3.2 тэрбум ам.долларт хүрлээ.

**2025 оны урьдчилсан гүйцэтгэл:** Төлбөрийн тэнцэл 2025 оны эцэст 1,034 сая ам.долларын ашигтай гарч, гадаад валютын улсын нөөц 7,005 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 1,495 сая ам.доллараар нэмэгдлээ. Нүүрсний үнийн уналтаас шалтгаалан 2025 оны эхний хагаст экспортын орлого буурч, төлбөрийн тэнцэл алдагдалтай байсан ч Засгийн газраас экспортын орлого, санхүүгийн дансны ашгийг нэмэгдүүлэх замаар гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж оны сүүлийн хагас экспорт эрчимжиж урсгал данс

алдагдал буурч 784 сая ам.долларт хүрлээ. Мөн импорт өмнөх оноос 2.6 хувиар буурсан нь урсгал дансны алдагдал буурахад нөлөөллөө.

Зураг 1.6 Төлбөрийн тэнцэл, гадаад валютын нөөц



**2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:** Төлбөрийн тэнцэл 2026 оны эхний хоёр сарын байдлаар 479 сая ам.долларын алдагдалтай гарсан байна. Харин гадаад валютын улсын нөөц 2025 оны 3 дугаар сарын эцсийн байдлаар 7,188 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 2,192 сая ам.доллаар нэмэгдсэн байна.

Төлбөрийн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс буурахад экспортын орлого өссөн, импорт буурсан, улмаар урсгал данс ашигтай гарсан нь голлон нөлөөлсөн байна. 2026 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын Засгийн газар Сенчири-5 бондыг олон улсын зах зээлд арилжаалж, 2026 онд төлөгдөх Номад болон 2028 онд төлөгдөх Сенчири-2 бондуудын төлбөрөөс тодорхой хэсгийг дахин санхүүжүүлсэн нь төлбөрийн дарамтыг бууруулсан.

Гэсэн хэдий ч Ойрх Дорнодын бүс нутаг дахь мөргөлдөөний улмаас нефтийн бүтээгдэхүүний үнэ огцом өсөх хандлагатай байгаа нь импортын бараа, бүтээгдэхүүний зардлыг нэмэгдүүлэх, мөн нүүрс, төмрийн хүдэр зэрэг экспортын голлох бүтээгдэхүүний үнэ, эрэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Энэ нь цаашид төлбөрийн тэнцэлд дарамт үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

## 1.2 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2027-2029 оны төсөөлөл

Энэ бүлэгт дэлхийн эдийн засгийн дунд хугацааны төлөв байдлын мэдээлэл болон Монгол Улсын макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн дунд хугацааны төсөөллийг хүрээнд боловсрууллаа.

### 1.2.1 Дэлхийн эдийн засгийн төлөв


Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад бодлогын болон бүтцийн өөрчлөлтүүд явагдаж, худалдаа, хөрөнгө оруулалтын урсгал эрчимтэй өөрчлөгдөж буй энэ цаг үед дэлхийн улс төр, эдийн засгийн өрнөлд тодорхой бус байдал эрчимтэй нэмэгдэж байна. Тухайлбал, дэлхийн тодорхой бус байдлын индексийн үзүүлэлтээр дэлхийн тодорхой бус байдал 2025 оны 3 дугаар улиралд түүхэн дээд түвшинд хүрч, түүнээс аажмаар саарч буй ч индекс сүүлийн 10 жилийн дунджаас 4 дахин өндөр байна. Олон улсын валютын сан (ОУВС) дэлхийн эдийн засгийн өсөлт 2026-2027 онд 3.1-3.2 орчим хувьд хүрч саарах таамаглалыг 2026 оны 4 дүгээр сард зарласан бөгөөд Ойрх Дорнодод үүсээд буй нөхцөл байдал дэлхийн эдийн засгийн идэвхжилийг хязгаарлах, инфляцыг өдөөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Түүнчлэн, БНХАУ-ын үл хөдлөх салбарын уналт, ОХУ-Украины дайн даамжрах болон худалдааны дайн дахин сэдрэх зэрэг эдийн засаг, геополитикийн эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй байна.

Хүснэгт 1.1 Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

	2025	2026*	2027*
ОУВС (%)	3.4	3.1	3.2
Дэлхийн банк (%)	2.7	2.6	2.7
ОECD (%)	3.3	2.9	3.0

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд, 2026 оны 1-4 дүгээр сар

Зураг 1.7 Дэлхийн тодорхой бус байдлын индекс



Эх сурвалж: World Uncertainty Index

**БНХАУ:** БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд 5.0 хувь буюу тус улсын засгийн газрын зорилтот түвшинд хүрсэн хэдий ч үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилсэн хэвээр, дотоод эрэлт сул байгаа нь эдийн засгийн идэвхжилийг хязгаарлаж байна. Тус улсын Засгийн газраас 2026 онд дотоод эрэлт, тэр дундаа өрхийн хэрэглээг дэмжих бодлогыг баримталж, эдийн засгийн өсөлтийг 4.5-5.0 орчим хувьд хүргэх зорилтыг зарлаад байна. Энэ хүрээнд хэрэглээг дэмжихэд чиглэсэн татаас, урамшуулал, татварын дэмжлэгийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ төсвийн алдагдлыг ДНБ-ий 4 хувьд, засгийн газрын урт хугацаат бондын хэмжээг 1.3 их наяд юань, орон нутгийн бондын хэмжээг 4.4 их наяд юаньд хүргэхээ зарлаад байна. ОУВС энэ оны 4 дүгээр сард БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 2026 онд 4.4 хувь, 2027 онд 4.0 хувь байх төсөөллийг зарласан. Гэсэн хэдий ч сүүлийн саруудад Ойрх Дорнодод үүсээд буй нөхцөл байдалтай холбоотой тодорхой бус байдал нэмэгдэж байгаа нь БНХАУ-ын төдийгүй дэлхий эдийн засгийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

**ОХУ:** ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 онд 1 хувьд хүрч саарсан байна. Төсвийн зарлага өндөр хэвээр, төсвийн алдагдал өргөжсөн ч хөдөлмөрийн хүчний хомсдол, үйлдвэрлэлийн хүчин чадлын хязгаарлалт, инфляцын дарамт нь өсөлтийг хязгаарласан байна. Цаашид дайнтай холбоотойгоор тус улсын эдийн засаг тогтворгүй байдал үргэлжлэх төлөвтэй байна. Ойрх Дорнодод үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор ОУВС ОХУ-ын эдийн засгийн өсөлтийг 2026 онд 1.1 хувь болгож 1 дүгээр сарын төсөөллөөс 0.3 нэгжээр, 2027 онд 1.1 хувь болгож өмнөх төсөөллөөс 0.1 нэгжээр тус тус нэмэгдүүлээд байна.

**АНУ:** Худалдааны хурцадмал байдал түр намдаж, АНУ төсвийн тэлэх бодлого хэрэгжүүлж, хиймэл оюун ухааныг дагасан технологийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээс шалтгаалан ОУВС тус улсын эдийн засгийн 2025 оны өсөлтийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг 2.1 хувь болгож, 2026 оны өсөлтийн төсөөллийг 2.3 хувь, 2027 онд 2.1 хувь болгож нэмэгдүүлээд байна. Гэсэн хэдий ч бодлогын тодорхой бус байдал, худалдааны саад, хөдөлмөрийн зах зээлийн өсөлт саарснаар эдийн засгийн өсөлт 2024 оны түвшин (2.8 хувь)-тэй харьцуулахад суларсан үзүүлэлттэй байна.


**Евро бүс:** Евро бүсийн эдийн засаг 2025 онд 1.4 хувиар тэллээ. Бүсийн өсөлтөд дотоод эрэлт, ялангуяа үйлчилгээний салбарын сэргэлт эерэг нөлөө үзүүлсэн бол бүсийн эдийн засгийн 30 орчим хувийг бүрдүүлдэг ХБНГУ-ын аж үйлдвэрийн салбарын идэвхжил сул хэвээр байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. ОУВС евро бүсийн эдийн засгийн өсөлт 2026 онд 1.1 хувь, 2027 онд 1.2 хувьд хадгалагдана гэж тооцоолж байна.

### **1.2.2 Уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн хандлага**


**Зэсийн үнэ:** Лондоны металлын бирж дээрх цэвэр зэсийн дундаж үнэ 2025 онд 9,947 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 8.8 хувиар өссөн байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар цэвэр зэсийн дундаж үнэ 12,979 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 30.5 хувиар өссөн байна. Индонези, Чили улсад байрлах зэсийн томоохон уурхайнуудын үйл ажиллагаа ослын улмаас доголдож, зэсийн нийлүүлэлт буурснаар оны эхэнд дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ өсөхөд голлон нөлөөлөв. Дунд хугацаанд цахилгаан эрчим хүч болон технологид суурилсан салбаруудын өсөлтөөс шалтгаалан зэсийн эрэлт нэмэгдэж, үнэ өсөх хүлээлттэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2026 онд 11,900 ам.доллар, 2027 онд 12,200 ам.долларт хүрэхээр байна.

**Алтны үнэ:** Лондоны металлын бирж дэх алтны дундаж үнэ 2025 онд 3,446 ам.доллар/унц болж, өмнөх оноос 44.3 хувиар өссөн байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 4,926 ам.доллар/унц болж, өмнөх оноос 42.9 хувиар өссөн байна. Геополитикийн зөрчил нэмэгдэж, олон улсын хурцадмал байдал өндөр хэвээр байгаа энэ үед дэлхийн төв банкнуудын алтны худалдан авалт нэмэгдсэн нь алтны үнэ өсөхөд нөлөөллөө. Дэлхийн тодорхой бус байдал нэмэгдэж байгаатай холбоотойгоор алтны үнэ тогтвортой байх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2026 онд 4,500 ам.доллар, 2027 онд 4,000 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 1.8 Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Зураг 1.9 Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/унц)



Эх сурвалж: Блүүмберг терминал

**Төмрийн хүдрийн үнэ:** Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) үнэ 2025 онд 102 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 7.5 хувиар буурсан байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 105 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 3.2 хувиар өслөө.

Австрали, Бразил зэрэг улсуудын нийлүүлэлтийн өсөлт, БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт төмрийн хүдрийн үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар богино хугацаанд сэргэх төлөвгүй байгаагаас гадна Австрали, Бразил зэрэг улсуудын олборлолт тогтвортой өсөхөөр байгаа тул төмрийн хүдрийн үнэ буурах төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2026 онд 95 ам.доллар, 2027 онд 85 ам.долларт хүрэхээр байна.

**Коксжих нүүрсний үнэ:** Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний дундаж үнэ 2025 онд 189 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 22.4 хувиар буурсан байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 233 ам.доллар/тонн болж, өмнөх оноос 23.6 хувиар өслөө. Австрали улсад их хэмжээний бороо орсноос шалтгаалан уурхай, тээвэр логиستيкийн үйл ажиллагаа доголдож, мөн уурхайн засвар үйлчилгээний саатлууд давхацсанаар нийлүүлэлт богино хугацаанд хумигдаж, үнэ өслөө. Олон улсын шинжээчдийн таамаглалаар коксжих нүүрсний дундаж үнэ 2026 онд 205 ам.доллар, 2027 онд 215 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 1.10 Төмрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)




Зураг 1.11 Коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал

**Газрын тосны үнэ:** Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2025 онд 66 ам.доллар/баррель болж, өмнөх оны эцсээс 10.2 хувиар буурсан байна. Харин 2026 оны эхний 3 сарын байдлаар 72 ам.доллар/баррель болж, өмнөх оны эцсээс 9.4 хувиар өслөө. Персийн булангийн бүсэд үүссэн зөрчлөөс шалтгаалан Ормузын хоолойн тээвэрлэлт багассантай холбоотойгоор дэлхийн газрын тосны нийлүүлэлтэд буурч, үнэ өсөхөд голлон нөлөөллөө. Геополитикийн тодорхой бус байдал нэмэгдэж, нийлүүлэлт тасалдах эрсдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор 2026 онд газрын тосны үнэ өсөх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар Brent төрлийн газрын тосны дундаж үнэ 2026 онд 80 ам.доллар, 2027 онд 70 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 1.12 Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)




### 1.2.3 Дотоодын нийт бүтээгдэхүүн

Эдийн засгийн өсөлт 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд 6.3 хувь орчимд байх төлөвтэй байна. Уул уурхайн салбарт зэсийн баяжмал үйлдвэрлэл, нүүрс, төмрийн хүдэр олборлолтын хэмжээ нэмэгдсэнээр салбарын өсөлтийг 2027 онд тэтгэх хүлээлттэй байна. Оюу толгойн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, мөнгөний агуулга нэмэгдэж байгаагаас гадна дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ дунд хугацаанд өсөх хүлээлттэй байгаа нь өсөлтийг дэмжиж байна. Харин нийт алт олборлолтын хэмжээ болон Оюу толгойн зэсийн баяжмал дахь алтны хэмжээ буурахаар байгаа нь өсөлтийг сааруулахаар байна. Ингэснээр салбарын өсөлт 4.5 хувь, өсөлтөд үзүүлэх нөлөө 0.6 нэгж хувь байхаар байна.

Зураг 1.13 Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүн (хувь, их наяд төгрөг)



Эх сурвалж: ЭЗХЯ тооцоолол, ҮСХ

Уул уурхайн бус салбаруудын үйлдвэрлэл 2027 онд 6.0 хувиар, 2028 онд 6.8 хувиар, 2029 онд 6.6 орчим хувиар тус тус өсөхөөр төсөөлж байна. Тээврийн салбарт уул уурхайн болон уул уурхайн бус бүтээгдэхүүний ачаа тээвэр нэмэгдэж, Ойрх Дорнодын нөхцөл байдлаас үүдэн транзит тээвэр нэмэгдэх, боомтуудын хил холболтын бүтээн байгуулалт хийгдэн, тээврийн дэд бүтэц сайжирснаар тус салбар дунд хугацаанд 5 орчим хувиар өсөхөөр байна.

Мөн Хүнсний хувьсгал, Атар-4, Цагаан алт хөтөлбөрүүдийн нөлөөгөөр хөдөө аж ахуй, боловсруулах салбарын өсөлт дунд хугацаанд тогтвортой хадгалагдах төлөвтэй байна. Тухайлбал, Цагаан алт хөдөлгөөний хүрээнд 2028 он гэхэд ноолуурын боловсруулалтын түвшнийг 20 хувиас 40 хувьд, ноосны боловсруулалтын түвшнийг 25 хувиас 55 хувьд, арьс ширний боловсруулалтын түвшнийг 30 хувиас 50 хувьд хүртэл нэмэгдүүлэх зорилтыг тавьсан. Энэ хүрээнд нэхмэл эдлэлийн үйлдвэрлэл жил бүр дунджаар 5 орчим хувиар тогтвортой нэмэгдэж, 2028 оны эцэст зорилтот түвшинд хүрэхээр тооцоолж байна. Мөн Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд хүнсний үйлдвэрүүдийн тоо 53-аар нэмэгдсэн нь салбарын хүчин чадлыг тэлэхэд эерэг нөлөө үзүүлж байна. Цаашид 2028 он гэхэд гурилын хэрэглээг дотоодоос бүрэн хангах, үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээлийг 200 мянган тонноор нэмэгдүүлэх Атар-4 аяны зорилтуудтай уялдуулан улаан буудайн ургацын хэмжээ 2027 онд 449 мянган тоннд хүрч, 2028-2029 онд тогтвортой нэмэгдэх, газар тариалангийн үйлдвэрлэл болон боловсруулах салбарын үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл өсөхөөр тооцоолж байна.

Харин боловсруулах салбарын 30 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах үйлдвэрлэлийн дунд хугацааны өсөлтөд Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт нөлөө үзүүлнэ гэж хүлээж байна. Уг техникийн зохицуулалтын хүрээнд хоол үйлдвэрлэл, худалдааны газарт борлуулах мах болон цэцэрлэг, эмнэлэг, сургуулийн хоолыг “мал төхөөрөх үйлдвэр”-т бэлтгэсэн мах хэрэглэхээр заасан. Улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгт жилд дунджаар 12 орчим мянган тонн махыг хэрэглэж байгаа нь мах боловсруулах үйлдвэрт бэлтгэсэн малын махны 20-30 орчим хувьтай тэнцдэг бөгөөд дээрх зохицуулалтын хүрээнд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжтой байна. Иймд сургууль, цэцэрлэгийн нийт хэрэглээний махны мах боловсруулах үйлдвэрт бэлтгэгдэх хэмжээг тогтвортой нэмэгдэхээр, мөн мах, махан бүтээгдэхүүний экспортыг хориглох аливаа шийдвэр гарахгүй байх суурь нөхцөлийн хүрээнд төсөөллийг боловсрууллаа.

Түүнчлэн ирэх онуудад хэрэгжих томоохон төслүүд аж үйлдвэрийн салбарын өсөлтийг голчлон тэтгэхээр байна. Тухайлбал, Эрдэнэбүрэнгийн УЦС, Газрын тос боловсруулах үйлдвэр, Баян ДЦС, Даланзадгад ДЦС, Сэлэнгэ ДЦС, Бөөрөлжүүт ДЦС, Дулааны тавдугаар цахилгаан станц, Зэс хайлуулах үйлдвэр, Гангийн үйлдвэр, Нүүрс-химийн цогцолбор зэрэг бүтээн байгуулалтын төслүүд барилга, эрчим хүч, боловсруулах салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, нийт эдийн засгийн өсөлтийг дэмжих хөшүүрэг болохоор байна.

Мөн дунд хугацаанд уул уурхай, тэр дундаа нүүрсний экспорт нэмэгдсэнээр эдийн засгийн дотоод эрэлтийг дэмжиж худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа тогтвортой үргэлжлэн 2027-2029 онд эдийн засгийн өсөлтөд жил бүр 3 орчим нэгж хувийн тогтвортой хувь нэмэр оруулахаар байна.

#### **1.2.4 Хэрэглээний үнийн түвшин, мөнгөний бодлогын үндсэн үзүүлэлт**

Инфляц 2027 онд дунджаар 7.0 хувь байх төлөвтэй байна. Тодруулбал, ирэх онд хүнсний үнийн өсөлт тогтворжиж алгуур буурах, эрэлтийн шинжтэй инфляц буурах,

өндөр өсөлттэй байсан суурь үеийн нөлөө зэргээс шалтгаалан инфляц төв банкны зорилтот интервалд хүрч тогтворжихоор байна. Дунд хугацаанд инфляц 2028 онд 6 хувь, 2029 онд 5 хувьд хүрэхээр төсөөлж байна. Төв банкнаас төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлд заасны дагуу инфляцын зорилтыг 2027 оноос 5 хувь болгон бууруулах мөнгөний бодлогыг хэрэгжүүлнэ. Үүний зэрэгцээ “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний нөлөөгөөр хүнсний нийлүүлэлт нэмэгдэж, дотоодын хүнсний үнийн өсөлт буурах хүлээлттэй байна. Тухайлбал, хүнсний чиглэлийн аж ахуйн нэгжийн тоо 2024 оны эцсийн байдлаар 2022 онтой харьцуулахад 28 хувиар нэмэгдсэн байна. Мөн 2025-2028 онд хэрэгжих “Атар-4” тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэл нэмэгдэж, нийлүүлэлт өсөх төлөвтэй байна. Цаашилбал, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл дунд хугацаанд дунджаар 2.1 хувиар нэмэгдэх хүлээлттэй байна. Мөн Засгийн газраас авч хэрэгжүүлэх гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг хязгаарлахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр инфляц үргэлжлэн буурахаар байна. Түүнчлэн Монгол Улс болон Евроазийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнуудын хооронд байгуулж буй худалдааны түр хэлэлцээрийн хүрээнд 367 нэр төрлийн бараа тарифын хөнгөлөлт, чөлөөлөлттэй болсноор худалдааг хөнгөвчилж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар инфляцын дарамтыг бууруулахаар байна.

#### **1.2.5 Ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин**

Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын судалгаагаар дундаас дээш орлоготой улс орнуудын ажиллах хүчний оролцооны түвшин дунджаар 66 хувь байдаг бөгөөд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт ажиллах хүчний оролцооны түвшнийг дээрх улс орнуудын түвшинд хүргэх буюу 2025 онд 63 хувь, 2030 онд 65 хувьд хүргэх зорилт тавьсан. Энэ хүрээнд Засгийн газраас хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, хэрэгцээнд нийцсэн орчныг бүрдүүлэх, хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, тогтвортой ажлын байр бий болгох, хүний нөөцийн ур чадварыг хөгжүүлэх, мэдээллийн нэгдсэн платформ бүрдүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, нийгмийн түншлэлийг бэхжүүлэх замаар иргэдийн ажил эрхлэлтийг дэмжих бодлого, арга хэмжээнүүд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Түүнчлэн төрөлтийн түвшин 1990-2005 оны хооронд буурснаас шалтгаалан хөдөлмөрийн насны хүн амын өсөлт удааширч, ажиллах хүчний нийлүүлэлт саарч буй байдал 2026 оноос эхлэн суларч, хөдөлмөрийн насны хүн амын өсөлт эргэн нэмэгдэх хандлагатай байна.

Нөгөөтээгүүр, 2027-2029 онд жилд дунджаар 38 мянган хүн тэтгэвэрт гарах төлөвтэй байгаа бол хөдөлмөрийн зах зээлд жилд дунджаар 67 мянган шинэ төгсөгч нийлүүлэгдэхээр байна. Судалгаагаар<sup>5</sup> цар тахлаас өмнөх 4 жилийн хугацаанд жилд дунджаар 75 мянган ажлын байр, үүний дотор 45 мянган шинэ ажлын байр бий болох хүлээлттэй байсан бол цар тахлаас хойших онуудад жилд дунджаар 85 мянган ажлын байр, үүнээс 51 мянган шинэ ажлын байр бий болох хүлээлттэй болж нэмэгдсэн байна. Түүнчлэн уул уурхай, боловсруулах зэрэг салбаруудад хэрэгжих томоохон бүтээн байгуулалтын төслүүдэд ойрын жилүүдэд урьдчилсан байдлаар 12

<sup>5</sup> Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа

мянга<sup>6</sup> ажлын байр шаардагдахаар байх тул хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна.

Эдгээрийн үр дүнд ажилчдын тоо 2027 онд 1 сая 450 мянгад хүрч, цаашид өсөлтөө тогтвортой хадгалан 2028-2029 онд ойролцоогоор 1.5 саяд хүрэх төлөвтэй байна. Үүний зэрэгцээ иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж, сонирхол нэмэгдсэнээр ажиллах хүчнээс гадуурх хүн ам буурна гэж таамаглаж байна. Ингэснээр ажилгүй иргэдийн тоо аажмаар буурч 2027 онд 83 мянга, 2028-2029 онд 82 мянгад хүрнэ гэж үзэж байна. Энэ нь ажиллах хүчний оролцооны түвшнийг 2027 онд 63 хувь, цаашлаад 2029 онд 65 хувьд хүргэх бөгөөд 2026-2028 онд ажилгүйдлийн түвшин 5 хувь орчимд хэлбэлзэх хандлагатай байна.

### 1.2.6 Гадаад худалдааны тэнцэл

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2027-2029 онд дунджаар 6 орчим тэрбум ам.долларын ашигтай байх төлөвтэй байна.

Уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний экспорт 2027-2029 онд дунджаар 5-6 хүртэл хувиар өсөхөөр төсөөлж байна. Тухайлбал, дунд хугацаанд нүүрсний баяжуулах үйлдвэрийн нөлөөгөөр нийт нүүрсэнд эзлэх баяжуулсан коксжих нүүрсний хувь хэмжээ өсөхийн зэрэгцээ нүүрсийг ангилан ялгалгүй, жигд борлуулах бодлогын хүрээнд эрчим хүчний нүүрсний эзлэх хувь мөн нэмэгдэх хандлагатай байна. Түүнчлэн, Оюу толгойн зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдэж байгаагаас гадна дэлхийн зах зээл дэх зэсийн үнэ дунд хугацаанд өсөх нь экспортын орлогыг нэмэгдүүлэхээр байна.

Үүнээс гадна, төмөр замын суурь дэд бүтцийг сайжруулж, хилийн Гашуунсухайт боомтын хил холболтын ажлыг 2028 онд бүрэн хэрэгжүүлж дууссанаар нүүрс болон төмрийн хүдрийн экспорт дунд хугацаанд тогтвортой нэмэгдэхээр байна.

Хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр ноолуур, арьс шир, малын мах зэрэг уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт 2027-2029 онд 8-13 орчим хувиар өсөхөөр байна. Улмаар нийт экспорт 2027 онд 19.4 тэрбум ам.доллар хүрэхээр тооцлоо.

Ойрх Дорнодод үүсээд буй геополитикийн хурцадмал байдал, түүнээс үүдсэн дизель түлшний үнийн өсөлтийн нөлөөгөөр 2026 онд импорт 12.5 тэрбум ам.долларт хүрэхээр тооцоолж байна. Дунд хугацаанд эдийн засгийн идэвхжил хадгалагдаж, дайны нөлөө саарч, газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн УЦС зэрэг томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр импорт 2027 онд 12.7 тэрбум ам.доллар, 2028 онд 13.1 тэрбум ам.доллар, 2029 онд 14.1 тэрбум ам.долларт хүрнэ гэж төсөөлж байна. Мөн

Зураг 1.14 Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн төсөөлөл

Гадаад худалдаа (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Тооцоолол, ГЕГ-ын статистик

<sup>6</sup> Мега төслүүд хариуцсан салбар яамд болон төслүүдийн ТЭЗҮ-ээс авч тооцоолов.

бараа, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой бүртгэлийг автоматжуулж, боомтуудын хүчин чадлыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна.

#### **1.2.7 Төлбөрийн тэнцэл**

Дунд хугацаанд нүүрс, төмрийн хүдрийн үнэ буурах хандлагатай байгаа хэдий ч гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдэж буй нь алт, зэс, газрын тос зэрэг манай улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийг өсгөх хүлээлтийг бий болгож байна. Үүний үр дүнд урсгал дансны алдагдал буурч, төлбөрийн тэнцэлд зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Гэсэн хэдий ч ирэх жилүүдэд гадаад өрийн төлбөрийн ачаалал нэмэгдэх хандлагатай байгаа тул макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах замаар гадаад зах зээлээс татах хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна. Энэ хүрээнд Засгийн газар хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, зээлжих зэрэглэлийг ахиулах замаар гадаад зах зээлээс хөрөнгө татах өртөг, зардлыг бууруулах бодлогыг баримталж байна.

Түүнчлэн өрийн удирдлагын бодлогын хүрээнд 2027–2029 онд төлөгдөх “Сенчири-1”, “Сенчири-2”, “Сенчири-3” бондын нийт 1.0 тэрбум ам.долларын төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах замаар зохицуулж, үе шаттайгаар төлөх арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр байна.

*Шигтгээ 1.1. Хөдөө аж ахуйн салбарт дунд хугацаанд хэрэгжих хөтөлбөрүүдийн зорилт*

**Хүнсний хувьсгал хөдөлгөөн**

Монгол улсын их хурлын 2022 оны “хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36 дугаар тогтоолын дагуу “хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг 2022-2026 онд хэрэгжүүлж байна. Энэхүү хөдөлгөөн нь хүнсний аюулгүй байдлыг хангах, хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж, мал аж ахуй, газар тариалангаа эрчимжүүлэн хөгжүүлэх зорилготой. “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, газар тариалан, мал аж ахуй болон хүнсний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих чиглэлд нийт 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Тус хөдөлгөөний үр дүнд мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногоо, гурил ба гурилан бүтээгдэхүүн, өндөг, цөцгийн тос, элсэн чихэр, цөцгийн тос, төрөл бүрийн будаа, жимс, жимсгэнэ зэрэг гол нэр төрлийн 19 хүнсний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангаж, цаашлаад хүнс экспортлох суурь нөхцөлийг бүрдүүлэх юм. Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах, цаашид экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд 2022-2026 онд нийт 1.7 их наяд төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд санхүүжилтийн эх үүсвэрийг 2022-2026 оны улсын төсвөөс зээлийн хүүгийн татаас болон батлан даалт, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр бүрдүүлж байна.

2025 оны эцсийн байдлаар “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний хэрэгжилт 71 хувьтай байна. Нийт олгосон зээлийн хэмжээ 2023 онд 833 тэрбум төгрөг, 2024 онд 429 тэрбум төгрөг байна. Үүнээс 48 хувь нь эргэлтийн хөрөнгийн зээл, 52 хувь нь хөрөнгө оруулалтын зээл байна. Олгосон зээлийг ангиллаар авч үзвэл, нийт зээлийн 60 хувь буюу 753.5 тэрбум төгрөгийг газар тариалангийн салбарт, 8 хувь буюу 102.2 тэрбум төгрөгийг мал аж ахуйн салбарт тус тус олгосон байна. Мөн хүнс, хөдөө аж ахуйн салбарын аж ахуйн нэгжийн тоо 2022 онтой харьцуулахад 47 хувиар өсөж, 2024 оны эцсийн байдлаар 7,635-д хүржээ. Түүнчлэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2025 онд өмнөх оноос 16.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тус хөдөлгөөний үр дүнд 19 гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаснаар нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамт буурч, иргэдийн бодит орлого нэмэгдэх нөхцөл бүрдэх ач холбогдолтой.

*Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам*

**Цагаан алт хөдөлгөөн**

Монгол улс жилд дунджаар 30-35 мянган тонн хонины ноос, 10 мянга орчим тонн ямааны ноолуур, 2 мянга орчим тонн тэмээний ноосны түүхий эдийн нөөцтэй байна. Бэлтгэсэн түүхий эдийн нөөцийн 70-75 орчим хувийг угаан экспортолж байна. Тухайлбал, ямааны ноолуурын боловсруулалтын түвшний хувьд 70 орчим хувийг угааж, 10 орчим хувийг самнаж, 20 орчим хувиар бэлэн бүтээгдэхүүн болгож байна. Харин хонины ноосны 75 орчим хувийг угааж, 25 хувиар бэлэн бүтээгдэхүүн, тэмээний ноосны 90 хувийг угааж, 10 хувиар бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Харин жилд дунджаар 18 сая ширхэг арьс, ширэн түүхий эд нөөц бэлтгэх нөөцтэй хэдий ч 30 хүрэхгүй хувийг нь боловсруулж, үлдсэн хувийг нь боловсруулж чадахгүй байна. Тухайлбал, дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд 2023 онд нийт 5.5 сая ширхэг нь боловсруулсны 3.3 сая ширхэгт хагас боловсруулалт, 2.3 сая ширхэгт гүн боловсруулалт хийсэн бол 12.5 сая ширхэг арьс ширийг боловсруулж чадаагүй байна.

*Хүснэгт 1.2 Цагаан алт хөдөлгөөний зорилт*

Хүрэх үр дүн	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилт 2028		
Ноолуурын бүрэн боловсруулалтын түвшинд нэмэгдүүлнэ	Хувь	20	40		
Ноосны боловсруулалт, ашиглалтын хувь хэмжээг нэмэгдүүлнэ	Хувь	25	55		
Арьс, ширний ашиглалт, гүн боловсруулалтын түвшнийг нэмэгдүүлнэ	Гүн боловсруулалтын түвшин		Хувь	30	50
	Арьс, ширний ашиглалт	Гүн боловсруулсан	Сая, ширхэг	2.3	4.0
		Хагас боловсруулсан		3.3	5.2
		Боловсруулаагүй		12.5	8.8

Иймд уул уурхайн бус экспортын гол бүтээгдэхүүн ноос, ноолуурын нөөцийг дотооддоо бүрэн боловсруулж, нэмүү өртөг болон эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар боловсруулах салбарын өсөлтийг хадгалж, экспортын орлогыг дэмжих боломжтой. Энэ хүрээнд нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор монгол улсын их хурлын 2024 оны “малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын дагуу “цагаан алт” хөдөлгөөнийг эхлүүлсэн. Мөн монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “цагаан алт” хөдөлгөөний хүрээнд малын гаралтай түүхий эдийн инновац шингэсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг дэмжих бодлогыг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр заасан. “цагаан алт” хөдөлгөөн нь салбарын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, түүхий эдийн чанар, бэлтгэлийн тогтолцоог дэмжих, үйлдвэрлэл,

борлуулалт, экспортыг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх, салбарын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах гэсэн үндсэн 4 чиглэлийн хүрээнд хэрэгжинэ. Тус хөдөлгөөний хүрээнд 2028 он гэхэд ноолуурын бүрэн боловсруулалтын түвшнийг 20 хувиас 40 хувьд, ноосны боловсруулалтын түвшнийг 25 хувиас 55 хувьд, арьс ширний боловсруулалтын түвшнийг 30 хувиас 50 хувьд хүргэж нэмэгдүүлэх зорилтыг тавьсан. Эдгээр зорилт, арга хэмжээ нь боловсруулах салбарын өсөлтийг дэмжихэд чухал нөлөөтэй байна.

*Эх сурвалж: хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам*

#### **Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян**

Монгол улсын тариалангийн талбайн 61.6 хувь нь хүчтэй элэгдсэн, 47.7 хувь нь маш бага үржил шимтэй байна. Газар тариалангийн салбар дах хөрөнгө оруулалт алгуур нэмэгдэж, тариалсан талбайн хэмжээ өсөж байгаа ч таримал ургамлын үр сортын тогтолцоо алдагдсан, таримлын үрийн чанар, үр үйлдвэрлэл, хуваарилалтын тогтолцоо бүрдээгүй, нутагшсан сортын үрийн хүрэлцээ хангамж дутагдах зэрэг асуудлууд нь газар тариалангийн салбарын бүтээмж, үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж байна. Иймд монгол улсын засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хүн амын өсөн нэмэгдэж байгаа хүнсний хэрэгцээг хангах зорилгоор "атар-4" аяныг хэрэгжүүлэхээр тусгасан. Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны зорилго нь тариалангийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хөрс, уур амьсгалын онцлогт тохирсон шинэ болон ашигт таримлыг нутагшуулах, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар газар тариалан, мал аж ахуйн төгс хослолыг бий болгож, төвийн бүсийг хөдөө аж ахуйн жишиг бүс болгон хөгжүүлэхэд чиглэж байна.

Энэ хүрээнд эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах, тариалангийн талбайн хөрсний элэгдэл эвдрэлийг хамгаалах, хөрсний үржил шимийг сайжруулах, таримлын зохистой сэлгээ, тэг элдэншүүлгийн технологийг үе шаттай нэвтрүүлэх, ургамал хамгааллын цогц арга хэмжээг төлөвшүүлэх, үр үржүүлгийн аж ахуйг цогцолбор байдлаар хөгжүүлэх усалгааны дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Тус аяныг хэрэгжүүлснээр хөдөө аж ахуйн салбарын боломжит нөөцийг бүрэн ашиглах, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хүн амыг баталгаат хүнсээр, үйлдвэрлэлийг түүхий эдээр тогтвортой хангахад чиглэсэн бодит үр дүнд хүрч эдийн засагт тодорхой өсөлт бий болно гэж хүлээж байна.

Атар-4 аяны хүрээнд газар тариалангийн талбайг 200 мянган га талбайгаар нэмэгдүүлэх, гурилыг дотоодоос 100 хувь хангах, үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн тэжээлийг 200 мянган тонноор нэмэгдүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлсэн. Мөн газар тариалангийн салбарын бүтээмжийг нэмэгдүүлэхэд мах, сүүний кластер байгуулах, агуулахын хүчин чадлыг 100 мянган тонноор нэмэгдүүлэх, өвлийн хүлэмж байгуулах зэрэг зорилт, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Эдгээр зорилт, арга хэмжээ нь хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлт дунд хугацаанд тогтвортой хадгалагдахад гол нөлөө үзүүлнэ.

*Хүснэгт 1.3 Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны зорилт*

Хүрэх үр дүн		Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилт 2028
Газар тариалангийн талбайг 200 мян.га-аар нэмэгдүүлэх		Мянган га	962.0	1,162.0
Малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.	Малын тэжээл тариалалтын талбайг 105 мян.га-аар	Мянган га	94.9	200.0
	Малын тэжээл үйлдвэрлэл 353 мян.тонн-оор	Мянган тонн	246.9	600.0
	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн тэжээл 200 мян.тонн-оор	Мянган тонн	278.0	390.0
Дотоодын гурилын хангамж		Хувь	59.1	100.0
Мах, сүүний кластер байгуулах хүрээнд үүлдрийн үхрийг 200 мянгаар		Кластерийн тоо	-	15.0
Агуулахын хүчин чадлыг 100 мян.тонн-оор нэмэгдүүлэх		Мянган тонн	355.0	455.0
Шинээр болон сэргээн засах усалгаат тариалангийн талбайг 10 мян.га-аар нэмэгдүүлэх		Мянган га	63.4	73.4
Ойн зурвас 20 сая мод тарина		Км	3,557.0	10,000.0
Өвлийн хүлэмж байгуулна 50 га		Га	39.1	89.0

*Эх сурвалж: хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам*

*Шигтгээ 1.2. Монгол улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр*

Хамрах хүрээ: хэлэлцээрийн төсөл нь нийт 31 зүйл, 4 хавсралтаас бүрдэнэ. Үүнд: барааны ангилал, гаалийн татварын хөнгөлөлт болон/эсхүл чөлөөлөлт, гарал үүслийн дүрэм, гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөх, гаалийн хамтын ажиллагаа, чөлөөтэй дамжин өнгөрөх, амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ, төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор хэрэгжүүлэх хязгаарлалт, худалдааны хохирлыг арилгах арга хэмжээ, ил тод байдал болон мэдээлэл солилцох, цахим худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, хамтарсан хороо зэрэг багтаж байна. Хэлэлцээрт хөрөнгө оруулалт, үйлчилгээний худалдаа, банк санхүү, төлбөр тооцоо зэрэг асуудлууд тусгагдаагүй бөгөөд зөвхөн барааны худалдааны хүрээнд байгуулахаар тохиролцсон. Хэлэлцээрийг 3 жилийн хугацаатай байгуулах бөгөөд талууд харилцан тохиролцон тус хугацааг сунгах боломжтой.

Тарифын хөнгөлөлт эдлүүлэх нөхцөл: энэхүү хэлэлцээрээр монгол улсаас гаралтай нийт 367 мөр бараанд хамаарах нийт 621 нэр төрлийн бараа, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай нийт 367 мөр бараанд хамаарах нийт 499 нэр төрлийн барааны гаалийн тарифын хувь хэмжээг тохиролцсон. Талууд дараах байдлаар харилцан нөгөө талдаа тарифын хөнгөлөлт эдлүүлнэ.

Монголын тарифын үүрэг		ЕАЭЗХ -ны тарифын үүрэг	
Нөхцөл	Хамаарах барааны тоо /6 оронтой мөр бараа/	Нөхцөл	Хамаарах барааны тоо /6 оронтой мөр бараа/
Гаалийн тарифыг шууд тэглэх	356	Гаалийн тарифыг шууд тэглэх	365
Тарифыг бууруулах (25, 50 хувиар бууруулах)	6	Татварын бууралт хийх (25 хувиар бууруулах)	2
Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг тэглэх	2		
Квот тогтоож, заасан хэмжээнд тарифыг бууруулах	3		

Монгол улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад экспортлох нийт 621 нэр төрлийн бараанаас 619 барааны гаалийн тарифыг тэглэж, цагаан архи, шар айргийн тарифыг 25 хувиар бууруулна. Өөрөөр хэлбэл, манай улсын экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий бараанууд татваргүй экспорт хийх боломжтой. Жишээлбэл, үхрийн махны 50 хувь, адууны махны 15 хувь, махан бүтээгдэхүүний 15-20 хувь, ноос, ноолуурын 5-10 хувь, нэхмэл, оёмол эдлэлийн 18 хувийн гаалийн тариф энэхүү хэлэлцээрийн хүрээнд татваргүй болж байна.

Үүнийг 2023 онд ОХУ руу гаргасан экспортын гүйцэтгэлээр тооцож үзвэл монгол улсын аж ахуйн нэгжүүд 1 жилд багадаа 16.6 сая ам.доллартой тэнцэх гаалийн тарифыг тэглүүлэх бөгөөд хэлэлцээрийн хүрэх үр дүн, ач холбогдол нь монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдтэй нийцтэй болно.

Манай улсын стратегийн хүнсний бүтээгдэхүүн болох улаанбуудай болон өндөгний хувьд дотоодын үйлдвэрлэл, хэрэглээний хэмжээг харгалзан дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор квот тогтоож, тарифыг тэглэхгүйгээр бууруулах байдлаар тохирсон.

Сүүлийн 3 жилийн өндөгний дотоодын нийт хэрэглээ 448.6 сая ширхэг бөгөөд үүнээс 165 сая ширхэг буюу 36.8 хувийг импортоор нийлүүлсэн. Дотоодын өндөг үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор нийт зах зээлийн 20 хувийг импортын орон зайд хэвээр үлдээж, 90 сая ширхэг хүртэлх импортын өндөгт татварыг 50 хувь бууруулж 7.5 хувийн татвартай байх, 90 саяас дээш импортлох тохиолдолд татварыг хэвээр үлдээх буюу 15 хувийн татвартай байхаар тохиролцсон.

Мөн жил бүр ургац хураалтын нөхцөл байдлаас хамааран 30.0-50.0 мянган тонн улаанбуудайг импортлох шаардлага үүсдэг. Энэ хүрээнд айлын талаас хатуу болон зөөлөн улаанбуудайд нийтдээ 180.0 мянган тонны квот санал болгосныг 50.0 мянган тонн болгон бууруулж, айлын талыг буулт хийлгэснээр талууд тохиролцоонд хүрээд байна.

Ийнхүү монгол улсаас экспортлох бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэснээр тухайн барааг үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын шинэ зах зээлд нэвтрэх боломж бүрдэж, дотоодын бизнес эрхлэгчдийн гадаад худалдааны туршлага, чадвар нэмэгдэж, олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болно. Тухайлбал:

- 9 нэр төрлийн мах, махан бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 29 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ;
- 24 нэр төрлийн арьс ширэн бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 60 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ;
- 64 нэр төрлийн ноос, ноолууран бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 204 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ;
- 22 нэр төрлийн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн татвартай экспортолж байгаа бол 73 болж нэмэгдэн, татвар тэглэгдэнэ.

**Худалдааг хөнгөвчлөх зохицуулалт: хэлэлцээрийн төсөлд худалдааг хөнгөвчлөх болон гадаад худалдаа эрхлэгчдэд давуу байдал үүсгэх дараах зохицуулалт тусгагдсан:**

- *Гарал үүслийг илүү таатай, уян хатан байдлаар тодорхойлох нөхцөлийг тусгасан. Тухайлбал, ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас гаралтай түүхий эд, материалыг ашиглан монгол улсад боловсруулсан барааг монгол улсын гарал үүсэлтэйд тооцох боломжийг олгосон. Мөн тухайн барааны гарал үүслийн хувь 50 ба түүнээс дээш байхад гарал үүслийг хүлээн зөвшөөрөх, зарим тохиолдолд гарал үүсэлгүй материалыг ашиглах боломжийг нээж өгсөн. Барааг тээвэрлэхэд зориулсан сав, баглаа боодол зэргийг тухайн барааны гарал үүслийг тогтооход тооцохгүй байх;*
- *Бараа бүтээгдэхүүнийг гаальд мэдүүлснээс хойш 4 цагийн дотор олгоно;*
- *Гаалийн мэдээлэл, гарал үүслийн гэрчилгээг цахимаар солилцох боломжтой;*
- *Гаалийн хяналт шалгалтын тухайд өндөр эрсдэлтэй бараанд шалгалтыг төвлөрүүлж, бага эрсдэлтэй бараанд хялбарчилна;*
- *Талууд итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр хэрэгжүүлнэ. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн ААН бараагаа гаалийн байгууллагад байнга шалгуулах шаардлагагүй болох ба гаалийн бүрдүүлэлтэд шаардлагатай баримт бичгийн тоо, гаалийн бүрдүүлэлтийн хугацаа, зардал болон ачаа саатал багасах зэрэг боломж бүрдэнэ;*
- *5000 еврогоос доош үнийн дүн бүхий барааны гарал үүслийн гэрчилгээг экспортлогч заавал итгэмжлэгдсэн байгууллагаас буюу монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим (цаашид "МҮХАҮТ" гэх)-аас авахгүйгээр өөрөө гаргаж болно. Энэ нь барааны нэхэмжлэх, гэрээ зэрэг хэлбэртэй байх боломжтой;*
- *Гарал үүслийн гэрчилгээг гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдрөөс хойш 12 сарын дотор нөхөн гаргаж тарифын хөнгөлөлт эдлэх боломжтой;*
- *Талууд тохирлын үнэлгээний үр дүнг харилцан зөвшөөрөх гэрээ байгуулах хэлэлцээ эхлүүлж болно;*
- *Цахим худалдаа эрхлэгчдийн гаалийн бүрдүүлэлтийг хөнгөөчилнө;*
- *Цахим гарын үсэг нь цаасан хэлбэрийн гарын үсэгтэй адил эрх зүйн хүчинтэй байна;*
- *Монгол улсаас ЕАЭЗХ-д экспортлох бараанд үндэсний нөхцөл олгож байгаа буюу тухайн улсын дотоодод үйлчлэх татвар, хураамжтай ижил хэмжээний татвар ногдуулах, дотоодын бараатай ижил дүрэм, журам, шаардлага тавигдах боломж бүрдсэн;*
- *Худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэсэн тохиолдолд талууд хамтарсан хорооны түвшинд техникийн зөвлөлдөх уулзалт хийн асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдсэн. Мөн ХАА-н гаралтай бүтээгдэхүүн экспортлох үеийн эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хялбаршуулах, тохирлын гэрчилгээний үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээг эхлүүлэх боломж бүрдэнэ.*

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ), түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2025.11.28-ны өдөр Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд УИХ-ын чуулганы 2025.12.12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар соёрхон баталсан.

Өнөөдрийн байдлаар (2026.04.27) ЕАЭЗХ-ны гишүүн Улс орнууд дараах байдлаар соёрхон баталсан байна. Үүнд:

- 2025.12.23 - Бүгд Найрамдах Беларусь Улс
- 2025.12.29 – Оросын Холбооны Улс
- 2026.02.12 – Бүгд Найрамдах Казахстан Улс
- 2026.03.25 - Бүгд Найрамдах Армени Улс
- 2026.04.24 - Бүгд Найрамдах Киргиз Улс

Гишүүн улс орнууд хэлэлцээрийг соёрхон баталсны дараа Евразийн эдийн засгийн комисс (ЕАЭЗК)-д албан ноотоор мэдэгдэж, тухайн шийдвэрийг баталгаажуулах зорилгоор гишүүн орнуудын төрийн тэргүүнүүд гарын үсэг зурах ажиллагааг зохион байгуулдаг. Одоогийн байдлаар Казахстан Улсын гарын үсэг хүлээгдэж байна. Албан ёсны бүх процедур бүрэн дууссаны дараа ЕАЭЗК-оос Монгол Улсын Гадаад харилцааны яаманд албан ноот хүргүүлж, хэлэлцээр хүчин төгөлдөр болох огноог албан ёсоор мэдэгдэнэ.

Үүний зэрэгцээ, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2026 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар тус хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах Ажлын хэсгийг байгуулсан. Улмаар 2026 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн А/46 дугаар тушаалаар хэлэлцээр хүчин төгөлдөр болох хүртэлх бэлтгэл ажлыг зохион байгуулах, цаашдын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Энэхүү хүрээнд Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон харьяа байгууллагууд, Гаалийн ерөнхий газар, Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон бусад холбогдох байгууллагууд хамтран, түр хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгох бэлтгэл ажлыг хангахын зэрэгцээ түүний 3 жилийн хугацаанд үр дүнтэй хэрэгжилтийг хангахад чиглэн ажиллаж байна.

Мөн түр хэлэлцээрийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Монголын талын санаачилгаар "Монгол Улс, Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хооронд байгуулсан худалдааны түр хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны хамтарсан замын зураглал"-ыг боловсруулж, гишүүн улс орнууд руу санал авахаар хүргүүлж, 2026 оны 05 дугаар сарын эхээр батлахаар ЕАЭЗК-той нягт хамтран ажиллаж байна.

### **1.3 Макро эдийн засгийн төлөв, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцсон арга зүй, тооцооны үндэслэл<sup>7</sup>**

Макро эдийн засгийн төлөв байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийг боловсруулахад богино хугацааны төсөөлөл болон хэтийн төлөвийн шинжилгээнд үндэслэсэн байх шаардлагатай байдаг. Макро эдийн засгийн төсөөлөл, бодлогын шинжилгээнд дараах загварууд ашиглагдаж байна. Үүнд,

#### **1. Хагас бүтцийн GAP загвар**

Дунд хугацааны төсөөлөл боловсруулахад Шинэ кэйнсийн онолд суурилсан эдийн засгийн бүтцийн шинж чанар бүхий хагас бүтцийн GAP загварыг ашиглаж байна. Тус загвар нь ханшийн төгс бус шилжих суваг, эдийн засгийн сектор бүрийн харьцангуй үнийн тренд, бодит ханшийн илүү ба дутуу үнэлэгдсэн байдал, хөрөнгө оруулалтын шок зэргийг эдийн засгийн тухайн нөхцөл байдалд нийцтэйгээр тохируулах боломжийг судлаачид олгодог онцлогтой. Мөн эдийн засаг дах тодорхой бус байдлын нөлөө, судлаачийн хүлээлтийг тусгах замаар эдийн засгийн төрөл бүрийн хувилбарын шинжилгээ хийх, бодлогын шийдвэр гаргалтын нөлөөг тусгах давуу талтай.

#### **2. Эконометрик загварууд**

Богино хугацааны төсөөлөлд хугацаан цувааны ARIMA загвар болон вектор авторегрессив (VAR) загварыг ашиглаж байна. ARIMA загвар нь нэг хувьсагчийн хугацаан цувааны таамаглалын загвар бөгөөд тухайн хувьсагчийн өмнөх утгуудын автокорреляци болон санамсаргүй шокийн нөлөөг ялгаж, ирээдүйн утгыг таамаглах боломж олгодог. Хувьсагчийн түүхэн өгөгдөл сайн нөхцөлд богино хугацааны таамаглал боловсруулахад өргөн хэрэглэгддэг. VAR загвар нь олон хувьсагчийн хугацааны цувааны загвар бөгөөд хувьсагч бүрийг өөрийн өмнөх утгууд болон систем дэх бусад холбоотой хувьсагчдын өмнөх утгуудаар тайлбарлаж, эдийн засгийн бүтцийн хамаарлыг тусгах боломж олгодог давуу талтай. Тус загвар нь хувьсагчдын харилцан нөлөө болон динамик холбоог шинжлэхэд түгээмэл ашиглагддаг. Эдгээр загваруудыг инфляц, төсвийн орлого, хөдөлмөрийн зах зээл, эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд ашиглагдах үзүүлэлтүүд зэргийн төсөөллийг боловсруулахад өргөнөөр ашиглаж байна.

#### **3. Санхүүгийн програмчлал**

Эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт талын нийцэл, бодит, төсөв, мөнгө, гадаад секторуудын үзүүлэлтүүдийн уялдааг хангахад ОУВС-гийн санхүүгийн програмчлал (financial programming)-г ашиглаж байна.

#### **4. Салбар хоорондын тэнцэл**

Томоохон төсөл, бүтээн байгуулалтын эдийн засагт үзүүлэх нөлөөг салбар хоорондын тэнцэлд тулгуурлан тооцож, хагас бүтцийн загварт шок хэлбэрээр тусган тооцож байна. Салбар хоорондын тэнцлийн шинжилгээ нь Леонтьевийн орц гарцын

---

<sup>7</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.5.Макро эдийн засгийн төлөв байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцоход хэрэглэсэн аргачлал, тооцооны үндэслэл”

загварт тулгуурладаг. Эдийн засгийн салбаруудын уялдааг буцах болон урагшлах холбоо, үржүүлэгчийн шинжилгээгээр тодорхойлж, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын хөрөнгө оруулалт, экспортыг тодорхой хувиар нэмэгдүүлэхэд нийт эдийн засгийн өсөлт болон бусад салбаруудын өсөлтөд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлдог. Эдийн засаг дах нөлөөг тодорхойлсны дараагаар GAP загварт шокоор дамжуулан оруулж, дунд хугацааны эдийн засгийн дах нөлөөллийг тодорхойлдог.

#### 5. Аж ахуйн нэгжүүдийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө

Уул уурхайн салбарын экспорт, олборлолтын төсөөллийг боловсруулахдаа томоохон аж ахуйн нэгжүүдийн богино, дунд хугацааны бизнес төлөвлөгөө, түүнчлэн Засгийн газраас хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний нөлөөллийг харгалзан үздэг.

Экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээний төсөөллийг үндсэн экспортлогч аж ахуйн нэгжүүдийн бодит үйл ажиллагааны төлөвлөгөө, идэвхжилийн төлөвт тулгуурлан боловсруулж байна. Тухайлбал, нүүрсний экспортын 80 орчим хувийг 9, төмрийн хүдрийн 70 орчим хувийг 5, зэсийн баяжмал болон газрын тосны экспортыг тус бүр 2 аж ахуйн нэгж бүрдүүлж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүдээс бизнес төлөвлөгөөг жилд 2–5 удаа албан бичгээр авч, тогтмол уулзалт зохион байгуулан, төсөөлөлд тусгаж байна.

Мөн төсвийн секторын үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахдаа бодит үйлчилж буй хувь хэмжээ (effective tax rate), татварын мэдрэмжийн аргачлалууд, эконометрик шинжилгээ болон хугацаан цуваан эконометрик загваруудыг ашиглалаа.

## 2. ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСВИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТӨСӨӨЛӨЛ<sup>8</sup>

Төсвийн үзүүлэлтүүдийн 2024 оны гүйцэтгэл, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл, 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл болон 2027-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийн агуулгаар боловсруулсан болно.

### 2.1 Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2024 оны гүйцэтгэл, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл, 2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл.

Энэ дэд бүлэгт төсвийн үзүүлэлтүүдийн үзүүлэлтүүдийн нөхцөл байдлыг статистик тоон мэдээлэлд үндэслэн боловсруулсан.

#### 2.1.1 Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл

**2024 оны гүйцэтгэл:** Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2024 онд 29,670.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 27.4 хувиар өсөж, батлагдсан дүнгээс 798.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 102.8 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Эдийн засгийн идэвхжил сайжирсан, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ нэмэгдсэн нь ААНОАТ, НӨАТ-ын орлого өсөхөд голлон нөлөөллөө. Өмнөх онтой харьцуулахад ААНОАТ 2.5 их наяд төгрөгөөр буюу 65.3 хувиар, НӨАТ 1.1 их наяд төгрөгөөр буюу 22.8 хувиар, ХХОАТ 746 тэрбум төгрөгөөр буюу 39.6 хувиар, онцгой албан татвар 317 тэрбум төгрөгөөр буюу 40.2 хувиар тус тус өссөн байна.

Орлогын өсөлтөд уул уурхайн салбарын идэвхжил хадгалагдаж, нүүрсний экспортын биет хэмжээ 2024 онд 83.8 сая тоннд хүрч өмнөх оноос 20.3 хувиар, зэсийн баяжмалын биет хэмжээ 1 сая 695 мянган тоннд хүрч өмнөх оноос 11.2 хувиар өссөн нь тус салбараас төвлөрөх орлого өндөр хэвээр хадгалагдахад чухал нөлөө үзүүлсэн байна.

Хүснэгт 2.1 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2024 оны төлөвлөгөө, гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2024 бат.	2024 гүйц.	2024 гүйц. хувь
<b>Тэнцвэржүүлсэн орлого</b>	<b>28,872.5</b>	<b>29,670.8</b>	<b>102.8%</b>
Орлогын албан татвар	7,986.0	8,970.6	112.3%
Нийгмийн даатгалын орлого	5,064.8	4,731.8	93.4%
НӨАТ	6,220.2	5,866.8	94.3%
Онцгой албан татвар	968.0	1,107.4	114.4%
АМНАТ	3,630.2	3,536.8	97.4%
Бусад орлого	5,003.3	5,457.4	109.1%

Эх сурвалж: Сангийн яам

<sup>8</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.8.өмнөх 2 жилийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөвлөлт, дараагийн жилийн болон түүний дараах дараалсан хоёр жилийн төлөв байдлыг хамруулан тооцсон төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө болон түүний гүйцэтгэл, төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт, төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл, улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалтын талаарх нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүд”

**2025 оны урьдчилсан гүйцэтгэл:** Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 30,057.7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 386.8 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар өсөж, батлагдсан дүнгээс 152.2 тэрбум төгрөг буюу 0.5 хувиар дутуу гүйцэтгэлтэй гарлаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өмнөх оноос өссөн хэдий ч дэлхийн зах зээл дэх нүүрсний үнийн уналттай холбоотойгоор ААНОАТ, АМНАТ-ын орлого буурлаа. Өмнөх онтой харьцуулахад ААНОАТ 754.5 тэрбум төгрөгөөр буюу 11.8 хувиар, АМНАТ 309.4 тэрбум төгрөг буюу 6.6 хувиар тус тус буурснаар уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого 9,789.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 12.8 хувиар буурсан байна.

Түүнчлэн суудлын автомашины улсын дугаар олголтын шийдвэртэй холбоотойгоор импортын суудлын автомашины тоо хэмжээ өмнөх оноос 32.7 мянган ширхгээр буюу 26.6 хувиар буурснаар онцгой албан татварын орлого өмнөх оноос 152.3 тэрбум төгрөг буюу 13.8 хувиар буурсан бөгөөд батлагдсан дүнгээс 299.4 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

*Хүснэгт 2.2. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2025 оны төлөвлөгөө, урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)*

Үзүүлэлт	2025 бат.	2025 урьд. гүйц.	2025 гүйц. хувь
<b>Тэнцвэржүүлсэн орлого</b>	<b>30,209.9</b>	<b>30,057.7</b>	<b>99.5%</b>
Орлогын албан татвар	8,622.2	8,539.1	99.0%
Нийгмийн даатгалын орлого	6,001.4	5,624.1	93.7%
НӨАТ	6,646.8	6,224.4	93.6%
Онцгой албан татвар	1,254.5	955.1	76.1%
АМНАТ	2,270.6	2,350.0	103.5%
Бусад орлого	5,414.4	6,365.0	117.6%

*Эх сурвалж: Сангийн яам*

**2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:** Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсвийн нийт орлогын хэмжээг 35,253.8 тэрбум төгрөг, тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүнг 31,930.0 тэрбум төгрөг байхаар баталсан.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 оны эхний 3 сарын байдлаар 6,302.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 153.1 тэрбум төгрөг буюу 2.5 хувиар өссөн байна. Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс өсөхөд түүхий эдийн экспортын биет хэмжээ болон зэсийн үнийн өсөлт голлон нөлөөллөө.

Гэсэн хэдий ч гадаад орчинд үүсээд буй нөхцөл байдлаас үүдэн төсвийн орлого батлагдсан дүнгээс дутах эрсдэл үүсэж болзошгүй байна. Засгийн газраас экспортын үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн идэвхжихийг дэмжиж, төсвийн орлого төвлөрөлтийг сайжруулахад онцгойлон анхаарч ажиллаж байна.

### **2.1.2 Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт**

**2024 оны гүйцэтгэл:** Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 2024 онд 30,591.1 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 8,082.1 тэрбум төгрөг буюу 35.9 хувиар

өссөн байна. Нийт зарлагын өсөлтийн 5,085.3 тэрбум төгрөг буюу 22.6 нэгж хувийг урсгал зардал, 2,782.5 тэрбум төгрөг буюу 12.4 нэгж хувийг хөрөнгийн зардал бүрдүүлсэн байна.

Засгийн газраас иргэдийн бодит орлогыг хамгаалах бодлогын хүрээнд тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дунджаар 10 хувиар нэмэгдүүлсэн нь урсгал зардлын өсөлтөд голлон нөлөөлсөн байна. Улмаар төсвийн цалин, үр дүнд суурилсан урамшууллын зардал 5,368.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 2.3 дахин, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардал 7,141.2 тэрбум төгрөгт хүрч 28.8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 2.3. Төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт (тэрбум төгрөг)*

Үзүүлэлт	2024 гүйц.	2025 урьд. гүйц.	2026 Бат
<b>Төсвийн нийт зарлага</b>	<b>30,591.1</b>	<b>31,289.2</b>	<b>32,980.0</b>
<i>Өсөлтийн хувь</i>	35.9%	2.3%	5.4%
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	38.3%	34.8%	32.2%
Урсгал зардал	22,176.6	24,186.5	24,901.9
<i>Цалин хөлс</i>	5,368.4	6,223.1	6,990.6
<i>НД, НХ-ийн тэтгэвэр, тэтгэмж</i>	5,905.9	6,755.6	7,650.0
<i>Хүүхдийн мөнгө</i>	1,540.9	1,549.7	1,575.4
<i>Бусад урсгал зардал</i>	9,361.4	9,658.1	8,685.9
Хөрөнгийн зардал	7,970.8	7,090.4	8,568.5

*Эх сурвалж: Сангийн яам*

**2025 оны урьдчилсан гүйцэтгэл:** Нэгдсэн төсвийн нийт зарлагыг 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн төсвийн тодотголоор 31,573.9 тэрбум төгрөгөөр баталж, анх батлагдсан дүнгээс 1,858 тэрбум төгрөг буюу 5.6 хувиар бууруулсан.

Төсвийн нийт зарлага 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31,289.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 2.3 хувиар өссөн гүйцэтгэлтэй гарлаа. Нийт зардлын 77.3 хувийг урсгал зардал, 22.7 хувийг хөрөнгийн зардал бүрдүүлж байна. Урсгал зардлын 70.9 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардал, 9.5 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 6.4 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр 3.3 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас, бусад урсгал зардал 9.9 хувийг тус тус эзэлж байна.

Төсвийн нийт урсгал зардал 24,186.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өссөн байна. Засгийн газраас өрхийн бодит орлогыг дэмжих зорилгоор тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс инфляцын түвшинтэй уялдуулан дунджаар 6.0 хувиар нэмэгдүүлснээр төсвийн цалин, үр дүнд суурилсан урамшууллын зардал 6,223.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 15.9 хувиар, тэтгэвэр, тэтгэмжийн зардал 8,305.3 тэрбум төгрөгт хүрч 11.5 хувиар нэмэгдсэн нь нийт зардлын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

**2026 оны хүлээгдэж буй гүйцэтгэл:** Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд нэгдсэн төсвийн нийт зарлагыг 32,980.0 тэрбум төгрөг, урсгал зардлыг 24,901.9 тэрбум төгрөг байхаар баталсан.

Нийт зарлага 2026 оны эхний 3 сарын байдлаар 7,663.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.9 хувиар, урсгал зардал 6,565.9 тэрбум төгрөгт хүрч

11.3 хувиар тус тус өссөн байна. Нэгдсэн төсвийн нийт зарлагын гүйцэтгэл өмнөх оны мөн үед 19.0 хувьтай байсан бол 2026 оны эхний улиралд 23.2 хувь болж өссөн хэдий ч төлөвлөгөөтэй харьцуулахад 603.3 тэрбум төгрөгөөр буюу 7.3 хувиар бага зарцуулагдсан үзүүлэлттэй байна.

Засгийн газрын 2025 оны “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 241-р тогтоол, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 242-р тогтоолоор 2026 оны төсвийн жилээс эхлэн нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг шинэчилсэн, мөн тэтгэврийн доод хэмжээг 80 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тогтоосноор тэтгэвэр, тэтгэмж 2,368.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.1 хувиар өссөн байна.

Түүнчлэн Засгийн газрын 2025 оны “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224-р тогтоол батлагдаж, зарим салбарын албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 1,898.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 25.6 хувиар өссөн байна. Тус өсөлтөд эрүүл мэнд болон боловсролын салбарын цалингийн өсөлт голлох нөлөөг үзүүлж байгаа бөгөөд үйлдвэрчний эвлэлийн холбоотой тохиролцсон гурван талт хэлэлцээрийн дагуу эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалинг 8 сараас эхлэн сар бүр 9 хувиар нэмэгдүүлэхэд 2026 оны цалингийн санд 150.0 тэрбум нэмэлтээр шаардлагатай байна. Харин боловсролын салбарын албан хаагчдын үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 10 дугаар сарын 31 хүртэл 50 хувь, 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дахин 26 хувиар нэмэгдүүлэн, нэмэгдэл хөлс, одоогийн цалин, хөлсний бүтцийг хэвээр хадгалахад 2026 оны батлагдсан төсөв дээр 822.2 тэрбум төгрөгийн хэрэгцээ үүсээд байна.

### **2.1.3 Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ**

**2024 оны гүйцэтгэл:** Хөрөнгө оруулалтын чиглэлээр нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдолтой төслүүдийг 2024 онд нэн тэргүүнд санхүүжүүлэх, хэрэгжүүлж дуусах, санхүүжилтийг бүрэн олгох бодлого баримталсан. Улмаар нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 10,379.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 7,970.8 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэж, 76.8 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Үүнээс барилга байгууламж 5,355.3 тэрбум төгрөг, их засвар 314.7 тэрбум төгрөг, тоног төхөөрөмж 803.7 тэрбум төгрөг, бусад хөрөнгийн зардалд 1,486.6 тэрбум төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт (тодотгол) оруулснаар хөрөнгийн зардлыг 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд энэ нь Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, түгжрэлийг бууруулах, томоохон хөгжлийн бүтээн байгуулалтыг дэмжихэд чиглэсэн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд нийт 11,706.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 1320 төсөл, арга хэмжээнд 3,853.6 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж, нийт гүйцэтгэл 3,093.5 тэрбум төгрөг буюу 80.3 хувьтай гарсан байна. Хөрөнгө оруулалтын зардлын 39.7 хувь буюу 3,093.5 тэрбум төгрөг нь улсын төсвөөс, 37.1 хувь буюу 2,888.7 тэрбум төгрөгийг орон нутгийн төсвөөс, 23.2 хувь буюу 1,807.4 тэрбум төгрөг нь гадаад зээл, тусламжаас бүрдсэн байна.

**2025 оны урьдчилсан гүйцэтгэл:** Хөрөнгө оруулалтын чиглэлээр 2025 онд бүсчилсэн хөгжлийн бодлогыг эхлүүлж, авто зам, эрчим хүч, дэд бүтцийн салбарт шинээр хөрөнгө оруулалт хэрэгжүүлснээс гадна бүх салбарт тоног төхөөрөмж, их засвар, ТЭЗҮ, зураг төсвийн санхүүжилтийг тусгах зарчим баримталж, төсвийн хөрөнгө оруулалтын зардалд нийт 9,456.2 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнээс 7,090.4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож, 75.0 хувийн урьдчилсан гүйцэтгэлтэй гарсан байна. Тухайлбал, барилга байгууламж 5,184.3 тэрбум төгрөг 75.5 хувь, их засвар 382.2 тэрбум төгрөг 73.2 хувь, тоног төхөөрөмж 594.9 тэрбум төгрөг 78.8 хувийн тус тус урьдчилсан гүйцэтгэлтэй байна.

Эдийн засгийн ангиллаар авч үзвэл, нийт хөрөнгө оруулалтын зардлын 73.1 хувийг барилга байгууламж, 13.0 хувийг бусад хөрөнгө, 8.4 хувийг тоног төхөөрөмж, 5.4 хувийг их засварт зарцуулжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,033.9 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 613 төсөл, арга хэмжээг 3,022.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд уг санхүүжилтийн урьдчилсан гүйцэтгэл 70.7 хувьтай буюу 2,135.9 тэрбум төгрөгт хүрсэн байна.

**2026 оны батлагдсан төлөвлөгөө:** Төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд зам тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, гэрээ зарчмыг баримталж, нийт 11,142.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 738 төсөл, арга хэмжээнд 3,280.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталсан. Нийт батлагдсан санхүүжих дүнгийн 29.0 хувь буюу 952.4 тэрбум төгрөгийг зам тээврийн салбарт, 15.4 хувь буюу 506.8 тэрбум төгрөгийг боловсролын салбарт, 9.5 хувь буюу 312.6 тэрбум төгрөгийг эрчим хүчний салбарт, 6.8 хувь 223.7 тэрбум төгрөгийг эрүүл мэндийн салбарт, 6.6 хувь буюу 216.6 тэрбум төгрөгийг хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын чиглэлээр, үлдсэн хөрөнгийг бусад салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2026 оны эхний улирлын байдлаар 463.4 тэрбум төгрөг буюу 14.1 хувьтай байна.

*Хүснэгт 2.4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2026 оны төлөвлөгөө, тэрбум төгрөг*

Ангилал	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
<b>Улсын төсөв</b>	<b>738</b>	<b>11,142.8</b>	<b>3,280.2</b>
Шилжих	442	7,608.8	1,966.9
Шинэ	296	3,534.0	1,313.3
<b>Нийт</b>	<b>738</b>	<b>11,142.8</b>	<b>3,280.2</b>

*Эх сурвалж: Сангийн яам*

#### **2.1.4 Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэл**

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2024 онд 920.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.1 хувь, 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,231.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.4 хувьтай тэнцэх хэмжээний тус тус алдагдалтай гарсан нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9-д заасан зорилтот түвшний үзүүлэлтийг хангасан байна.

Хүснэгт 2.5. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл, түүний гүйцэтгэл (ДНБ-нд эзлэх хувь)

Үзүүлэлт	2024	2025	2026
	гүйц.	урьд. гүйц.	бат.
Хуулийн хязгаар	-2.8	-2.0	-2.0
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.1	-1.4	-1.0

Эх сурвалж: Сангийн яам


Төсвийн тэнцэл нь эдийн засгийг тогтворжуулахад ашигладаг бодлогын тохируулга хийдэг чухал үзүүлэлт юм. Тухайн үеийн эдийн засгийн идэвхжилд үндэслэн төсвийн тэнцлийг алдагдалтай эсвэл ашигтай хэрэгжүүлэхээр зохицуулалт хийдэг. Эдийн засгийн идэвхжил сул байгаа үед төсвийг алдагдалтай баталж, зарцуулалтаар дамжуулан нийт эрэлтийг нэмэгдүүлж, эдийн засгаа дэмждэг. Эсрэгээрээ эдийн засгийн идэвхжил сайн байх үед төсвийг ашигтай баталж, нийт эдийн засагт хэт өндөр идэвхжил бий болох, инфляцын өсөлтөөс сэргийлж, макро эдийн засгийг тогтворжуулдаг.

### 2.1.5 Улсын өрийн нийт үлдэгдэл, авч ашиглах зээл, өрийн бичиг гаргалт

**Улсын нийт гадаад өр:** Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 40.5 тэрбум ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 3.3 тэрбум ам.доллараар өслөө.

Нийт гадаад өрийг бүтцээр авч үзвэл шууд хөрөнгө оруулалт 18.1 тэрбум ам.доллар, Засгийн газрын гадаад өр 8.7 тэрбум ам.доллар, Төв банкны өр 1.1 тэрбум ам.доллар, арилжааны банкнуудын өр 4.0 тэрбум ам.доллар, бусад салбарын өр 8.5 тэрбум ам.доллар байна.

Зураг 2.1. Улсын нийт гадаад өрийн статистик, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Сангийн яам

**Засгийн газрын өр:** Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр нэрлэсэн дүнгээр 35.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 их наяд төгрөгөөр өссөн байна. Засгийн газрын нийт өрийн 25.3 хувийг гадаад үнэт цаас, 65.2 хувийг гадаад зээл, 1.9 хувийг дотоод үнэт цаас үлдсэн 7.6 хувийн бусад өр төлбөр бүрдүүлж байна.

Хүснэгт 2.6. Засгийн газрын өрийн үлдэгдэл, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Өрийн хэрэгсэл	2024	2025*
<b>I. Засгийн газрын дотоод өр</b>	<b>400.5</b>	<b>688.5</b>
1.1 Үнэт цаас	400.5	688.5
<b>II. Засгийн газрын гадаад өр</b>	<b>30,296.6</b>	<b>32,052.8</b>
2.1 Үнэт цаас	8,655.0	8,817.5
2.2 Зээл	21,641.6	23,088.1
<b>III. Засгийн газрын бусад өр</b>	<b>2,736.4</b>	<b>2,678.8</b>
3.1 Засгийн газрын өрийн баталгаа	178.0	164.7
3.2 Орон нутгийн зээллэг	2,558.4	2,514.1
3.3 Концесс	-	-
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I, II, III)</b>	<b>33,433.5</b>	<b>35,420.1</b>

Эх сурвалж: Сангийн яам

**Засгийн газрын гадаад зээл:** Гадаад зээлийн үлдэгдэл нэрлэсэн дүнгээр 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 23.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар өссөн байна. 2025 онд төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх зорилгоор 1,544.0 тэрбум төгрөгийг гадаад зээлийн ашигласан бол эргэн төлөлтийн хүрээнд үндсэн төлбөрт 1,411.9 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 548.0 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

2026 онд гадаад зээл, тусламжийн ашиглалтыг 1,600.3 тэрбум төгрөг байхаар баталсан бөгөөд 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар гадаад зээлийн ашиглалт 20 хувь, буцалтгүй тусламжийн ашиглалт 1.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд Газрын тос боловсруулах үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц зэрэг томоохон төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, зээлийн ашиглалтыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор холбогдох анхдагч хуулийн төслийг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Уг хуулийн төсөл батлагдсанаар 2027–2029 онд нийт 5.2 их наяд төгрөгийн санхүүжилтийг ашиглах боломж бүрдэж, төслүүдийн санхүүжилтийг холбогдох гэрээ, хэлэлцээрт заасан хугацаанд бүрэн, үр ашигтай зарцуулах нөхцөл бүрдэхээр байна.

**Засгийн газрын үнэт цаас:** Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны нэрлэсэн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 8,817.5 тэрбум төгрөгт хүрлээ.

Хүснэгт 2.7 Гадаад үнэт цаас, 2025 оны урьдчилсан гүйцэтгэл (тэрбум төгрөг)

№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл сая \$	Үлдэгдэл тэрбум.₮
1	Номад	5.125%	5.5 жил	174.3	619.9
2	Сенчири-1 2027	3.500%	6 жил	413.1	1,469.4
3	Сенчири-2	8.650%	5 жил	541.7	1,926.6
4	Сенчири-3	7.875%	5.5 жил	350.0	1,244.8
5	Сенчири-4	6.625%	5 жил	500.0	1,778.3
6	Сенчири-1 2031	4.450%	10 жил	500.0	1,778.3
<b>НИЙТ</b>				<b>2,479.1</b>	<b>8,817.5</b>

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт шинээр гадаад үнэт цаас гаргасан тохиолдолд зөвхөн дахин санхүүжилт буюу өрийн зохицуулалтын хүрээнд гаргах бөгөөд төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх, төсвийн алдагдал санхүүжүүлэх зорилгоор гадаад үнэт цаас гаргахгүй байхаар заасан.


Засгийн газар 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдөр өрийн зохицуулалт хийх зорилгоор 500 сая ам.долларын “Сенчири-4” бондыг олон улсын зах зээл дээр амжилттай арилжаалсан. Уг бондоор 2026 онд төлөгдөх нөхцөлтэй “Номад” бондын 391.7 сая ам.доллар, 2028 онд төлөгдөх нөхцөлтэй “Сенчири-2” бондын 108.3 сая ам.долларын төлбөрийг тус тус төлсөн.

Мөн 2026 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Засгийн газар 500 сая ам.долларын хэмжээтэй, 5.95 хувийн хүүтэй, 6 жилийн хугацаатай “Сенчири-5” бондыг олон улсын санхүүгийн зах зээлд амжилттай арилжаалсан. Уг бондын хүрээнд 2026 онд төлөгдөх 5.125 хувийн хүүтэй “Номад” бондын 174.3 сая ам.доллар, 2028 онд төлөгдөх 8.65 хувийн хүүтэй “Сенчири-2” бондын 321.6 сая ам.долларын төлбөрийг тус тус дахин санхүүжүүлэх өрийн зохицуулалт хийсэн.

Ингэснээр 2028 онд төлөгдөх өндөр хүүтэй гадаад бондын 14.5 сая ам.доллар буюу 51.7 тэрбум төгрөгийн хүүгийн зардлыг хэмнэж, төсөв, төлбөрийн тэнцэлд ирэх гадаад төлбөрийн дарамтыг багасгасан.

Гадаад зах зээл дэх Монгол Улсын Засгийн газрын бондуудын өгөөж 2025 оны байдлаар дунджаар 6.6 хувьтай байна.

Зураг 2.2. Гадаад үнэт цаасны олон улсын зах зээл дээрх өгөөж



Эх сурвалж: Блуумберг терминал

2025 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр АНУ-аас “харилцан импортын тариф” тогтоож, АНУ-БНХАУ-ын худалдааны хурцадмал байдал нэмэгдсэнээр дэлхийн санхүүгийн зах зээлд тодорхойгүй байдал эрчимжсэн. Үүний үр дүнд хөрөнгө оруулагчдын эрсдэлийн хандлага өөрчлөгдөж, бондын үнэ буурч, өгөөж өсөх дарамт нэмэгдсэн байна.

Сүүлийн үед Ойрх Дорнодын бүс нутагт геополитикийн нөхцөл байдал дахин хурцадсантай холбоотойгоор дэлхийн зах зээл дэх тодорхойгүй байдал нэмэгдэж, хөрөнгө оруулагчдын эрсдэлийн хандлага өөрчлөгдөж байна. Үүний үр дүнд Засгийн газрын бондуудын үнэ буурч, өгөөж өсөх болон дарамт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Тухайлбал, 2026 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөс хойш Монгол Улсын Засгийн газрын бондын өгөөж 1.1 нэгж хувиар өссөн байна. Бондын өгөөж өндөр түвшинд хадгалагдах нь 2027 онд хийгдэх өрийн дахин санхүүжилтийн зардлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

**Засгийн газрын дотоод үнэт цаас:** Монгол улсын засгийн газар 2023-2025 оны стратегийн баримт бичгийн зорилт 4-т “Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна” гэж туссаны дагуу Сангийн сайдын 2025 оны 51 дүгээр тушаалыг баталж 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлээд байна.

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн байдлаар байдлаар 688.5 тэрбум төгрөгт хүрээд байна. Сайн хувьцаа хөтөлбөрийг 2016 онд санхүүжүүлэх зорилгоор 97.1 тэрбум төгрөгийн үнэт цаасыг, 2025 онд зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 133.5 тэрбум төгрөгийн үнэт цаасыг тус тус арилжаалсан байна.

Мөн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 2025 оны 4 дүгээр сарын 16-ны өдрөөс 12 дугаар сарын 24-ний өдрийн хооронд нийт 148.7 тэрбум төгрөгийн үнэт цаасыг хоёр долоо хоног тутам арилжаалсан байна.

Эдгээр бондуудын хувьд 1 жил хүртэлх богино хугацаатай үнэт цаасны хүү дунджаар 9.3 хувь, 2-5 жилийн хугацаатай дунд хугацааны үнэт цаасны хүү дунджаар 11.2 хувь байгаа нь бодлогын хүүгээс 0.8-2.7 хувиар доогуур арилжаалагдаж байгаа бол урт хугацаат үнэт цаас 13.3 хувийн өгөөжтэй байна.

Засгийн газар дотоод үнэт цаасны нээлттэй арилжааг эхлүүлснээр дотоодын зах зээлд төгрөгийн эрсдэлгүй өгөөжийн муруйг тогтоон, аж ахуйн нэгжүүдийн дотоодын зах зээлээс төвлөрүүлэх эх үүсвэрийн үнэлгээ бодитоор буюу харьцангуй бага хэмжээнд хүү тогтох, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын бааз суурийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна.

Мөн, нээлттэй арилжаалсан үнэт цаасны 36.2 хувийг богино хугацаат үнэт цаас, 63.8 хувийг дунд хугацаат болон урт хугацаат үнэт цаас эзэлж байна.

Засгийн газрын дотоод үнэт цаасыг эзэмшигчээр ангилбал 78.6 хувийг арилжааны банк, 21.4 хувийг даатгалын байгууллага, үлдсэн 0.08 хувийг гадаад, дотоодын иргэд болон ААН-үүд эзэлж байна.

**Орон нутгийн нийт өр төлбөр:** Орон нутгийн зээллэгийн үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар буурлаа.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 оны 4 дүгээр улиралд нийт 798.0 тэрбум төгрөгийн дотоод үнэт цаасыг “Бөөрөлжүүтийн ДЦС-ыг барих төсөл”,

“Батарей хуримтлуурын төсөл” болон Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлийн ажил төслүүдийг санхүүжүүлэх зорилгоор гаргасан.

Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичгийн зорилт 3-т заасан Тухайн аймаг, нийслэлийн гаргасан үнэт цаасны нэрлэсэн үлдэгдэл нь тухайн жилийн төсвийн орлогын харьцааны үзүүлэлтээс 2026 онд 70 хувиас хэтрэхгүй гэж заасан ба нийслэлийн бондын үлдэгдэл 2025 оны жилийн эцсийн үлдэгдэл 2.5 их наяд төгрөг буюу 2026 оны батлагдсан нийслэлийн төсвийн 44.6 хувийг эзэлж байна.

#### **2.1.6 Засгийн газрын болзошгүй өр төлбөр**

***Засгийн газрын болзошгүй өр төлбөр:*** “Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна. Одоогийн байдлаар Монгол Улсын Хөгжлийн банк болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Засгийн газрын өрийн баталгаа гаргаад байна.

***Монгол Улсын Хөгжлийн банканд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа 2031 онд бүрэн төлөгдөх хуваарьтай байна.*** Улсын Их Хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын Хөгжлийн банкнаас 420.0 сая юаньтай тэнцэх хэмжээний 10 жилийн хугацаатай зээлийг Засгийн газрын өрийн баталгаатайгаар Хятадын хөгжлийн банкнаас авч ашигласан. Энэхүү зээлийг 2019 онд авч ашиглаж эхэлсэн боловч 2023 оны жилийн эцсийн байдлаарх Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүгийн харьцаа үзүүлэлтүүдээс шалтгаалж Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах шаардлагатай болсон тул 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр гаргуулсан болно. Уг зээлийн хугацаа 2031 онд дуусах бөгөөд Монгол Улсын Хөгжлийн банкнаас хуваарьт үндсэн болон хүүгийн төлбөрийг тухай бүр бүрэн төлж барагдуулж байгаа бөгөөд 2025 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр үлдэгдэл төлбөр 164.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

**2.1.7 Төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөөг гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан байдал<sup>9</sup>**

**2024 оны гүйцэтгэл:** Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2024 онд 30,639.5 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 817.1 тэрбум төгрөгөөр давж, 102.7 хувийн гүйцэтгэлтэй, тэнцвэржүүлсэн орлого 798.3 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч 102.8 хувийн гүйцэтгэлтэй гарлаа. Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 30,487.9 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 100.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2024 онд 1,615.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 2.0 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байхаар баталсан бөгөөд жилийн эцсийн гүйцэтгэлээр төсвийн алдагдал батлагдсан дүнгээс 695.2 тэрбум төгрөгөөр буурч, ДНБ-ий 1.2 хувьтай тэнцэх гүйцэтгэлтэй гарсан байна.

**2025 оны урьдчилсан гүйцэтгэл:** Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2025 онд 32,540.2 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд урьдчилсан гүйцэтгэлээр 105.7 тэрбум төгрөгөөр давуу төвлөрч, 100.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Харин тэнцвэржүүлсэн орлого 152.2 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрч, 99.5 хувийн урьдчилсан гүйцэтгэлтэй гарлаа. Төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн батлагдсан дүнгээс 284.7 тэрбум төгрөгөөр бага заруулагдаж, 99.1 хувийн урьдчилсан гүйцэтгэлтэй байна. Үүнээс урсгал зардал батлагдсан дүнгээс 222.4 тэрбум төгрөгөөр илүү зарцуулагдсан бол хөрөнгө оруулалтын зардал 791.2 тэрбум төгрөг буюу 10 хувиар гүйцэтгэл дутуу гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 онд 1,364.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 1.5 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байхаар батлагдсан бөгөөд жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн алдагдал 132.5 тэрбум төгрөгөөр буурч, ДНБ-ий 1.4 хувьтай тэнцсэн байна.

*Хүснэгт 2.8 Төсвийн нэгдсэн үзүүлэлтүүд, түүний гүйцэтгэл (тэрбум төгрөг)*

Үзүүлэлт	2024	2024	Гүйц %	2025	2025	Гүйц %
	Бат	гүйц		Бат	урь.гүйц	
Төсвийн нийт орлого	30,639.5	31,456.6	102.7%	32,540.2	32,645.9	100.3%
<b>Тэнцвэржүүлсэн орлого</b>	<b>28,872.5</b>	<b>29,670.8</b>	<b>102.8%</b>	<b>30,209.9</b>	<b>30,057.7</b>	<b>99.5%</b>
<b>Төсвийн нийт зарлага</b>	<b>30,487.9</b>	<b>30,591.1</b>	<b>100.3%</b>	<b>31,573.9</b>	<b>31,289.2</b>	<b>99.1%</b>
Урсгал зарлага	22,470.8	22,176.6	98.7%	23,964.1	24,186.5	100.9%
Хөрөнгийн зардал	8,066.2	7,970.8	98.8%	7,881.6	7,090.4	90.0%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-49.1	443.7		-271.8	12.3	
<b>Тэнцвэржүүлсэн тэнцэл</b>	<b>-1,615.4</b>	<b>-920.2</b>	<b>57.0%</b>	<b>-1,364.0</b>	<b>-1,231.5</b>	<b>90.3%</b>
<i>ДНБ-д эзлэх хувь</i>	<i>-2.0</i>	<i>-1.2</i>		<i>-1.5</i>	<i>-1.4</i>	

*Эх сурвалж: Сангийн яам*

<sup>9</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.6.төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөөг гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан байдал”

## 2.2 Нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн 2027-2029 оны төсөөлөл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.3.8 дахь заалтын дагуу төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө, түүний гүйцэтгэл, төсвийн нийт зарлагын хэмжээ, түүний өсөлт болон төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт, түүний гүйцэтгэлийн талаарх нэгдсэн төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсрууллаа.

### 2.2.1 Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын 2027-2029 оны төсөөлөл

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагын<sup>10</sup> дагуу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2027 онд 34,780.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо.

Хүснэгт 2.9. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2027 төсөөлөл	2028 төсөөлөл	2029 Төсөөлөл
Тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ	34,780.0	37,371.8	39,737.5
ДНБ-д эзлэх хувь	30.4	29.4	28.1

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого:** Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын орлогын төсөөллийг ОУВС-гийн бодит үйлчилж буй хувь хэмжээ (effective tax rate)-ний аргачлал болон бусад эконометрик тооцооллууд, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, биет хэмжээ, голлох компаниудын төлөвлөгөөнд үндэслэн тооцлоо. ААНОАТ-ын орлогын ойролцоогоор 50 хувийг уул уурхайн салбарын томоохон компаниуд бүрдүүлдэг тул тус орлого нь уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспортын хэмжээ, дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, компанийн ашигт ажиллагаанаас ихээхэн хамааралтай байдаг. Сүүлийн 10 жилд ААНОАТ-ын орлого дунджаар 28.7 хувь, харин сүүлийн 5 жилд дунджаар 35.9 хувиар өссөн байна.

Дунд хугацаанд ААНОАТ-ын орлогын өсөлтийг ойролцоогоор 10 хувьд хадгалагдана гэж төсөөлж байна. Ирэх онд төмөр замын суурь дэд бүтцийг сайжруулж, хил холболтын ажлыг дуусгаснаар түүхий эдийн экспортын биет хэмжээ нэмэгдэхээр байна. Түүнчлэн нүүрсний баяжуулах үйлдвэрийн нөлөөгөөр нийт нүүрсний экспортод эзлэх баяжуулсан коксжих нүүрсний хувь хэмжээ өсөх хүлээлттэй байна. Мөн Оюу Толгойн экспортолж буй зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдсэнээр аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогод эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Гэсэн хэдий ч дэлхийн зах зээл дэх нүүрсний үнийн хэлбэлзэл, гадаад худалдааны орчны тодорхойгүй байдал нь татварын орлогын өсөлтөд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй хэвээр байна.

**Хувь хүний орлогын албан татварын орлого:** Хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) нь иргэдийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй

<sup>10</sup> 6 дугаар зүйл. Төсвийн тусгай шаардлага: 6.1.1. Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх;

адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын хэмжээнд суурилан тооцогддог. Иймээс ХХОАТ-ын орлого нь хөдөлмөр эрхлэлтийн түвшин, цалин хөлсний хэмжээ, эдийн засгийн идэвхжил зэрэг хүчин зүйлээс хамаардаг. Сүүлийн 10 жилд ХХОАТ-ын орлого дунджаар 20.4 хувь, сүүлийн 5 жилд дунджаар 28.8 хувиар өссөн байна.

Дунд хугацаанд ХХОАТ-ын орлого дунджаар 12.8 хувиар өсөхөөр төсөөлж байна. Ирэх жилүүдэд ажиллах хүчний оролцооны түвшин тогтвортой нэмэгдэж, нэрлэсэн дундаж цалин дунджаар 11 орчим хувиар өсөх хүлээлттэй байна. Түүнчлэн Засгийн газрын 224-р тогтоолын хүрээнд багш, эмч нарын үндсэн цалингийн хэмжээг 30-50 хувиар, төрийн албан хаагчдын цалинг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх бодлого нь ХХОАТ-ыг орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

**Нийгмийн даатгалын орлого:** Нийгмийн даатгалын орлого нь төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрүүдийн нэг бөгөөд ХХОАТ-ын адил хөдөлмөр эрхлэлтийн тоо, тэдгээрийн орлогын хэмжээ, тэтгэврийн баталгааны эрэлт зэргээс шууд хамаардаг. Сүүлийн 10 жилд нийгмийн даатгалын орлого дунджаар 20.0 хувь, сүүлийн 5 жилд дунджаар 29.1 хувиар өссөн байна.

Дунд хугацаанд нийгмийн даатгалын орлого дунджаар 10.1 хувиар өсөхөөр төсөөллөө. Ирэх онуудад нийгмийн даатгалын хамралт нэмэгдэж, шимтгэл төлөгч ажил олгогчийн тоо ойролцоогоор 5.0 хувиар, албан журмын даатгуулагчдын тоо 2.5 хувиар өсөх төсөөлөлтэй байна.

**Нэмэгдсэн өртгийн албан татварын орлого:** Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нь эдийн засгийн дотоод идэвхжил, иргэдийн худалдан авах чадварын ерөнхий байдлыг илэрхийлдэг иргэдийн орлого, хэрэглээний түвшнээс шууд хамааралтай төсвийн орлогын чухал эх үүсвэрүүдийн нэг юм. НӨАТ-ын орлого сүүлийн 10 жилд дунджаар 20.6 хувь, 5 жилд дунджаар 23.5 хувиар өссөн байна.

Дунд хугацаанд НӨАТ-ын төсөвт төвлөрүүлэх орлого дунджаар 8.2 хувиар өсөхөөр төсөөллөө. Импортын НӨАТ нийт орлогод сүүлийн 10 жилд дунджаар 66 хувийг бүрдүүлсэн байна. Ирэх жилүүдэд гадаад зээлийн ашиглалтыг нэмэгдүүлснээр төсөл, хөтөлбөрүүдийн бүтээн байгуулалт эрчимжиж, тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өсөх хүлээлттэй байна. Мөн бараа, бүтээгдэхүүний бүртгэлийг автоматжуулж, боомтуудын хүчин чадлыг өргөжүүлснээр нэг боомт дээр төвлөрөх ачаалал буурч, импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр байгаа нь НӨАТ-ын орлогод эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Дотоодын НӨАТ-ын орлогын 30.6 хувийг худалдаа, үйлчилгээний салбар, 12.1 хувийг боловсруулах үйлдвэр, 11.1 хувийн уул уурхайн олборлолт, 9.8 хувийг барилгын салбараас төвлөрөх татварын орлого бүрдүүлж байна. Дунд хугацаанд аялал жуулчлалын салбарын сэргэлт, ялангуяа гадаадын жуулчдын урсгал нэмэгдэж, олон улсын томоохон арга хэмжээ зохион байгуулагдахтай холбоотойгоор худалдаа, үйлчилгээний салбарын орлого өсөхөөр хүлээгдэж байна. Мөн олон улсын зах зээл дэх үнийн өсөлтөөс шалтгаалан инфляц нэмэгдэж, бараа, үйлчилгээний үнэ өсгөнөөр НӨАТ-ын орлогод эерэг нөлөөтэй байна.

**Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр:** Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) нь уул уурхайн компаниудын ашиг, зардлаас үл хамааран олборлолт болон экспортын биет хэмжээ, түүхий эдийн үнэ,

борлуулалтын орлогод суурилан тооцогддог төсвийн орлогын чухал эх үүсвэрүүдийн нэг. АМНАТ-ын орлого сүүлийн 10 жилд дунджаар 31.2 хувь, сүүлийн 5 жилд дунджаар 32.3 хувиар өссөн байна.

Дунд хугацаанд АМНАТ-аас төсөвт төвлөрөх орлого дунджаар 2.6 хувиар өсөхөөр төсөөллөө. АМНАТ-ийн орлогын төсөөллийг боловсруулахдаа уул уурхайн томоохон компаниудын экспортын төлөвлөгөө, олборлолтын биет хэмжээ болон олон улсын судалгааны байгууллагуудаас таамаглаж буй дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн чиг хандлагад үндэслэн төсөөллөө. Зэсийн баяжмал дах цэвэр зэсийн агууламж нэмэгдэхтэй холбоотойгоор зэсийн АМНАТ-аас төсөвт төвлөрөх орлого нэмэгдэх хүлээлттэй байна. Харин нүүрсний хувьд дэлхийн зах зээлийн үнэ буурах хандлагатай байгаа нь орлогын өсөлтийг сааруулахаар байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.1.а дугаар заалтад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувийг Ирээдүйн өв санд төвлөрүүлнэ гэж заасан. Энэ хүрээнд 2027-2029 онд Ирээдүйн өв сангийн орлого хуульд заасны дагуу 65 хувиар төвлөрнө гэж тооцлоо.

## 2.2.2 Төсвийн нийт зарлагын 2027-2029 оны төсөөлөл

Нэгдсэн төсвийн нийт зарлага 2027 онд 36,493.4 тэрбум төгрөг болж, 2026 оны батлагдсан дүнгээс 10.7 хувиар буюу 3,513.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцооллоо. Дунд хугацаанд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан бодлогын хүрээнд эдийн засаг дахь төрийн оролцоо, төсвийн зардлын тэлэлтийг хязгаарлах, урсгал зардлын өсөлтөд зайлшгүй шаардлагатай нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлсийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, үр ашиггүй төсвийн зардлыг бууруулж, төсвийн сахилга батыг сахих бодлогыг баримтлан төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хэмжээг үе шаттай бууруулж 2027 онд 31.9 хувь, 2028 онд 30.4 хувь, 2029 онд 28.6 хувьд хүрэхээр тооцсон болно.

Хүснэгт 2.10 Нэгдсэн төсвийн нийт зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2027 төсөөлөл	2028 төсөөлөл	2029 төсөөлөл
Нийт зарлагын дээд хэмжээ	36,493.4	38,644.0	40,444.7
ДНБ-д эзлэх хувь	31.9	30.4	28.6

Төсвийн зардлыг ийнхүү үе шаттайгаар хязгаарлаж, ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулснаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад эерэг нөлөөтэй. Тухайлбал, эдийн засаг дахь төрийн оролцоо хумигдах, хувийн хэвшилд хөрөнгө оруулалт, бизнесээ өргөжүүлэх санхүүгийн болон зах зээлийн нөөц боломжийг олгох, төсвийн үр ашиггүй зардлыг танаж, сахилга бат, тогтвортой байдлыг сайжруулах, нийгмийн хамгааллын зардлыг зорилтот бүлэгт чиглүүлэн, давхардлыг арилгах, инфляцын дарамтыг бууруулах зэрэг эерэг нөлөөтэй. Цаашилбал төсвийн зардлын тэлэлтийг хязгаарлаж, сахилга батыг чангатгаснаар гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзэл зэрэг эрсдэлийг даван туулах санхүүгийн нөөц, хуримтлалыг бүрдүүлэх суурь тавигдах юм (Шигтгээ 2.1).

## 2.2.3 Нэгдсэн төсвийн суурь зарлагын 2027-2029 оны төсөөлөл

Нэгдсэн төсвийн суурь зарлага 2027 онд 32,495.4 тэрбум төгрөг болж, 2026 оны батлагдсан дүнгээс 8.8 хувиар буюу 2,636.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр тооцооллоо.

Хүснэгт 2.11 Нэгдсэн төсвийн суурь зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2027 Төсөөлөл	2028 төсөөлөл	2029 төсөөлөл
Суурь зарлагын дээд хэмжээ	32,495.4	34,827.4	36,908.5
ДНБ-д эзлэх хувь	28.4	27.4	26.1

**Урсгал зардал:** Төсвийн урсгал зарлагын хэмжээ 2027 онд ДНБ-ий 25.3<sup>11</sup> хувьтай тэнцэхээр төсөөллөө. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд төсвийн урсгал зардлын хэмжээг үе шаттай бууруулж 2030 онд 22.0 хувьд

<sup>11</sup> ОУВС-аас гаргасан судалгааны тайланд хөгжиж буй орнуудад төсвийн алдагдал, өрийн дарамтыг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор төсвийн урсгал зардлын хэмжээг ДНБ-ий 20-25 орчим хувьтай тэнцүү байхаар төсөвлөхийг зөвлөдөг. Эх сурвалж: IMF - Public Expenditure and Inclusive Growth - A Survey (2021.10 сар)

хүргэх зорилт тавьсан. Үүний дагуу дунд хугацаанд төсвийн хүрээний мэдэгдэлд урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулахаар төсөөллөө.

Хүснэгт 2.12 Нэгдсэн төсвийн урсгал зарлагын төсөөлөл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2027 төсөөлөл	2028 төсөөлөл	2029 төсөөлөл
Урсгал зарлага	28,843.0	30,532.9	32,072.8
ДНБ-д эзлэх хувь	25.3	24.0	23.0

**Цалин, тэтгэвэр, тэтгэмж:** “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилт, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд иргэдийн бодит орлогыг хамгаалах, шинээр батлагдсан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг хуваарилах бодлого баримталлаа. Тухайлбал, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, халамжийн тэтгэвэр, төрийн албан хаагчийн цалин хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, хүүхдийн мөнгөн тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр зэрэг өсөн нэмэгдэх зардлуудыг үргэлжлүүлэн олгохоор тооцоолов.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн зардлын төсөөлөлд иргэдийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд багш, эмч нарын цалингийн нэмэгдлээс гадна бусад төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх зардал, төрийн албан хаагчид, тэтгэвэр авагчдын дундаж өсөлт, Ерөнхийлөгчийн сонгуулийн зардлыг тус тус тусган тооцоолсон болно. Халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн нийгмийн баталгааг дээшлүүлэхэд чиглүүлж, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг зохистой түвшинд олгох ба бусад төрийн үр ашиггүй зардлуудыг бууруулах бодлого баримталсан болно.

**Хөрөнгийн зардал:** Дунд хугацаанд Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд туссан зорилт, тэдгээрийн хүрэх үр дүнгийн зорилтот түвшний үзүүлэлтийг хангах хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө дараах үндсэн зарчмуудыг баримтална. Үүнд:

**Нэг.** Хөрөнгө оруулалтын эх үүсвэр хооронд уян хатан тохируулга хийх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, нэн шаардлагатай, стратегийн ач холбогдолтой төслүүдийг цаг хугацаанд нь санхүүжүүлж, үр ашгийг нь нэмэгдүүлэх чиглэл баримтална.

**Хоёр.** Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон хөрөнгө оруулалт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөрөнгө оруулалтын удирдлага, бодлогыг хэрэгжүүлэх чиглэл баримтална.

**Гурав.** Их өгөгдөл, хиймэл оюунд суурилсан төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулж, иргэдийн оролцоонд суурилсан ил тод, цахим, үр ашигтай, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх чиглэл баримтална.


**Шигтгээ 2.1. Хөгжиж буй улс орнуудын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ, түүний харьцуулалт**

Төсвийн тогтвортой байдлыг ОУВС-аас Засгийн газар одоогийн бодлогын хүрээнд, ирээдүйд төлөх өр төлбөр, хүүгийн төлбөрөө орлого, зарлагынхаа харьцааг алдагдалгүйгээр санхүүжүүлэх чадвартай байх явдал гэж үздэг.


Монгол Улсын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2010-2025 онд ойролцоо эдийн засагтай, хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад өндөр хэлбэлзэлтэй байв. Тухайлбал, төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2010 онд 32.0 хувь байсан бол 2025 онд 36.3 хувь болж өсжээ. Харин нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь 2016 онд 39.7 хувь болж, сүүлийн 15 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн бол 2018 онд хамгийн бага түвшинд буюу ДНБ-ий 28.4 хувьд хүрсэн хэдий ч сүүлийн жилүүдэд эргэн нэмэгдэж, 2024 онд огцом өсөж 37.5 хувьд хүрчээ. Нийт төсвийн зардал ДНБ-ий харьцааны хэлбэлзэлд сонгуулийн жилүүдийн улс төрийн амлалттай холбоотой, цалин, халамж, тэтгэврийн нэмэгдлүүд зэрэг урсгал зардал огцом өссөн дүр зураг харагдаж байна.

Төсвийн үзүүлэлтүүдийн хэлбэлзэл их байгаа нь гадаад шокийн төсөвт үзүүлэх нөлөө өндөр, голлох түүхий эдийн үнийн савлагаа их байгааг харуулж байна. Иймд макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд төсвийн сахилга батыг сайжруулах, эдийн засаг дах төрийн оролцоог үе шаттайгаар бууруулах шаардлагатай байна.

**Зураг 2.3 Улс орнуудын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ**



**Зураг 2.4 Улс орнуудын төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь, хэмжээ**



Эх сурвалж: ОУВС, World Economic Outlook Database, 2026.04 сар

## 2.2.4 Засгийн газрын нийт өрийн 2027-2029 оны төсөөлөл

Засгийн газрын нийт өрийн нэрлэсэн үлдэгдлээр 2027 онд ДНБ-ий 50 хувь буюу 57,114.9 тэрбум төгрөг болж, 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэлд батлагдсан дүнгээс 5,914.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхээр төсөөлсөн. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх хуулийн төсөлтэй уялдуулан Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хэмжээг 2027-2028 онд 50.0 хувь, 2029 онд 45.0 хувь байхаар тооцооллоо.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2027-2029 онуудад хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.

*Хүснэгт 2.13 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (тэрбум төгрөг)*

Үзүүлэлт	2027 төсөөлөл	2028 төсөөлөл	2029 төсөөлөл
Хуулийн хязгаар	60.0%	60.0%	60.0%
Засгийн газрын нийт өр	57,114.9	63,610.1	63,651.0
ДНБ-д эзлэх хувь (төсөөлөл)	50.0%	50.0%	45.0%

Дунд хугацаанд гадаад өрийн дарамтыг үе шаттай бууруулах хүрээнд шинээр гадаад үнэт цаас гаргасан тохиолдолд зөвхөн дахин санхүүжилт буюу өрийн зохицуулалтын зорилгоор ашиглах, засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэн, арилжааг тогтмол зохион байгуулах, улсын төсвөөс төлөгдөх нөхцөлтэй өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх, шинээр авах гадаад зээлийг эдийн засгийн өсөлтийг дэмжих томоохон төсөл, хөтөлбөрүүдэд чиглүүлэх бодлого баримтална.

## 2.2.5 Гадаад зээл, үнэт цаасаар санхүүжих

**Гадаад зээл, үнэт цаас:** Эдийн засгаа идэвхжүүлэх, томоохон бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлэх хүрээнд ирэх гурван жилийн хугацаанд нийт 11.3 их наяд төгрөгийн гадаад зээл, үнэт цаасаар санхүүжих төслийн орон зайг стратегийн түвшинд бий болголоо. Гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжих төслүүд нь дунд хугацаанд эдийн засгийн суурийг тэлснээр төсвийн орлогын баазыг нэмэгдүүлж, цаашид дотоод нөөц боломжоороо хөгжлийн санхүүжилтийг шийдвэрлэх суурийг бэхжүүлэх ач холбогдолтой юм.

2026 оны байдлаар Монгол Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан, хэрэгжилтийг Засгийн газар хэрэгжүүлж байгаа нийт 18.3 их наяд төгрөгийн амлалтын дүн бүхий гадаад зээлийн 65 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд үүнээс 4.4 их наяд төгрөг буюу 24.2 хувийг ашигласан, үлдсэн 13.8 их наяд төгрөг буюу 75.8 хувь нь одоогоор ашиглагдаагүй, үүнээс 2026 онд 1.6 их наяд төгрөгийг ашиглахаар 2026 оны төсвийн тухай хуульд батлагдсан. Эдгээр төслүүдийн 94 хувь нь 2027-2030 онд хэрэгжиж дуусахаар гэрээ, хэлэлцээртэй байгаа нь гэрээний хугацаанд санхүүжилтийн ашиглалтыг нэмэгдүүлж, төслүүдийг ашиглалтад оруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

**Гадаад зээл, үнэт цаасны ашиглалт, баримтлах зарчмууд.** Дунд хугацааны гадаад зээл, тусламжийн ашиглалтын төсөөллийг Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого чиглэлтэй уялдуулан дараах зарчмыг үндэслэн төлөвлөлөө. Үүнд:

**Нэг.** Гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих шинээр эхлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөө, Шинэ сэргэлтийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хүнсний хангамж, аюулгүй байдлын бодлого зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулна. Энэ хүрээнд Өрийн удирдлагын тухай хуульд заасан “өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах” зарчмын хүрээнд арилжааны нөхцөлтэй гадаад зээллэгийн эх үүсвэрээр эргэн төлөгдөх чадвартай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэхгүй байх чиглэл баримтална.

Түүнчлэн төслүүдийг нэн тэргүүний ач холбогдол, бэлэн байдлаар нь эрэмбэлж, зайлшгүй шаардлагатай, бодит үр дүн гарах, нийгэм, эдийн засгийн ач холбогдолтой мега төслүүдийг гадаад зээл, тусламжаар санхүүжүүлнэ. Тухайлбал, газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл, Эрдэнэбүрэний усан цахилгаан станц барих төсөл, хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төсөл, бүсчилсэн хөгжлийг дэмжих зэрэг эдийн засгийн үр өгөөж өндөртэй, экспортыг дэмжсэн, импортыг орлох болон дэд бүтцийн стратегийн ач холбогдол бүхий чухал нөлөөтэй төслүүдийг гадаадын зээлээр хэрэгжүүлэх чиглэл баримтална.

Хөдөө аж ахуйн салбарт төрийн оролцоог хязгаарлаж, татаасыг оновчтой болгох, гадаад зээл, тусламжийн хөрөнгийг хувийн хэвшилд дамжуулан зээлэх, Засгийн газрын татаас хэлбэрээр олгох зэрэг үйл ажиллагааг дэмжихгүй.

**Хоёр.** Зээл, тусламжийн хөрөнгөөр 2026 онд хэрэгжиж дуусах төслүүдийн хувьд санхүүжилтийг бүрэн олгож, төслүүдийн хугацааг сунгахгүй байх, төслийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй байх замаар хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлж, дуусах чиглэлийг баримтална.

**Гурав.** Хөгжлийн бодлогын баримт бичигт туссан тэргүүлэх ач холбогдолтой, шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд анхаарна. Эдийн засгийн бодит өсөлт, экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй төслүүд, төлбөрийн тэнцэлд сөргөөр нөлөөлөх төслүүд, хэрэгжилт хангалтгүйгээс хугацааг удаа дараа сунгаж байгаа төслүүд болон шаардлагагүй зөвлөх үйлчилгээг зогсоох, хэрэгжүүлэхгүй байх чиглэл баримтална.

## 2.2.6 Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн зорилтот үзүүлэлт

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2027 онд ДНБ-ий -1.5 хувьтай, 2028 онд ДНБ-ий -1.0 хувьтай, 2029 онд ДНБ-ий -0.5 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай байхаар тооцлоо.

*Хүснэгт 2.14 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь)*

Үзүүлэлт	2027 төсөөлөл	2028 төсөөлөл	2029 Төсөөлөл
Хуулийн хязгаар	-2.0	-2.0	-2.0
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-1.5	-1.0	-0.5

## 2.3 Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн тоог ашиглаагүй бол үндэслэл, шалтгааныг үзүүлэлт тус бүрээр бодлогын өөрчлөлтөөр тодорхойлсон тайлбар

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 10.1.2-т Засгийн газар “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс дараах таамаглалыг 2027 оны 3 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн.

*Хүснэгт 2.15. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийн төсөөлөл*

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд ашигласан төсөөлөл			Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн таамаглал		
	2027 он	2028 он	2029 он	2027 он	2028 он	2029 он
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.8	6.0	6.3	5.6	5.0	5.2
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.0	5.0	7.2	7.0	6.7
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	34,780.0	37,371.8	39,737.5	33,644.2	36,996.3	40,951.0
ДНБ-д эзлэх хувь	30.4	29.4	28.1	29.8	30.3	31.0
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	36,493.4	38,644.0	40,444.7	35,902.2	39,438.3	43,593.0
ДНБ-д эзлэх хувь	31.9	30.4	28.6	31.8	32.3	33.0
5 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,713.4	-1,272.2	-707.2	-2,258.0	-2,442.0	-2,642.0
ДНБ-д эзлэх хувь	-1.5	-1.0	-0.5	-2.0	-2.0	-2.0
6 Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	32,495.4	34,827.4	36,908.5	-	-	-
ДНБ-д эзлэх хувь	28.4	27.4	26.1	-	-	-
7 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	2,284.6	2,544.4	2,828.9	-	-	-
ДНБ-д эзлэх хувь	2.0	2.0	2.0	-	-	-
8 Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	57,114.9	63,610.1	63,651.0	47,756.7	54,700.8	59,577.1
ДНБ-д эзлэх хувь	50.0	50.0	45.0	42.3	44.8	45.1
9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,823.0	2,998.2	3,173.0	-	-	-
ДНБ-д эзлэх хувь	2.5	2.4	2.2	-	-	-

*Эх сурвалж: Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, 2026 оны 3 дугаар сар*

**ДНБ-ий бодит өсөлт:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ДНБ-ий бодит өсөлтийг 2027 онд 5.5 хувь, 2028 онд 5.3 хувь, 2029 онд 5.3 хувь байх таамаглалыг ирүүлсэн.

Тус зөвлөлөөс эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2026-2028 оны таамаглалыг боловсруулах хүрээнд DIGNAR-19 загвар болон FPP-CAEM загварыг ашигласан байна. DIGNAR-19 загварын хувьд экспорт, засгийн газрын хөрөнгө оруулалт зэрэг үзүүлэлтүүдийн 2026-2029 оны төсөөллийг нэг хувьсагчийн хугацаан цуваан загваруудаар тооцож, ДНБ-ий 2027 онд 5.6 хувь, 2028 онд 5.5 хувь, 2029 онд 5.8 хувь байх төсөөллийг боловсруулжээ. Харин FPP-CAEM загварын хувьд 2026-2028 онд эдийн засгийн өсөлт 5 хувь орчим байхаар төсөөлөгдсөн гэжээ.

Олон улсын байгууллагууд дэлхий дахинаа үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор 2026 оны дөрөвдүгээр сард дэлхийн эдийн засаг болон тухайн улсын эдийн засгийн төсөөллөө шинэчлэн танилцуулсан. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг жишээлбэл, Олон улсын валютын сан 2027 онд эдийн засаг 5.3 хувь, 2028, 2029 онд 5.2 хувиар өснө гэж тооцоолсон бол Дэлхийн банк 2027, 2028 онд эдийн засгийн өсөлтийг 5.5 хувь байхаар, Азийн хөгжлийн банк 2027 онд 6.0 хувь байна гэж тус тус төсөөлжээ. Харин Монголбанк 2026 оны дөрөвдүгээр сард танилцуулсан Мөнгөний бодлогын тайландаа эдийн засгийн өсөлт 2027 онд 6.0 хувь, 2028 онд 4.7 хувь байна гэсэн төсөөллийг дэвшүүлсэн байна.

Макро эдийн засгийн төлөв байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийг боловсруулахад ДНБ-ий бодит өсөлт 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6.0, 2029 онд 6.3 хувь байхаар төсөөлж байна. Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулахдаа томоохон аж ахуйн нэгжүүдийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын арга хэмжээнүүдийн нөлөөг харгалзан үйлдвэрлэлийн хэмжээг салбар тус бүрээр тооцон боловсруулсан болно. Тухайлбал, уул уурхайн салбарын төсөөлөлд Оюу толгойн гүний уурхайн үйлдвэрлэлтэй холбоотойгоор зэсийн баяжмал дахь эрдсийн агуулгын өөрчлөлтийг тусгасан бол хөгжлийн томоохон төслүүдийн хэрэгжилтийн нөлөөг барилга, боловсруулах, эрчим хүч зэрэг салбаруудын төсөөллийг боловсруулахад ашигласан. Улмаар эдийн засгийн эрэлт, нийлүүлэлт талын нийцэл, бодит, төсөв, мөнгө, гадаад секторуудын уялдааг ханган эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулсан болно.

Эдийн засгийн өсөлтийн 2027-2029 оны төсөөллийн талаар дэлгэрэнгүйг энэ танилцуулгын 1.2.3 дахь хэсгээс харах боломжтой.

**Инфляц:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс инфляц 2027 онд 7.2 хувь, 2028 онд 7.0 хувь, 2029 онд 6.7 хувь байх төсөөллийг ирүүлсэн. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд инфляцыг 2027 онд 7.0 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд 5.0 хувь байхаар тусгасан. Дунд хугацаанд “Хүнсний хувьсгал” хөдөлгөөн, “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян” зэрэг эрчимжсэн мал ахуйг хөгжүүлэх, дотоодын хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийн үр дүнд дотоодын хүнсний үнийн өсөлт саарч, инфляцын дарамт буурахаар төсөөлж байна. Түүнчлэн Засгийн газраас худалдааны эргэлтийг сайжруулах чиглэлд гаалийн үйл ажиллагааг цахимжуулж, худалдааг хөнгөвчлөхийн

зэрэгцээ экспортын зохион байгуулалтыг оновчтой хийж, валютын нөөцийг тогтвортой нэмэгдүүлэн, мөчлөг сөрсөн төсвийн бодлого баримтална. Мөн төрөөс мөнгөний бодлогын талаар 2026 онд баримтлах үндсэн чиглэлд төв банк 2027 оноос инфляцын зорилтот түвшнийг 5 хувь болгон бууруулахаар заасны дагуу дунд хугацаанд инфляцыг 5 хувийн орчимд тогтворжуулахад чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжихээр байна.

Инфляцын 2027-2029 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 1.2.4 дэх хэсгээс харах боломжтой.

**Төсвийн орлого:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс төсвийн орлогын ДНБ-д харьцах харьцааг 2027 онд 29.8 хувь, 2028 онд 30.3 хувь, 2029 онд 31.0 хувьд хүрч, нэрлэсэн дүнгээр 2027 онд 33.6 их наяд төгрөг, 2028 онд 37.0 их наяд төгрөг, 2029 онд 41.0 их наяд төгрөгт хүрэх таамаглалыг ирүүлсэн.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгагдсан төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д харьцах харьцаа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалтай нийцтэй байгаа бөгөөд 2027 онд дээрх төсөөллөөс 0.6 нэгж хувиар их буюу 30.4 хувь, 2028 онд 0.9 нэгж хувиар бага буюу 29.4 хувь, 2029 онд 2.9 нэгж хувиар бага буюу 28.1 хувьд хүрэхээр тооцсон болно.

Төмөр замын суурь дэд бүтцийг сайжруулж, боомтуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, хил холболтын ажлыг дуусгаснаар түүхий эдийн экспортын биет хэмжээ нэмэгдэх хүлээлттэй байна. Мөн нүүрсний баяжуулах үйлдвэрийн нөлөөгөөр нийт нүүрсний экспортод эзлэх баяжуулсан коксжих нүүрсний хувь хэмжээ өсөхөөр хүлээгдэж байгаа нь төсвийн орлогод эерэг нөлөө үзүүлэхээр байна. Эдгээр хүчин зүйлсийг харгалзан 2027 оны төсвийн орлогын ДНБ-д харьцах харьцааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн таамаглалаас дээгүүр төсөөллөө. Харин 2028-2029 онд төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн хязгаарт багтсан болно.

Цаашид бодлогын хувьд татварын ачааллыг үе шаттайгаар бууруулах, төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг зохист түвшинд хүргэх зорилтын хүрээнд орлогын өсөлтийн хурд саарахаар тооцлоо.

Төсвийн орлогын 2027-2029 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 2.2.1 дэх хэсгээс харах боломжтой.

**Төсвийн зарлага:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д харьцах харьцааг 2027 онд 31.8 хувь, 2028 онд 32.3 хувь, 2029 онд 33.0 хувьд хүрч, нэрлэсэн дүнгээр 2027 онд 35.9 их наяд төгрөг, 2028 онд 39.4 их наяд төгрөг, 2029 онд 43.6 их наяд төгрөгт хүрэх таамаглалыг ирүүлсэн.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгагдсан төсвийн нийт зарлагын ДНБ-д харьцах харьцаа нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалын хязгаарт багтаж байгаа бөгөөд 2027 онд 0.1 нэгж хувиар их буюу 31.9 хувь, 2028 онд 1.9 нэгж хувиар бага буюу 30.4 хувь, 2029 онд 4.4 нэгж хувиар бага буюу 28.6 хувьд хүрэхээр тооцсон болно.

Төсвийн зарлага ДНБ-ий харьцаа 2027 оны хувьд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тооцоололтой нийцэж байгаа бол дунд хугацаанд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан бодлогын хүрээнд эдийн засаг дахь төрийн оролцоог хязгаарлах, төсвийн зардлын тэлэлт, гадаад өрийн хэмжээг бууруулах, урсгал зардлын өсөлтөд зайлшгүй шаардлагатай нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлсийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, үр ашиггүй төсвийн зардлыг бууруулж, төсвийн сахилга батыг сахих бодлогыг баримтлан төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хэмжээг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн таамаглалаас доогуур төсөөллөө.

Төсвийн зарлагын 2027-2029 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 2.2.2 дахь хэсгээс харах боломжтой.

**Засгийн газрын өр:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалд Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийн ДНБ-д харьцах харьцааг 2027 онд 42.3 хувь, 2028 онд 44.8 хувь, 2029 онд 45.1 хувьд хүрэхээр төсөөлсөн байна.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд Засгийн газрын өрийн хязгаарыг 2027-2028 онд 50.0 хувь, 2029 онд 45 хувь буюу төсвийн тусгай шаардлагад тусгагдсан хязгаар<sup>12</sup>-аас 10-15 нэгж хувиар бага байхаар тусгасан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглал болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл нь Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулах бодлогын хувьд нийцтэй байна.

Харин "Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай" хуулийн төслийн нөлөөгөөр Газрын тосны үйлдвэр, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц барих төслүүдийг төсвөөс гаргаснаар Засгийн газрын гадаадын өрийн орон зайг нэмэгдүүлэх шаардлага үүссэн тул Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн таамаглалаас дээгүүр төсөөллөө.

Засгийн газрын өрийн 2027-2029 оны төсөөллийн талаар энэ танилцуулгын 2.2.4 дахь хэсгээс харах боломжтой.

---

<sup>12</sup> Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх.

### 3. ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1 дэх заалтын дагуу дунд хугацааны төсвийн бодлогыг төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн тодорхойллоо.

#### 3.1 Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, стратегийн зорилт<sup>13</sup>

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төсвийн удирдлагын зарчимд нийцүүлэн макро эдийн засгийн болон татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, төсвийн тусгай шаардлагыг хангах замаар макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн дунд хугацааны төсвийн бодлого, стратегийн зорилтыг боловсрууллаа.

Түүнчлэн төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн олон талт оролцоог хангах, холбогдох хуулийн шаардлагуудад нийцүүлэх, хэрэгжихүйц, бодитой байх зэрэг төлөвлөлтийн үндсэн шалгуурыг баримталсан болно.

***Нэг. Макро эдийн засгийг тогтворжуулахад мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.***

Дэлхий дахинд тодорхой бус байдал өндөр байгаагаас шалтгаалан олон улсын зах зээл дээрх ашигт малтмалын бүтээгдэхүүний болон газрын тосны үнэ хэлбэлзэл өндөртэй байгаа нь манай улсын эдийн засгийн гадаад эрэлтийг сааруулах төлөвтэй байна. Иймд эдийн засгийг идэвхжилийг дэмжих, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор томоохон төслүүдийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, гадаад зээл ашиглалтыг нэмэгдүүлнэ. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2027 онд ДНБ-ий 1.5 хувь, 2028 онд ДНБ-ий 1.0 хувь, 2029 онд ДНБ-ий 0.5 хувийн алдагдалтай байхаар хуулийн төсөлд тусгалаа. Мөн зарим томоохон төслийг төсвийн хязгаараас гаргасантай холбоотойгоор Засгийн газрын өрийн орон зайг нэмэгдүүлж, шинээр авах гадаад зээлийг эдийн засгийн өсөлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд чиглүүлэхээр төлөвлөв.

***Хоёр. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулж, хувийн хэвшлийн бизнес тэлэх орон зайг нэмэгдүүлнэ.***

Нэгдсэн төсвийн нийт зарлагын эдийн засаг дахь харьцааг 2027 онд 31.9 хувь, 2028 онд 30.4 хувь, 2029 онд 28.6 хувь байхаар үе шаттай бууруулахаар хуулийн төсөлд тусгав. Төсвийн зардлын өсөлтийг ийнхүү хязгаарлаж байгаа нь төсвийн зарцуулалтыг үр ашгийг нэмэгдүүлэх, эрэлтийн гаралтай инфляцыг хязгаарлахад

<sup>13</sup>

*Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.9. төсвийн төлөвлөлтийн төсвийн тусгай шаардлагад нийцсэн байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тавигдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдал”*

мөнгөний бодлоготой уялдах замаар дунд хугацаанд инфляцын зорилтот дүнг үе шаттай бууруулахад хувь нэмэр оруулна. Ингэснээр дунд хугацаанд зээлийн хүү буурах, Засгийн газрын зээлжих зэрэглэл тогтвортой нэмэгдэх, төсвийн бодлогын орон зай бэхжих зэрэг чухал ач холбогдолтой юм.

Төсвийн сахилга батыг сайжруулан, урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. Уг бодлогын хүрээнд нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээг 2027 онд ДНБ-ий 2.5 хувь, 2028 онд 2.4 хувь, 2029 онд 2.2 хувь болгож үе шаттай бууруулахаар тусгав.

**Гурав. Салбаруудын үйл ажиллагааг зах зээлийн механизм руу чиглүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг дэмжинэ.**

Хуулийн төсөлд эдийн засгийн өсөлтийг 2027 онд 5.8 хувь, 2028 онд 6.0 хувь, 2029 онд 6.3 хувь байхаар тооцож тусгалаа. Мөн инфляцыг төв банкны зорилтот түвшинд байхаар тооцож, хуулийн төсөлд тусгасан болно. Эдийн засгийн өсөлтийг тогтвортой хангах, инфляцыг зорилтот түвшинд барих хүрээнд бизнесийн орчныг бүх салбарт сайжруулж, хөрөнгө оруулалт татах, үйлдвэрлэл, худалдааны үйл ажиллагааг дэмжих, хувийн хэвшлийн бизнес эрхлэх эрх чөлөөг хангана. Үүний зэрэгцээ салбар бүр дэх төрийн оролцоог үе шаттайгаар бууруулж, зах зээлийн либералчлалыг гүнзгийрүүлэх замаар өрсөлдөөнийг нэмэгдүүлж, шийдвэр гаргалтыг хараат бус, мэргэжлийн байгууллагын зарчимд тулгуурласан бие даасан тогтолцоонд шилжүүлэн хөгжүүлнэ. Дээрх бодлогын хүрээнд зарим салбарт хэрэгжүүлэх арга хэмжээг дараах байдлаар тодорхойлов.

**Уул уурхай:** Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах хүрээнд геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, хайгуулын лицензийн тоог нэмэгдүүлэх, хайгуулын ажлын гүйцэтгэлийг сайжруулж, ордуудын ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг өргөжүүлнэ. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний төрөлжилтийг хүрээнд шинэ ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, эдийн засгийн суурийг тэлэх, Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлтийг яаралтай УИХ-д өргөн мэдүүлж, батлуулна.

**Боомтын шинэчлэл, тээвэр логистик:** Хилийн боомтын дэд бүтцийг нэмэгдүүлэх хүрээнд хил дамнасан төмөр замуудын холболтыг эрчимжүүлж, боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, экспортыг нэмэгдүүлнэ. Мөн тээврийн зохицуулалтыг оновчтой болгож, хилийн боомтуудад тээврийн нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, ажлын цагийг уртасгах, тээврийн дарааллыг хүний оролцоогүй шийдэн гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг хялбарчилж, шуурхай болгоно. Тээврийн салбарын либералчлалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж авто зам ашигласны төлбөр, хураамжийг үе шаттай нэмэгдүүлэн, зам засварын ажлуудыг хувийн хэвшилд шилжүүлж, зам дагасан үйлчилгээг хөгжүүлэх бодлого баримтална.

**Эрчим хүч:** Либералчлалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, тархмал эх үүсвэрүүдийг эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбох хялбар зохицуулалтыг үе шаттайгаар нэвтрүүлэн, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах чадвартай салбар болгон хөгжүүлнэ. Цаашид хямд өртөгтэй нийлүүлэгдэж байгаа эрчим хүчний эрэлтийг түрүүлж хангах бодлогыг баримтлан төрөөс дахиж хатуу үнэ тохирсон гэрээ

хийхгүй байх, эрчим хүчний биржийг байгуулна. Мөн сэргээгдэх эрчим хүчний салбарын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, нэмэгдүүлнэ.

**Хөдөө аж ахуй:** Салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж ажиллахын зэрэгцээ зах зээл дэх төрийн оролцоог үе шаттайгаар бууруулна. Тухайлбал, мах, улаан буудай зэрэг бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх замаар үнийг шууд зохицуулах, үнэд нөлөөлөх шинжтэй арга хэмжээнээс татгалзана. Мөн хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааг идэвхжүүлж, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн сувгийг өргөжүүлэх, зах зээлийн ил тод, өрсөлдөөнт орчныг бүрдүүлнэ. Малын эрүүл мэндийн хамгаалах цогц арга хэмжээг хэрэгжүүлж, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.

**Боловсруулах салбар:** Бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг шат ахиулж, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэр, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах ажлыг үргэлжлүүлэн, үйлдвэрлэл технологийн паркуудын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. Түүнчлэн төрөөс хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй Атар-4, Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Цагаан алт хөдөлгөөний хэрэгжилтийг эцсийн үр дүнд хүргэх, үр ашгийг нэмэгдүүлэхэд анхаарна.

### 3.2 Төсвийн тусгай шаардлага хангасан байдал<sup>14</sup>

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу төсвийн хүрээний мэдэгдэл нь дараах төсвийн тусгай шаардлагуудыг хангаж байна.

**Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2027 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 10,249.9 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 125.4 ам.доллар байхаар тооцлоо (шигтгээ 3.1.).

**Нэгдсэн төсвийн суурь тэнцэл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байхаар заасан. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээг 2027-2029 онд 2.0 хувьтай тус тус тэнцэж байхаар тооцоолсон нь хуулийн тусгай шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.1 Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь)

	2027	2028	2029
Хуулийн хязгаар	2.0%	2.0%	2.0%
Төсөөлөл	2.0%	2.0%	2.0%

<sup>14</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.9. төсвийн төлөвлөлтийн төсвийн тусгай шаардлагад нийцсэн байдал, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр тавигдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн байдал”

**Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээ 2027 онд 25.3 хувь, 2028 онд 24.0 хувь, 2029 онд 23.0 хувь байхаар тус тус төсөөлсөн нь төсвийн урсгал зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээний тусгай шаардлагыг хангаж байна.

*Хүснэгт 3.2 Нэгдсэн төсвийн урсгал зарлагын төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь)*

	2027	2028	2029
Хуулийн хязгаар	30.0%	30.0%	30.0%
Төсөөлөл	25.3%	24.0%	23.0%

**Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.1.4-т заасан төсвийн тусгай шаардлагыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилгоор өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2024 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас хэтрүүлэхгүй байна” гэж заасан. Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл 2027-2029 онуудад хуульд заасан хязгаарт байхаар байна.

*Хүснэгт 3.3 Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдлийн төсөөлөл (ДНБ-нд эзлэх хувь)*

	2027	2028	2029
Хуулийн хязгаар	60.0%	60.0%	60.0%
Төсөөлөл	50.0%	50.0%	45.0%

### Шигтгээ 3.1. Тэнцвэржүүлсэн үнэ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т “тухайн төсвийн жилийн дараах жилийн төсвийн төсөлд баримтлах, түүний дараагийн хоёр, гурав дахь жилийн төсвийн төсөөлөлд тусгах гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг Олон улсын валютын сангаас гаргасан түүхий эдийн үнийн статистикт тусгасан тухайн төсвийн жилийн өмнөх дараалсан харгалзах 20, 19, 18 жилийн дундаж үнэ, эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсад нэр хүнд бүхий, Засгийн газраас тодорхойлсон санхүүгийн мэдээллийн байгууллагаас тухайн жилийн гуравдугаар сард анх зарласан өдрийн тухайн төсвийн жилийн болон түүний дараах гурван жилийн дундаж үнийн төсөөллийг дундажлан тус тус тооцох” гэж заасан. Мөн тус хуулийн 4.1.3-т “гол нэр төрлийн эрдэс баялаг” гэж тухайн жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг хэлнэ хэмээн тодорхойлсон бөгөөд 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр зэс болон нүүрс дээрх шаардлагыг хангаж байна.

Хүснэгт 3.4 Гол нэр төрлийн эрдэс баялгийн татварын орлогын төсвийн орлогод эзлэх хувь

	Орлого (Тэрбум төгрөг)	Эзлэх хувь
Төсвийн орлого	32,645.9	100%
<b>Зэс</b>	<b>3,697.5</b>	<b>11.3%</b>
<b>Нүүрс</b>	<b>4,373.8</b>	<b>13.4%</b>
Алт	579.9	1.8%
Төмрийн хүдэр	457.8	1.4%
Бусад	680.9	2.1%

Эх сурвалж: Сангийн яам<sup>15</sup>

#### 1. Олон улсын валютын сангийн түүхий эдийн үнийн статистик

ОУВС-аас түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнийн мэдээллийг Голлох Түүхий Эдийн Үнийн Систем (PCPS<sup>16</sup>)-ээр дамжуулан мэдээлдэг. Тус өгөгдлийн сангаас Австрали, Өмнөд Африкийн нүүрсний үнийг хамруулсан Нүүрсний Үнийн Индекс (2016=100)-ийн дунджийг ашигласан.

#### 2. Эрдэс баялгийн үнийн төсөөллийг мэдээлдэг олон улсын байгууллага

Тэнцвэржүүлсэн үнийн тооцоололд ашиглагдах гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн төсөөллийг “Bloomberg Terminal”-д бүртгэлтэй BMI, a Fitch Solutions company, Citigroup, Bank of America, Morgan Stanley, JP Morgan Chase & Co болон бусад санхүүгийн байгууллагуудаас 2026 оны 3 дугаар сард анх зарласан өдрийн төсөөллийг авч ашиглалаа. Нүүрс болон зэсийн үнийн төсөөллийг BMI, a Fitch Solutions company тус оны 3 дугаар сарын 2-ны өдөр хамгийн эхэнд зарласан байна. Дээрх байгууллагын төсөөлөл ирэх онуудад нүүрсний хувьд дунджаар 95.0 ам.доллар байгаа бол зэсийн хувьд 13,225 ам.доллар байна.

Хүснэгт 3.5 Тэнцвэржүүлсэн үнийн тооцоолол

Өмнөх жилүүдийн дундаж			
	18 жил	19 жил	20 жил
<b>Нүүрс</b>	163.3	159.9	155.7
<b>Зэс</b>	7,312.9	7,303.4	7,274.8
Ирээдүйн үнийн төсөөлөл			
	2026	2027	2028
<b>Нүүрс</b>	98.0	92.0	90.0
Дундаж		95.0	
<b>Зэс</b>	12,500	13,500	15,000
Дундаж		13,225	
Тэнцвэржүүлсэн үнэ			
	2026	2027	2028
<b>Нүүрс</b>	125.4	127.4	129.2
<b>Зэс</b>	10,249.9	10,264.2	10,268.9

Эх сурвалж: ОУВС, Блүүмберг, ЭЗХЯ-ны тооцоолол


<sup>15</sup> Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн татварын орлогын мэдээ

<sup>16</sup> Өгөгдлийн сантай дараах холбоосоор танилцана уу: <https://legacydata.imf.org/?sk=471dddf8-d8a7-499a-81ba-5b332c01f8b9>

### 3.3 Макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ<sup>17</sup>

Төсвийн бодлого нь эдийн засгийн агшилтын үед тэлж, халалтын үед хумих замаар эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэх шаардлагатай. Төсвийн бодлого эдийн засгийг тогтворжуулах чиглэлд хэрхэн нөлөөлж байгааг шинжлэх хүрээнд төсвийн тэнцэл дэх төсвийн бодлогын нөлөөг салгаж харах шаардлагатай. Төсвийн тэнцэл нь зөвхөн төсвийн бодлого төдийгүй эдийн засгийн өөрийн бизнесийн мөчлөг болон эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран төлөх үүрэг хүлээсэн хүүгийн төлбөрөөс хамаардаг. Тухайлбал, эдийн засаг идэвхжихийн хэрээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа эрчимжсэнээр төсвийн бодлогоос үл хамааран төсвийн орлого нэмэгддэг бол эдийн засгийн уналтын үед татварын орлого буурч, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг төсвийн зардал өсөж, төсвийн тэнцэл төсвийн бодлогоос үл хамааран буурдаг. Ийнхүү эдийн засгийн мөчлөгийн нөлөөгөөр төсвийн тэнцэл автоматаар өөрчлөгдөж байгааг “автомат тогтворжуулагч” гэх үзүүлэлтээр хэмжинэ. Мөн эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн бодлогын төлөвөөс үл хамааран хуваарийн дагуу төлөх үүрэг хүлээсэн өрийн үйлчилгээний төлбөрүүд төсвийн тэнцэлд нөлөөлнө. Иймд төсвийн бодлогын төлөвийг тооцоолоход төсвийн тэнцлийн дүнгээс бизнесийн мөчлөг болон хүүгийн төлбөрийн нөлөөг ялган харах шаардлагатай. Зураг 3.1-т төсвийн тэнцэлд үзүүлж буй төсвийн бодлогын нөлөөг төсвийн төлөвөөр, төсвийн бодлогоос хамаарахгүй эдийн засгийн мөчлөгийн нөлөөг төсвийн автомат тогтворжуулагчаар, өрийн үйлчилгээний төлбөрийн нөлөөг хүүгийн зардлаар салган харуулав.

Зураг 3.1 Төсвийн бодлогын төлөв



Эх сурвалж: ЭЗХЯ-ны тооцоолол

Цар тахлын хямралын үед буюу 2020-2021 онд эдийн засгийн үйлдвэрлэл боломжит түвшнээсээ хамгийн ихдээ -11.3 хувиар бага байсан байна. Энэхүү уналтын үед төсвийн төлөв дунджаар потенциал ДНБ-ий -4.0 хувьд хүрсэн нь макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн мөчлөг сөрсөн төсвийн тэлэх бодлого хэрэгжсэнийг харуулж байна (Зураг 3.1).

<sup>17</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “12.3.3. Макро эдийн засгийн тогтвортой байдалд төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ”

### 3.4 Монгол Улсын 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл

Хүснэгт 3.6 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлт

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
	2027	2028	2029
1 Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.8	6.0	6.3
2 Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.0	5.0
3 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	34,780.0	37,371.8	39,737.5
ДНБ-д эзлэх хувь	30.4	29.4	28.1
4 Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	36,493.4	38,644.0	40,444.7
ДНБ-д эзлэх хувь	31.9	30.4	28.6
5 Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,713.4	-1,272.2	-707.2
ДНБ-д эзлэх хувь	-1.5	-1.0	-0.5
6 Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	32,495.4	34,827.4	36,908.5
ДНБ-д эзлэх хувь	28.4	27.4	26.1
7 Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	2,284.6	2,544.4	2,828.9
ДНБ-д эзлэх хувь	2.0	2.0	2.0
8 Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	57,114.9	63,610.1	63,651.0
ДНБ-д эзлэх хувь	50.0	50.0	45.0
9 Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,823.0	2,998.2	3,173.0
ДНБ-д эзлэх хувь	2.5	2.4	2.2

#### 4. ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТУЛГАРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

**Нэг. Ойрх Дорнодын мөргөлдөөн:** 2026 оны хоёрдугаар сарын сүүлчээс Иран–АНУ-ын зөрчил хурцадсанаар Ормузын хоолойн аюулгүй байдал алдагдаж, дэлхийн эрчим хүчний нийлүүлэлт тасалдах бодит эрсдэл үүсэв. Ингэснээр дэлхийн газрын тосны далайн тээврийн ойролцоогоор 20 хувь дамжин өнгөрдөг стратегийн ач холбогдолтой Ормузын хоолойгоор тээвэрлэлтийг хязгаарлах арга хэмжээ авснаар богино хугацаанд LNG-ийн нийлүүлэлт тасалдах эрсдэл нэмэгдэв. Үүний улмаас нийлүүлэлтийн огцом хязгаарлалт, даатгал, тээврийн зардал өсөж, брент төрлийн газрын тосны үнэ эрчимтэй нэмэгдсэн. Энэхүү нөхцөл байдал нь дэлхийн эрчим хүчний зах зээл дэх тодорхойгүй байдлыг гүнзгийрүүлж, газрын тосны нийлүүлэлт тасалдах эрсдэлийг өсгөснөөр нефтийн үнийн савлагаа үргэлжлэх хандлагатай байна.

Тухайлбал, брент төрлийн газрын тосны үнэ Ойрх Дорнодын мөргөлдөөн хурцдахаас өмнө буюу 2026 оны 2 дугаар сард дунджаар 69.4 ам.доллар/баррель байсан бол 3 дугаар сард дунджаар 99.6 ам.доллар, 4 дүгээр сард дунджаар 100.4 ам.доллар, хамгийн өндөртөө 118.4 ам.долларт хүрсэн байна. Энэ нь дэлхийн инфляцын дарамтыг нэмэгдүүлж, голлох төв банкнуудын мөнгөний бодлого илүү тодорхой бус орчинд шилжихэд нөлөөлж байна. Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ тогтворгүй байгаа нь шатахууны импортын өртгийг өсгөж, стратегийн нөөцийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэлтэй. Монгол Улс шатахууны хэрэглээгээ 100 хувь импортоор, түүний 95 орчим хувийг ОХУ-аас хангадаг тул олон улсын нийлүүлэлтийн сүлжээ доголдох, тээвэр логистикийн өртөг өсөх, дэлхийн зах зээл дээрх үнэ өсөх үед дотоодын ханган нийлүүлэлтийн тогтвортой байдал богино хугацаанд тасалдах, үнэ нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна. Газрын тосны үнэ огцом өсөх нь Монгол Улсын хувьд шатахууны импортын зардлыг өсгөж, инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна. Ойрх Дорнодоос шалтгаалан шатахууны үнэ өсөхийн зэрэгцээ хүнс, эм, эрчим хүч зэрэг стратегийн барааны үнэ даган нэмэгдэх эрсдэл өндөр байгаа нь өрхийн бодит орлого, аж ахуйн нэгжийн зардалд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

**Хоёр. Худалдааны дайн:** АНУ-ын худалдааны бодлогын зарим шийдвэрүүдийн эрчим саарсан хэдий ч дэлхийн эдийн засаг дахь тодорхой бус байдал хэвээр байна. АНУ худалдааны алдагдлыг бууруулах зорилгын хүрээнд түнш орнуудад ногдуулах тарифын хэмжээг нэмэгдүүлэх, мөн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих үүднээс тодорхой бараа бүтээгдэхүүнд өндөр тариф тогтоох зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үүний зэрэгцээ компаниуд тарифын өсөлтөөс үүдэлтэй нэмэлт зардлыг өөртөө шингээх, хэрэглэгчдэд үнийн өсөлтөөр дамжуулах, эсвэл эдгээрийг хослуулан хэрэгжүүлэх замаар дасан зохицож байгаа бөгөөд энэ нь инфляцыг өдөөх нэг хүчин зүйл болж байна. Улмаар энэ нь манай улсын экспортын орлого буурах, инфляц өсөх, гадаад санхүүжилтийн өртөг, зардал нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

**Гурав. БНХАУ-ын эдийн засаг:** БНХАУ-ын эдийн засагт үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, дотоод эрэлт сул хэвээр байгаа нь эдийн засгийн идэвхилийг хязгаарлаж байна. Тус улсын Засгийн газраас дотоод эрэлт, өрхийн хэрэглээг дэмжих бодлогыг баримталж, эдийн засгийн өсөлтийг 4.5-5.0 орчим хувьд

хүргэх зорилт дэвшүүлсэн боловч Ойрх Дорнодын мөргөлдөөнтэй холбоотойгоор тодорхой бус байдал нэмэгдэж байгаа нь сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тухайлбал, дэлхийн зах зээл дээр эрчим газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалсан өртөг өсөж, инфляцын дарамт нэмэгдэж байна. Түүнчлэн геополитикийн эрсдэл, худалдааны бодлогын тодорхой бус байдал хэвээр хадгалагдаж байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулах эрсдэлийг дагуулж байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах нь Монгол Улсын экспортод сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

**Дөрөв. ОХУ-Украины дайн:** ОХУ-Украины дайнтай холбоотойгоор газрын тосны үнэ 2022 онд огцом өссөн нь импортын зардлыг нэмэгдүүлж, дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг эрчимжүүлэхэд нөлөөлсөн. Цаашид дайны нөхцөл байдал хурцдах тохиолдолд газрын тосны зах зээл дэх тодорхой бус байдал нэмэгдэж, нефтийн үнийн өсөлтөөр дамжин инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэл хэвээр байна. Мөн ОХУ-д чиглэсэн Европын холбоо, АНУ, Их Британи зэрэг орнуудын хориг арга хэмжээ үргэлжилснээр гадаад төлбөр тооцоо, санхүүгийн гүйлгээнд саатал үүсэх эрсдэлийг хадгалж байна.

**Тав. Инфляц:** Дэлхий дахинд үүссэн геополитикийн хурцадмал байдал, эрчим хүчний зах зээл дэх тодорхой бус нөхцөл нь түүхий эд, тээвэр, логистикийн зардлыг нэмэгдүүлэх хандлагатай байна. Үүний нөлөөгөөр шатахуун, эрчим хүч, хүнс зэрэг голлох бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн өртөг нэмэгдэж, олон улсад үнийн дарамт нэмэгдэж байна. Тухайлбал, дэлхийн хүнсний үнийн индекс Ойрх Дорнод дахь мөргөлдөөнтэй холбоотойгоор 2026 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэглээний сагсны 45.6 хувийг импортын бараа бүрдүүлдэг манай улсын хувьд эдгээр үнийн өсөлт импортын сувгаар дамжин инфляцад суурь дарамт үүсгэх эрсдэлтэй байна. Ялангуяа шатахууны үнийн өсөлт нь инфляцыг шууд нөлөөгөөр нэмэгдүүлэхээс гадна үйлдвэрлэл, тээвэр, үйлчилгээний өртгийг өсгөж, бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлтийг дам байдлаар эрчимжүүлж болзошгүй.

**Зургаа. Уур амьсгалын өөрчлөлт:** Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт эрчимжихийн хэрээр цаг агаарын хэв шинж өөрчлөгдөж, улмаар бэлчээрийн чанар доройтож, ургац буурах зэрэг сөрөг үр дагаврууд нэмэгдэж байна. Тухайлбал, 2023–2024 онд өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрснээс шалтгаалан хөдөө аж ахуйн салбар 28.7 хувиар агшиж, хорогдсон малын тоо 9.4 саяд хүрсэн байна. Малын зүй бус хорогдол нэмэгдсэнээр махны нийлүүлэлт буурч, махны үнэ 20 гаруй хувиар өссөн байна. Мөн 2025 оны зун тохиосон гангийн нөлөөгөөр ургац алдсан бөгөөд хүнсний ногооны ургац 19.3 хувиар буурч, үнэ нь 24-34 хүртэл хувиар өссөн байна. Цаашид цаг агаарын нөхцөл байдлаас өндөр хамааралтай хөдөө аж ахуйн салбарт зуд тохиох, хаваржилт хүндрэх, зуншлага тааруу байх, ган болох, малын халдварт өвчин тархах зэрэг эрсдэлүүд хадгалагдсан хэвээр байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, өрхүүдийн орлого буурах, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, дотоодын хүнсний инфляц нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байна.

**Долоо. Эрчим хүчний тасралтгүй, найдвартай байдал:** Эрчим хүч нь эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах суурь хүчин зүйл боловч манай улс дотоодын цахилгаан хүчний хэрэглээг бүрэн хангаж чадахгүй, 21 орчим хувийг хөрш орнуудаас худалдан авч хэрэглэж байна. Тухайлбал, Монгол Улсад 2025 онд эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадал 1,926.6 МВт байна. Гэсэн ч Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний оргил ачаалал дангаар 2025-2026 оны өвөл 1,803 МВт хүрч нэмэгдсэн нь цаашид эрчим хүчний хэрэглээг хангаж чадахгүйд

хүрэх эрсдэлтэйг харуулж байна. Түүнчлэн Монгол Улсын эрчим хүчний үйлдвэрлэл өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангаж чадахгүй байгаагийн зэрэгцээ станцуудын насжилт өндөр, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна. Мөн цахилгаан эрчим хүчний эх үүсвэрийн дутагдлын улмаас өнгөрсөн хугацаанд шинээр цахилгааны техникийн нөхцөл авах нийт 3,240 МВт-ын хүсэлт ирснээс бодит нөхцөл боломжид хязгаарлагдан 974 МВт буюу 30 орчим хувийг олгож, 2,266 МВт хэрэглээ буюу 70 хувь нь шийдвэрлэгдээгүй хүлээгдэж байна. Эрчим хүчний тасалдал, дутагдал нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй.

***Найм. Зээлжих зэрэглэл буурах болон аливаа төрлийн хориг:*** Хөрш орнуудыг хамарсан геополитикийн хүндрэлтэй асуудлууд өрнөж буй энэ үед манай улс аливаа төрлийн хоригт өртөхгүй байх, зээлжих зэрэглэлийг сайжруулах хүрээнд олон улсад баримталж буй дүрэм журмуудыг мөрдөж, зээлжих зэрэглэл тогтоодог болон хориг арга хэмжээ авах эрх бүхий олон улсын байгууллагуудад хүргүүлэх холбогдох үнэлгээний тайлангуудыг сайтар бэлтгэх нь зүйтэй байна. Зээлжих зэрэглэл буурч, аливаа хоригт орсон тохиолдолд гадаадын хөрөнгө оруулалт, зээлийн урсгал буурах, төлбөр тооцоо саатах зэрэг эрсдэлүүд үүсэж болзошгүй.

## 5. ТАВДУГААР БҮЛЭГ. ХАВСРАЛТ

### 5.1 Салбаруудын төсөөлөлд туссан төслүүдийн талаар

#### Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төсөл

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд	Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон	
Хариуцагч:	Эхлэх огноо:	Бүс:				
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>55.7 тэрбум ₮</b>	40.6 тэрбум ₮	4.6 тэрбум ₮	5.2 тэрбум ₮	5.2 тэрбум ₮	-	-
<b>Гадаад зээл /БНЭУ Эксим банк/</b>		<b>2028</b>			<b>Дорноговь аймаг</b>	
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>6.01 их наяд ₮</b>	1.03 их наяд ₮	207.7 тэрбум ₮	2.4 их наяд ₮	2.4 их наяд ₮	-	-

#### Баянгийн 660 МВт-ын дулааны цахилгаан станц

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд	Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон	
Хариуцагч:	Эхлэх огноо:	Бүс:				
<b>Эрчим хүчний яам</b>	<b>2024</b>	<b>Төвийн бүс</b>				
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:	Аймаг/хот:				
<b>Шууд хөрөнгө оруулалт</b> /“Касэн пауэр грийн энерги” ХХК/	<b>2028</b>	<b>Төв аймаг</b>				
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>4,304.7 тэрбум ₮</b>	1,721.9 тэрбум ₮	860.9 тэрбум ₮	860.9 тэрбум ₮	860.9 тэрбум ₮	-	-

## Дулааны тавдугаар цахилгаан станц (ДЦС-5)

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд	Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон	
Хариуцагч:	Эхлэх огноо:	Бүс:				
<b>Эрчим хүчний яам</b>	<b>2026</b>	<b>Улаанбаатар</b>				
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:	Аймаг/хот:				
<b>Төр, хувийн хэвшлийн түншлэл, орон нутгийн төсөв</b>	<b>2028</b>	<b>Улаанбаатар хот</b>				
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>ТХХТ-1,855.7 тэрбум ₮</b>	-	618.6 тэрбум ₮	618.6 тэрбум ₮	618.6 тэрбум ₮	-	-
<b>ОНТ- 463.9 тэрбум ₮</b>	-	154.6 тэрбум ₮	154.6 тэрбум ₮	154.6 тэрбум ₮	-	-

## Эрдэнэбүрэнгийн 90 МВт-ын хүчин чадалтай усан цахилгаан станц

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд	Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон	
Хариуцагч:	Эхлэх огноо:	Бүс:				
<b>Эрчим хүчний яам</b>	<b>2025</b>	<b>Баруун бүс</b>				
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:	Аймаг/хот:				
<b>Гадаад зээл /БНХАУ Эксим банк/</b>	<b>2030</b>	<b>Ховд аймаг, Эрдэнэбүрэн сум</b>				
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>865.8 тэрбум ₮</b>	230.1 тэрбум ₮	99.4 тэрбум ₮	134.1 тэрбум ₮	134.1 тэрбум ₮	134.1 тэрбум ₮	134.1 тэрбум ₮

## "Гашуунсухайт-Ганцмод" боомтын хил дамнансан 19.5 км холболтын төмөр зам

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд	Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон	
Хариуцагч:	Эхлэх огноо:	Бүс:				
<b>Зам тээврийн яам</b>	<b>2025</b>	<b>Говийн бүс</b>				
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:	Аймаг/хот:				
<b>Шууд хөрөнгө оруулалт /"Эрдэнэс Тавантолгой" ХК/</b>	<b>2027</b>	<b>Өмнөговь аймаг</b>				
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>848.86 тэрбум ₮</b>	254.5 тэрбум ₮	424.4 тэрбум ₮	169.96 тэрбум ₮	-	-	-

### Сэлэнгэ аймгийн төвд 70 МВт-ын хүчин чадалтай цахилгаан станц

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд		Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон
Хариуцагч:	Эхлэх огноо:		Бүс:			
<b>Эрчим хүчний яам</b>	<b>2024</b>		<b>Төв</b>			
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:		Аймаг/хот:			
<b>Шууд хөрөнгө оруулалт /"Райд Монголиа" ХХК/</b>	<b>2026</b>		<b>Сэлэнгэ, Сүхбаатар сум</b>			
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>521.90 тэрбум ₮</b>	393.6 тэрбум ₮	128.3 тэрбум ₮	-	-	-	-

### Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтэц

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд		Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон
Хариуцагч:	Эхлэх огноо:		Бүс:			
<b>НЗДТГ</b>	<b>2025</b>		<b>Улаанбаатар</b>			
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:		Аймаг/хот:			
<b>Улсын болон орон нутгийн төсөв</b>	<b>2030</b>		<b>Улаанбаатар хот</b>			
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>503.4 тэрбум ₮</b>	30.0 тэрбум ₮	96.9 тэрбум ₮	94.0 тэрбум ₮	94.0 тэрбум ₮	94.0 тэрбум ₮	94.5 тэрбум ₮

### Даланзадгадын 50 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд		Хэрэгжилтийн шатанд			Ашиглалтад орсон
Хариуцагч:	Эхлэх огноо:		Бүс:			
<b>Эрчим хүчний яам</b>	<b>2026</b>		<b>Говийн бүс</b>			
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:		Аймаг/хот:			
<b>Орон нутгийн төсөв /Өмнөговь ЗДТГ/</b>	<b>2028</b>		<b>Өмнөговь аймаг</b>			
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>500.0 тэрбум ₮</b>	-	166.7 тэрбум ₮	166.7 тэрбум ₮	166.6 тэрбум ₮	-	-

## "Шинэ Ховд" үйлдвэр технологийн паркийн дэд бүтэц, барилга байгууламж байгуулах төсөл

Төслийн төлөвлөлтийн шатанд	ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах шатанд	Хэрэгжилтийн шатанд	Ашиглалтад орсон			
Хариуцагч:	Эхлэх огноо:	Бүс:				
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</b>	<b>2022</b>	<b>Баруун бүс</b>				
Санхүүжилтийн эх үүсвэр:	Дуусах огноо:	Аймаг/хот:				
<b>Улсын төсөв</b>	<b>2028</b>	<b>Ховд аймаг, Жаргалант сум</b>				
<b>НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ:</b>	Санхүүжилтийн гүйцэтгэл:	2026	2027	2028	2029	2030
<b>55.7 тэрбум ₮</b>	40.6 тэрбум ₮	4.6 тэрбум ₮	5.2 тэрбум ₮	5.2 тэрбум ₮	-	-

## 5.2 Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
	2021	2022	2023	2024	2025
<b>БОДИТ СЕКТОР</b>					
Нэрлэсэн ДНБ (тэрбум төгрөгөөр)	43,555	53,852	70,442	79,956	89,937
Бодит ДНБ өсөлт - үйлдвэрлэл (хувиар)	1.6	5.0	7.4	4.9	6.8
Бодит ДНБ өсөлт - эцсийн ашиглалт (хувиар)	1.6	5.0	7.2	5.1	6.9
Дотоод эрэлтийн оролцоо (нэгж хувиар)	17.6	11.4	5.4	21.2	1.8
Бараа, үйлчилгээний экспортын оролцоо (нэгж хувиар)	-7.5	13.9	18.0	0.5	4.0
Бараа, үйлчилгээний импортын оролцоо (нэгж хувиар)	-8.5	-20.3	-16.2	-16.6	-1.1
<b>Бодит ДНБ-ий өсөлт дэх оролцоо (нэгж хувиар)</b>					
Эцсийн хэрэглээ	-2.3	6.5	7.0	11.5	5.3
Өрхийн хэрэглээ	-4.0	5.1	6.3	8.7	6.6
Төрийн байгууллагын хэрэглээ	1.7	1.4	0.7	2.8	-1.3
Хөрөнгийн нийт хуримтлал	19.9	4.9	-1.6	9.7	-3.6
Цэвэр экспорт	-16.0	-6.4	1.8	-16.1	5.1
<b>ҮНИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>					
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцэст, хувиар)	13.8	13.2	7.9	9	7.5
Зэсийн үнэ* (\$/тонн)	9,315	8,815	8,479	9,145	9,947
Алтны үнэ* (\$/трой. унц)	3,008	3,490	2,647	2,389	3,346
ДНБ дефлятор (хувиар)	14.4	17.7	21.8	8.2	4.4
(тэрбум төгрөгөөр)					
<b>НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>					
Нийт орлого ба тусламжийн дүн	14,306	18,522	24,387	31,457	32,646
Тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	12,711	17,127	23,295	29,671	30,058
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	15,630	18,160	22,509	30,591	31,289
Нийт тэнцэл	-1,324	362	1,878	1,641	1,357
Нийт үндсэн тэнцэл	-488	1,160	3,028	2,877	2,914
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2,919	-1,033	786	-920	-1,232
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, ДНБ-д эзлэх хувиар)	62.6	61	45	42.2	39.4
ЗГ-ын нийт өр (нэрлэсэн, тэрбум төгрөгөөр)	26,918	31,965	30,774	33,430	35,420
<b>МӨНГӨНИЙ СЕКТОР</b>					
M2 мөнгөний өсөлт (хувиар)	13.8	6.5	24.2	15.5	10.6
Нөөц мөнгөний өсөлт (хувиар)	6.5	39.9	7.4	51.9	39.5
Мөнгөний эргэлтийн хурд (нэгжээр)	1.6	1.8	1.9	1.9	1.9
Мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	5.8	4.4	5.1	3.9	3.1
Зээлийн өсөлт** (хувиар)	18.5	7.5	22.8	31.0	20.0
(сая ам.доллаароор)					
<b>ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ</b>					
Төлбөрийн тэнцэл	-222	-727	1,457	622	1,034
Урсгал дансны тэнцэл	-2,108	-2,304	121	-2,485	-2,191
ГВУН	4,366	3,400	4,922	5,510	7,005
сарын бараа, үйлчилгээний импортын хүрэлцээ	5.7	3.4	4.4	4.0	5.3
<b>Гадаад валютын ханш</b>					
Валютын ханш USD/MNT (дунджаар)	2,849	3,140	3,466	3,390	3,546
Валютын ханш USD/MNT (хугацааны эцсээр)	2,849	3,445	3,411	3,420	3,557
Нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	41.3	38.8	37.6	39.6	37.3
Бодит үйлчилж буй ханшийн индекс (дунджаар)	102.8	105.7	111.1	120.2	126.3

\*Bloomberg Terminal

\*\*Ипотекийн зээлээр баталгаажсан бондыг оруулсан дүн

**БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

	<b>2021</b>	<b>2022</b>	<b>2023</b>	<b>2024</b>	<b>2025</b>
Нэрлэсэн ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	43,555	53,852	70,442	80,663	89,937
Бодит ДНБ (үйлдвэрлэлийн аргаар)	27,092	28,455	30,567	32,133	34,332
(өсөлт, хувиар)					
<b>Бодит ДНБ-ий өсөлт</b>	1.6	5.0	7.4	5.1	6.8
Уул уурхайн	0.8	-15.3	23.4	10.8	6.8
Уул уурхайн бус	1.8	8.2	5.4	4.3	6.3
Хөдөө аж ахуй	-5.5	12.0	-8.9	-28.7	33.2
Уул уурхай	0.8	-15.3	23.4	10.8	10.6
Боловсруулах аж үйлдвэр	-0.9	6.1	5.1	-4.2	10.0
Цахилгаан дулаан	10.6	3.5	5.2	5.0	10.2
Барилга	-22.8	8.2	3.1	14.0	15.9
Бөөний болон жижиглэн худалдаа	5.8	10.1	6.8	11.9	-4.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-7.3	9.2	39.6	16.4	4.8
Мэдээлэл, холбоо	20.7	6.6	17.0	17.4	7.2
Бусад үйл ажиллагаа	5.1	5.5	6.8	9.7	3.9
Цэвэр татвар	12.2	11.5	6.6	14.7	0.3
Дефлятор	14.4	17.7	21.8	8.9	4.4
(нэгж хувиар)					
<b>ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо</b>					
Хөдөө аж ахуй	-0.8	1.7	-1.3	-3.6	2.9
Уул уурхай	0.1	-2.1	2.6	1.4	1.4
Боловсруулах аж үйлдвэр	-0.1	0.5	0.4	-0.3	0.7
Цахилгаан дулаан	0.2	0.1	0.1	0.1	0.2
Барилга	-0.9	0.2	0.1	0.4	0.5
Бөөний болон жижиглэн худалдаа	0.6	1.1	0.8	1.4	-0.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-0.3	0.4	1.8	1.0	0.3
Мэдээлэл, холбоо	0.5	0.2	0.5	0.5	0.2
Бусад үйл ажиллагаа	1.1	1.6	1.7	2.5	1.1
Цэвэр татвар	1.3	1.4	0.8	1.8	0.0
(тэрбум төгрөгөөр)					
Нэрлэсэн ДНБ (эцсийн ашиглалтын аргаар)	44,703	54,878	71,202	80,208	92,588
Анхдагч орлого	(2,232)	(1,615)	(2,233)	(2,671)	(3,555)
Үндэсний нийт орлого	37,197	48,696	62,716	71,614	79,845
Хоёрдогч орлого	429	434	398	421	312
Үндэсний нийт эзэмшлийн орлого	38,419	50,048	64,097	73,039	81,105
Нийт дотоод эрэлт	45,574	58,219	64,404	81,027	87,704
Үндэсний хадгаламж	14,360	21,083	31,730	32,382	34,261
Хөрөнгийн нийт хуримтлал	15,993	22,796	23,880	28,672	28,252

**НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

	2021	2022	2023	2024	2025
(тэрбум төгрөгөөр)					
<b>НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>14,306</b>	<b>18,522</b>	<b>24,387</b>	<b>31,457</b>	<b>32,646</b>
Ирээдүйн өв сан	967	0	416	841	1,572
Тогтворжуулалтын сан	628	1,395	676	444	562
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>12,711</b>	<b>17,127</b>	<b>23,295</b>	<b>29,671</b>	<b>30,058</b>
<b>Татварын орлого</b>	<b>11,300</b>	<b>15,459</b>	<b>21,484</b>	<b>27,417</b>	<b>27,086</b>
Орлогын албан татвар	3,326	3,827	5,703	8,971	8,539
Нийгмийн даатгалын орлого	2,286	3,038	3,951	4,732	5,624
Хөрөнгийн албан татвар	201	238	395	459	608
Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,838	3,946	4,777	5,867	6,224
Онцгой албан татвар	827	848	790	1,107	955
Тусгай зориулалтын орлого	17	19	22	26	25
Гаалийн албан татвар	939	1,256	1,465	1,792	1,849
Бусад татвар, төлбөр, хураамж	866	2,288	4,382	4,463	3,261
<b>Татварын бус орлого</b>	<b>1,412</b>	<b>1,668</b>	<b>1,811</b>	<b>2,253</b>	<b>2,972</b>
Нийтлэг татварын бус орлого	1,250	1,364	1,452	1,779	2,622
Хөрөнгийн орлого	2	4	8	6	10
Тусламжийн орлого	160	300	351	469	339
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>15,630</b>	<b>18,160</b>	<b>22,509</b>	<b>30,591</b>	<b>31,289</b>
<b>Урсгал зарлага</b>	<b>12,804</b>	<b>14,229</b>	<b>17,091</b>	<b>22,177</b>	<b>24,186</b>
Цалин, хөлс	2,532	1,666	2,327	5,368	6,223
Бараа, үйлчилгээний бусад зардал	2,170	2,140	2,758	4,188	1,033
Татаас	454	537	580	955	799
Урсгал шилжүүлэг	6,813	9,088	10,276	10,429	11,762
Зээлийн үйлчилгээний төлбөр	836	798	1,150	1,236	1,557
Гадаад	681	694	1,054	1,187	1,197
Дотоод	155	104	95.5	49	360
<b>Хөрөнгийн зардал ба цэвэр зээл</b>	<b>2,826</b>	<b>3,930</b>	<b>5,418</b>	<b>8,414</b>	<b>7,103</b>
Хөрөнгийн зардал	2,982	3,803	5,188	7,971	7,090
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-156	127	229	444	12
<b>НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-1,324</b>	<b>362</b>	<b>1,878</b>	<b>1,641</b>	<b>1,357</b>
<b>ҮНДСЭН тэнцэл</b>	<b>-488</b>	<b>1,160</b>	<b>3,028</b>	<b>2,877</b>	<b>2,914</b>
<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН тэнцэл</b>	<b>-2,919</b>	<b>-1,033</b>	<b>786</b>	<b>-920</b>	<b>-1,232</b>

**ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

	2021	2022	2023	2024	2025
	(сая ам.доллаароор)				
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	-2,108	-2,304	121	-2,485	-2,191
Бараа	1,370	1,233	4,549	3,081	3,864
Экспорт Ф.О.Б (кредит)	8,136	9,854	13,914	14,750	14,932
Импорт Ф.О.Б (дебит)	6,766	8,622	9,366	11,668	11,068
Үйлчилгээ	-1,675	-2,355	-2,592	-3,317	-2,855
Кредит	814	1,135	1,587	1,604	2,011
Дебит	2,490	3,490	4,179	4,922	4,866
Анхдагч орлого	-2,232	-1,615	-2,233	-2,671	-3,541
Кредит	292	344	455	559	548
Дебит	2,524	1,959	2,687	3,230	4,088
Хоёрдогч орлого	429	434	398	421	341
<b>II. ХӨРӨНГИЙН ДАНС</b>	114	154	135	171	127
Кредит	115.7	165.9	148.6	183.3	143
Дебит	1.7	11.7	13.8	12.0	16
<b>III. САНХҮҮГИЙН ДАНС: (зээлдүүлэгч/зээллэг-)</b>	1,982	1,644	1,477	3,330	3,321
Шууд хөрөнгө оруулалт (цэвэр)	2,060	2,428	2,172	2,727	2,616
Багцын хөрөнгө оруулалт (цэвэр)	-25	-445	-818	1,105	833
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (цэвэр)	8	11	2	13	-7
Бусад хөрөнгө оруулалт (цэвэр)	-60	-351	121	-515	-121
Үүнээс: Бэлэн мөнгө ба харилцах	-245	-298	-354	-1,075	-945
Зээл	501	-67	529	630	586
Худалдааны зээл	-413	15	-54	-70	239
<b>IV. Алдаа болон орхигдуулга</b>	-209	-222	-276	-393	-223
<i>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</i>	-222	-727	1,457	622	1,034
<b>V. Нөөц хөрөнгө</b>	-222	-727	1,457	622	1,034
ГВУН	-225	-751	1,398	540	974
ОУВС-гийн зээл	-3.3	-23.7	-59.1	-82.5	-59.9
Тусгай санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0	0.0
<b>Нэмэлт үзүүлэлтүүд:</b>					
Нэрлэсэн ДНБ (сая ам.доллаароор)	15,286	17,124	20,325	23,793	25,367
Гадаад валютын албан нөөц (сая ам.доллараар)	4,366	3,400	4,922	5,510	7,005
Гадаад валютын албан нөөц (сарын импортоор)	5.7	3.4	4.4	4.0	5.3
Валютын ханш MNT/USD (дунджаар)	2,849	3,140	3,466	3,390	3,546
Валютын ханш MNT/USD (хугацааны эцсээр)	2,849	3,445	3,411	3,420	3,557

**МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

	2021	2022	2023	2024	2025
(тэрбум төгрөгөөр)					
<b>Гадаад цэвэр актив</b>	<b>3,806</b>	<b>2,492</b>	<b>8,959</b>	<b>8,704</b>	<b>8,700</b>
<b>Дотоод цэвэр актив</b>	<b>24,057</b>	<b>27,173</b>	<b>27,872</b>	<b>33,847</b>	<b>38,377</b>
Дотоодын цэвэр зээл	24,298	25,648	29,106	35,343	43,287
Бусад цэвэр зүйлс	(241)	1,525	(1,233)	(1,496)	(4,911)
<b>M2 мөнгө</b>	<b>27,863</b>	<b>29,665</b>	<b>36,832</b>	<b>42,551</b>	<b>47,077</b>
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	847	831	906	978	999
Харилцах болон хадгаламж	27,016	28,834	35,926	41,573	46,078
(өсөлт, хувиар)					
<b>Жилийн өсөлт</b>					
<b>M2 мөнгө</b>	<b>13.8</b>	<b>6.5</b>	<b>24.2</b>	<b>15.5</b>	<b>10.6</b>
Гадаад цэвэр актив	-34.6	-34.5	259.5	-2.8	0.0
Дотоод цэвэр актив	28.9	13.0	2.6	21.4	13.4
Дотоодын цэвэр зээл	27.0	5.6	13.5	21.4	22.5
ЗГ-аас авах авлага	-49.8	107.6	91.3	64.2	3.2
Бусад салбараас авах авлага	19.2	9.9	19.8	27.0	19.3
Улсын байгууллагаас авах авлага	25.0	-5.0	-16.7	13.1	-7.8
Хувийн сектороос авах авлага	18.8	10.8	21.7	27.5	20.1
(нэгж хувиар)					
<b>M2 мөнгөний өсөлт дэх оролцоо</b>					
<b>M2 мөнгө</b>	<b>13.8</b>	<b>6.5</b>	<b>24.2</b>	<b>15.5</b>	<b>10.6</b>
Гадаад цэвэр актив	-8.2	-4.7	21.8	-0.7	0.0
Дотоод цэвэр актив	22.0	11.2	2.4	16.2	10.6
<b>Нэмэлт үзүүлэлтүүд:</b>					
Мөнгөний эргэлтийн хурд	1.6	1.8	1.9	1.9	1.9
Нэрлэсэн ДНБ-ий өсөлт (хувиар)	16.3	23.6	30.8	14.5	11.5
Инфляц (ХҮИ-ийн өсөлт, хугацааны эцсээр, хувиар)	13.8	13.2	7.9	8.3	7.5



**МАКРО ЭДИЙН  
ЗАСГИЙН ҮНДСЭН  
ҮЗҮҮЛЭЛТ, ТӨЛӨВ  
БАЙДЛЫН ТААМАГЛАЛ**

**2027-2029**

**Дунд хугацааны төсвийн хүрээний  
мэдэгдлийн төслийг боловсруулахад  
баримтлах макро эдийн засгийн  
үндсэн үзүүлэлт, төлөв байдлын  
таамаглал боловсруулах ажлын  
хүрээнд бэлтгэв.**

**Төсвийн тогтвортой байдлын  
зөвлөл**

2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр

---

## АГУУЛГА

<b>УДИРТГАЛ</b>	<b>5</b>
<b>НЭГ. ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН НӨХЦӨЛ</b>	<b>9</b>
1.1. Дэлхийн эдийн засаг, геополитикийн өнөөгийн нөхцөл байдал	9
1.2. Хөрш орнуудын эдийн засгийн байдал, хөгжлийн зорилтууд	9
1.3. Түүхий эдийн эрэлт хэрэгцээний цаашдын хандлага	15
<b>ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА, УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ</b>	<b>18</b>
2.1. Эдийн засгийн өсөлтийн төлөв байдал	18
2.2. Гадаад худалдаа, төлбөрийн тэнцэл	25
2.3. Мөнгөний нийлүүлэлт ба инфляц	33
2.4. Төсвийн тогтвортой байдал, цаашдын хандлага	38
2.5. Төсвийн эрсдэл ба гадаад өр	46
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН 2027-2029 ОНЫ ТААМАГЛАЛ, ЗАГВАРЫН ҮР ДҮНГҮҮД</b>	<b>59</b>
3.1. Экспортын гол нэрийн түүхий эдийн үнэ, биет хэмжээ	59
3.2. DIGNAR19 загварын төсөөлөл	72
3.3. CAEM загварын төсөөлөл	84
<b>ДҮНЭЛТ, ЗӨВЛӨМЖ</b>	<b>102</b>
<b>ХАВСРАЛТ</b>	<b>104</b>

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт /ДНБ-ий өсөлт, улирлаар/, хувиар .....	10
Зураг 2. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт /1980-2025 он/, хувиар .....	11
Зураг 3. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн таамаглал .....	11
Зураг 4. Түүхий эдийн үнийн төсөөлөл /эрчим хүч, ХАА, уул уурхайн салбарт/ .....	16
Зураг 5. Монгол Улсын эдийн засгийн өсөлт /1990-2025 он/, хувиар .....	18
Зураг 6. Монгол Улсын 2025 оны эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө бүхий салбарууд .....	19
Зураг 7. ДНБ-ий болон ХАА-н салбарын 1990-2025 оны өсөлтийн харьцуулалт, хувиар .....	19
Зураг 8. Монгол Улсын эдийн засгийн бүтэц /2025 он/, хувиар .....	21
Зураг 9. Голлох салбаруудын эдийн засагт эзлэх хувь /1990-2025/ .....	21
Зураг 10. Эдийн засгийн бүтэц 2025 он .....	22
Зураг 11. Эдийн засаг дахь төрийн болон хувийн хэвшлийн оролцооны харьцуулалт /2015-2026/, хувиар .....	23
Зураг 12. Эдийн засгийн өндөр өсөлттэй салбарууд /1996-2025/ .....	24
Зураг 13. Гадаад худалдааны нийт эргэлт, тэнцэл, /2021-2025 он/, сая ам.доллаар .....	25
Зураг 14. Экспортолсон нүүрсний тоо хэмжээ, орлого /2021-2025 он/ .....	27
Зураг 15. Экспортолсон зэсийн хүдэр, баяжмалын тоо хэмжээ, орлого /2021-2025 он/ .....	28
Зураг 16. Урсгал дансны динамик /2019-2025 он/ .....	31
Зураг 17. Санхүүгийн дансны динамик .....	32
Зураг 18. Монгол Улсын мөнгөний нийлүүлэлтийн динамик /2014-2025 он/, сая төгрөгөөр .....	33
Зураг 19. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, инфляцын түвшин, мөнгөний бодлогын хүү, жилийн дундаж /2017-2025 он/, хувиар .....	34
Зураг 20. Монгол Улсын инфляцын динамик /2019-2026 он/, хувиар .....	35
Зураг 21. Инфляцын зорилт, төсөөлөл болон бодит түвшний харьцуулалт /2022-2026/, хувиар .....	36
Зураг 22. Монгол Улсын 2010-2025 оны нэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл, /сая төгрөг/ .....	39
Зураг 23. Төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь /2010-2025/ .....	41
Зураг 24. Төсвийн нийт болон урсгал зардлын динамик, нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувь /2010-2025 он/ .....	42
Зураг 25. Төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь /2010-2025/ .....	43
Зураг 26. Монгол Улс, өндөр хөгжилтэй улс орнууд, хөгжиж буй улс орнууд болон дэлхийн эдийн засгийн бодит өсөлт /1990-2030 он/, хувиар .....	49
Зураг 27. Эдийн засгийн өсөлт болон инфляц, экспортын өсөлт /2015-2025 он/, хувиар .....	49
Зураг 28. Төсвийн нийт орлого ба тусламжийн болон АМНАТ, ААХОАТ, бусад орлогын жилийн өсөлт 2015-2026 онд хувиар .....	50
Зураг 29. Уул уурхайн салбарын төсвийн орлого болон зэс, алт, нүүрсний орлогын өсөлтийн хувь /2015-2026 он/ .....	51
Зураг 30. Төсвийн нийт орлого болон орлогын төрлүүдийн ДНБ-д эзлэх хувь /2015-2026 он/ .....	52
Зураг 31. ДНБ-ий бодит өсөлт ба ДНБ-д төсвийн нийт зарлагын эзлэх хувь /2015-2026 он/ .....	52
Зураг 32. ДНБ-д төсвийн нийт зарлагад урсгал болон хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх цэвэр зээлийн эзлэх хувь /2015-2026 он/ .....	53
Зураг 33. Төсвийн нийт урсгал зардал болон урсгал зардалд цалин хөлсний зардлын эзлэх хувь, 2015-2026 он .....	54
Зураг 34. Инфляцын өсөлт ба цалин хөлсний зардлын өсөлт /2015-2026 он/, хувиар .....	55
Зураг 35. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт /2015-2025 он/, сая төгрөг .....	56
Зураг 36. Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2015-2025 оны байдлаар, /тэрбум төгрөг/, гадаад өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа, нэрлэсэн үнээр .....	57

Зураг 37. Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн үндсэн өрийн төлбөр төсвийн зардалтай харьцуулсан хувь болон хүүгийн төлбөр урсгал зардалтай харьцуулсан хувь 2015-2025 оны байдлаар.....	58
Зураг 38. Алтны биет хэмжээний төсөөлөл.....	67
Зураг 39. Алтны биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	67
Зураг 40. Алтны үнийн төсөөлөл.....	67
Зураг 41. Алтны үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	68
Зураг 42. Нүүрсний биет хэмжээний төсөөлөл.....	68
Зураг 43. Нүүрсний биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	68
Зураг 44. Нүүрсний үнийн төсөөлөл.....	69
Зураг 45. Нүүрсний үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	69
Зураг 46. Зэсийн үнийн төсөөлөл.....	69
Зураг 47. Зэсийн үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	70
Зураг 48. Зэсийн биет хэмжээний төсөөлөл.....	70
Зураг 49. Зэсийн биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	70
Зураг 50. Төмрийн хүдэр, баяжмалын үнийн төсөөлөл.....	71
Зураг 51. Төмрийн үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	71
Зураг 52. Төмрийн хүдэр, баяжмалын биет хэмжээний төсөөлөл.....	71
Зураг 53. Төмрийн биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%).....	72
Зураг 54. Системийн бүтэц, агентуудын харилцан үйчлэл.....	73
Зураг 55. DIGNAR загварын хэрэглэгчийн орчин.....	74
Зураг 56. DIGNAR загварын схем.....	74
Зураг 57. input.xlsx файлыг оруулах.....	75
Зураг 58. Загварын хувьсагчид.....	76
Зураг 59. Засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөөлөл /2026-2029 он/.....	80
Зураг 60. Засгийн газрын хэрэглээний төсөөлөл /2026-2029 он/.....	80
Зураг 61. Засгийн газрын шилжүүлэг (халамж)-ийн төсөөлөл /2026-2029 он/.....	81
Зураг 62. Буцалтгүй тусламжийн орлогын төсөөлөл /2026-2029 он/.....	81
Зураг 63. Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн төсөөлөл /2026-2029 он/.....	82
Зураг 64. Ажилчдын мөнгөн гуйвуулгын төсөөлөл /2026-2029 он/.....	82
Зураг 65. АХОТ-ний төсөөлөл /2026-2029 он/.....	83
Зураг 66. САЕМ-ийн бүрэлдэхүүн хэсгүүд.....	85
Зураг 67. Үйлдвэрлэлийн зөрүү.....	86
Зураг 68. Бодит ДНБ-ий өсөлт.....	87
Зураг 69. ДНБ-ий өсөлтөд салбарын оролцоо.....	88
Зураг 70. Нэрлэсэн ДНБ.....	88
Зураг 71. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл.....	91
Зураг 72. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ.....	91
Зураг 73. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлтийн оролцоо, төсвийн орлогын ангиллаар.....	92
Зураг 74. Төсвийн урсгал зардал.....	92
Зураг 75. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл, татварын реформын нийт нөлөө.....	94
Зураг 76. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь, татварын реформын нөлөө.....	95
Зураг 77. Татварын реформын бодит ДНБ-д үзүүлэх нөлөө, өсөлтийн хувь.....	95
Зураг 78. Бараа, үйлчилгээний экспортын өсөлт, бодит секторт.....	97
Зураг 79. Бараа, үйлчилгээний импортын өсөлт, бодит секторт.....	98
Зураг 80. Урсгал дансны тэнцэл ДНБ-д эзлэх хувь.....	100

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. БНХАУ-ын эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн таамаглал .....	12
Хүснэгт 2. БНХАУ-ын ДНБ-ий өсөлт, түүний төсөөлөл .....	12
Хүснэгт 3. БНХАУ-ын хөгжлийн үндсэн зорилтууд.....	14
Хүснэгт 4. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн таамаглал .....	17
Хүснэгт 5. ХАА-н салбарын 2023-2025 оны зарим үзүүлэлт .....	20
Хүснэгт 6. Эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлж буй салбарууд /2016-2025/, хувиар.....	24
Хүснэгт 7. Экспортын гол бүтээгдэхүүний үнийн дүн, тоо хэмжээ /2021-2025 он/, сая ам.доллараар .....	26
Хүснэгт 8. Нүүрсний биет хэмжээ, үнэ, орлогын төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү /2021-2025 он/ ....	27
Хүснэгт 9. Экспортолсон зэсийн хүдэр, баяжмалын тоо хэмжээ, үнэ, орлого /2021-2025 он/ .....	28
Хүснэгт 10. Зэсийн хүдэр, баяжмалын биет хэмжээ, үнэ, орлогын төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү /2021-2025 он/.....	29
Хүснэгт 11. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн динамик.....	30
Хүснэгт 12. Төлбөрийн тэнцэл /2021-2025 он/.....	31
Хүснэгт 13. Нүүрсний экспортын нийт хэмжээ, тэнцвэржүүлсэн болон зах зээлийн үнэ .....	40
Хүснэгт 14. 2026-2030 оны төсвийн тогтвортой байдлын эрсдэлийн матриц.....	44
Хүснэгт 15. Эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ .....	45
Хүснэгт 16. Үндсэн индикаторууд /2026-2030 он/ .....	45
Хүснэгт 17. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл /2015-2024 он/, сая ам.доллараар.....	56
Хүснэгт 18. Түүхий эдийн үнэ болон биет хэмжээний таамаглалын үр дүн .....	64
Хүснэгт 19. Экспортын гол нэрийн барааны төсөөлөлд ашигласан хувьсагчид, тэдгээрийн эх сурвалж.....	66
Хүснэгт 20. Үндэсний тооцооны хэсгийн калибрац.....	76
Хүснэгт 21. Бодит хүүгийн хэсгийн калибрац .....	77
Хүснэгт 22. Бүтцийн параметрийн хэсгийн калибрац.....	78
Хүснэгт 23. Төсвийн болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн калибрац .....	78
Хүснэгт 24. DIGNAR загварын төсөөлөл .....	83
Хүснэгт 25. Төсвийн орлого болон суурь хувьсагчдын хамаарал .....	89
Хүснэгт 26. Суурь хувьсагчдаас хамааран татвар ногдох хувь хэмжээ .....	90
Хүснэгт 27. Нэгдсэн төсвийн урсгал зардал.....	93
Хүснэгт 28. Төсвийн үзүүлэлтүүдийн төсөөлөл /2026-2029 он/ .....	93
Хүснэгт 29. Загварт тусгасан татварын реформын төсөвт үзүүлэх шууд нөлөө, тэрбум төгрөг .....	94
Хүснэгт 30. Татварын реформын бодит ДНБ-ий бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөө, тэрбум төгрөг .....	95
Хүснэгт 31. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний таамаглал .....	96
Хүснэгт 32. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын үнийн таамаглал, сая ам доллар.....	96
Хүснэгт 33. Төлбөрийн тэнцэл .....	98
Хүснэгт 34. Бонд .....	99
Хүснэгт 35. Гадаадын шууд хөрөнгө оруулалт.....	100

## ХАВСРАЛТ

Хавсралт 1. Эдийн засгийн өсөлт, салбарын оролцоо (2016-2025).....	104
Хавсралт 2. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан өөрчлөлтүүд.....	105

## УДИРТГАЛ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8.1.2 дахь заалт<sup>1</sup>, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.4, 16<sup>1</sup>.5.1 дэх заалтын<sup>2</sup> дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-өөс Монгол Улсын 2027-2029 оны дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг толилуульж байна.

Таамаглалыг боловсруулахдаа а) Гадаад эдийн засаг, геополитикийн нөхцөл байдал, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, эрэлтийн хандлага, б) Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдлын шинжилгээ, в) Макро эдийн засгийн загварын тооцоололд үндэслэсэн.

Гадаад эдийн засгийн нөхцөл байдлыг юуны өмнө геополитикийн нөхцөл байдал, хөрш орнуудын эдийн засаг, түүхий эдийн эрэлт хэрэгцээний цаашдын хандлагад суурилсан бол Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн судалгаа шинжилгээнд үндэслэн тодорхойлсон болно.

Гадаад, дотоод эдийн засгийн орчны хувьд геополитикийн нөхцөл байдал, Монгол Улсын эдийн засаг, гадаад худалдааны бүтэц, хандлагатай холбоотой тодорхой эрсдэлүүд байгааг анхаарах шаардлагатай хэмээн үзэж байна.

Гадаад нөхцөлийн хувьд дэлхийн эдийн засгийн өсөлтөд томоохон эерэг хандлага байхгүйгээс гадна Зүүн Ази, Номхон далайн бүсийн өсөлт, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарахтай холбоотой эрдсийн бүтээгдэхүүнд хамгийн гол сөрөг нөлөөтэй гэж үзэж байна. Мөн геополитикийн нөхцөл байдал хурцадмал болж байгаа нь дэлхийн эдийн засаг, эрдсийн бүтээгдэхүүний үнэд ихээхэн нөлөөлж буйг харгалзан үзэх шаардлагатай.

Дотоод эдийн засгийн хувьд хэдийгээр 2025 оны эдийн засаг өндөр өсөлттэй гарсан боловч ийм хэмжээний өсөлт цааш хадгалагдах боломж бага гэх нь үндэслэлтэй байна. Учир нь энэхүү эдийн засгийн өсөлтөд ХАА-н салбар, тодруулбал МАА-н салбарын нөлөөлөл өндөр байгаа нь суурь оны хүчтэй нөлөөлөлтэй байгаа явдал юм. Үүнээс гадна гадаад худалдааны нийт эргэлт, экспорт буурсан, төсвийн орлогын өсөлт саарсан, татварын орлого буурсан нь мөн анхаарах нэг гол хүчин зүйл болж байна. Экспортын бууралтад нүүрс голлох нөлөөг үзүүлсэн нь томоохон эрсдэл боловч зэсийн экспорт үүнийг нөхөж бүтцийн хувьд харьцангуй эерэг өөрчлөлт гарсныг дурдах хэрэгтэй. Гэсэн ч голлох эрдсийн бүтээгдэхүүний хэмжээ, үнийн таамаглал зөрүүтэй байхаас шалтгаалсан эрсдэл гадаад худалдааны хувьд тод ажиглагдаж байна.

Төлбөрийн тэнцлийн хувьд урсгал дансны алдагдлыг санхүүгийн дансаар нөхөх хандлага хэвээр үргэлжилж байгаа бөгөөд энэ тэнцвэр алдагдвал төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэх, валютын ханшид дарамт болох хандлагатай байна.

Төсвийн тогтвортой байдал, төсвийн эрсдэлийн хувьд анхаарах асуудлууд хэвээр байсаар байна. Энд төсвийн эрх зүйн орчин, төсвийн төлөвлөлт, таамаглал, төсвийн зарлагын өсөлт зэрэг голлох эрсдэлүүдийг дурдах шаардлагатай. Ялангуяа нэг салбараас эдийн засаг хүчтэй хамаарч байгаа үед төсвийн зардлын хэт тэлэлт эрсдэлтэй гэдгийг анхаарах цаг гэдгийг

<sup>1</sup> 8.1.2. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалын тооцоог хийж, жил бүрийн 03 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн болон эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

<sup>2</sup> 16<sup>1</sup>.5.1. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал боловсруулах;

дахин анхааруулах нь зүйтэй гэж үзнэ. Өрийн ДНБ-д эзлэх хувийн жин буурч байгаа ч өрийн үйлчилгээний зардал өсөж байгааг ч анхаарах хэрэгтэй.

Иймд гадаад, дотоод орчны хүчин зүйлсийг харгалзан өмнөх жилд өгч байсан гол дүгнэлт болох “нөхцөл байдал хэдийн таагүй болж эхлээд байна” гэсэн дүгнэлтээ “ эдийн засгийн өсөлт өндөр гарсан ч энэ нь дунд хугацаанд хадгалагдах боломж багатай” хэмээн сануулах шаардлагатай гэж үзлээ.

Макро эдийн засгийн таамаглалд DIGNAR (Debt, Investment, Growth, and Natural Resources) болон CAEM (Comprehensive Adaptive Expectations Model; IMF-CDC-CCAMTAC) загварыг гол суурь болгон ашигласан. DIGNAR нь Динамик Стохастик Ерөнхий Тэнцвэр (Dynamic Stochastic General Equilibrium DSGE)-ийн загвар бөгөөд уг загварыг ОУВС-аас байгалийн баялаг бүхий хөгжиж буй орнуудын макро эдийн засгийн судалгаа болон бодлогын үр нөлөөг шинжлэхэд зориулан хөгжүүлж байгаа тул бид энэ загварыг сонгон өөрсдийн таамаглалд ашигласан. Загвар хоёр төрлийн өрхийн аж ахуй, арилжааны болон арилжааны бус бүтээгдэхүүн (фирмүүд), байгалийн баялаг, Засгийн газар гэсэн бүтэцтэй, эдийн засгийн агентууд ирээдүйгээ харж ханамж, ашгаа хамгийн их байлгах аар рациональ сонголтыг хийдэг гэж үздэг.

CAEM нь Бодит, Мөнгөний, Сангийн, Гадаад сектор хоорондын холбоосыг динамик тэгшитгэлүүд ашиглан тодорхойлдог цогц загвар юм. Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт, үнэ, хэмжээний төлөв, таамаглалыг тооцоолохдоо өмнөх жилийн нэгэн адил ARIMA, BVAR, SVAR аргуудыг ашигласан бөгөөд энэ жилийн хувьд шинээр загварын итгэх завсрын төсөөллийг (fan chart) тооцож харуулав. Загварын үр дүн нь өнөөг хүртэл үргэлжилж ирсэн ерөнхий хандлага цаашид хадгалагдах тохиолдолд гарч болох төлөв, түүний эерэг сөрөг үр нөлөөг тодорхой харуулсан болохыг харгалзан төсвийн бодлогын зарим зөвлөмжийг тодорхой тусгах нь зүйтэй хэмээн үзлээ. Сүүлийн 3 жилийн дотоод эдийн засгийн нөхцөл байдал, ялангуяа ДНБ-д нөлөөлөх экспортын орлого, импортын өсөлтийн сааралт, хөдөө аж ахуйн огцом сэргэлт зэрэг хүчин зүйлс ихээхэн өндөр гүйцэтгэлтэй байсан, үүнтэй холбоотойгоор ТТБЗ болон олон улсын байгууллагын таамаглалаас ихээхэн өндөр гарсан 2025 оны эдийн засгийн өндөр өсөлт, шинээр үүсэж байгаа тодорхой бус байдлыг загварт шингээхэд амаргүй гэж бид үзэж байна.

Загварын тооцооллыг хийхдээ 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр УИХ-аар баталсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-д тусгагдсан 2027 оноос мөрдөгдөх татвар төлөгчдөд урамшуулал олгох тухай заалтын нөлөө, 2025 онд 12 дугаар сарын 30-ны өдөр Засгийн газраас өргөн мэдүүлээд байгаа татварын багц хуулийн өөрчлөлтийг харгалзсан хувилбаруудыг авч үзсэн. Энэ онцлог нөхцөл байдлаас шалтгаалж ТТБЗ-өөс 2027-2029 оны төсвийн төсөөллийг гаргахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын голлох үзүүлэлтүүдийг хоёр хувилбараар гарган хүргүүлж байна.

**МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТААМАГЛАЛ**

**МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,  
ТӨЛӨВ БАЙДЛЫН ТААМАГЛАЛ - 1**

№	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Төлөв байдлын таамаглал		
		2027	2028	2029
1	ДНБ-ий бодит өсөлт (хувь)	5.6	5.0	5.15
2	Нэрлэсэн ДНБ (их наяд төгрөг)	112.9	122.1	132.1
3	Инфляц (хувь)	7.2	7.0	6.7
4	Төсвийн орлого (ДНБ-д эзлэх хувь)	29.8	30.3	31.0
5	Татварын орлого (ДНБ-д эзлэх хувь)	27.0	27.4	28.0
6	Төсвийн зарлага (ДНБ-д эзлэх хувь)	31.8	32.3	33
7	Засгийн газрын өр (ДНБ-д эзлэх хувь)	42.3	44.8	45.1
8	Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт (хувь)	25.0	19.5	17.0
9	Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)	63.5	64.0	64.9
10	Хувийн хэрэглээний өсөлт (хувь)	3.8	4.0	4.5
11	Урсгал дансны алдагдал (ДНБ-д эзлэх хувь)	1.3	-0.1	-2.2

**ТӨЛӨВ БАЙДЛЫН ТААМАГЛАЛ – 2**

*/Зарим хувьсагч дээр татварын өөрчлөлтийн нөлөөг тооцсон хувилбар/*

№	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Төлөв байдлын таамаглал		
		2027	2028	2029
1	ДНБ-ий бодит өсөлт (хувь)	5.5	5.3	5.3
2	Нэрлэсэн ДНБ (их наяд төгрөг)	111.4	121.0	131.2
3	Инфляц (хувь)	7.3	6.9	6.7
4	Төсвийн орлого (ДНБ-д эзлэх хувь)	26.8	28.5	30.2
5	Татварын орлого (ДНБ-д эзлэх хувь)	24.0	25.7	27.4
6	Төсвийн зарлага (ДНБ-д эзлэх хувь)	28.8	30.5	32.2
7	Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт (хувь)	25.8	20.7	17.3
8	Хувийн хэрэглээний өсөлт (хувь)	4.5	3.5	4.1
9	Урсгал дансны алдагдал (ДНБ-д эзлэх хувь)	2.7	0.4	-2.2

Зөвлөл хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд өргөн цар хүрээтэй таамаглал боловсруулж, эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг сонгон дээрх хоёр хүснэгтэд тусгалаа.

ТТБЗ нь төсвийн тогтвортой байдлыг хангуулах үүргийн дагуу дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахтай холбогдуулан баримтлах дараах бодлогын зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Эдийн засгийн нөхцөл байдал, ирээдүйн эрсдэлийг харгалзан мөчлөг дагасан, төсвийн орлогыг дагуулж зарлагыг хэт тэлсэн бодлого хэрэгжүүлэх нь эрсдэлтэй гэдгийг анхаарч төсвийн бодлогын зөв сонголт хийх;
- Дунд хугацаанд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг бууруулж буй Засгийн газрын бодлого нь төсвийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулах, төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлэх гол үндэс болох тул одоо хүчин төгөлдөр мөрдөж буй ДХТХМ-д тусгагдсан төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийг 2027 онд 30 хувь, 2028 онд 28.6 хувь, 2029 онд 28 хувьд хүргэж Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нийцүүлэх;
- Төсвийн алдагдлыг үе шаттайгаар бууруулах бодлогыг хүчин төгөлдөр мөрдөж буй ДХТХМ-д тусгагдсан хэмжээнд үргэлжлүүлж нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 2027 онд -0.8 хувь, 2028 онд 0.4 хувь, 2029 онд 0 хувь хүргэх байдлаар төлөвлөх;
- Тооцоолол, загварын зарим үр дүнгээс уул уурхайн салбарын хувьд эерэг өөрчлөлт гарч сэргэлт бий болох магадлалтай, мөн экспортын бүтэц сайжирч үнэ болон хэмжээний нөлөөлөл нь орлогыг өсгөж болох ч төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2023-2024 оны өндөр түвшинд хүрэх магадлал бага байгаа тул эрсдэлийг бууруулах үүднээс мөчлөг сөрсөн бодлогыг бодитой хэрэгжүүлэх;
- Татварын хууль, Ашигт малтмалын тухай хууль зэрэг эдийн засаг, төсвийн орлогод ихээхэн нөлөөтэй хууль эрх зүйн орчны өөрчлөлтийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бодитой тооцож төсвийг төлөвлөх шаардлагатай.

ТТБЗ-ийн зүгээс эдийн засгийн орчны шинжилгээ, загварын таамаглалд үндэслэсэн эдгээр зөвлөмж нь төсвийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийг бууруулахад бодитой нөлөөлөх хүчин зүйл гэж үзэж байна. Иймд энэхүү тайланд тусгагдсан шинжилгээ, таамаглал, зөвлөмж нь бидний зүгээс хүргүүлж буй ДХТХМ-ийг боловсруулахад ашиглах нэгдмэл баримт гэдгийг дурдах нь зүйтэй.

## НЭГ. ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН НӨХЦӨЛ

### 1.1. ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, ГЕОПОЛИТИКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Дэлхийн эдийн засгийн өсөлт ойрын жилүүдэд огцом хурдацтай тэлэхээс илүүтэй харьцангуй тогтуун боловч эмзэг хандлагатай үргэлжлэх суурь нөхцөл давамгайлж байна.

ОУВС-гийн 2026 оны 1 дүгээр сарын “Дэлхийн эдийн засгийн төлөв” тайлангийн шинэчлэлтэд дэлхийн эдийн засгийн өсөлт 2026 онд 3.3 хувь, 2027 онд 3.2 хувь байна гэж төсөөлсөн бөгөөд өсөлтийг технологийн хөрөнгө оруулалт, санхүүгийн нөхцөл, хувийн хэвшлийн дасан зохицол дэмжих боловч худалдааны бодлогын өөрчлөлт, тодорхойгүй байдал, геополитикийн эрсдэл зэрэг хүчин зүйлс нь өсөлтийн эрсдэлийг өндөр түвшинд хадгална гэж үзсэн байна. Ийнхүү дэлхийн аль нэг өнцөг буланд болж байгаа улс төр, геополитикийн тодорхойгүй үйл явдлууд ирэх жилүүдэд ч тохиож болзошгүй гэж олон улсын ажиглагчид, судлаачид үзэж байгаа тул ирэх жилүүдийн эдийн засгийн өсөлтийн таамаглалыг боловсруулахад ихээхэн анхаарал болгоомжтой хандах шаардлага тулгарч байна.

Дэлхийн банкны 2026 оны “Дэлхийн эдийн засгийн хэтийн төлөв” тайланд мөн адил 2026–2027 онд дэлхийн өсөлт ерөнхийдөө тогтвортой байх боловч Зүүн Ази, Номхон далайн бүсийн өсөлт 2026 онд 4.4 хувь, 2027 онд 4.3 хувь болж саарах, үүний дотор БНХАУ-ын өсөлт 2026 онд 4.4 хувь, 2027 онд 4.2 хувь болж буурах төсөөлөл туссан нь Монгол Улсын экспортын гол зах зээлд бүтцийн сааралт үргэлжлэх суурь нөхцөлийг илэрхийлж байна. Ийм нөхцөлд 2028–2029 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2027 оны ойролцоо түвшинд хадгалагдах суурь таамаглал нь бодитой боловч худалдааны бодлогын өөрчлөлт, геополитикийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдлаас шалтгаалан өсөлтийн хэлбэлзэл нэмэгдэх магадлал өндөр байна.

Монгол Улсын эдийн засагт 2027–2029 онд гадаад орчноос дамжин нөлөөлөх хамгийн хүчтэй суваг нь түүхий эдийн үнэ, ялангуяа нүүрс, зэс, төмрийн хүдрийн эрэлт, үнэ ханш, мөн БНХАУ-ын дотоод эрэлт ба үйлдвэрлэлийн мөчлөг хэвээр байна.

Дэлхийн банкны “Түүхий эдийн зах зээлийн төлөв” тайланд нийт түүхий эдийн үнэ 2025–2026 онд сулрах хандлагатай бөгөөд аж үйлдвэрийн түүхий эдүүдээс төмрийн хүдрийн үнэ буурах, цаашид тогтворжилт удаашрах хандлагатай байгааг тэмдэглэсэн нь БНХАУ-ын ган, барилгын мөчлөг сул байх үед Монгол Улсын төмрийн хүдэр, коксжих нүүрсний эрэлт, үнэ ханшид доош чиглэсэн дарамт үүсгэх эрсдэлийг илтгэнэ.

Харин зэс зэрэг цэвэр эрчим хүчний шилжилттэй холбоотой суурь металлын хувьд дунд хугацаанд тогтворжилт, тодорхой нөхцөлд өсөлтийн боломж хадгалагдаж байгаа нь Монгол Улсын зэсийн экспортын орлогын тогтвортой байдалд харьцангуй дэмжлэг үзүүлэх магадлалтай байна.

### 1.2. ХӨРШ ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

#### БНХАУ-ын эдийн засгийн өнөөгийн байдал


Хятад улс таван жилийн төлөвлөлтийн тухай хуулиа илүү сайжруулан боловсруулж баталлаа. Уг хуульд үндэсний хөгжлийн төлөвлөгөө гэдгийг дараах байдлаар тодорхойлон тусгажээ. Үүнд:

- Үндэсний хөгжлийн төлөвлөгөө бол төлөвлөж буй цаг хугацаанд социалист нийгмийг илүү сайтар төгөлдөржүүлэх үе шаттай арга хэмжээний төлөвлөгөө юм. Энэхүү төлөвлөгөөнд улс орны хүрэхээр зорьж байгаа стратегийн зорилт, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүд, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой чиглэл, дүрэм журам багтана.
- Үндэсний хөгжлийн төлөвлөгөө нь улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтууд, зах зээлийн зохицуулалт, засаглал, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах зэрэг асуудлаар төр засгийн бүхий л түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний нийлбэр цогц юм.

БНХАУ 2021-2025 онд хэрэгжүүлэхээр дэвшүүлэн тавьсан 14 дүгээр таван жилийн төлөвлөгөөнд туссан нийгэм, эдийн засгийн хөгжлийн зорилтуудаа амжилттай биелүүлжээ. Гэсэн ч тус улсын эдийн засгийн өсөлт саарч, хүн амын тоо ихээхэн буурч, өндөр настны эзлэх хувийн жин нэмэгдэх зэрэг зарим бэрхшээлтэй асуудлууд тулгарсаар байна.

2025 оны тухайд тус улс жилийн эдийн засгийн өсөлтийг 5 хувьд хүргэх зорилт тавьсан ч тухайн оны 3, 4-р улиралд өсөлтийн хурд нь саарч 4-р улирлын өсөлт 4.5 хувьд хүрчээ.


Зураг 1. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт /ДНБ-ий өсөлт, улирлаар/, хувиар



Эх сурвалж: China-briefing.com

Эндээс БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн өндөр түвшин саарч байгаа нь ажиглагдаж байна. 1990-2010 оны БНХАУ-ын эдийн засгийн өндөр өсөлтийн үе өнгөрсөн боловч 1978 онд тухайн цаг үеийн БНХАУ-ын удирдагч Дэн Сяопины хэрэгжүүлж эхэлсэн нээлттэй хаалганы бодлогын үр нөлөөгөөр Хятад улсын эдийн засаг өнгөрсөн 35 жилд өндөр хурдтай өргөжин тэлж, орлогын түвшнээр эдүгээ өндөр орлоготой улс орнуудын эгнээнд багтахуйц хэмжээнд хүрээд байна. Ийнхүү нээлттэй хаалганы бодлого баримталж, гадаадын хөрөнгө оруулалтыг илүү чөлөөтэй оруулсан, хувийн хэвшлийг дэмжих бодлого хэрэгжүүлсэн, таван жилийн төлөвлөлтийг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлсний үр дүнд 1980 онд 306.0 тэрбум ам.доллаар (459.5 тэрбум юань) хэмжигдэж байсан Хятадын эдийн засаг 40 жилийн хугацаанд 66.6 дахин өсөн нэмэгдэж 2025 оны байдлаар 20.4 их наяд ам.долларт (140.0 их наяд юань) хүрлээ.


Зураг 2. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт /1980-2025 он/, хувиар



Эх сурвалж: MGM Research institute, ADB

Хятадын эдийн засгийн өнөөгийн өсөлтийг бүрдүүлэхэд сүүлийн жилүүдэд тус улсын баримталж ирсэн аж үйлдвэр, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого болон бусад улс орнуудтай хийж байгаа гадаад худалдааны эргэлт ихээхэн хурдтай өсөн нэмэгдэж ирсэн нь нааштай нөлөө үзүүлжээ.

Зураг 3. БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн таамаглал



Эх сурвалж: IMF, 2026

Гэвч Хятад улсын зүгээс эдийн засгийн хувьд цаашид анхаарах хэд хэдэн асуудал үүсээд байгааг тус улсад өнгөрсөн онд ажилласан ОУВС-гийн ажлын хэсгийн тайланд дурджээ. Саяхан буюу 2026 оны 2 дугаар сард ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн хурлаар Хятад улсын эдийн засгийн төлөв байдлын талаарх ОУВС-гийн ажлын хэсгийн “2025 Article IV consultation-press release. Staff report and Statement by the Executive director for the People’s Republic of China” тайланг хэлэлцэх явцад хэд хэдэн захирал “Хятад улс цаашид хэрэглээг түлхүү урамшуулж, хөрөнгө оруулалт нь “экспортод суурилсан эдийн засгийн загвараас хэрэглээнд тулгуурласан загварт шилжих” шаардлагатай болохыг онцолсон.

Хятад улсын хувьд ийнхүү хөгжлийн загварын шилжилт хийх үйл явц ойрын жилүүдэд үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд энэ явцад тус улсын эдийн засгийн өсөлтийн хурдац

тодорхой хэмжээгээр саарч болзошгүй байна. Энэ талаар олон улсын байгууллагуудын хувьд ч тодорхой байр суурийг илэрхийлж байгаагийн нэг нь ОУВС юм. ОУВС-гийн ажлын хэсгийн өнгөрсөн оны эцсээр боловсруулан гаргасан, 2026 оны 2 дугаар сард ОУВС-гийн Захирлуудын Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн БНХАУ-ын эдийн засаг, төсөв, санхүүгийн байдлын талаарх тайланд тусгагдсан макро эдийн засгийн тооцооллоос үзвэл тус улсын эдийн засгийн өсөлт дунд хугацаанд ч мөн саарч 2029 он гэхэд 3 хувьд хүрч болзошгүй гэж таамагласан байна.

Ийнхүү БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 2030 он хүртэл нэлээд эрчимтэй саарахаар таамаглаж байгаа бөгөөд үүнийг дагаад хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлт удааширна гэсэн хүлээлттэй байгаа төдийгүй эерэг үзүүлэлт нь инфляц харьцангуй буурах боломжтой гэж үзэж байгаа явдал юм.

#### Хүснэгт 1. БНХАУ-ын эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийн таамаглал

Үзүүлэлт	2025	2026	2027	2028	2029	2030
Бодит ДНБ-ий өсөлт (хувь)	5.0	4.5	4.0	3.9	3.7	3.4
Үйлдвэрлэлийн зөрүү (хувь)	-1.0	-0.8	-0.5	-0.2	0.0	0.0
Инфляц (дундаж, хувь)	0.0	0.9	1.5	1.8	1.9	2.0
Суурь инфляц (дундаж, хувь)	0.8	1.1	1.5	1.8	1.9	2.0
Урсгал данс (ДНБ-д эзлэх хувь)	3.3	3.1	2.8	2.5	2.3	2.2
Хуримтлагдсан өр (ДНБ-д эзлэх хувь) <sup>3</sup>	126.6	135.3	141.5	146.2	150.0	153.7

Эх сурвалж: IMF, 2026

БНХАУ-ын ирэх жилүүдийн эдийн засгийн өсөлтийн талаарх Олон улсын байгууллагууд, судалгааны байгууллагуудын боловсруулан гаргасан таамаглалуудыг нэгтгэн дараах хүснэгтэд харууллаа.

#### Хүснэгт 2. БНХАУ-ын ДНБ-ий өсөлт, түүний төсөөлөл

№	Үзүүлэлт	2024	2025	2026f	2027f	2028f
1	Дэлхийн банк (China Economic update 2025)	5.0	5.0	4.4	4.2	-
2	ОУВС (China Article IV staff report)	5.0	5.0	4.5	4.0	3.9
3	Азийн хөгжлийн банк (Asian Development Outlook December 2025)	5.0	4.7	4.3	-	-
4	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD Global Economic Outlook December 2025)	5.0	5.0	4.4	4.3	-
5	НҮБ-ийн Ази, номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс (UNESCAP) (The World Economic Situation and Prospects 2025)	5.0	4.9	4.6	4.5	-
6	BVA Research Institute (China Economic Outlook 2025)	5.0	4.8	4.5	4.0	-

<sup>3</sup> "1/ Хуримтлагдсан өрийн дүнд орон нутгийн санхүүжилт болон төсвөөс гадуурх Засгийн газрын бусад санхүүжилт орно."

7	Хятадын Хөгжил шинэтгэлийн хороо, Сангийн яам	5.0	5.0	4.5-5.0	-	-
8	БНХАУ-ын ШУА-ийн харьяа Нийгмийн шинжлэх ухааны академи ( <i>Prospective research on China's economic development for the 15th five year plan</i> )	-	-	4.5-4.75	4.5-4.75	4.5-4.75

Эх сурвалж: Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ОУВС, ЭЗХАХБ, Хятадын Хөгжил шинэтгэлийн хороо, Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академи, BVA Research institute.

Энэ бүхнээс үзвэл цаашид БНХАУ-ын гангийн үйлдвэрлэл болон экспорт саарах, улмаар коксжих нүүрсний эрэлт буурах эрсдэл оршиж байна. БНХАУ-ын зүгээс эдийн засгийн өсөлтийн энэхүү буурах хандлагыг саармагжуулах алхмуудыг хийж байна. Хятад улсын 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжлийн талаар “Хятад улсад 2026 онд эдийн засгийн өсөлтийн зорилтыг сүүлийн 35 жилд анх удаа 5 хувиас доош бууруулж 4.5–5.0 хувь орчимд байх зорилтыг дэвшүүлж байна. Мөн улсын төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 4 орчим хувьтай байлгана” гэсэн зорилтыг тусгажээ.

Өнгөрсөн 20 гаруй жилийн туршид өргөжин тэлж, өндөр өсөлттэй явж ирсэн БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах нь тус улсын ган төмөрлөг, нүүрсний хэрэглээг бууруулж болзошгүй юм. Өнгөрсөн 2025 оны 8 дугаар сард БНХАУ-ын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо болон бусад 5 яам хамтран тус улсын гангийн үйлдвэрлэлийн ашигт ажиллагааг сайжруулах, үйлдвэрлэлийг тогтворжуулахад чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлан гаргаж байсан. Тус улсын гангийн үйлдвэрлэлийн хэмжээ сүүлийн 4 жилийн туршид аажим саарч буй юм.

Олон улсын улс төр, геополитикийн нөхцөл байдал хурдан өөрчлөгдөж, тогтворгүй байгаа энэ цаг үед БНХАУ-ын гадаад худалдаа, экспорт саарах эрсдэлтэй болохыг тус улсын судлаачид анхааруулсаар байна.

БНХАУ болон АНУ-ын хооронд яригдсаар ирсэн гадаад худалдааны асуудлууд, тарифын асуудал нэг мөр болоогүй, АНУ-ын Засгийн газрын зүгээс БНХАУ-ын импортын бараанд өндөр татвар тогтоох тухай удаа дараа мэдэгдэж ирсэн. Саяхан АНУ-ын Дээд шүүхээс гаргасан шийдвэрийн дагуу Ерөнхийлөгч Дональд Трампын тогтоосон өндөр татваруудыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзсэн ч АНУ-ын Сангийн яамны зүгээс бүхий л улс орнуудын импортын бараанд 15 хувийн татвар тогтоох асуудлыг боловсруулаад байгаагаа мэдэгдсэн.

Хэрэв ирэх 4 дүгээр сард АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трампын БНХАУ-д хийхээр товлогдсон айлчлал ямар нэг шалтгаанаар цуцлагдахгүй нөхцөлд энэхүү айлчлалын явцад хоёр улсын төрийн тэргүүн нар гадаад худалдаа, тарифын асуудлаар ойлголцолд хүрч чадах эсэхээс цаашдын олон зүйл хамаарахаар байна.

Гадаад, дотоодын олон талын ийм эрсдэлтэй нөхцөлд БНХАУ эдийн засгийн өсөлтөө сааруулан тооцож байгаа нь асуудалд бодитой хандаж байгаагийн илрэл юм. Гагцхүү энэ удааширч байгаа өсөлт нь тус улсын эдийн засгийн аль салбарт илүү нөлөөлж болохыг бид олон талаас нь урьдчилан судлах, таамаглал хийх шаардлага үүсэж байна.

БНХАУ-ын 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд тусгагдсан хөгжлийн үндсэн зорилтуудын тухайд:

Таван жилийн төлөвлөгөөнд тус улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, чанартай өсөлтөд хүргэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд ирэх 5 жилийн хугацаанд 6 үндсэн салбарын хүрээнд 109 томоохон (буюу мега) төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Үүнд:

### Хүснэгт 3. БНХАУ-ын хөгжлийн үндсэн зорилтууд

№	БНХАУ-ын хөгжлийн үндсэн зорилтууд
1	Шинэ чанартай өсөлтийг хангаж, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 28 том төсөл хэрэгжүүлнэ. Аж үйлдвэрлэлийн салбарын өрсөлдөх чадварыг бэхжүүлэх, аж үйлдвэрийн шинэ дэд салбарыг хөгжүүлэх, шинжлэх ухаан технологийн тэргүүлэх чиглэлүүдийг хөгжүүлж ололт амжилтыг нэвтрүүлэх, инновацын чадавхыг улам бэхжүүлэхтэй холбоотой төслүүд багтсан.
2	Дэд бүтцийн сүлжээг илүү сайтар хөгжүүлж, орчин цагийн шаардлагыг хангах түвшинд хүргэх зорилтын хүрээнд 23 төсөл хэрэгжүүлнэ. Үндэсний олон талт, олон хэлбэрийн тээвэрлэлтийн сүлжээг хөгжүүлэх, эрчим хүчний шинэ системийг хөгжүүлэх, дэд бүтцийн шинэ төрлүүдийг хөгжүүлэхтэй холбоотой төслүүд багтсан.
3	Хот ба хөдөөгийн хөгжлийг харилцан уялдаатай хангах зорилтын хүрээнд 9 төсөл хэрэгжүүлнэ. Шинэ хот барьж байгуулах, ХАА, орон нутгийн хөгжлийг түргэтгэхэд чиглэсэн төслүүд энд багтсан.
4	Хүн амын тав тухтай амьдрах орчныг хангах зорилтыг хангах хүрээнд 25 төсөл хэрэгжүүлнэ. Өндөр түвшний боловсролын тогтолцоог хөгжүүлэх, Эрүүл Хятад улс санаачилгыг улам эрчимжүүлэх, өндөр настны асаргаа, сувилгаа, хүүхдийн асаргаа болон нийгмийн халамжийн тогтолцоог илүү сайжруулахад чиглэсэн төслүүд энд багтсан.
5	Карбоны ялгаруулалт багатай, ногоон хөгжлийн хангах зорилтын хүрээнд 18 төсөл хэрэгжүүлнэ. Карбоны ялгаруулалтыг бууруулах, нүүрс хүчлийн давхар ислийн ялгаруулалтын оргил түвшинээс цааш бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд чиглэсэн төслүүд энд багтсан.
6	Нэн чухал салбаруудын аюулгүй байдлыг хангахад чиглэсэн 6 төсөл хэрэгжүүлнэ. Үүнд хүнсний болон эрчим хүчний аюулгүй байдлыг хангахтай холбоотой төслүүд багтсан.

### ОХУ-ын эдийн засгийн өнөөгийн байдал

Украинд явуулж байгаа дайны үйл ажиллагаа, олон улсын эдийн засгийн хориг арга хэмжээний улмаас ОХУ-ын эдийн засгийн өсөлт саарч, төсвийн алдагдал нь ихээхэн нэмэгдэж байна. Орос-Украины дайны өмнөх жил эдийн засгийн өсөлт нь 5.6 хувьд хүрч байсан Оросын эдийн засаг 2025 оны байдлаар 1.0 орчим хувьд хүрч эрс саарсан. Олон улсын байгууллагуудын шинжээчдийн үзэж буйгаар энэ 2026 онд тус улсын эдийн засгийн өсөлт 0.6 -0.8 орчим хувьд хүрэх магадлалтай гэж үзэж байна.

Өнгөрсөн 2025 оны намар ОХУ-ын Төрийн Думын хуралдаанаар хэлэлцэн баталсан тус улсын 2026 оны төсөвт батлан хамгаалах салбар, цэрэг дайны үйл ажиллагаанд зарцуулах төсвийг ихээхэн нэмэгдүүлсэн. Ингэснээр 2026 оны төсвийн 30 орчим хувийг батлан хамгаалах салбарын зардал эзлэх болж байна.

ОХУ-ын улсын төсвийн алдагдал 2025 оны байдлаар 5.6 их наяд рубльд буюу ДНБ-ий 2.6 хувьд хүрч өссөн. Мөн 2026 батлагдсан төсөвт төсвийн орлогыг 40.3 их наяд рубль, төсвийн зарлагыг 44.1 их наяд рубль, төсвийн алдагдлыг 3.8 их наяд рубль буюу ДНБ-ий 1.6 хувьтай

тэнцүү байхаар төсөөлсөн байна. Тус улсын төсвийн алдагдлыг ирэх 2027 онд 3.2 их наяд рубль, 2028 онд 3.5 их наяд рубльтэй тэнцүү байхаар төсөөлж байна.

ОХУ-ын эсрэг авч хэрэгжүүлж байгаа өрнөдийн орнуудын хориг арга хэмжээ үргэлжилж, тус улсын газрын тос, шатдаг хийн экспорт ихээхэн хэмжээгээр буурч байгаа нь төсвийн орлогыг төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлж чадахгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Эдийн засгийн хоригийн улмаас Европын Холбооны гишүүн орнууд төдийгүй саяхан Энэтхэг улс ч гэсэн ОХУ-аас худалдан авах газрын тосны импортыг бууруулах амлалт авсан. Ираны асуудлаас хамаарч нэг сарын хугацаатай ОХУ-аас газрын тос худалдан авах боломжтой гэж АНУ-ын Сангийн яамнаас саяхан мэдэгдсэн.

ОХУ-ын газрын тосны экспорт буурч хориг арга хэмжээтэй байгаа нь Монгол Улсад нийлүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний үнэ ханш ойрын хугацаанд тогтвортой байх боломжийг олгож байна.

Ирэх 2 жилийн хугацаанд Сайншандын газрын тос боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулахтай холбоотой олон талын бэлтгэл ажлыг хангах, эргэлтийн хөрөнгө бүрдүүлэх, газрын тосны бүтээгдэхүүнийг тээвэрлэх вагон цистерн болон дотоодын тээвэрлэлтийн сүлжээг эртнээс сайтар бэлтгэх шаардлагатай. Ийнхүү дотоодын газрыг тос боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхнээсээ саадгүй, үйл ажиллагаа нь зөв зүгширч чадвал Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгагдсан газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангах гэсэн зорилт хэрэгжиж эхлэх болно.

Дэлхийн дахинд, олон улсын түвшинд эгзэгтэй халуун цэгүүд цөөнгүй, үүний дотор Азийн бүс нутагт Өмнөд Хятадын тэнгис, Тайваны хоолой, Умард Солонгосын цөмийн зэвсэглэлийн гэсэн эрсдэлтэй, эгзэгтэй цэгүүд байгааг бид дунд, урт хугацааны хөгжлийн төлөвлөлтийн явцад байнга анхаарч, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээг урьдчилан төлөвлөж, хэрэгжүүлж байх шаардлагатай.

---

### 1.3. ТҮҮХИЙ ЭДИЙН ЭРЭЛТ ХЭРЭГЦЭЭНИЙ ЦААШДЫН ХАНДЛАГА

Дээр дурдсанчлан ирэх жилүүдэд Хятадын эдийн засгийн хөгжлийн загвар өөрчлөгдөх, өсөлтийн хурд саарах, олон улсын геополитикийн нөхцөл байдлаас хамаарсан эрсдэлтэй тулгарч болзошгүй байна.

БНХАУ-д жил тутамд 15.0-16.0 тэрбум ам долларын түүхий эдийг экспортолж байгаа энэхүү орлогоос ихээхэн хамааралтай Монгол Улсын хувьд Хятад улсын эдийн засаг, зах зээлд гарч буй өөрчлөлтийг тухай бүрд нь анхааралтай судалж байх нь нэн чухал.

Хятад улсын 15 дугаар таван жилийн төлөвлөгөөнд тус улсын эдийн засгийн өсөлтийн зорилтыг өмнөх оны түвшнээс 0.5 пунктээр бууруулж 4.5 -5.0 орчим хувьд байна гэж тусгаж байна. Үүний зэрэгцээ энэ зорилтод хүрэхийн тулд 6 гол салбар хүрээнд хэрэгжүүлэх 109 том төслөөс аж үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын 51 төсөл нь өнгөт болон хар төмөрлөгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнтэй ямар нэг байдлаар холбоотой байж болзошгүй. Эдгээр төслийг хэрэгжүүлэх явцад Хятадын Засгийн газраас ихээхэн хэмжээний урт хугацааны бонд гаргаж, хөрөнгө санхүүгийн хувьд дэмжлэг үзүүлэхээр тооцож байна.

Иймээс 2026-2027 оны тухайд Хятад улсын гангийн үйлдвэрлэл 2025 оны түвшинд тогтвортой байж чадах уу гэдэг нь маш чухал асуудал болно. Гангийн үйлдвэрлэл

тогтвортой байх эсэхээс хамаарч Хятад улсын коксжих нүүрсний эрэлт хэрэгцээ ямар түвшинд байх нь тодорхой болох юм.


БНХАУ-ын тухайд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай улс бөгөөд бүхэлдээ улс орны хувьд ч муж улсууд, том хотуудын хувьд ч төвлөрсөн байдлаар эдийн засаг, аж үйлдвэрлэл, дэд бүтцийн хөгжлийг төлөвлөж байгаа гэдгийг бид маш сайн анхаарч байх ёстой.

### Эрдсийн бүтээгдэхүүний зах зээл, үнийн төлөв байдал, цаашдын хандлага

Хятад улсын эдийн засгийн өсөлт удааширч, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй том төслүүдийн хэрэгжилт удааширах, хүндрэл учрах нөхцөлд тус улсын гангийн үйлдвэрлэл цаашид үргэлжлэн буурах эрсдэлтэй. Энэ нөхцөлд ирэх жилүүдэд коксжих нүүрсний үнэ өнөөгийн түвшинд буюу түүнээс доогуур байх магадлал өндөр байна.

Үүнээс гадна түүхий эдийн зах зээлийн үнийн талаарх Дэлхийн банкны таамаглалаас харвал дараагийн жилүүдэд нүүрсний зах зээлийн хувьд эерэг өөрчлөлт гарах магадлал багатай байдал ажиглагдаж байна.

Зураг 4. Түүхий эдийн үнийн төсөөлөл /эрчим хүч, ХАА, уул уурхайн салбарт/



Эх сурвалж: <https://blogs.worldbank.org/en/developmenttalk/the-commodity-markets-outlook-in-eight-charts0>

Түүхий эдийн хувьд эрдсийн бүтээгдэхүүн төдийгүй ХАА, эрчим хүчний салбарын хувьд дунд хугацаанд томоохон эерэг өөрчлөлт гарахгүй байдалтай харагдаж байна. Бидний гол экспортын бүтээгдэхүүн болох нүүрсний хувьд дэлхийн банкны таамаглаж буй байдлаас харвал 2021-2024 оны нүүрсний зах зээлийн томоохон сэргэлт үнийн өндөр байдал цаашид үргэлжлэхгүй, дунд хугацаанд харьцангуй тогтвортой байх хандлага харагдаж байна. Харин зэсийн хувьд эерэг дүр зурагтай байгаа бол алтны үнийг тогтвортой байна хэмээн үзсэн нь бидний хувьд анхаарах асуудал юм.

Хүснэгт 4. Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн таамаглал

Түүхий эд	Нэгж хэмжээ	2023	2024	2025f	2026f	2027f
Нүүрс (Австрали)	(ам.доллар/тн)	172.8	136.1	107.0	100.0	105.0
Зэс	(ам.доллар/тн)	8,490	9,142	9,700	9,800	10,000
Алт	ам.доллар/трой унц)	1,943	2,388	3,400	3,575	3,375
Мөнгө	ам.доллар/трой унц)	23.4	28.3	38.0	41.0	37.0

Эх сурвалж: <https://www.worldbank.org/en/research/commodity-markets>

Үүнээс гадна Олон Улсын эрчим хүчний агентлагийн тайланд нүүрсний эрэлт ойрын ирээдүйд огцом буурахгүй байж болох ч дунд урт хугацаанд анхаарах шаардлагатай дараах асуудлуудыг дурдсан байна. Үүнд:

- Дэлхийн эрчим хүчний эрэлт өсөж байгаа боловч эрэлтийн 80 орчим хувь нь нарны эрчим хүчнээс хамаарна. Гэхдээ Азийн бүс нутагт бий болох шинэ эрэлтийн бүс нь дотоодын нүүрсний нөөц, нефть, шингэрүүлсэн байгалийн хийнээс хамаарч байдаг.
- Эрчим хүчний нүүрсний эрэлтийн хамгийн гол нь Хятад бөгөөд дараа нь Энэтхэг, Индонез болон Зүүн Өмнөд Азийн бусад орнууд ордог. Дэлхийн нүүрсний эрэлтийн тал орчим хувийг эдгээр эдийн засагт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд ашигладаг бөгөөд нүүрсний хэтийн төлөв нь тэдний цахилгаан эрчим хүчний хэрэгцээ, сэргээгдэх эрчим хүчний одоогийн эрч хүч тогтвортой байгаа эсэх, хийн үнэ өрсөлдөхүйц хэмжээнд хүрч чадах эсэхээс ихээхэн хамаардаг. Энэ бүс нутагт сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлын нэмэгдэл эрчимтэй явагдаж байгаа нь нүүрсний эрэлтэд нөлөөлж болох түвшинд байна.
- Эрчим хүчний нүүрсний экспорт коксжих нүүрсний экспортоос илүү хурдацтай бууралттай байна. Жишээлбэл, 2035 он гэхэд уурын нүүрсний экспорт Колумбид 85 гаруй хувиар, Индонезид 45 орчим хувиар буурсан бол Монголын коксжих нүүрсний экспорт 25 гаруй хувиар буурсан байна. Австралийн уурын нүүрсний экспорт бараг 20 хувиар буурсан бол коксжих нүүрсний экспорт 5 орчим хувиар өссөн байна. Мозамбик бол нүүрсний экспортыг мэдэгдэхүйц нэмэгдүүлсэн цөөхөн орны нэг бөгөөд шинэ уурхайн хөгжил эрчимжиж байгаатай холбогдуулан 2035 он гэхэд 15 сая тонноос дээш хэмжээнд хүрч өснө.
- Дэлхийн хамгийн том эрчим нүүрс экспортлогч Индонезийн хувьд дотоодын нүүрсний эрэлт бараг 45 хувиар өссөн ч CPS-д 2024-2035 онд үйлдвэрлэл 20 орчим хувиар буурсан байна.

Дэлхийн хамгийн том коксжих нүүрс экспортлогч Австралийн үйлдвэрлэл 2035 он хүртэл 15 хувиар, дотоодын эрэлт 45 хувиар буурах төлөвтэй байгаа бөгөөд голчлон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд ашигладаг эрчим хүчний нүүрсний эрэлт буурах төлөвтэй байна. Орос, Монголын гол экспортын бүс нутаг болох Хятад улс импортоо бууруулснаар дагаад үйлдвэрлэл буурахаар байна.

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА, УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ


Монгол Улсын 2025 оны эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр 6.8 хувьтай гарсан нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ) болон олон улсын байгууллагуудын таамаглалаас ихээхэн өндөр үзүүлэлт юм. ТТБЗ 2025 оны эдийн засгийн өсөлтийг 5.4 хувьтай гарна гэж таамаглаж байсан бол Олон улсын байгууллагууд мөн энэ түвшинтэй ойролцоо буюу 5.5 хувь хэмээн таамаглаж байсан. Монгол Улсын эдийн засгийн хувьд өндөр өсөлттэй гарах тохиолдол олон байдаг ч энэ өсөлтийн шалтгаан юу болох, цаашид тогтвортой хадгалагдаж чадах эсэх нь дунд хугацааны таамаглалын хувьд илүү чухал асуудал юм. Энэ хэсэгт эдийн засгийн түүхэн болон өнөөгийн нөхцөл байдалд суурилан Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн хандлагыг тодорхойлохыг зорилоо.

### 2.1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

#### Эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засгийн хувьд хамгийн гол зүйл нь өсөлтийн тогтвортой бус байдал юм. Тогтвортой өсөлт бий болгож чадаагүй явдал нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэж чадахгүйд хүргэсэн нь бидний гол асуудал гэдгийг Зөвлөл олон таамаглал, дүгнэлтдээ дурдаж байгаа билээ.

Зураг 5. Монгол Улсын эдийн засгийн өсөлт /1990-2025 он/, хувиар



Эх сурвалж: УСХ, 2026


Энэхүү өсөлтийн хэт савлагаатай байдал эдийн засгийн таамаглал, өсөлтийн өөрчлөлтийг бий болгож байгаа бөгөөд үүнийг харьцангуй тодорхой болгохын тулд эдийн засгийн өсөлтийн бүтэц, эдийн засгийн бүтцийн асуудлыг тодруулах зайлшгүй шаардлагатай юм. Ингэснээр өнгөрсөн цаг хугацааны, өнөөгийн эдийн засгийн өсөлтийн нөхцөл байдал, төлөвийг харах суурь болох боломжтой.

2025 онд эдийн засаг 6.8 хувийн урьдчилсан гүйцэтгэлтэй гарсан нь сайн үзүүлэлт боловч энэ үзүүлэлт нь цаашид хэрхэн хадгалагдах вэ? гэсэн асуудал ихээхэн чухал байна. Үүний тулд эдийн засгийн өсөлтийн бүтцийг харах шаардлагатай болно. 2026 оны эдийн засгийн

өсөлтийн дийлэнхийг ХАА-н салбар тодорхойлж байгааг урьдчилсан гүйцэтгэлд дурдсан байна. Энэ нь эдийн засгийн нийт өсөлтөд ХАА-н салбарын нөлөөлөл 42 хувь байгааг илэрхийлж байна. Түүнчлэн эдийн засагт голлох цөөн салбар эдийн засгийн өсөлтийн голыг бүрдүүлж байгааг мөн харах боломжтой.

2026 оны хувьд ХАА-н салбараас гадна уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарууд 91 хувийн эерэг нөлөөллийг үзүүлсэн бол бусад салбарууд 17 хувийн эерэг нөлөө, худалдааны салбар -8 хувийн нөлөөлөл үзүүлсэн байна. Тодруулбал, эдийн засгийн 20 салбараас голлох 5 салбар өсөлтийн үнэмлэхүй хувийг бүрдүүлж байгаа нь эдийн засгийн бүтцийн бас нэг өрөөсгөл тал юм.


**Зураг 6. Монгол Улсын 2025 оны эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө бүхий салбарууд**



Эх сурвалж: УСХ, 2026

Эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлж байгаа салбаруудын өсөлтийн хандлага тогтвортой эсэх нь энэхүү өрөөсгөл бүтцийн бас нэг асуудал гэхэд болно. Энэ оны өсөлтөд ХАА-н салбарын нөлөөлөл өндөр байна. Тэгвэл энэхүү салбарын өсөлт болон эдийн засгийн өсөлтийн уялдаа холбоо, тухайн салбарын өсөлтийн асуудлыг харахыг шаардлагатай юм.

**Зураг 7. ДНБ-ий болон ХАА-н салбарын 1990-2025 оны өсөлтийн харьцуулалт, хувиар**



Эх сурвалж: УСХ, 2026

Дээрх зурагт үзүүлсэн үр дүн нь ДНБ-ий өсөлт болон ХАА-н салбарын өсөлт хоорондоо нягт шүтэлцээтэй биш болохыг харуулж байгаа бөгөөд энэ нь 1990 оноос хойших эдгээр үзүүлэлтийн хамаарлын корреляц 0.33 байгаагаас харагдаж байна. Иймээс ХАА-н салбар нь эдийн засгийн голлох салбарын нэг бөгөөд томоохон нөлөөтэй салбар мөн ч эдийн засгийн өсөлтийн тогтвортой учир шалтгаан бас биш байж болох талтай. Үүний бас нэг шалтгаан нь салбарын өсөлт өөрөө тогтвортой бус байсан явдал юм. 1991 оноос хойш 35 жилд ХАА-н салбар 12 жилд уналттай байсан бөгөөд хамгийн ихдээ -28.71 хувиар унасан нь 2024 он бөгөөд 2025 оны суурь он болж таарч байна. Үүний улмаас суурь оны нөлөөлөл өндөр байх магадлалтай тул ойрын ирээдүйд тухайн салбараас ийм өндөр нөлөөлөл хүлээх боломжтой эсэх нь бас нэг анхаарал татсан асуудал юм.

ХАА-н салбар нь мал аж ахуй, газар тариалан гэсэн хоёр томоохон салбараас бүрдэх тул эдгээр салбарын нөхцөл байдлыг сүүлийн жилүүдээр харах нь бас нэг тодруулах өнцөг гэж үзэж болно.

#### Хүснэгт 5. ХАА-н салбарын 2023-2025 оны зарим үзүүлэлт

Үзүүлэлт	2023	2024	2025	Өөрчлөлт, хувь 2025/2024
ХАА /оны үнээр тэрбум ₮/	6,988.2	5,881.1	8,093.3	36.7
ХАА / 2015 оны зэрэгцүүлэх үнээр тэрбум ₮/	3,873.3	2,761.1	3,678.9	33.2
Малын тоо бүгд /мянган толгой/	64,681.9	57,649.7	58,104.2	0.8
Бойжуулсан төл /мянган толгой/	18,323.0	16,232.2	21,682.0	33.5
Хорогдсон мал /мянган толгой/	4,921.5	9,364.1	358.9	
Тариалсан талбар /мянган га/	642.2	632.7	598.8	-5.3
Хураасан ургац /мянган тонн/				
Үр тариа	470.3	443.2	294.5	-33.5
Төмс	179.4	251.4	114.1	-54.6
Хүнсний ногоо	208.4	282.3	239.8	-15.1
Таримал ургамал	258.2	259.2	198.2	-23.5
Техникийн ургамал	55.4	59.4	31.5	-46.9
Бэлтгэсэн хадлан	1,564.7	1,577.4	1809.5	14.7

Эх сурвалж: УСХ, 2026

ХАА-н салбарын ерөнхий нөхцөл байдал сайнаар өөрчлөгдсөн нь зөвхөн МАА-н салбар түүний дотор малын хорогдол буурснаар тодорхойлогдох хандлагатай байна. Харин газар тариалангийн салбарын хувьд нэлээд бууралттай байгаа нь өсөлтөд сөргөөр нөлөөлсөн нь тодорхой юм. Эндээс тус салбарын энэхүү эерэг нөлөөлөл цаашид үргэлжлэх эсэх, дунд хугацаанд эдийн засагт томоохон нөлөө үзүүлж чадах эсэх дээр анхаарал хандуулах хэрэгтэй. 2025 он бол тухайн салбарын сүүлийн 35 жилийн дээд өсөлтийг харуулсан жил байсан төдийгүй суурь оны томоохон нөлөөлөл бүхий жил юм.

Мөн 2025 оны эдийн засгийн хувьд ихээхэн өсөлттэй байсан нэг салбар нь цахилгаан хий, уур, халаагуур гэсэн салбар бөгөөд энэ өсөлтийн голлох шалтгаан нь тухайн салбартай холбоотой үнийн өөрчлөлтийн асуудал байх боломжтой. Учир нь энэ салбар дахь төрийн оролцоо дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд үнийг төрийн бодлогоор тогтоож ирсэн нь салбарын өсөлтөд сөргөөр нөлөөлж байсан.

Түүнчлэн өмнөх жилүүдийн эдийн засгийн өсөлтийг 2022 онд ХАА, үйлчилгээ, 2023 онд уул уурхай, үйлчилгээ, 2024 онд уул уурхайн салбар голлон бүрдүүлж байсан байна. Ийнхүү эдийн засгийн өсөлтийн бүтэц тогтворгүй, тодорхой салбаруудаас ихээхэн хамааралтай байгаа нь эдийн засгийн бүтцийн шалтгаантай холбоотой юм.

### Эдийн засгийн бүтэц

Монгол Улсын эдийн засгийн бүтцийг шинэчлэх нь эдийн засгийн өсөлтийн хандлагыг тодруулах эхний алхам бөгөөд эдийн засгийн 50 хувийг 4 салбар, түүний мөн л 50 хувийг уул уурхайн салбар дангаар бүрдүүлж байна.


Зураг 8. Монгол Улсын эдийн засгийн бүтэц /2025 он/, хувиар



Эх сурвалж: УСХ, 2026

Уул уурхайн салбар 1990 онд эдийн засгийн 12.5 хувийг эзэлж байсан бол 2004 оноос 20-оос дээш хувьд хүрч 2006 онд 28.45 хүрсэн нь дээд үзүүлэлт болж, 2023 онд дахин 28 хувьд хүрч байсан бол хамгийн бага нь 8 хувь байсан байна.


Зураг 9. Голлох салбаруудын эдийн засагт эзлэх хувь /1990-2025/



Эх сурвалж: УСХ, 2026

Уул уурхайн салбарын нөлөөлөл нэмэгдэхээс гадна бас нэг үзэгдэл эдийн засгийн бүтцэд ажиглагдаж байгаа нь ХАА, боловсруулах үйлдвэрийн салбарын эдийн засгийн нөлөө багасаж байгаа явдал бөгөөд эдийн засгийн бүтцийн хувьд төдийгүй өсөлтийн таамаглалд хийхэд анхаарах гол үзүүлэлтийн нэг болж байна. ХАА-н салбар 1996 онд эдийн засгийн 38.5 хувийг эзэлж байсан бол 2024 онд хамгийн доод түвшин болох 7.25 хувьд хүрсэн. Боловсруулах үйлдвэрлэлийн салбар 1990 онд 21.4 хувьтай байсан бол мөн 2024 онд хамгийн доод түвшин болох 6.6 хувьд хүрсэн байна. Эдийн засгийн үлдсэн хэсэг нь төрийн болон төрийн бус үйлчилгээний салбар бөгөөд 2025 оны байдлаар нийт эдийн засгийн 52 орчим хувьтай тэнцэж байна. 1990 оноос Монгол Улсын эдийн засгийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөнийг доорх зурагт харуулав.

Зураг 10. Эдийн засгийн бүтэц /2025 он/



Эх сурвалж: УСХ, 2026


Монгол Улсын хувьд 1990 оноос хойш буюу сүүлийн 35 жилд эдийн засгийн бүтэц ихээхэн суларсныг эндээс харж болно. Боловсруулах үйлдвэрлэл, ХАА-н салбарын эзлэх хувийн жин эрс буурч оронд нь уул уурхай, бүтээгдэхүүний цэвэр татвар, санхүү, даатгал, төрийн удирдлагын салбарын эдийн засаг дахь хувийн жин нэмэгдсэн байна. Харин эрчим хүч, ус цахилгаан, мэдээлэл холбоо зэрэг гол салбаруудын хувьд дорвитой өөрчлөлт гараагүй байна.

Эндээс бид уул уурхай, худалдаа, үйлчилгээний салбар голлосон эдийн засгийн загвартай болсон нь харагдах ба эдийн засгийг ойрын ирээдүйд уул уурхайн салбар, түүнээс хамаарах тээвэр, барилга, бусад худалдаа үйлчилгээ гэсэн байдлаар харах шаардлагатай болж байна.

Эдийн засгийн бүтцийн хувьд бидний бас нэг онцолж байгаа зүйл нь эдийн засаг дахь төрийн оролцоо юм. Үүнийг ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хувь, эдийн засгийн гүйцэтгэлд хувийн хэвшлийн эзэлж буй хувь хэмжээгээр төлөөлүүлэн харах боломжтой. Үүнээс гадна эдийн засаг дахь “Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал” хэмээх салбар нь 1990 онд нийт эдийн засагт 2.2 хувь эзэлж байсан бол 2025 онд 5.3 болж 2.4 дахин өссөн нь төрийн оролцоо нэмэгдсэнийг бас нэг илрэл гэж хэлж болно.

Төрийн оролцоо тодорхой хэмжээнд нэмэгдэх нь эдийн засгийн өсөлтийг удаашруулах нөлөөтэй байж болно. Үүнээс эсрэгээр байхын тулд засаглалын чадавх, бүтээмж, төсвийн үр ашигт байдал сайн байх шаардлага тавигдана.

**Зураг 11. Эдийн засаг дахь төрийн болон хувийн хэвшлийн оролцооны харьцуулалт /2015-2026/, хувиар**



Эх сурвалж: Сангийн яам, 2025. ҮСХ, 2026

Эдийн засаг дахь төрийн оролцооны түвшин сүүлийн 12 жилд хамгийн дээд тал нь 2016 онд 39.8, хамгийн бага нь 2018 онд 29.0 хувьтай байжээ. Энэ нь эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамаарч төсвийг тодорхой улс төрийн мөчлөгөөс хамаарч тэлдэгтэй уялдаатай юм. Үүний нөгөө талд эдийн засгийн гүйцэтгэлд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг суларч байгаа нь харагдаж байна. Эдгээр нь эдийн засгийн бүтцийн хувьд ирээдүйн хандлагад томоохон сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай хүчин зүйлс юм.

### Монгол Улсын эдийн засгийн төлөв


Төлөв гэдгийг тодруулахын өмнө бидэнд ямар төлөв байна? гэсэн асуултыг эдийн засгийн таамаглал хийхэд гарцаагүй асуух шаардлагатай болдог. Бид төлөвлөлтийн хувьд болон бодит байдал дээр ирээдүйг тодорхой харахад дэм болохуйц төлөвийг бий болгож чадсан эсэхийг өмнөх хэсгээс зарим талаар харсан гэж бодож байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд тодорхой тогтсон төлөвийг бий болгож чадаагүй байх магадлалтай юм.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд 2026 онд эдийн засгийн өсөлт 5.7 хувь, 2027 онд 6.3 хувь, 2028 онд 6.5 хувьтай өсөхөөр төсөөлж байгаа. Төсвийн тогтвортой байдлыг хадгалахад энэхүү таамаглалтай холбоотойгоор ДНБ энэ түвшинд өсөх эсэх, түүнтэй холбоотой төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд төвлөрөх эсэх тухай асуудал гарна. Иймээс юуны өмнө эдийн засгийн өсөлтийг тодорхойлж байгаа салбаруудыг харах шаардлагатай.

Сүүлийн 10 жилийн хугацаанд хоёр гол салбар болон бүтээгдэхүүний цэвэр татвар нь эдийн засгийн өсөлтөд голлох үүрэг гүйцэтгэж байсан бөгөөд тухайн жилийн өсөлтөд 80 хүртэл хувийн нөлөөтэй байна. 2025 оны гол өсөлтийг тодорхойлсон ХАА-н салбар сүүлийн 10 жилийн эдийн засгийн өсөлтөд 4 удаа томоохон эерэг нөлөө үзүүлж байсан бол 4 удаа сөрөг нөлөө үзүүлж 2 жилд нь хэвийн өсөлттэй байсан нь салбарын өсөлтийн тогтворгүй байдлыг

харуулж байна. Сүүлийн 30 жилийн байдлаар эдийн засгийн өсөлт хамгийн өндөр байсан салбаруудыг дараах зурагт харуулав.

Зураг 12. Эдийн засгийн өндөр өсөлттэй салбарууд /1996-2025/



Эх сурвалж: УСХ, 2026

Хүснэгт 6. Эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлж буй салбарууд /2016-2025/, хувиар

Эдийн засгийн салбар	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Бүгд	1.49	5.64	7.75	5.6	-4.56	1.64	5.03	7.42	5.12	6.84
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.76	-0.04	0.9	0.72	0.79	-0.83	1.68	-1.33	-3.64	2.86
Уул уурхай, олборлолт	-0.29	-0.68	0.86	-0.25	-1.44	0.12	-2.08	2.58	1.36	1.41
Бүтээгдэхүүний цэвэр татвар	0.21	1.94	1.98	1.04	-1.06	1.31	1.36	0.83	1.83	0.04
Өндөр өсөлттэй салбарын эдийн засгийн өсөлтөд эзлэх хувь	51%	34%	26%	19%	17%	80%	33%	35%	36%	42%

Эх сурвалж: УСХ, 2026

Монгол Улсын 2025 оны эдийн засгийн өсөлтөд ХАА-н салбар голлох нөлөө үзүүлсэн нь тухайн салбарын сүүлийн 35 жилийн дээд өсөлт бөгөөд суурь оны нөлөөлөл өндөр байсанд голлох анхаарлаа хандуулах хэрэгтэй. Мөн тухайн жилд нэрлэсэн дүнгээр хамгийн өндөр өсөлт үзүүлсэн салбарын нэг нь Цахилгаан, хий, уур болон агааржуулалтын салбар бөгөөд үнийн зохицуулалтын нөлөө өндөр байснаас шалтгаалсан байх магадлалтай. 2020 онд цар тахлын нөлөөгөөр эрүүл мэндийн салбар хамгийн өндөр өсөлт үзүүлсэн гэх мэт гэнэтийн шалтгаанууд их байгаа нь Монгол Улсын эдийн засгийн нэг сул тал юм. Тогтвортой өсөлтөөс гадна хүртээмжтэй өсөлтийн асуудал ихээхэн чухал бөгөөд үүний цаана эдийн засгийн өсөлт нь өрх, иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаа тухай асуудлыг хөндөх шаардлагатай.

Монгол Улсын эдийн засаг уул уурхай үйлчилгээний хандлагатай болсон нь эдийн засгийн бүтэц, өсөлт, голлох өсөлтийг гаргаж байгаа салбаруудын байдлаас харагдаж байна. Эдийн засгийн бүтцийг ажиглавал уул уурхайн салбарын хувийн жин нэмэгдсэн үйлчилгээний салбар давамгайлсан, боловсруулах үйлдвэрлэл, ХАА-н салбарын оролцоо буурсан хандлагатай нь харагдана. Нөгөө талаас төсвөөр дамжин төрийн оролцоо нэмэгдсэн, хувийн хэвшлийн эдийн засагт гүйцэтгэх үүрэг суларч байгаа дүр зурагтай байгаа нь бас нэг анхаарах хүчин зүйл юм. Үүнээс үүдээд эдийн засгийн өсөлтийг уул уурхайн салбар, түүнд шаардагдах бараа, бүтээгдэхүүний худалдаатай холбоотой тээвэр, үйлчилгээний салбар, гадаад худалдаа тодорхойлсон байдалтай байгаа юм.


ХАА-н салбар зарим онд эдийн засгийн өсөлтөд томоохон нөлөөлөл үзүүлсэн нь уул уурхайн салбарын уналттай жилүүдэд голлон илэрч нь илэрч байгаагаас гадна өөрөө байгалийн хамаарал ихтэй эрсдэлтэй салбар юм. Иймд 2027-2029 оны эдийн засгийн төлөвийг таамаглах гол суурь нь мөн л эрдсийн бүтээгдэхүүний үнэ, гарцын асуудал тул түүнд суурилах шаардлага үүсэж байна. Уул уурхайн салбар, тээвэр болон бусад салбартаа хэрхэн нөлөөлөх нь таамаглалын гол үндэс болно.

## 2.2. ГАДААД ХУДАЛДАА, ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

### Гадаад худалдаа

Монгол Улсын экспорт, импортын бүтэц сүүлийн арван жилд мэдэгдэхүйц тэлсэн боловч бүтцийн хувьд уул уурхайн бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай хэвээр байна. 2025 онд гарсан эерэг өөрчлөлт нь эрдсийн бүтээгдэхүүний экспортод бүтцийн тэнцвэртэй байдал бий болж эхэлсэн явдал юм. 2025 оны байдлаар нийт экспорт 15.7 тэрбум ам.доллар, нийт импорт 11.3 тэрбум ам.долларт хүрч, *гадаад худалдааны тэнцэл 4.4 тэрбум ам.долларын ашигтай гарсан* байна. Энэ нь Монгол Улсын гадаад худалдааны нийт тэнцэл эерэг хэвээр байгааг илтгэх боловч *экспортын орлогын үндсэн хэсгийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлж байгаагаас шалтгаалан гадаад орчны өөрчлөлтөд эмзэг байдал үргэлжилж байгааг харуулж* байна.

Зураг 13. Гадаад худалдааны нийт эргэлт, тэнцэл, /2021-2025 он/, сая ам.доллаароор



Эх сурвалж: ҮСХ, 2026

2024 оны гадаад худалдааны хувьд гол анхаарал татсан асуудал нь нүүрсний экспортын үнээс хамаарсан орлогын хэмжээ, мөн экспорт, импортын өөрчлөлтийн зөрүү юм. Эдгээр асуудал 2025 онд улам даамжирч байгааг эхний 2 сарын дүнгээр гадаад худалдааны нийт

бараа эргэлт 3715.8 сая ам.доллар болж, 2024 оны мөн үеэс 120.4 сая ам.доллар буюу 3.1 хувиар буурсан нь харуулж байна. Ийнхүү экспорт 10.5 хувиар багассан нь эрдэс баялгийн бүтээгдэхүүн, нүүрсний экспортын бууралтаас шалтгаалсан.

**Экспортын бүтэц:** 2025 онд нийт экспортын 92.7 хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлсэн. Үүний дотроос зэсийн хүдэр, баяжмал 5.8 тэрбум ам.доллар, чулуун нүүрс 5.6 тэрбум ам.доллар, мөнгөжөөгүй алт 1.2 тэрбум ам.доллар, төмрийн хүдэр, баяжмалын 634.5 сая ам.долларын экспорт хийсэн нь *Монгол Улсын экспортын орлого хэдхэн нэр төрлийн уул уурхайн бүтээгдэхүүнд буюу зэс, нүүрсний экспортод төвлөрч буйг* илтгэнэ. Тодруулбал, зөвхөн зэсийн хүдэр, баяжмал болон чулуун нүүрсний экспорт нийлээд нийт экспортын 72.5 орчим хувийг бүрдүүлж байна. Энэ нь экспортын орлогын суурь зэс, нүүрсний экспортод төвлөрсөн хэвээр байгааг харуулж буй юм. Энэ нь экспортын хэмжээ өссөн ч *Монгол Улсын гадаад худалдааны тогтвортой байдал бүтээгдэхүүний төрөлжилтөөс бус, харин түүхий эдийн үнэ, эрэлтээс шууд шалтгаалж байгааг* илэрхийлж байна.

Экспортын хувьд 2023–2025 онд нүүрсний экспортын биет хэмжээ огцом өсөж, 2023 онд 69.6 сая тонн, 2024 онд 83.8 сая тонн, 2025 онд 90.0 сая тоннд хүрсэн байна. Энэ нь Монгол Улсын экспортын орлогын өсөлтийг сүүлийн жилүүдэд нүүрсний экспортын хэмжээ голлон дэмжсэнийг харуулна. Үүнтэй зэрэгцэн зэсийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээ 2024 онд 1.7 сая тонн байсан бол 2025 онд 2.3 сая тоннд хүрч нэмэгдсэн нь зэсийн экспортын орлого огцом өсөхөд нөлөөлсөн байна.

Мөн төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээ 2022 оноос хойш сэргэх хандлагатай байгаа бөгөөд 2025 онд 8.8 сая тоннд хүрсэн нь уул уурхайн экспортын бүтцэд тодорхой хэмжээнд төрөлжилт бий болж буйг илтгэнэ. Энэхүү төрөлжилт нь бодлогын хувьд анхаарах гол асуудал бөгөөд цаашид зэс, нүүрс, газрын ховор элементийн хувьд ямар бодлогыг баримтлах нь экспорт, эдийн засаг, төсвийн орлогын хувьд голлох нөлөөг үзүүлэхээр байна.


**Хүснэгт 7. Экспортын гол бүтээгдэхүүний үнийн дүн, тоо хэмжээ /2021-2025 он/, сая ам.доллароор**

Гол нэр төрлийн барааны үнийн дүн	2021	2022	2023	2024	2025
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт (сая ам.доллар)	1,004.5	1,127.4	738.0	899.4	1,240.9
Зэсийн хүдэр, баяжмал (сая ам.доллар)	2,899.9	2,734.8	2,625.7	3,319.1	5,808.7
Жоншны хүдэр ба баяжмал (сая ам.доллар)	144.0	110.5	272.4	318.5	320.9
Төмрийн хүдэр, баяжмал (сая ам.доллар)	952.2	391.0	444.7	597.6	634.5
Нүүрс (сая ам.доллар)	2,774.1	6,503.2	8,898.5	8,697.9	5,768.8
Боловсруулаагүй нефть (сая ам.доллар)	273.4	241.8	364.7	322.1	251.3
Гол нэр төрлийн барааны тоо хэмжээ	2021	2022	2023	2024	2025
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт (тн)	17.3	19.7	11.7	11.7	10.8
Зэсийн хүдэр, баяжмал (мян.тн)	1,282.5	1,453.3	1,525.0	1,695.4	2,281.9
Жоншны хүдэр ба баяжмал (мян.тн)	644.3	387.7	1087.8	1369.1	1,818.1
Төмрийн хүдэр, баяжмал (сая.тн)	7.1	4.7	5.7	7.5	8.8
Нүүрс (сая.тн)	16.1	31.8	69.6	83.8	90.0
Боловсруулаагүй нефть (сая.барр)	4.3	2.6	4.7	4.1	3.5

Эх сурвалж: ҮСХ, ГЕГ, 2026

**Нүүрс.** Нүүрсний экспортын хувьд 2021 онд 16.1 сая тонн нүүрс экспортолж 2.8 тэрбум ам долларын орлого олж байсан бол 2025 онд биет хэмжээ 90.0 сая тонн-д хүрч борлуулалтын орлого 5.8 тэрбум ам.доллар болжээ. Тайлант онд нүүрсний дундаж үнэ анх төсөвт тусгаж байсан 105 ам.доллараас даруй 40.0 орчим хувиар унаж, дундаж үнэ 64.0 ам.долларт хүрсэн. Үүний улмаас нүүрсний экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 6.7 сая тонноор давсан боловч экспортын орлого 2.7 их наяд төгрөгөөр тасалдсан байна.

Зураг 14. Экспортолсон нүүрсний тоо хэмжээ, орлого /2021-2025 он/



Эх сурвалж: УСХ, ГЕГ, 2026

Энэ нь голчлон нүүрсний үнийг өндөр таамаглаж, төсөөлсөнтэй холбоотой. Төсөөлсөн үнэ бодит зах зээлийн үнээс өндөр байсан тул орлого төсөөллөөс эрс доогуур гарсан.

Өмнөх жилүүдэд (2022–2024 онд) орлого төсөөллөөс давсан нь биет хэмжээ болон үнийн таамаглал бодит байдалтай ойролцоо байсан буюу орлогыг нэмэгдүүлэх хүчин зүйл болсон. Харин 2025 оны үр дүн нь төсөвт үнийн таамаглалын эрсдэл хэр том нөлөө үзүүлж болохыг харуулж байна. Тиймээс ирээдүйд нүүрсний орлогын төсөөлөл гаргахдаа үнийн таамаглалд болгоомжтой хандаж, бодит зах зээлийн үнэтэй ойролцоо тооцоолох, мөн орлогын эрсдэлийг бууруулах стратеги боловсруулах шаардлагатай юм.

Хүснэгт 8. Нүүрсний биет хэмжээ, үнэ, орлогын төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү /2021-2025 он/

Төсвийн жил	Төсөөлөл			Гүйцэтгэл			Зөрүү=Гүйцэтгэл-Төсөөлөл		
	Биет хэмжээ (Сая.тн)	Үнэ (Ам.долл./тн)	Орлого (тэрбум төг.)	Биет хэмжээ (Сая.тн)	Үнэ (Ам.долл./тн)	Орлого (тэрбум төг.)	Биет хэмжээ (сая.тн)	Үнэ (Ам.долл./тн)	Орлого (тэрбум төг.)
2021	28.7	107.6	1,287.8	16.2	172.4	980.9	-12.5	64.8	-306.9
2022	18.0	184.0	1,346.5	31.8	204.4	2,260.7	13.8	20.4	914.2
2023	50.0	140.0	2,649.0	69.6	127.8	4,723.8	19.6	-12.2	2,074.8
2024	78.1	115.0	6,019.1	83.8	103.9	7,373.2	5.7	-11.1	1,354.1
2025	83.3	105.0	7,125.5	90.0	64.1	4,373.8	6.7	40.9	-2,751.7

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, 2021-2024 он

Нүүрсний экспорт өсөж байгаа эерэг хандлагыг хадгалахтай зэрэгцэн үнийн эрсдэлийг бууруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх нь экспортын орлогын тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой.

**Зэсийн хүдэр, баяжмал.** Зэсийн хүдэр, баяжмалын экспортын хувьд 2021 онд 1.3 сая тонн зэсийн баяжмал экспортолж 2.9 тэрбум ам.долларын орлого олж байсан бол тайлант онд экспортын биет хэмжээ 2.3 сая тоннд хүрч, экспортын орлого ойролцоогоор хоёр дахин өсөж 5.8 тэрбум ам.доллар болсон байна. Энэхүү өсөлт нь голчлон Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлж, зэсийн үйлдвэрлэл болон баяжмалын агууламж нэмэгдсэнтэй холбоотой юм. Түүнчлэн олон улсын зах зээл дээр зэсийн үнэ өсөх хандлагатай байгаа нь экспортын орлогын өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн байна. Зэсийн экспортоос 2025 онд орох орлого нь зэсийн үнийн өсөлтөөс шалтгаалан 747.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.


**Хүснэгт 9. Экспортолсон зэсийн хүдэр, баяжмалын тоо хэмжээ, үнэ, орлого /2021-2025 он/**

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025
Зэсийн хүдэр, баяжмалын тоо хэмжээ (мянган тонн)	1,282.5	1,453.3	1,525.0	1,695.4	2,281.9
Зэсийн хүдэр, баяжмалын экспортын орлого (сая ам.доллар)	2,899.9	2,734.8	2,625.7	3,319.1	5,808.7

Эх сурвалж: УСХ, ГЕГ, 2026

Зэсийн хүдэр, баяжмалын хувьд сүүлийн 5 жилийн турш зэсийн олборлолт тогтмол нэмэгдэж (1.3-2.3 сая тонн), орлого тогтвортой өсөж байгаа нь биет хэмжээний өсөлт үнийн хэлбэлзлийг нөхөж байгааг харуулж байна.

**Зураг 15. Экспортолсон зэсийн хүдэр, баяжмалын тоо хэмжээ, орлого /2021-2025 он/**



Эх сурвалж: УСХ, ГЕГ, 2026

Гэвч үнэ хэт хэлбэлзэх нь орлогын таамаглалд эрсдэл үүсгэдэг тул ирээдүйд орлогын төсөөлөлд үнэ болон биет хэмжээг хамтад нь нарийвчлан тооцох шаардлагатай.

**Хүснэгт 10. Зэсийн хүдэр, баяжмалын биет хэмжээ, үнэ, орлогын төсөөлөл, гүйцэтгэлийн зөрүү /2021-2025 он/**

Төсвийн жил	Төсөөлөл			Гүйцэтгэл			Зөрүү=Гүйцэтгэл-Төсөөлөл		
	Биет хэмжээ (сая.тн)	Үнэ (Ам.долл./тн)	Орлого (тэрбум төг.)	Биет хэмжээ (сая.тн)	Үнэ (Ам.долл./тн)	Орлого (тэрбум төг.)	Биет хэмжээ (сая.тн)	Үнэ (Ам.долл./тн)	Орлого (тэрбум төг.)
2021	1.2	8,550.0	1,669.3	1.3	9,314.4	2,448.2	0.1	764.4	778.9
2022	1.2	9,100.0	1,966.7	1.5	8,813.9	2,425.6	0.3	-286.1	458.9
2023	1.5	8,670.0	2,547.3	1.5	8,482.8	2,742.6	-	-187.2	195.3
2024	1.6	9,500.0	2,631.6	1.7	9,184.0	2,699.6	0.1	-316.0	68.0
2025	1.8	7,491.7	2,949.7	2.3	-	3,697.5	0.5	-	747.8

*Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, 2021-2024 он*

Зэсийн үнийн хандлага ихээхэн эерэг байдалтай байгаа тул энэ нөхцөл байдал цаашид үргэлжилнэ хэмээн үзэж болох боловч эдийн засгийг тэлэх, төсвийн орлогын эрсдэлийг бууруулах үүднээс үнийн болон хэмжээний хувьд тодорхой бодлоготой байж зэсийн гарцыг нэмэгдүүлэх асуудлыг анхаарах шаардлагатай. Дунд хугацаанд Монгол Улсын гадаад худалдааны төлөв 2027–2029 онд уул уурхайн экспортын хэмжээ, үнэ болон дэд бүтцийн хүчин чадлаас голлон хамаарах төлөвтэй байна. *Нүүрсний экспортын биет хэмжээ сүүлийн жилүүдэд огцом тэлсэн тул цаашид өсөлтийн хурд саарах, харин орлогын динамик нь үнэ ханшиаас илүүтэй шалтгаалах хандлага давамгайлах* магадлалтай.

Зэсийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээ 2025 онд мэдэгдэхүйц өссөн нь ойрын жилүүдэд экспортын орлогыг дэмжих нэг гол хүчин зүйл хэвээр байх төлөвтэй боловч үнэ ханшийн савлагаа болон БНХАУ-ын эрэлтээс хамаарах эрсдэл өндөр хэвээр байна. Төмрийн хүдэр, алт зэрэг бусад бүтээгдэхүүний экспорт тодорхой хэмжээнд орлогын эх үүсвэрийг төрөлжүүлж болох боловч нийт экспортын бүтэц дэх жин харьцангуй бага хэвээр байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад Монгол Улсын нүүрсний экспортын орлого нь нүүрсний олон улсын зах зээлийн үнийн хэлбэлзлээс өндөр хамааралтай хэвээр байна. Иймд экспортын орлогын тогтвортой байдлыг хангах зорилгоор дараах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Нүүрсний экспортын орлогын хэлбэлзлийг бууруулах зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг төрөлжүүлэх, зэс, төмрийн хүдэр зэрэг бусад ашигт малтмалын олборлолт, экспортыг нэмэгдүүлэх бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Нүүрсний экспортыг зөвхөн түүхий хэлбэрээр гаргахаас илүүтэйгээр угаах, баяжуулах, коксжуулах зэрэг гүн боловсруулалтын үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэгж бүтээгдэхүүнээс олох нэмүү өртгийг нэмэгдүүлэх;

- Нүүрсний экспортыг нэг зах зээлээс хэт хамааралтай байдлыг бууруулах зорилгоор тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулж, экспортын шинэ зах зээл нээх, дамжин өнгөрөх тээврийн боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр бодлого хэрэгжүүлэх;
- Уул уурхайн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс төсвийн орлого хэт савлах эрсдэлийг бууруулах зорилгоор төсвийн төлөвлөлтөд консерватив үнийн таамаглал ашиглах, үнийн өсөлтийн үед орлогын тодорхой хэсгийг хуримтлуулах сангийн механизмыг бэхжүүлэх шаардлагатай байна.

## Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн динамик нь экспортын бүтэц, уул уурхайн түүхий эдээс өндөр хамааралтай байдгаас шалтгаалан дэлхийн түүхий эдийн үнийн мөчлөг, гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал, импортын эрэлтийн өөрчлөлт, валютын ханшийн хөдөлгөөн зэрэг хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай хэвээр байна.

### Хүснэгт 11. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн динамик

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023	2024	2025
I. Урсгал данс	-2,161.7	-674.6	-2,108.4	-2,303.5	121.3	-2,485.4	-2,190.6
II. Хөрөнгийн данс	160.8	102.8	114.0	154.3	134.9	171.4	127.0
III. Санхүүгийн данс	-2,677.7	-1,504.2	-1,982.2	-1,644.1	-1,476.6	-3,329.6	-3,320.7
IV. Алдаа болон орхигдуулга	-223.9	-145.6	-209.4	-222.1	-275.7	-393.2	-222.8
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	452.9	786.9	-221.6	-727.3	1,457.0	622.3	1,034.3
V. Нөөц хөрөнгө	452.9	786.9	-221.6	-727.3	1,457.0	622.3	1,034.3
1. ГВУН	452.9	786.9	-224.9	-750.9	1,398.0	539.8	974.4
2. ОУВС-гийн зээл	0.0	0.0	-3.3	-23.7	-59.1	-82.5	-59.9
3. Тусгай санхүүжилт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0


Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо, 2026

Сүүлийн жилүүдийн төлбөрийн тэнцлийн мэдээллээс харахад барааны худалдааны данс ихэнх тохиолдолд ашигтай гарч байгаа боловч үйлчилгээний дансны алдагдал, гадаадын хөрөнгө оруулагчдын орлогын шилжүүлэг, импортын өсөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр урсгал данс ихэнхдээ алдагдалтай хэвээр байна.

**Урсгал дансны алдагдлын гол шалтгаан** нь үйлчилгээний импортын өндөр түвшин болон анхдагч орлогын дансны гадагш урсгал юм. Тухайлбал, уул уурхайн төслүүдтэй холбоотой техник тоног төхөөрөмж, тээвэр, логистик, инженерийн үйлчилгээ зэргийн импорт өндөр хэвээр байгаа нь үйлчилгээний дансны алдагдлыг нэмэгдүүлдэг.

Үүний зэрэгцээ гадаадын шууд хөрөнгө оруулалттай компаниудын ашиг, ногдол ашиг, хүүгийн төлбөрүүд гадагш урсах нь анхдагч орлогын дансны алдагдлыг нэмэгдүүлж, урсгал дансны нийт алдагдлыг тэлэхэд нөлөөлж байна. Нөгөө талаас, уул уурхайн экспортын орлого өсөх үед барааны худалдааны ашиг нэмэгдэж, урсгал дансны алдагдлыг тодорхой хэмжээгээр бууруулж иржээ.

Зураг 16. Урсгал дансны динамик /2019-2025 он/



Эх сурвалж: Монголбанк, 2026

**Урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр** нь үндсэндээ санхүүгийн дансны урсгалд тулгуурлаж ирсэн байна. Санхүүгийн дансны хамгийн том эх үүсвэр нь гадаадын шууд хөрөнгө оруулалт бөгөөд уул уурхайн салбарын томоохон төслүүдэд орж ирсэн хөрөнгө оруулалт нь урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Гадаадын шууд хөрөнгө оруулалт нь урт хугацааны санхүүжилтийн эх үүсвэр тул төлбөрийн тэнцлийн тогтвортой байдалд харьцангуй эерэг нөлөөтэй байдаг.

Хүснэгт 12. Төлбөрийн тэнцэл /2021-2025 он/


№	Индикатор	2021	2022	2023	2024	2025
1	Урсгал данс	-2,108.4	-2,303.5	121.3	-2,485.4	-2,190.6
2	Хөрөнгийн данс	114.0	154.3	134.9	171.4	127.0
3	Санхүүгийн данс	-1,982.2	-1,644.1	-1,476.6	-3,329.5	-3,320.7
4	Төлбөрийн тэнцлийн нийт дүн	-221.6	-727.2	1,457.0	622.3	1,034.3

Эх сурвалж: Монголбанк, 2026

Дээрх хүснэгтээс урсгал дансны алдагдлыг санхүүгийн данс нөхсөнөөр 2025 онд төлбөрийн тэнцэл 1 их наяд төгрөгийн ашигтай гарсан харагдаж байна. Үүнээс гадна урсгал дансны алдагдлыг нөхөх санхүүжилтийн эх үүсвэрт гадаад зээл, хөрөнгө оруулалт болон олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл багтдаг. Засгийн газрын гадаад бондын санхүүжилт, банкны салбарын гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн гадаад зээл зэрэг нь санхүүгийн дансны урсгалыг бүрдүүлж, төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж ирсэн. Гэвч ийм эх үүсвэр нь гадаад өрийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй юм.

Санхүүгийн дансны урсгал хангалтгүй үед төлбөрийн тэнцлийн тэнцвэрийг гадаад валютын албан нөөцийн өөрчлөлтөөр дамжуулан хадгалдаг. Экспортын орлого өсөх үед валютын нөөц нэмэгдэх боломж бүрддэг бол экспортын орлого буурах, санхүүгийн урсгал саарах үед валютын нөөц буурах замаар төлбөрийн тэнцлийн богино хугацааны савлагааг шингээж ирсэн байна.

Зураг 17. Санхүүгийн дансны динамик



Эх сурвалж: Монголбанк, 2026

Өнөөгийн нөхцөл байдалд уул уурхайн экспортын орлого нэмэгдэж, гадаад худалдааны ашиг тодорхой хэмжээгээр өссөн нь төлбөрийн тэнцлийн нийт алдагдлыг бууруулахад дэмжлэг үзүүлж байна. Гэвч үйлчилгээний дансны алдагдал болон анхдагч орлогын дансны гадагш урсгал өндөр хэвээр байгаа нь урсгал дансны алдагдал үргэлжлэн хадгалагдах гол хүчин зүйл болж байна. Ийм нөхцөлд урсгал дансны алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн урсгал болон зарим тохиолдолд валютын нөөцийн өөрчлөлтөөр нөхөж буй бүтэц хэвээр байна.

**Цаашид төлбөрийн тэнцэл 2027-2029 онд** уул уурхайн экспортын орлого, ялангуяа **нүүрс, зэс зэрэг түүхий эдийн үнэ болон экспортын биет хэмжээнээс ихээхэн хамаарах төлөвтэй** байна. Хэрэв экспортын орлого тогтвортой өсөх нөхцөл бүрдвэл барааны худалдааны ашиг нэмэгдэж, урсгал дансны алдагдал буурах боломжтой. Харин түүхий эдийн үнэ буурах, экспортын хэмжээ саарах нөхцөл үүсвэл урсгал дансны алдагдал дахин нэмэгдэх эрсдэлтэй.

Үүнээс гадна гадаад санхүүжилтийн нөхцөл, олон улсын санхүүгийн зах зээлийн хүүгийн түвшин, хөрөнгө оруулалтын урсгалын чиглэл өөрчлөгдөх нь санхүүгийн дансны урсгалд нөлөөлөх боломжтой. Хэрэв гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал буурах, эсвэл олон улсын санхүүгийн нөхцөл чангарах тохиолдолд урсгал дансны алдагдлыг санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж, валютын нөөцөд дарамт үүсэх эрсдэл нэмэгдэх магадлалтай.

Иймд дунд хугацаанд төлбөрийн тэнцлийн тогтвортой байдлыг хангахад **экспортын бүтцийг төрөлжүүлэх, үйлчилгээний импортын өртгийг бууруулах, дотоодын үйлдвэрлэлийн чадавхыг нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг тогтвортой хадгалах бодлого чухал** хэвээр байна. Мөн гадаад өрийн зохистой удирдлага, валютын нөөцийн хангалттай түвшнийг хадгалах нь төлбөрийн тэнцлийн богино хугацааны савлагааг бууруулах үндсэн нөхцөл болох юм.

### 2.3. МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ БА ИНФЛЯЦ


#### Мөнгөний нийлүүлэлт

Монгол Улсын мөнгөний нийлүүлэлт (M2) 2014 оны эцэст 10.6 их наяд төгрөг байсан бол 2025 оны эцэст 47.1 их наяд төгрөгт хүрч, сүүлийн 11 жилийн хугацаанд ойролцоогоор 4.4 дахин өссөн байна. Энэхүү өсөлт нь эдийн засгийн мөчлөг, экспортын орлогын хэлбэлзэл, төсвийн бодлогын чиглэл, банкны зээлийн тэлэлт, мөнгөний бодлогын төлөвтэй уялдан өөрчлөгдөж иржээ.

Мөнгөний нийлүүлэлт 2015 онд өмнөх оноос 5.5 хувиар буурсан нь тухайн үеийн эдийн засгийн идэвхжил сул, санхүүгийн нөхцөл хязгаарлагдмал байснаас шалтгаалжээ. Харин 2016–2018 онд мөнгөний нийлүүлэлт эрчимтэй өсөж, 2017 онд 30.4 хувь, 2018 онд 22.8 хувийн өсөлттэй гарсан нь зээлийн тэлэлт, эдийн засгийн сэргэлт, төсвийн идэвхжил нэмэгдсэнтэй холбоотой. Энэ үед мөнгөний урсгалын огцом нэмэгдсэн нь дотоод эрэлтийг дэмжиж, инфляцын дарамтыг өсгөх суурь нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн хурд 2019–2022 онд саарч, жилийн өсөлт 6.5–16.2 хувийн хооронд хэлбэлзсэн нь мөнгөний бодлогыг харьцангуй хязгаарлах чиглэлд шилжүүлсэн, эдийн засгийн гадаад орчны тодорхой бус байдал нэмэгдсэн, цар тахлын нөлөө зэрэг хүчин зүйлстэй уялдаж байна. Гэвч 2023 онд мөнгөний нийлүүлэлт 24.2 хувиар огцом өссөн нь экспортын орлого нэмэгдсэн, санхүүгийн урсгал сайжирсан, зээлийн тэлэлт дахин идэвхжсэнтэй холбоотой бөгөөд энэ нь инфляцын дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулсан юм.

Зураг 18. Монгол Улсын мөнгөний нийлүүлэлтийн динамик /2014–2025 он/, сая төгрөгөөр



Эх сурвалж: Монголбанк, Үндэсний статистикийн хороо, 2026


Мөнгөний нийлүүлэлт 2024 онд 42.6 их наяд төгрөг болж 2023 оноос 15.5 хувиар өсжээ. Үүний дотор төгрөгийн харилцахын үлдэгдэл 10.7 их наяд төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 1.0 их наяд төгрөг, төгрөгийн хадгаламж 22.0 их наяд төгрөг, валютын хадгаламж 4.9 их наяд төгрөг, валютын харилцахын үлдэгдэл 4.0 их наяд төгрөг байсан байна. Харин 2025 оны жилийн эцэст мөнгөний нийлүүлэлт 47.1 их наяд төгрөг

болж, өмнөх оноос 10.6 хувиар өссөн бөгөөд төгрөгийн харилцахын үлдэгдэл 10.2 их наяд төгрөг, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 1.0 их наяд төгрөг, төгрөгийн хадгаламж 26.0 их наяд төгрөг, валютын хадгаламж 5.7 их наяд төгрөг, валютын харилцахын үлдэгдэл 4.1 их наяд төгрөг болж төгрөгийн харилцахаас бусад нь өссөн дүнтэй байна.

Ийнхүү мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2024, 2025 онд харгалзан 15.5 ба 10.6 хувьд тогтворжсон нь мөнгөний бодлого инфляцын дарамтыг хязгаарлах чиглэлд ажиллаж байгааг илэрхийлж байна. Ийм түвшний өсөлт нь эдийн засгийн бодит өсөлттэй харьцангуй нийцтэй байж болох боловч экспортын орлого дахин огцом нэмэгдэх, төсвийн зардал тэлэх, зээлийн өсөлт хурдсах нөхцөлд мөнгөний нийлүүлэлт дахин өндөр хурдаар өсөх эрсдэл хадгалагдана.

ДНБ-д мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2014 онд 47.8 хувь байсан бол 2020 онд 65.4 хувь болж хамгийн өндөр хувьд хүрсэн байна. 2020 оны өсөлт нь цар тахлын үед эдийн засгийг дэмжих бодлогын арга хэмжээ, санхүүгийн систем дэх хөрвөх чадварын нэмэгдэлтэй холбоотой гэж үзэх үндэслэлтэй. Үүнээс хойш ДНБ-д эзлэх мөнгөний нийлүүлэлтийн хувь буурч, 2022–2025 онд 52.3-55.1 хувийн түвшинд тогтворжсон нь мөнгөний тэлэлт эдийн засгийн бодит өсөлттэй харьцангуй ойртсон, харин 2020 оны огцом тэлэлтийн нөлөө аажмаар саарсныг илэрхийлж байна. Доорх зургаас мөнгөний нийлүүлэлт нь инфляцын төлөвтэй нягт уялдаатайг харж болно. Мөнгөний нийлүүлэлтийн огцом өсөлттэй (ялангуяа 2017, 2018, 2023 он) оны дараагийн жилд дотоод эрэлт нэмэгдэж, үйлчилгээ болон импортын барааны үнэ өсөх нөхцөл бүрдсэн. Харин мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарсан үед инфляц буурах хандлага ажиглагдсан. Энэ нь мөнгөний нийлүүлэлт, зээлийн тэлэлт, инфляцын хоорондын уялдаа Монгол Улсад бодитой оршиж буйг харуулж байна.

**Зураг 19. Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт, инфляцын түвшин, мөнгөний бодлогын хүү, жилийн дундаж /2017-2025 он/, хувиар**



Эх сурвалж: Монголбанк, ҮСХ, 2026


Зах зээлд байгаа мөнгөний нийлүүлэлтийн тоо хэмжээний жилийн өсөлт 2024, 2025 онд өмнөх оноос буурсан ч хэрэглээний үнийн индекс 2024 онд өмнөх онтой харьцуулахад өссөн, харин 2025 онд буурсан байна. Мөнгөний бодлогын хүү 2017-2025 онд цар тахлын үе буюу 2019-2021 оныг оруулахгүйгээр тооцвол 10.1-13.0 хувь байсан. Эндээс Төв банк

нийт зах зээлд байгаа мөнгөний нийлүүлэлтийн нийт хэмжээ болон инфляцын түвшнийг харгалзан мөнгөний бодлогын хүүгээр дамжуулан хатуу бодлого хэрэгжүүлж ирсэн нь харагдаж байна. Хэрэв мөнгөний нийлүүлэлт бодит эдийн засгийн өсөлтөөс давсан хурдаар өсвөл инфляц зорилтот түвшнээс хазайх, ханшийн дарамт нэмэгдэх, хөрөнгийн зах зээл дээр хөөсрөлт үүсэх эрсдэлтэй. Нөгөө талаас мөнгөний өсөлтийг хэт огцом сааруулах нь зээлийн урсгал хумигдаж, хөрөнгө оруулалт, эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөх боломжтой. Иймд дунд хугацаанд мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг тогтвортой, эдийн засгийн бодит өсөлт болон инфляцын зорилттой уялдуулсан бодлогын хүрээнд барих нь макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах суурь нөхцөл болно гэж үзэж байна.

### Инфляцын төлөв байдал, учирч болох эрсдэл

Монгол Улсын инфляцын динамик нь *экспортын орлогын мөчлөг, валютын ханшийн савлагаа, импортын үнийн өөрчлөлт, хүнсний нийлүүлэлтийн нөхцөл, мөн төсвийн бодлогын эрэлтийн нөлөөллөөс өндөр хамааралтай хэвээр* байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн зах зээл дээр түүхий эд, шатахуун, хүнсний үнэ огцом өссөн, тээвэр логистикийн өртөг нэмэгдсэн, дотоодын эрэлт тэлсэн зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц богино хугацаанд эрчимжиж, үнийн өсөлтийн дарамт өндөр түвшинд хүрсэн. Улмаар мөнгөний бодлого чангарч, нийлүүлэлтийн шок аажмаар саарснаар инфляц буурах чиглэл давамгайлсан боловч *зорилтот түвшинд тогтвортой хадгалагдаж чадахгүй* байна.

Зураг 20. Монгол Улсын инфляцын динамик /2019-2026 он/, хувиар




Эх сурвалж: УСХ, [www.1212.mn](http://www.1212.mn)

Сүүлийн жилүүдийн байдлаар инфляц зорилтот түвшнээс дээгүүр хадгалагдаж байгаа хэдий ч харьцангуй тогтвортой түвшинд байгаа нь нийт инфляцад хүнсний бүлэг, импортын барааны өртгийн хэлбэлзэл илүү хүчтэй нөлөөлж байгааг илэрхийлнэ. Ийм нөхцөлд инфляцын суурь дарамт аажмаар буурах боломжтой боловч богино хугацаанд үнийн хэлбэлзэл өндөр хэвээр байх төлөвтэй байна.

Инфляцын гүйцэтгэлийг авч үзвэл 2025 оны жилийн эцсийн байдлаар хэрэглээний үнийн индекс өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар өссөн байна. Инфляцын түвшинд хүнсний бүлгийн үнийн өсөлт голлон нөлөөлсөн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын байдлаар хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 11.3 хувиар өссөн нь нийт инфляцын өсөлтөд хамгийн ихээр нөлөөлжээ. Харин орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ 4.6 хувь, тээврийн бүлгийн үнэ 2.2 хувиар өссөн нь инфляцын нийт түвшинд дунд зэргийн нөлөө үзүүлсэн

байна. Ийнхүү 2025 онд инфляц харьцангуй тогтворжих хандлага ажиглагдсан боловч хүнсний инфляц өндөр хэвээр байснаар нийт инфляц зорилтот түвшнээс дээгүүр гарчээ.

Зураг 21. Инфляцын зорилт, төсөөлөл болон бодит түвшний харьцуулалт /2022-2026/, хувиар



Эх сурвалж: ҮСХ (2026). [www.1212.mn](http://www.1212.mn). Монголбанк (2026). <https://www.mongolbank.mn/mn/v/11382>. ТТБЗ, 2025. <https://www.parliament.mn/mn/74278/>

Тайлбар: 2026\* - энд ҮСХ-оос нийтэлсэн 2026 оны 2-р сард зарласан инфляцын түвшнийг оруулсан болно.

2026 оны эхний 2 сарын инфляцын түвшнийг авч үзвэл үнийн өсөлтийн дарамт тодорхой хэмжээгээр буурах хандлага ажиглагдаж байна. 2026 оны 1 дүгээр сарын байдлаар инфляц 7.5 хувь байсан бол 2026 оны 2 дугаар сард 6.5 хувь болж буурсан байна. Хэдийгээр нийт инфляц буурах чиглэлд шилжиж байгаа боловч хүнсний бүлгийн үнийн өсөлт өндөр хэвээр байгаа юм. Тухайлбал, 2026 оны 1 дүгээр сард хүнсний инфляц 12.6 хувь, 2026 оны 2 дугаар сард 12.3 хувь байсан нь нийт инфляцын түвшинд үргэлжлэн гол нөлөө үзүүлж байна. Харин орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн инфляц 2026 оны 1 дүгээр сард 4.3 хувь, 2 дугаар сард 2.0 хувь болж буурсан байна.

Монголбанк инфляцын зорилтот түвшнийг 2019-2023 онд  $6 \pm 2$  хувь байхаар тооцсон бол ҮСХ-оос мэдээлдэг инфляцын бодит гүйцэтгэл 2023-2025 онд зорилтот дээд түвшинд болон уг түвшнээс ялимгүй өндөр гарсан байна. Харин ТТБЗ-өөс 2024, 2025 онд бэлтгэсэн “Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал”-даа инфляцыг 2024, 2025 онд 8.0 хувь, 2026 онд 8.2, 2027 онд 7.2, 2028 онд 6.8 хувь байхаар төсөөлсөн. Инфляцын бодит гүйцэтгэлийг ҮСХ-оос гаргасан мэдээлэлтэй харьцуулж үзэхэд ТТБЗ-ийн төсөөлөл нь бодит гүйцэтгэлтэй илүү ойр байгаа юм.

Инфляцын цаашдын төлөвт цалин, тэтгэврийн өсөлт, төсвийн тэлэлтийг дагасан эрэлтийн шалтгаантай дарамт нэмэгдэхээс гадна Засгийн газар болон нийслэлээс хэрэгжүүлэх мега төслүүдийн санхүүжилт нь төлбөрийн тэнцэл, валютын ханшаар дамжин инфляцын дарамт учруулах, цахилгаан дулааны төлбөр, шатахууны үнийн өсөлт нь зардлын болон хүлээлтийн сувгаар инфляцыг өдөөх эрсдэлийг дагуулахаар байна.

Цаашид дотоодын эрэлт буюу Засгийн газрын хэрэглээ болон хөрөнгө оруулалт нэмэгдэх, нөгөө талаас гадаад эрэлт хязгаарлагдах, экспортын бууралт болон импортын өсөлтөөс

шалтгаалан бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бий болох магадлалтай байна. Энэ нь нийт эдийн засагт инфляцын сөрөг нөлөөлөл бий болох эрсдэлийг дагуулж байгаа юм.

Сүүлийн жилүүдэд Засгийн газрын үйл ажиллагаанаас шалтгаалсан инфляцыг хөөрөгдөх явц ойр ойрхон давтагдах болсон. Төсвийн хувьд авч үзэхэд цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийн нэмэгдэл, ногдол ашиг хуваарилалт гэх мэт. Нэг талдаа орлого багатай иргэдийн хувьд амьдралд нь нэмэртэй боловч нийт эдийн засгийн утгаараа бэлэн мөнгөний нийлүүлэлт ихсэхийн хэрээр мөнгөний нийт нийлүүлэлт ихсэж улмаар инфляц өсөж байна. Өнгөрсөн онд гэхэд зах зээлд нийлүүлэгдэж байгаа мөнгөний тоо хэмжээ сар тутам 1 их наяд төгрөгөөр нэмэгдэж байсан. Хэрэглээний үнийн индекс өсөхөд нөлөөлж байгаа нэг гол зүйл бол өргөн хэрэглээний хүнсний бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт голлож байгааг статистикийн тоон мэдээлэл харуулж байна.

Төсвийг тэлэх бодлого явуулах, төсвийн зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээ нь Төв банкнаас явуулж байгаа мөнгөний хатуу бодлого буюу үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах зорилгод сөргөөр нөлөөлдөг. Иймээс өнөөгийн нөхцөлд Төв банк мөнгөний хатуу бодлого баримтлахаас өөр аргагүй байдалд орж байна. Энэ нь нөгөө талаас эдийн засагт буюу бодит секторт орох мөнгөний нийлүүлэлт тасалдах, үйлдвэрлэл, үйлчилгээ хумигдах байдалд хүргэнэ.

*Дунд хугацаанд* буюу 2027–2029 онд инфляцын суурь төлөв нь мөнгөний бодлогын зорилт, төсвийн бодлогын чиг баримжаа, гадаад орчны үнийн динамик, экспортын орлогын тогтвортой байдал, валютын ханшийн хөдөлгөөнөөс ихээхэн хамаарна. Инфляцыг дунд хугацаанд тогтвортой, нам түвшинд хадгалах бодлогын зорилт хэрэгжих суурь нөхцөл бүрдэх боломжтой боловч бодит гүйцэтгэл нь дотоод болон гадаад эрсдэлээс шалтгаална.

*Дотоод эрсдэлийн хувьд* төсвийн зардлын өсөлт, хөрөнгө оруулалтын тэлэлт, цалин, тэтгэвэр, нийгмийн халамжийн нэмэгдэл нь нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар үйлчилгээ, дотоодын барааны үнийн өсөлтийг хурдасгах эрсдэлтэй. Хэрэв төсвийн бодлогыг тэлэх чиглэл давамгайлбал инфляцын дарамт нэмэгдэх магадлалтай бөгөөд үүнийг сааруулах зорилгоор мөнгөний бодлогыг хязгаарлах шинжтэй хадгалбал санхүүжилтийн өртөг өсөх, зээлийн өсөлт саарах, улмаар эдийн засгийн өсөлтийн хурд буурах эрсдэл үүсэх боломжтой. Иймээс *инфляцын төлөвийг үнэлэхдээ бодлогын уялдаа, макро тэнцвэрийн шаардлагыг харгалзан үзэх нь зүйтэй.*

*Гадаад эрсдэлийн хувьд* валютын ханшийн савлагаа, ам.долларын чангаралт, олон улсын санхүүгийн нөхцөлийн өөрчлөлт, тээвэр логистикийн өртгийн өсөлт нь импортын үнийн сувгаар дамжин инфляцыг нэмэгдүүлэх эрсдэл хэвээр байна. Монгол Улс импортын хамаарал өндөртэй эдийн засаг тул ханш сулрах үед шатахуун, өргөн хэрэглээний бараа, тоног төхөөрөмжийн үнэ богино хугацаанд өсөх хандлагатай байдаг. Хэрэв экспортын орлого буурах мөчлөгтэй давхацвал ханшаар дамжсан инфляцын дарамт нэмэгдэж, төлбөрийн тэнцэл болон валютын нөөцөд сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

*Нийлүүлэлтийн талын эрсдэлийн хувьд* хүнсний салбарын үйлдвэрлэл, цаг уурын нөхцөл, хадгалалт, тээвэрлэлтийн хүндрэл зэрэг нь инфляцын хэлбэлзлийг тодорхойлох хүчин зүйл хэвээр байна. Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд сөрөг шок үүсэх, мах, гурил, хүнсний ногооны нийлүүлэлт тасалдах тохиолдолд нийт инфляц түр хугацаанд огцом өсөх магадлалтай. Үүний зэрэгцээ эрчим хүч, дулаан, нийтийн үйлчилгээний зохицуулалттай үнэ тарифын үе шаттай шинэчлэл инфляцын богино хугацааны өсөлтийг үүсгэж болзошгүй.

Иймд **2027-2029 оны суурь төсөөллөөр** инфляц аажмаар намжиж, зорилтот түвшинд ойртох боломжтой боловч эрэлтийн тэлэлт, ханшийн сулрал, импортын өртгийн өсөлт, хүнсний нийлүүлэлтийн шок, зохицуулалттай үнэ тарифын өөрчлөлт зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр инфляц зорилтот түвшинээс түр хугацаанд хазайх эрсдэл хадгалагдана.

*Инфляцын тогтвортой байдал* нь эдийн засгийн тогтвортой өсөлт, бодит орлогын хамгаалалт, гадаад өрийн тогтвортой байдал, санхүүгийн зах зээлийн итгэлцлийн үндсэн нөхцөл тул 2027-2029 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд инфляцын төлөвийг бодлогын шийдвэр гаргалтын төв үзүүлэлт болгон авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

---

#### 2.4. ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, ЦААШДЫН ХАНДЛАГА

##### **Монгол Улсын нэгдсэн төсвийн өнөөгийн төлөв байдал**

---

Дэлхийн банкны тодорхойлсноор төсвийн тогтвортой байдал гэдэг нь Засгийн газрын санхүүгийн байдал дунд болон урт хугацаанд тогтвортой, зээлийн эрсдэл багатай байхыг (World Bank, 2019, Fiscal Sustainability, Debt, and Economic Growth) хэлдэг байна. ЭЗХАХБ-аас төсвийг оновчтой удирдахад баримтлах 10 зарчмыг дурдсаны нэг нь “Урт хугацааны тогтвортой байдал болон төсөвт учрах эрсдэлийг тодорхойлж, үнэлж, тооцоотойгоор удирдах” гэж заасан байдаг. Эдүгээ төсвийн шаардлага, дүрэм тогтоосон 100 гаруй улс байгаа бөгөөд тусгай шаардлагуудыг дагаж мөрдөж чадвал ялангуяа эрдэс баялгаас хараат эдийн засаг бүхий орнуудын хувьд чухал хамгаалалтын хэрэгсэл болдог байна. Монгол Улс 2010 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, төсөв, санхүүгийн удирдлагыг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн, эдийн засгийн мөчлөг дагасан хэлбэлзэлгүй, өрийн дарамтыг хэт нэмэгдүүлэхгүйгээр төлөвлөн хэрэгжүүлж, төсвийн тогтвортой байдлыг хангана гэсэн агуулгыг тусган мөрдөж, төсвийн эрсдэлийн удирдлагад хяналт тавих чиг үүрэг бүхий Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг 2017 онд байгуулж, 2024 оноос байнгын ажиллагаатай болгосон. Хэдийгээр энэ хуульд эрсдэлээс хамгаалах тусгай шаардлагуудыг тусгасан боловч биелэлт нь хангалтгүйн дээр элдэв аргаар тойрон гарах, эсвэл ойр ойрхон өөрчлөх хандлага давтагдсаар байгааг хавсралт 3-аас харж болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хууль 2010 онд батлагдсанаас хойш 2025 он хүртэл 21 удаа өөрчлөлт орсон нь ихэвчлэн төсвийн тусгай шаардлагын нөхцөлийг сулруулах, хэрэгжих хугацааг хойшлуулахад чиглэж ирсэн байдаг.

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн орлого 31.6 их наяд, зарлага 32.98 их наяд төгрөг буюу 1.3 хувийн алдагдалтай байхаар батлагдсан. 2025 оны гүйцэтгэлээр орлого буурч зарлага зарим талаар нэмэгдсэн нь төсвийн тэнцэлд дарамт үзүүлж байна. 2023 онд Монгол Улс анх удаа төлбөрийн болон төсвийн тэнцлийн хувьд ашигтай байсан нь эдийн засгийн хувьд ихээхэн эерэг үзүүлэлт болсон ч энэ нь удаан хадгалагдаж чадаагүй бөгөөд 2024, 2025 онд тэнцлийн хос алдагдалтай гарсан. 2026 онд ч энэ байдал давтагдах эрсдэлтэй юм. ОУВС-гийн 2025 оны тайланд “2023-2024 онд эдийн засаг өсөлттэй, төсөв ашигтай гарсан нь гадаад валютын нөөц нэмэгдэх, төсвийн орлого өсөх, өрийн дарамт буурах гол нөхцөлийг бүрдүүлсэн ч мөн хугацаанд төсвийн зарлага огцом тэлсэн нь зээлийн өсөлт, инфляцыг өдөөж, 2025 оны I дүгээр сараас нүүрсний экспорт буурч, голчлон үнийн уналт, дэлхийн тодорхойгүй байдалтай холбоотойгоор хэтийн төлөв тааламжгүй болсон” (Mongolia: 2025 Article IV Consultation) гэжээ. Энэ нь төсвийн тогтвортой байдлын хувьд

богино хугацаанд нааштай үр дүнгүүд гарсан ч дунд хугацааны эрсдэлүүд байгаа гэсэн дохио юм.


Дэлхийн банкны судалгаанд уул уурхайн салбараас олж буй орлогоор төсвийн зардлыг нэмэгдүүлсэн нь зарим талаар нөхцөл байдлыг сайжруулсан ч эмзэг байдлыг нэмэгдүүлж байгааг онцолжээ. Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь цар тахлын өмнөх үеэс өндөр, уул уурхайн бүтээгдэхүүний үнэ, экспортын зах зээлийн байдал төсвийн орлогод шууд нөлөөлдөг учраас орлого тасалдах, нийгмийн халамж, урсгал төсвийн зардлууд нэмэгдсэн нь дунд хугацаанд дарамт үүсгэх эрсдэлтэйг тооцон төсвийн бодлогод шинэчлэл хийх шаардлагатайг анхааруулж байна.

Монголын эдийн засгийн хамгийн эмзэг цэг бол төсвийн орлогын 35-45 хувийг бүрдүүлж буй нүүрс, зэс, алтны экспорт, эдгээртэй шууд ба шууд бус холбоотой орлого бүрдүүлэлт юм. Өөрөөр хэлбэл, дэлхийн зах зээлийн үнэ, Хятад улсын эрэлт, тээвэр-логистик гээд биднээс үл хамаарах хүчин зүйлс ихээхэн нөлөөтэй байна.

Орлого өндөр үед тогтворжуулалтын санд хангалттай хуримтлал үүсдэггүй, уул уурхайн орлогыг байнгын эх үүсвэр мэт бодож төсөвлөдөг нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үзэл санаатай зөрчилдөж байна. Түүнчлэн НӨАТ, ХАОАТ, ААНОАТ-ын орлого нэмэгдэж байгаа ч дотоодын үйлдвэрлэл, бүтээмж сул учраас татварын бааз суурь өргөн биш, нэг үгээр уул уурхайн салбар өсөлттэй байвал төсөв сайн, бусад үед хүндрэлтэй байх бүтцийн хамаарал хэвээр үргэлжилж байна. Хөрөнгө оруулалт тарамдсан, эдийн засгийн өгөөж багатай, ашиглалт, засвар үйлчилгээний дарамт ихтэй тул өнөөдрийн хөрөнгө оруулалт маргаашийн урсгал зардлыг өсгөдөг. Эндээс харвал Монгол Улсын төсвийн үндсэн шинж нь орлогын хувьд уул уурхайгаас хэм хамааралтай, зарлагын бүтцэд урсгал зардал давамгайлсан, мөчлөг дагах байдал өндөр, дунд хугацаанд тогтвортой байдлын хувьд эрсдэлтэй байна.

**Хуульд ойр ойрхон өөрчлөлт оруулж, төсвийн тусгай шаардлагыг сулруулснаар сүүлийн жилүүдэд төсвийн тэлэлт огцом нэмэгдэж ирсэн. Дараах зурагт Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдсанаас хойших хугацааны төсвийн орлого, зарлага, тэнцэл, тэнцлийг харуулав.**

**Зураг 22. Монгол Улсын 2010-2025 оны пэгдсэн төсвийн орлого, зарлага, тэнцэл, /сая төгрөг/**



Эх сурвалж: (ҮСХ, 2025)

Эндээс үзэхэд 2010, 2018, 2023 оныг эс тооцвол бусад бүх жилд төсөв алдагдалтай явж ирсэн бөгөөд энэ хугацаанд төсвийн тэнцвэржүүлсэн орлого 9.5, зарлага ба цэвэр зээл 9.9 дахин нэмэгдэж, 19.6 их наяд төгрөгийн алдагдалтай байв. Ийнхүү алдагдал бий болсон нь нэг талаас төсвийн эрх зүйн орчин, Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ)-ийг тогтмол өөрчилж ирсэнтэй, нөгөө талаас тухайн төсвийн жилийн дараах жилийн төсвийн төсөлд баримтлах, түүний дараагийн хоёр, гурав дахь жилийн төсвийн төсөөлөлд тусгах гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийг тооцож буй одоогийн аргачлал нь төсвийн орлогыг хийсвэрээр нэмэгдүүлэх нэг нөхцөл болж байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл, төсөвт нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг өөрсдийн зардаг үнээр биш дэлхийн зах зээлийн үнийг дундажлан тооцдог учраас төсвийн төлөвлөлт бодитой болж чадахгүй, төсвийн тэнцвэржүүлсэн орлогод тооцож буй тэнцвэржүүлсэн үнийн нөлөө, суурь оны өөдрөг таамаглалтай холбоотой эрсдэл гарч байна. Түүнээс гадна Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.2.1-д заасан Төсвийн тогтворжуулалтын сангийн нэг гол эх үүсвэр болох “татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлого” тогтвортой бүрдэхгүй байх нөхцөл болж байна. Иймээс гол нэрийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн үнийн төсөөллийг Засгийн газар, Сангийн яамнаас аль болох хараат бус субъект тодорхойлж байх нь төсвийн тогтвортой байдлыг хангахад нэн чухал юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2025 оны төсвийн төсөлд бүхэлд нь хориг тавьснаар анх удаа алдагдалгүй төсөв батлагдсан нь тун удалгүй өөрчлөгдсөн билээ. Харин 2026 оны төсвийн зарлагын хэмжээ 2025 оны түвшинд байхаар төлөвлөгдсөн нь эдийн засгийн тодорхой бус нөхцөл байдалд төсвийг хэт тэлэх бодлого баримтлахыг зогсоох эхлэл болж, ТТБЗ-ийн 2024 оноос баримталж ирсэн бодлогын хандлагатай нийцэж байна. Гэхдээ сүүлийн гурван жилд нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг өндрөөр тооцож, дагуулаад орлого, зарлагаа нэмсэн нь төсөвт алдагдал үүсэх гол шалтгаан болсон төдийгүй 2026 онд 101 сая тонн нүүрс экспортод гаргаж, тэнцвэржүүлсэн үнийг 133.7 ам. доллар байхаар төлөвлөж байна.

### Хүснэгт 13. Нүүрсний экспортын нийт хэмжээ, тэнцвэржүүлсэн болон зах зээлийн үнэ

Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нүүрсний экспорт, сая тонн	36.2	36.6	28.6	16.1	31.8	69.6	83.7	89.5
Тэнцвэржүүлсэн үнэ, тн/ам.доллар	75.9	75.5	76.3	73.4	110.8	182.5	129.0	129.0
Тэнцвэржүүлсэн үнээр тооцсон орлого, тэрбум ам.доллар	2.75	2.76	2.18	1.18	3.52	12.70	10.79	11.54
Жилийн дундаж зах зээлийн үнэ, тн/ ам.доллар	77.3	81.9	73.4	167.7	204.3	127.8	103.8	64.2
Экспортын нийт орлого, тэрбум ам.доллар	2.79	2.99	2.09	2.70	6.49	8.89	8.68	5.74
Зөрүү, тэрбум ам.доллар	+0.04	+0.23	-0.09	+1.52	+2.97	-3.81	-2.11	-5.80

Эх сурвалж: ТТБЗ


Түүнчлэн Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр оруулсан өөрчлөлт болон Засгийн газраас боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлсэн “Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд тусгагдсан шинэчлэлийн төсөвт үзүүлэх шууд нөлөө Сангийн яамны тооцоолсноор -2.7 их наяд, ТТБЗ-ийн судалгаагаар -3.7 их наяд төгрөг орчим байгаа нь ДНБ-ий 3-4 хувь болох буюу мөн

хэмжээний төсвийн алдагдал үүсгэн 2027 оноос төсвийн тэнцлийн тусгай шаардлагууд биелэхгүйд хүрэхээр байна.

**Монгол Улсын төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг зохистой түвшинд барих ёстой.** Дэлхийн 156 орны төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувийг 2023 оны байдлаар тооцсон судалгаанаас харвал хамгийн өндөр нь Украин 41.86, Лесото 35.58, Ливи 35.28, хамгийн бага нь Ангол, Ливан тус бүр 5.17 хувь байжээ (IMF, 2024). Ихэнх судлаач энэ харьцаа 25-40 хувь байхыг эрүүл гэж үздэг ч дундаж үзүүлэлт суурь дэд бүтэц, эрүүл мэнд, боловсролын салбараа санхүүжүүлэх хэрэгцээ ихтэй хөгжиж буй орнуудын хувьд 25-30, нийгмийн хамгаалал, тэтгэвэр, эрүүл мэндийн үйлчилгээнд их зардал гаргадаг хөгжингүй орнуудын хувьд 35-45, өндөр татвартай ч маш өндөр хүртээмжтэй төрийн үйлчилгээ үзүүлдэг Нордикийн орнуудын тухайд 45-50+ хувь байна.

Харин Монгол Улс шиг уул уурхай давамгайлсан эдийн засагтай, орлогын хэлбэлзэл ихтэй, бүс нутгуудын хөгжил нь тэнцвэргүй орны хувьд төсвийн зарлагын хувь хэмжээ өндөр байх нь зохисгүй бөгөөд эрсдэлтэй байх магадлалтай. Дээрх зургаас харвал манай улсын тухайд энэ үзүүлэлт 30-40 хувьд хэлбэлзэж ирсэн нь уул уурхайн өсөлтийн үед ДНБ-ны өсөлтийг дагуулан төсвийг тэлэх, эсвэл эдийн засгийн хямралтай жилүүдэд төсвийн зарлагыг тэлсэн нь нөлөөлсөн гэж үзэж болохоор байна. ТТБЗ-ийн зүгээс энэ харьцаа буурч байгаа, цаашид бууруулах шаардлагатай бөгөөд бууруулах шаардлагатай хэмээн үзэж байгаа билээ.

**Зураг 23. Төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь /2010-2025/**



Эх сурвалж: ТТБЗ

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд жил бүхэн бууруулж, 2026 онд 32.2, 2027 онд 30.0, 2028 онд 28.6 хувьд хүргэхээр заасан нь нааштай хандлага гэж үзэхээр байгаа юм. Гэхдээ гол асуудал хувьдаа биш, ихэнх зардал чухам юунд зориулагдаж байна гэдэгт оршино. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалт уу, урсгал зардал уу, эдийн засгаа төрөлжүүлэхэд түлхэц болж байна уу гэдэг нь чухал юм.

Нэгдсэн төсвийн нийт зарлагын бүтцийг харвал урсгал зардал ойролцоогоор 65-70, хөрөнгө оруулалт 30-35 хувьтай байна. Зүй нь урт хугацааны өгөөжтэй, хувийн хөрөнгө оруулалтыг татах, экспортыг дэмжих төслүүдийг дэмжвэл төсөв эдийн засгийн хурдасгуур болох боломжтой. Гэвч бидний өнөөгийн бодит байдал орлого өсөхөд зардал тэлдэг, орлого буурахад буцаад агшдаггүй учраас шууд алдагдал, өр үүсэх нөхцөлийг бий болгодог. Үүний

улмаас хувийн хэвшил татвар, инфляцын дарамтад байнга өртөж, төр хамгийн том ажил олгогч болох нөхцөл бүрдэж, хувийн хэвшил хүний нөөцөө алдах болно.

Түүхий эд экспортлогч орны тухайд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь өндөр байх нь эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй байдаг гэсэн судлаачдын дүгнэлт бий. Дүгнэж хэлбэл, Монгол Улсын төсөв зөвхөн өнөөдрийн хэрэгцээг санхүүжүүлж, маргаашийн өсөлтийг хангаж чадахааргүй дүр зурагтай байна.

**Цаашид төсвийн орлого зөвхөн урсгал зардлаа даах төдий хэмжээнд хүрэх, төсвөөр эдийн засгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын бодлого хэрэгжих орон зай хумигдах магадлалтай байна.** Төсвийн тэлэлт бага, дунд болон урт хугацаандаа сөрөг нөлөөтэй бөгөөд ялангуяа төсвийн урсгал зардлыг ихээхэн нэмэгдүүлж, нийт зарлагын 64.8-81.9 хувийг эзлэх болсон нь анхаарал татах асуудал мөн.

Урсгал зардал давамгайлсан бүтэц богино хугацаанд өрхийн хэрэглээг дэмжих эерэг нөлөөтэй боловч дунд болон урт хугацаанд үйлдвэрлэл, бүтээмж, экспортын чадавхыг нэмэгдүүлэх хангалттай нөхцөлийг бүрдүүлж чаддаггүй учраас эдийн засгийн өсөлт, төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, нийгмийн халамж зэрэг урсгал зардлыг бууруулахад хүндрэлтэй тул төсөв орлогын хэлбэлзэлд эмзэг болж, эдийн засгийн уналтын үед төсвийн алдагдал, өрийн дарамт нэмэгдэх эрсдэлийг үүсгэдэг. Энэ байдал нь уул уурхайн салбараас өндөр хамааралтай Монгол Улсын эдийн засагт мөчлөг дагасан савлагааг улам гүнзгийрүүлж байгааг цаашид бодлогын түвшинд анхаарах шаардлагатай.

**Зураг 24. Төсвийн нийт болон урсгал зардлын динамик, нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувь /2010-2025 он/**



Эх сурвалж: (ҮСХ, 2025)


Иймд төсвийн бодлогын шинэчлэлийн хүрээнд зардлын бүтцийг эргэн харж, урсгал зардлын өсөлтийг хязгаарлахын зэрэгцээ хөрөнгө оруулалтын эзлэх хувийг нэмэгдүүлэх нь нэн тэргүүний зорилт юм. Чухам энэ үүднээс төсвийн урсгал зардлыг өсгөж буй эрх зүйн зохицуулалтыг эргэн харж, энэ үзүүлэлтийг 60-аас доош хувьд барих шаардлага гарцаагүй

үүсэж байгаа ч харамсалтай нь үүнийг шийдэх улс төрийн боломж хязгаарлагдмал харагдаж байна.

**Ойрын жилүүдэд төсвийн тусгай шаардлагуудыг хангахад хүндрэл учирч болзошгүй.** 2020-2025 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын жилийн дундаж өсөлт 26.2 хувь (үүнд цалин, хөлсний нөлөө хамгийн өндөр) байсан бол нэрлэсэн ДНБ-ий өсөлт 17 хувь байжээ. Энэ хандлага цааш үргэлжилбэл ойрын хэдхэн жилийн дараа урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь 30-аас хэтрэх буюу төсвийн тусгай шаардлага зөрчигдөх нөхцөл үүсэж болзошгүй байна.

**Төсвийн бодлогын гол алдаа нь мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүлж чадахгүй байгаа явдал юм.** Мөчлөг сөрсөн бодлогын асуудал зөвхөн эдийн засаг хүндэрсэн, төсвийн орлого тасалдсан эсвэл алдагдалтай төсөв батлах үед л сөхөгдөж, эдийн засаг өссөн, орлого нэмэгдсэн үед төсвийг тэлэхгүй байх, хуримтлал үүсгэх чиглэлд анхаарахгүй байгааг залруулж, мөчлөг сөрсөн бодлогыг төсөв тэлэх, агших мөчлөгт ялгаваргүйгээр хэрэгжүүлэх шаардлагатай байна. Хэрвээ мөчлөг сөрсөн бодлогыг сүүлийн гурван жилд тууштай хэрэгжүүлж чадсан бол төсвийн хүндрэл үүсэхгүй байх боломжтой байв. Монгол Улсын эдийн засгийн бүтэц, эрдсийн үнэ, хэмжээнээс ихээхэн хамааралтай байдал зэрэг нь байнгын тогтвортой өсөлтийг бий болгох боломжгүй болгодог. Таатай нөхцөл байдал удаан үргэлжилдэггүй болох нь бидний туулж ирсэн өмнөх түүхээс тодорхой харагдаж байна.

**Зураг 25. Төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь /2010-2025/**



Эх сурвалж: ТТБЗ

### ТӨСВИЙН БОДЛОГЫН ЦААШДЫН ХАНДЛАГА

Одоо баримталж буй төсвийн бодлого хэвээр үргэлжилвэл богино хугацаанд (1-2 жил) төсвийн байдал харьцангуй тогтвортой харагдах ч дунд хугацаанд (3-5 жилд) сулрах, бодлогын шинэчлэлийг цаг алдахгүй хийхгүй бол 5 жилийн дараагаас тогтворгүй нөхцөл үүсэх эрсдэл өндөр байна. Учир нь уул уурхайн орлого өндөр үед төсвийн үзүүлэлтүүд боломжийн байх ч зарлага тэлсэн хэвээр байх хандлагатай байна. Харин эрдэс баялгийн түүхий эдийн үнэ, экспортын нөхцөл муудахад орлого буурах ба урсгал зардлыг агшаах

боломж бага. Товчоор хэлбэл, “орлого сайн үед төсөв тогтвортой мэт, муу үед огцом ганхах” мөчлөг хэвээр үлдэнэ.

Нүүрсний үнийн уналт, Хятадын эдийн засгийн агшилт, геополитик, логистикийн шок гэх мэт гадаад орчны таагүй нөлөө үүсвэл төсвийн орлого буурч алдагдал ДНБ-ий 3-5 хувьд хүрэх, өрийн дарамт нэмэгдэх, хөрөнгө оруулалтын төслүүдийн хугацаа сунжрах магадлалтай. Иймд орлогын мөчлөгийг шингээх механизм бүрдүүлж, уул уурхайн орлогоор тогтворжуулалтын санг арвижуулах, зарлагын бүтцийг уян хатан болгож, урсгал зардлын өсөлтийг ДНБ-ий өсөлтөөс доогуур түвшинд барих, халамжийг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлж, хөдөлмөр эрхлэлтэй уялдуулах, хөрөнгө оруулалтын тоог цөөрүүлж, чанаржуулах, “бүгдэд нь багахан хүртээх” бус эдийн засгийн өгөөжтэй цөөн төслийг санхүүжүүлэх чиглэлээр бодлогын шинэчлэл хийх шаардлагатай.

Энэ тохиолдолд төсвийн тогтвортой байдал мөчлөгөөс хамаарал багатай болж, өрийн харьцаа тогтвортой буурч төсөв макро эдийн засгийг дагадаг бус тогтворжуулдаг болно. Гэхдээ бодлогын энэхүү хувилбарыг хэрэгжүүлэхэд улс төрийн зоригтой шийдэл шаардана. Эндээс дүгнэвэл, Монгол Улсын төсвийн тогтвортой байдлын цаашдын хандлага нь орлогын мөчлөгийг шингээх чадвар, урсгал зардлыг хязгаарлах бодлогоос шууд хамаарахаар байна.

Хүснэгт 14. 2026-2030 оны төсвийн тогтвортой байдлын эрсдэлийн матриц

№	Эрсдэлийн төрөл	Илрэх магадлал	Нөлөөллийн хэмжээ	Төсөвт үзүүлэх нөлөө	Тайлбар
1	Эрдсийн түүхий эдийн үнэ буурах	Өндөр	Өндөр	Маш сөрөг	Нүүрс, зэсийн үнэ 20-30 хувь унахад орлого огцом агшина.
2	Хятадын эрэлт саарах	Дунд, өндөр	Өндөр	Маш сөрөг	Экспортын биет хэмжээ буурна.
3	Урсгал зардлын өсөлт	Өндөр	Дунд, өндөр	Сөрөг	Цалин, тэтгэвэр, халамж танагдахгүй.
4	Мөчлөг дагасан төсвийн бодлого	Өндөр	Дунд	Сөрөг	Сайн үед тэлэх ч муу үед агшиж чаддаггүй байдал давтагдана.
5	Хөрөнгө оруулалтын үр ашиг хангалтгүй	Дунд	Дунд	Дунд	Өгөөж багатай төслүүд дарамт үүсгэнэ.
6	Өрийн дахин санхүүжилтийн эрсдэл	Дунд	Дунд, өндөр	Сөрөг	Валютын ханш, хүүгийн савалгаа үүснэ.
7	Улс төрийн мөчлөг	Өндөр	Дунд	Сөрөг	Сонгуулийн өмнөх зардлын өсөлт давтагдана.
8	Байгалийн ба логистикийн шок	Бага, дунд	Өндөр	Дунд, сөрөг	Тээвэр, боомтын үйл ажиллагаанд доголдол үүснэ.

Эх сурвалж: ТТБЗ

**Хүснэгт 15. Эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээ**

№	Эрсдэл	Хариу арга хэмжээ	Хугацаа	Төсөвт үзүүлэх нөлөө
1	Орлогын савалгаа	Бодит үнийн дүрэм+хуримтлал	Дунд	Алдагдал багасна.
2	Урсгал зардал	Зарлагын өсөлтийн дээд хязгаар тогтоох	Ойр	Дарамт буурна.
3	Халамж	Зорилтот бүлэгт чиглүүлэх	Дунд	Байнгын зардал хадгалагдана
4	Хөрөнгө оруулалт	Цөөн, өгөөжтэй төслийг санхүүжүүлэх	Ойр, дунд	Чанар сайжирна.
5	Өр	Өрийн дунд хугацааны зардлыг бууруулах	Ойр	Эрсдэл багасна.

Эх сурвалж: ТТБЗ

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлж чадвал төсвийн алдагдал ДНБ-ий 1-2 хувьд байж, өр тогтвортой буурах ба төсөв тогтворжуулалтын үүрэг гүйцэтгэнэ. Харин бодлогын дорвитой өөрчлөлт хийгээгүй нөхцөлд төсвийн алдагдал ДНБ-ий 4-5 хувьд хүрэх, өр нэмэгдэх, хөрөнгө оруулалт танагдах эрсдэл байна.

Дүгнэж хэлбэл, 2026-2030 онд Монгол Улсын төсвийн тогтвортой байдалд учрах гол эрсдэл нь уул уурхайн орлогын савлагаа болон урсгал зардлын уян хатан бус бүтэц хэвээр байгаатай холбоотой бөгөөд эдгээрийг саармагжуулах институтийн механизм хэрэгжүүлэхгүй тохиолдолд дунд хугацаанд төсвийн тогтворгүй байдал гүнзгийрэх магадлалтай байна. Дараах хүснэгтэд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас боловсруулсан алдагдал бодитоор үүсэхээс өмнө төсвийн эрсдэлийг илрүүлэх, “одоо засах уу, дараа хямрах уу” гэдгийг шийдэх дохио өгөх зорилго бүхий төсвийн тогтвортой байдлын сэрэмжлүүлэх индикаторуудыг харуулав (OECD, 2025).

**Хүснэгт 16. Үндсэн индикаторууд /2026-2030 он/**

№	Индикатор	Сэрэмжлүүлэх босго	Юуг илэрхийлэх
<b>Орлогын эрсдэлийн индикаторууд</b>			
1	Нүүрсний экспортын үнэ	-15% (6 сар дараалан)	Компаниудын ашиг буурч АМНАТ, ААНОАТ тасарч төсвийн орлого огцом унах дохио болно.
2	Зэсийн дундаж үнэ	-10% (нэг жил)	Валютын орлого хумигдаж, төлбөрийн тэнцэлд тогтмол дарамт үүснэ.
3	Экспортын биет хэмжээ	-10% (улирал)	Төлбөрийн тэнцэл муудаж, төгрөгийн ханш огцом сулрах эрсдэл дагуулна.
4	Уул уурхайн орлого/нийт орлого	>45%	Төсвийн тогтворгүй байдал нэмэгдэж, “голланд өвчин” гүнзгийрнэ. Эдийн засаг солонгорох боломж хумигдана.
5	Орлогын гүйцэтгэл/төлөвлөгөө	<95%	Төсөвт тодотгол хийх шаардлага үүснэ. Орлого тасрахад өр нэмэхээс өөр сонголтгүй болно.
<b>Зарлагын эрсдэлийн индикаторууд</b>			
1	Урсгал зардал/нийт зардал	>70%	Төсвийн уян хатан чанар алдагдаж, хөрөнгө оруулалт шахагдана.

2	Цалин+халамж/нийт зардал	>45%	Орлого тасрахад танах бараг боломжгүй зардал давгайлах болсны дохио.
3	Урсгал зардлын өсөлт	ДНБ-ий өсөлтөөс өндөр	Мөчлөг дагасан шинж бөгөөд төсөв эдийн эдийн засгаасаа түрүүлэн тэлж, тогтвортой байдлаа алдаж эхэлсний дохио болно.
4	Хөрөнгө оруулалтын тархалт	ТОП 10 төсөл <40%	Хөрөнгө оруулалт тарамдаж, эдийн засгийн өсөлт удааширна.
<b>Тэнцэл ба өрийн индикаторууд</b>			
1	Төсвийн алдагдал/ДНБ	>3%	Төсвийн тогтвортой байдал алдагдана
2	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	Хоёр жил дараалан сөрөг	Макро тогтвортой байдлын эрсдэл нэмэгдэнэ.
3	Засгийн газрын өр/ДНБ	>60%	Итгэлцлийн эрсдэл үүсэх буюу зээлдүүлэгчдийн нөхцөл шаардлага хатуу болно.
4	Өрийн хүү/орлого	>10%	Төсвийн орлогын 10 хувь нь зөвхөн өрийн хүү төлөхөд зарцуулагдаж байна гэсэн үг. Зээлжих зэрэглэл буурч санхүүжилтийн өртөг нэмэгдэн, төгрөгийн ханш сулрах, инфляц өсөх эрсдэл дагуулна.

Эх сурвалж: OECD, ТТБЗ

Эдгээр үзүүлэлтийг өнөөгийн бодит байдалтай харьцуулж үзвэл зарим нь сэрэмжлүүлэх дохионоос өндөр болсон зарим нь критик утгад дөхсөн үр дүн харагдаж байна. Цаашдын хандлагыг харвал Хятадын ДНБ-ий өсөлт 4 хувиас доош орох, уул уурхайн түүхий эдийн үнэ хоёр жил дараалан унах, ам.долларын ханш жилд 10 хувиар өсөх тохиолдолд төсвийн тусгай шаардлагууд зөрчигдөж, төсвийн тодотголыг ойр ойрхон хийх нөхцөл үүсэж болох юм. Иймээс бодлогын хариу арга хэмжээ болгож нэгдсэн төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувийг бууруулах, урсгал зардлын өсөлтийг хязгаарлах, үр ашиг багатай шинэ хөрөнгө оруулалтыг царцаах, халамжийн тэлэлтийг зогсоох, хуримтлалаас зөвхөн алдагдлыг нөхөх шаардлага үүснэ. Энэ бүхнийг харгалзан төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор орлого, зарлага, өрийн гол үзүүлэлтүүдэд суурилсан эрт сэрэмжлүүлэх индикаторын систем нэвтрүүлж, тодорхой босгонд ойртсон юмуу давсан тохиолдолд бодлогын хариу арга хэмжээг цаг алдахгүй хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

## 2.5. ТӨСВИЙН ЭРСДЭЛ БА ГАДААД ӨР

### Төсвийн эрсдэл

Төсвийн эрсдэлд дүн шинжилгээ хийхэд макро эдийн засгийн эрсдэл (эдийн засгийн өсөлтийн хэлбэлзэл, түүхий эдийн үнэ, ханшийн хэлбэлзэл, инфляц, зээлийн хүүгийн өөрчлөлт), төсвийн орлогын эрсдэл (татварын орлогын тасалдал, байгалийн баялаг, уул уурхайн орлогын тогтворгүй байдал), төсвийн зарлагын эрсдэл (нийгмийн халамж, тэтгэврийн тогтолцооны дарамт, бодлогын өөрчлөлтөөс үүдэлтэй нэмэлт зардал, тарийн албан хаагчдын цалингийн нэмэгдэл), төсвийн төлөвлөлтийн алдаа (хүн амын өсөлт, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, ялангуяа эрчим хүч, дулааны үнэ тарифын өөрчлөлт, бензин шатахууны үнийн нэмэгдэл, төсвийн орлого, зарлагын буруу тооцоолол), Засгийн газрын гадаад болон дотоод өрийн эрсдэл (гадаад болон дотоод өрийн үндсэн өр болон хүүгийн

төлбөрийн зардал, өрийн тогтвортой байдлын үзүүлэлтүүдийн хэлбэлзэл, Засгийн газрын баталгаа, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын өр төлбөр), төрийн санхүүгийн удирдлагын эрсдэл (төсвийн сахилга бат, төсвийн зардлын хэтрэлт, орон нутгийн төсвийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлээс үүдэлтэй өр төлбөр, авлага), байгалийн гамшиг, гадаад хүчин зүйлсийн эрсдэл (цаг уурын өөрчлөлт, ган, зуд, газар хөдлөлт зэрэг байгалийн урьдчилан тооцох боломжгүй гамшиг, геополитикийн эрсдэл, улс хоорондын гадаад худалдааны үнэ, тарифын өөрчлөлт) зэрэг асуудлууд хамаарч байна.

Төсвийн эрсдэл нь Засгийн газрын төсвийн зорилтуудыг биелүүлэхэд саад учруулж болзошгүй, төсөвт урьдчилан тооцоогүй зардал, орлогын тасалдал үүсгэх гэнэтийн нөхцөл, байдал<sup>4</sup> төдийгүй төсвийн алдагдал, өрийн өсөлт, эсвэл Засгийн газрын санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай, төсөвт нөлөөлөх боломжтой тодорхойгүй хүчин зүйлсээс бүрддэг<sup>5</sup>.

Дэлхийн банкны зүгээс *"Монгол Улс шийдвэрлэх цаг үед ирээд байна. Одоогийн эдийн засгийн өсөлт нь улс орны төсвийн байр суурийг бэхжүүлэх онцгой боломжийг бий болгож байна. Гэхдээ шинэчлэлийг хойшлуулбал өмнөх өсөлт-уналтын мөчлөгүүдийг давтах эрсдэл гарч байна"* гэж дүгнэсэн байна<sup>6</sup>. Засгийн газрын гадаад өрийн хэмжээг ДНБ-нд харьцуулсан харьцаа зохистой түвшинд байгаа хэдий боловч Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан томоохон дэд бүтцийн шинжтэй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх хэрэгцээ өндөр байгаагай холбоотойгоор ойрын жилүүдэд Засгийн газрын шинээр авах гадаад зээл, бондуудын дүн нэмэгдэх магадлал өндөр байгаа нь дээрх харьцаа эрс нэмэгдэх, үүнийг дагаад өрийн үйлчилгээний төсөвт өгөх өрийн үйлчилгээний дарамт, ачаалал өсөх магадлалтай байна.

## **Монгол Улсын төсвийн эрсдэл**

Төсвийн эрсдэлийг тоймлон авч үзвэл хэд хэдэн хүчин зүйлээс ихээхэн хамаарч байна. Үүнд:

1. **Макро эдийн засгийн эмзэг болон дэлхийн улс төр, эдийн засгийн тодорхой бус байдал нь эрсдэлийн нэг чухал хүчин зүйл хэвээр байна.** Дэлхийн нийтийг хамарсан цар тахлын буюу КОВИД-19-ын дараа манай улсын макро эдийн засаг, төсвийн байдал сайжирч тогтворжсон хэдий ч, өнөөгийн дэлхийн улс төр, эдийн засгийн сөргөлдөөнтэй тодорхойгүй байдал үргэлжилж байгаа нөхцөлд гадаад шокоос шалтгаалсан экспортын орлогын бууралт болон хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарч эрсдэлтэй учрахаар байна.
2. **Уул уурхайн салбарын орлогоос хэт хамааралтай байдал:** Монгол Улсын төсвийн орлогын ихэнх хэсэг нь уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай байдал хэвээр үргэлжилж байна. Тухайлбал, дэлхийн зах зээл дээр алт, зэс, нүүрсний үнэ хэлбэлзэх үед төсвийн нийт орлогод ихээхэн нөлөөлж, төлөвлөгдөөгүй орлогын тасалдал бий болох зэрэг асуудал нь төсвийн нийт тэнцэлд нөлөөлж байна.

<sup>4</sup> IMF 2016, Analyzing and Managing Fiscal Risks

<sup>5</sup> World bank 2024, managing Fiscal Risks in Resources-Rich Countries


<sup>6</sup> Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Taehyun Lee 2025.08.14

3. **Төсвийн нийт зарлагын ДНБ-д эзлэх хувь буурч байгаа хэдий ч цаашидаа нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувь өсөх хандлага ажиглагдаж байна.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т “нэгдсэн төсвийн урсгал зардлын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30 хувиас хэтрэхгүй байх” гэж заасан. Гэвч сүүлийн жилүүдэд улсын нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувь өсөх хандлага ажиглагдаж байна.
4. **Төрийн албан хаагчдын цалин хөлсний нэмэгдэл болон тэтгэвэр тэтгэмжийн зардлын өсөлт нь нийт зардлын өсөлтөд шууд нөлөөлж байна.** Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр тэтгэмжийн талаар нэгдсэн бодлого, стратеги байхгүйгээс шалтгаалан сүүлийн жилүүдэд тухайн жилийн төсвийн зардалд төлөвлөгдөж тооцоолоогүйгээр нийт төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлэх, эсвэл аль нэг салбарт ажиллагчдын цалин хөлсийг нэмэгдүүлснээр нийт зардалд цалин хөлсний зардлын эзлэх хувь хэмжээ өсөх хандлагатай байна.
5. **Гадаад өрийн үйлчилгээний зардал нэмэгдэх төлөвтэй байна.** Сүүлийн жилүүдэд Засгийн газрын гадаад өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа төсвийн тусгай шаардлагыг<sup>7</sup> хангаж байгаа боловч Засгийн газрын гадаад зээл өмнөх оны үлдэгдлээс 500 сая ам.доллороос 1 тэрбум ам.доллоор өссөн байна. Ингэснээр гадаад зээлийн болон Засгийн газрын үнэт цаасны үндсэн өр, хүүгийн төлбөрийн хэмжээ жилээс жилд нэмэгдэхээр байна.
6. **Төсөв-татварын эрх зүйн орчныг өөрчлөхтэй холбоотой эрсдэл үүсэж болохоор байна.** Хуулийн төсөл санаачлагчдаас боловсруулсан төсөв-татварын эрх зүйн орчинтой холбоотой хуулиудын төсөл нь ирэх жилүүдийн төсвийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй байна. Тухайлбал, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлээд байгаа татварын багц хуулиуд, НӨАТ, ААНОАТ той холбоотой хуулиуд батлагдаж (төсвийн татварын орлого ойролцоогоор 2.7 их наядаар буурна гэсэн тооцоолол-Сангийн яам) хэрэгжиж эхэлсэн тохиолдолд татварын орлогыг голлон бүрдүүлж буй орлогууд буурах, ингэснээр төсвийн алдагдал нэмэгдэх, түүнийг нөхөхийн тулд гадаад зээл авснаар гадаад өрийн үлдэгдэл нэмэгдэх зэрэг сөрөг үр дагаврууд бий болно. Хэрвээ гадаад шок буюу гол нэрийн эрдэс баялгийн бүтээгдэхүүн (зэс, алт, нүүрс зэрэг)-үүдийн үнэ буурсан тохиолдолд, нөгөө талаар импортын бараа бүтээгдэхүүн болох бензин, шатах тослох материалын үнэ нэмэгдэх үед төсвийн зарлагаа бууруулж чадахгүй өсөх, улмаар төсвийн алдагдал их хэмжээгээр бий болох эрсдэл хүлээж байгааг анхаарах хэрэгтэй. Энэ нь цаашидаа богино хугацаанд төсвийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх нь дамжиггүй.

**Нэг. Макро эдийн засгийн эрсдэл.** Дэлхийн эдийн засаг болон өндөр хөгжилтэй улс орнууд, хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн өсөлт сүүлийн жилүүдэд ойролцоогоор 3-4 хувийн өсөлттэй байна. Харин манай улсын эдийн засаг өсөлт цар тахлын дараа 5.0-7.4 хувиар өсөж байв. Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд (ОУВС, Дэлхийн банк)-аас манай улсын эдийн засгийн өсөлтийг ойрын жилүүдэд ойролцоогоор 5 хувийн өсөлттэй байхаар төсөөлж байна (Зураг 26).

<sup>7</sup> Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т “Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухай жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх”.

**Зураг 26. Монгол Улс, өндөр хөгжилтэй улс орнууд, хөгжиж буй улс орнууд болон дэлхийн эдийн засгийн бодит өсөлт /1990-2030 он/, хувиар**




Эх сурвалж: ОУВС.

[https://www.imf.org/external/datamapper/NGDP\\_RPCH@WEO/OEMDC/ADVEC/WEOWORLD/MNG](https://www.imf.org/external/datamapper/NGDP_RPCH@WEO/OEMDC/ADVEC/WEOWORLD/MNG)

Эдийн засгийн бодит өсөлт нь экспортын өсөлт, бууралтаас ихээхэн шалтгаалж байгаа бөгөөд цаашдаа ч энэ байдал хадгалагдахаар байна. Тухайлбал, 2015 онд экспортын орлогын өсөлт өмнөх оноос 19.1 хувиар буурч байсан бол 2017 онд 26.1 хувийн өсөлттэй, харин 2022 онд 35.7 хувиар тус тус өмнөх оноосоо өсөж байв. Гэтэл экспорт 2023 онд 22.1 хувь, 2024 онд 5.05 хувь өсөж, нийт өсөлтийн хандлага буурч, 2025 онд 0.5 хувиар мөн л буурсан үзүүлэлттэй гарчээ. Харин 2021 оноос хойш эдийн засгийн бодит өсөлт жил бүр нэмэгдэж, 2024 онд 5.05 хувь, 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6.8 хувийн өсөлтийг үзүүлээд байна. Инфляцын түвшин 2022 онд 13.2 хувь байсан бол сүүлийн 3 жил нэг оронтой тоонд шилжин ойролцоогоор 8 хувьтай байна.

**Зураг 27. Эдийн засгийн өсөлт болон инфляц, экспортын өсөлт /2015-2025 он/, хувиар**




Эх сурвалж: Сангийн яам, 2026.

**Хоёр. Уул уурхайн салбарын орлогын эрсдэл.** Манай улсын төсвийн нийт орлогод уул уурхайн салбараас төвлөрөх орлогын эзлэх дүнгээс ихээхэн хамаарч 2015 оноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ), Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ) төсвийн орлогын ихэнх хувийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ хоёр төрлийн орлогоос хамааран төсвийн орлого өсөж, буурч байгаа нь төсвийн орлогын байнгын эрсдэлийг дагуулж байна. Тухайлбал, уул уурхайн салбарын төсөвт оруулах орлого 2016 онд буурсан нь уул уурхайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн бууралттай холбоотой. Харин 2017-2019 онд энэ орлого тогтвортой өссөн.

Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 2017 онд өмнөх оноос 36.39 хувиар өссөн шалтгаан нь АМНАТ-ын орлого өмнөх оноос 193.6 хувиар, ААНОАТ-ын орлого 96.5 хувиар тус тус өсөж байсантай холбоотой. Харин 2020 онд төсвийн нийт орлого өмнөх оноос 13.3 хувиар буурсан шалтгаан нь АМНАТ-ийн орлого 14.6 хувиар, ААНОАТ-ын орлого 24.1 хувиар тус тус өмнөх оноосоо буурснаас шалтгаалсан байна. Энэ нь нөгөө талаар цар тахлын нөлөөгөөр уул уурхайн экспорт буурсантай ч холбоотой.

Харин 2022-2024 онд уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өссөнтэй холбоотойгоор орлого огцом өсөж, 2024 онд төсвийн нийт орлого өмнөх оноос 29.4 хувиар өсөлттэй гарсан. Уул уурхайн салбарын орлого 2025 онд өмнөх оноосоо 3.8 хувь өссөн боловч орлогын өсөлт нь өмнөх оноос буурч байгаа нь АМНАТ болон ААНОАТ гэсэн хоёр орлогын төрөл эрс буурсантай холбон тайлбарлагдаж болно. Эндээс харахад төсвийн нийт орлогод АМНАТ-ийн эзлэх хувь давамгайл байна (Зураг 28).

**Зураг 28. Төсвийн нийт орлого ба тусламжийн болон АМНАТ, ААНОАТ, бусад орлогын жилийн өсөлт 2015-2026 онд хувиар**




Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газар, 2026

Экспортын түүхий эд буюу алт, зэс, нүүрсний үнийн өндөр хэлбэлзэл төсвийн орлогод эмзэг байдлыг бий болгож байна. Дараах зургаас харахад 2017 онд өмнөх онтой харьцуулахад уул уурхайн салбарын төсвийн орлого 98.2 хувиар өсөхөд голлон нүүрсний орлогын өсөлт өмнөх оноос 275.9, зэсийн орлого 72.1 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Харин 2018-2020 онд зэс, алт, нүүрсний орлогын өсөлт өмнөх онуудтай харьцуулахад огцом буурснаас шалтгаалан төсвийн уул уурхайн салбараас орох орлого огцом багасаж, 2020 онд төсвийн уул уурхайн орлого өсөлт өмнөх онтой харьцуулахад -14 хувиар унасан. Зэсийн орлогын өсөлт 2021 онд өмнөх онтойгоо харьцуулахад буцаад 109.1 хувиар нэмэгдсэнээс шалтгаалан уул уурхайн салбарын орлого өмнөх оноосоо 52.9 хувиар өссөн байна.

Зураг 29. Уул уурхайн салбарын төсвийн орлого болон зэс, алт, нүүрсний орлогын өсөлтийн хувь /2015-2026 он/



Эх сурвалж: Сангийн яам, Татварын ерөнхий газар, 2026

Харин 2022-2024 он хүртэлх хугацаанд зэсийн орлогын өсөлт байнга буурч, 2025 онд өссөн байна. Нүүрсний орлого 2023-2025 онд буурснаас шалтгаалан уул уурхайн салбарын орлого багасаж, нөгөө талаар зэс, алтны орлого 2024-2025 онд өмнөх онуудаас өссөнөөс шалтгаалан уул уурхайн салбарын орлого өмнөх оноос 40.7 хувиар буурсан байна.


Төсвийн татварын орлого урт хугацаанд өсөх хандлагатай байна. Татварын нийт орлого 2015 онд ДНБ-д эзлэх хувь 22.1 байсан бол 2019 он хүртэл тогтвортой өсөж 26.6 хувьд хүрсэн байна. Харин 2020 онд цар тахлаас шалтгаалан эдийн засгийн идэвхжил буурсантай холбоотойгоор татварын орлого ДНБ-ий 23 хувь хүртэл буурсан боловч 2021 оноос дахин өсөж, 2023-2024 онд 32.4 хувьд буюу хамгийн өндөр түвшинд хүрчээ.

Татварын орлогын бүтцийг авч үзвэл орлогын албан татвар, НӨАТ болон нийгмийн даатгалын орлого нь нийт татварын орлогын голлох эх үүсвэр болж байна. Орлогын албан татвар 2015 онд ДНБ-ий 5.1 хувийг эзэлж байсан бол 2025 онд 9.5 хувьд хүрсэн нь хөдөлмөр эрхлэлт болон орлогын хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотой. Мөн НӨАТ 2015-2023 онд тасралтгүй өсөж ирсэн нь эдийн засгийн идэвхжил болон хэрэглээ нэмэгдсэнийг харуулж байна. Харин онцгой албан татварын орлого дээрх хугацаанд буурах хандлагатай байгаа нь тухайн татварт хамаарах бараа, бүтээгдэхүүний хэрэглээ буурах хандлагатай болсныг харуулж байна. Гадаад үйл ажиллагааны орлого болон бусад татварын орлого тодорхой хугацаанд өсөлттэй боловч харьцангуй тогтворгүй буюу хэлбэлзэлтэй байна.

Ерөнхийд нь дүгнэвэл, төсвийн татварын орлого нь эдийн засгийн өсөлт, хэрэглээ болон хөдөлмөрийн зах зээлийн өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай байгаа бөгөөд 2023-2024 онд хамгийн өндөр түвшинд хүрсэн боловч 2025, 2026 онд бага зэрэг буурах төлөв ажиглагдаж

байна. Иймд татварын орлогын тогтвортой өсөлтийг хангахын тулд татварын бааз суурийг өргөжүүлэх, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэх бодлого шаардлагатай байгааг харуулж байна (Зураг 30).


Зураг 30. Төсвийн нийт орлого болон орлогын төрлүүдийн ДНБ-д эзлэх хувь /2015-2026 он/



Эх сурвалж: Сангийн яам, 2026

**Гурав. Төсвийн нийт зарлагын өсөлтийн эрсдэл.** Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2016-2025 онд тодорхой өсөлт бууралттай буюу хэлбэлзэлтэй байсан бөгөөд 2018 онд хамгийн өндөр өсөлттэй, харин 2020 онд цар тахлын нөлөөгөөр эдийн засаг агшсан. Харин төсвийн зарлага 2018-2025 оны хооронд 3.38 дахин өссөн бөгөөд 2024 онд хамгийн өндөр буюу 35.9 хувиар өсөж байсан байна. 2018-2024 онд дунджаар 22.1 хувь өсөж байсан нь төсвийн тэлэлт хэт явагдсаныг харуулна. Харин 2025 оны төсвийн тодотголын үр дүнд төсвийн зарлага буурч төсвийн зарлагын өсөлт 3.2 хувь болсон нь төсвийн зарлагын тэлэлтийг хүчтэй бууруулсан томоохон эерэг өөрчлөлт болсон бөгөөд энийг хадгалах нь төсвийн тэлэлтийн эрсдэлийг бууруулах боломжийг бүрдүүлнэ.


Зураг 31. ДНБ-ий бодит өсөлт ба ДНБ-д төсвийн нийт зарлагын эзлэх хувь /2015-2026 он/



Эх сурвалж: Сангийн яам, 2026

Урсгал зардал 2015 онд ДНБ-ий 24.7 хувийг эзэлж байснаас 2021 онд 30.4 хувь болж дээд цэгтээ хүрсэн. Үүнээс хойш бага зэрэг буурч, 2026 оны төлөвлөгөөгөөр 24.4 хувь болж тогтворжих төлөв ажиглагдаж байна. Төсвийн нийт зардлын дийлэнх хувийг урсгал зардал дангаараа эзэлж байгаа нь төсөвт урсгал зардлын ачаалал их байгааг харуулж байна.

**Зураг 32. ДНБ-д төсвийн нийт зарлагад урсгал болон хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх цэвэр зээлийн эзлэх хувь /2015-2026 он/**



Эх сурвалж: Сангийн яам, 2026

ДНБ-д харьцуулсан хувиар тооцож үзвэл, төсвийн хөрөнгө оруулалтын зардал ДНБ-д харьцуулсан хувиар 2015-2018 онд буурах хандлагатай (6.0-аас 5.2 хувь хүртэл) байсан бол 2024 онд хамгийн өндөр буюу 10.0 хувьд хүрсэн байна. Цаашдаа 2025 оны төсвийн урьдчилсан гүйцэтгэл болон 2026 оны батлагдсан төсвөөр энэ зардал ДНБ-ий 7.9-8.4 хооронд буюу дундаж түвшинд байхаар харагдаж байна. Хөрөнгийн зардал нэмэгдэж байгаа нь бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг дэмжиж буй төсвийн бодлого хэрэгжиж байгаагийн нэг идрэл гэж үзэж болно.

**Дөрөв. Цалин, хөлсний зардлын өсөлтийн эрсдэл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардал нь 2015 онд 5.7 их наяд төгрөг байсан бол 2026 оны батлагдсан төсвөөр 24.9 их наяд төгрөг болохоор байна. Өнгөрсөн 11 жилийн хугацаанд урсгал зардал даруй 4.3 дахин өссөн байна. Үүнээс хамгийн өндөр өсөлт нь 2023-2024 онд гарсан бөгөөд урсгал зардал 17.1 их наяд төгрөгөөс 22.1 их наяд төгрөг болж, нэг жилийн дотор 5 их наяд төгрөгөөр огцом нэмэгдсэн. Харин урсгал зардалд эзлэх цалин, хөлсний хувь хэмжээ 2015 онд 29.9 хувь байсан бол 2022 онд хамгийн доод цэгтээ буюу 11.7 хувь болж, 2024 оноос эхлэн эргэн өсөж 24.2 хувь, 2026 онд 28.0 хувьд хүрэхээр төлөвлөгдсөн байна. Энэ нь төсвийн урсгал зардлын бүтцэд цалин хөлсний зардал эргээд жин дарж эхэлснийг харуулж байна.

Цар тахлын жилүүдэд буюу 2020-2021 онд урсгал зардал 10.5-12.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн ч цалингийн эзлэх хувь 24.5-19.8 хувьтай буюу харьцангуй бага байсан байна. Энэ нь тухайн үед халамж болон эрүүл мэндийн бусад зардлуудын өсөлт давамгайлсантай холбоотой. Харин 2024-2026 онд төсвийн тэлэлт маш өндөр байсан, ялангуяа 2024 оноос хойш урсгал зардал болон цалингийн зардал хоёулаа зэрэг өндөр дүнгээр өсөж байгаа нь инфляцад үзүүлэх дарамтыг нэмэгдүүлж байна.

**Зураг 33. Төсвийн нийт урсгал зардал болон урсгал зардалд цалин хөлсний зардлын эзлэх хувь, /2015-2026 он/**



Эх сурвалж: Сангийн яам, 2026

Төсвийн урсгал зардлын жилийн дундаж өсөлт 2015-2026 онд буюу 11 жилийн хугацаанд урсгал зардал жил бүр дунджаар 14.3 хувиар тогтмол өсөж ирсэн нь эдийн засгийн өсөлт болон инфляцаас давсан өндөр үзүүлэлт болж байна. 2024 оноос эхлэн урсгал зардал 22-25 их наяд төгрөгт хүрсэн нь төсвийн тогтвортой байдалд эрсдэл үүсгэхээр байна. Цалин болон урсгал зардлын ийм өндөр өсөлт, ялангуяа 2023 оноос 2024 онд 29.7 хувиар өссөн нь зах зээл дэх мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, хэрэглээний үнийн өсөлтөд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна (Зураг 33).


Манай улсын хувьд 2015-2020 оны хугацаанд хэрэглээний үнийн индекс буюу инфляцын түвшин харьцангуй тогтвортой бага 1.1-8.1 хувийн хооронд хэлбэлзэж байсан. Харин цар тахлын дараах нийлүүлэлтийн гинжин хэлхээний тасалдал, тээвэр логистикийн хүндрэлээс шалтгаалан 2021, 2022 онд инфляц харгалзан 13.4 хувь болон 13.2 хувь болж дээд цэгтээ хүрсэн.

Сүүлийн жилүүдэд инфляц аажмаар саарч, 2026 он гэхэд 7 хувь болж тогтворжих төлөвтэй байна. Нөгөө талаар цалин хөлсний өөрчлөлт 2021 онд -4.4 хувь, 2022 онд -34.2 хувь хүрч буурсан нь инфляц өндөр байхад цалингийн өсөлт сөрөг утгатай гарсан нь иргэдийн худалдан авах чадвар маш хүчтэй унасныг илтгэнэ. Цалин хөлсний зардал 2023 онд 39.7 хувь, 2024 онд 130.7 хувь гэсэн өндөр өсөлттэй харагдаж байгаа нь төрийн албан хаагчдын цалингийн тогтолцооны шинэчлэл болон өмнөх жилүүдийн уналтыг нөхөх томоохон арга хэмжээ авч хэрэгжүүлснийг харуулж байна.

Иргэдийн бодит орлогын хамаарал талаас нь авч үзэхэд 2021-2022 онд "Инфляц өндөр (+13 хувь)" + "Цалингийн өсөлт сөрөг (-34 хувь)" байсан нь дундаж өрхийн амьжиргаанд маш хүнд туссан үе байсан. Харин 2024-2026 онд цалингийн өсөлт (130.7 хувь -> 15.9 хувь -> 12.3 хувь) нь инфляцын түвшнээс өндөр байгаа нь иргэдийн бодит орлого эргэн сэргэж, худалдан авах чадвар нэмэгдэх таатай нөхцөл бүрдсэнийг харуулж байна. Эндээс харахад 2021-2022 оны эдийн засгийн хүндрэлийг 2024 оны цалингийн огцом өсөлтөөр нөхөж,

ирээдүйд (2025-2026 он) цалингийн өсөлтийг инфляцаас 5-8 хувиар өндөр байлгахаар төлөвлөсөн.


Зураг 34. Инфляцын өсөлт ба цалин хөлсний зардлын өсөлт /2015-2026 он/, хувиар



Эх сурвалж: Сангийн яам, 2026

**Тав. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлтийн эрсдэл.** Засгийн газрын гадаад зээлийн үйлчилгээний төлбөр болон түүний бүтэц улсын төсөвт ирж буй бодит төлбөрийн дарамтыг харуулдаг. Гадаад зээлийн үйлчилгээний нийт төлбөр 2015 онд 318.4 тэрбум байсан бол 2025 онд 4.3 их наяд төгрөг болж өссөн бөгөөд 2023 онд нийт өрийн үйлчилгээний төлбөр 5.3 их наяд төгрөгт хүрч, түүхэн дээд хэмжээндээ очсон. Энэ нь өмнөх онуудтай харьцуулахад 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн огцом үсрэлт юм. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд төлбөрийн хэмжээ даруй 13.5 дахин нэмэгдсэн. Үндсэн өр төлөлтийн хэмжээ 2023 онд 4.3 их наяд төгрөгт хүрсэн нь тухайн жил томоохон бондын эргэн төлөлтүүд давхацсаныг харуулж байна. Өмнөх үед буюу 2015-2017 онд үндсэн өрийн төлбөр 126-165 тэрбум төгрөг орчимд харьцангуй бага байсан. Харин 2021 оноос хойш (1.1 их наяд төгрөг) тэрбумаас их наядын ангилал руу шилжиж, төсөвт ирэх ачаалал эрс нэмэгдсэн байна. Гадаад зээлийн хүүгийн төлбөр нь улсын төсвөөс гарч буй "цэвэр зардал" бөгөөд жил бүр тасралтгүй өсөж ирсэн бөгөөд 2015 онд 192 тэрбум төгрөг байсан хүүгийн төлбөр 2025 онд 1.17 их наяд төгрөг болсон. Эндээс харахад гадаад зээлийн хүүгийн төлбөр 2015 оноос хойш 6.1 дахин өссөн нь авсан зээлийн хүүгийн ачаалал өндөр байгааг харуулж байна. Хэдийгээр 2023 онд үндсэн өр их төлөгдсөн ч хүүгийн төлбөр буурахгүй, харин ч өсөх хандлагатай (1.0 -> 1.17 их наяд) байгаа нь анхаарал татаж байна. Монгол Улсын Засгийн газрын гадаад зээлийн төлөлтийн хамгийн өндөр ачаалалтай үе 2023-2025 онууд байсан. Ялангуяа 2023 оны 5.3 их наяд төгрөгийн төлөлт нь төсвийн бусад зардалд (цалин, хөрөнгө оруулалт) очих боломжит эх үүсвэрийг ихээхэн хязгаарласан байх магадлалтай. Харин 2025 онд төлбөрийн хэмжээ 4.3 их наяд төгрөг байгаа нь өрийн дарамт өндөр хэвээр байгааг харуулж байна (Зураг 35).

**Зураг 35. Гадаад зээлийн үйлчилгээний төлбөрийн өсөлт /2015-2025 он/, сая төгрөг**



Эх сурвалж: Сангийн яам, 2026

**Гадаад өр**

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ жил ирэх тусам өсөж байна. Монгол Улсын нийт гадаад өрийн бүтцэд Засгийн газрын гадаад өр, Төв банкны гадаад өр, Төв банкнаас бусад байгууллагуудын гадаад өр, бусад салбаруудын гадаад өр, Компани хоорондын зээллэг буюу гадаадын шууд хөрөнгө оруулалт багтдаг.

Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл жил ирэх тусам өсөж байна. Тухайлбал, Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2015 онд 3.7 тэрбум ам. доллар байсан бол 2020 онд 8.6 тэрбум ам.доллар, 2024 онд 8.3 тэрбум ам.доллар, 2025 оны III улирлын байдлаар 8.8 тэрбум ам.долларт хүрээд байна.


**Хүснэгт 17. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл /2015-2024 он/, сая ам.доллаароор**

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024
Засгийн газар	3,759.86	4,868.61	7,320.98	7,184.19	7,806.20	8,653.84	8,454.23	8,012.47	8,105.10	8,397.08
Төвбанк	1,959.64	1,790.75	2,025.08	2,030.22	1,984.69	2,220.99	2,610.04	2,178.95	1,784.78	1,086.27
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,128.50	2,417.38	2,194.26	2,230.37	2,137.95	1,650.90	1,626.52	1,532.56	1,733.21	2,601.83
Бусад салбар	3,748.95	8,121.49	7,955.84	8,041.87	8,407.24	8,430.23	8,842.51	8,436.01	7,865.76	7,897.88
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	11,120.86	7,426.28	7,996.49	9,228.23	10,366.21	11,405.87	12,272.20	13,184.83	15,080.64	17,254.34
Нийт гадаад өр	22,717.82	24,624.50	27,492.66	28,714.89	30,702.29	32,361.83	33,805.50	33,344.82	34,569.48	37,237.40

Эх сурвалж: Монголбанк 2026

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл тасралтгүй өсөж даруй 4 дахин нэмэгдсэн байна. Тухайлбал 2015 онд 7,881.2 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 30,296.7 тэрбум төгрөг 2025 он 32,052.8 тэрбум төгрөг болж өссөн.

**Зураг 36. Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэл 2015-2025 оны байдлаар, /тэрбум төгрөг/, гадаад өрийн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа, нэрлэсэн үнээр**



Эх сурвалж: Сангийн яам, 2026

Хэдийгээр гадаад өрийн үлдэгдлийн хэмжээ өсөж байгаа ч эдийн засагт ирэх бодит ачаалал буурч байгаа дүр зураг харагдаж байна. Тухайлбал, Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь 2020 онд 67.24 хувьд хүрч байсан бол 2021 оноос хойш энэ үзүүлэлт тогтмол буурсаар 2025 оны урьдчилсан гүйцэтгэлээр 35.61 хувь болохоор байна. Энэ нь эдийн засгийн өсөлт Засгийн газрын гадаад өрийн өсөлтөөсөө илүү хурдан байгааг харуулж байна.


Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр оруулсан өөрчлөлтөөр тогтоосон өрийн дээд хязгаар ДНБ-ий 60% болсонтой холбогдуулан одоогийн байдлаар энэ босго хязгаараас доогуур түвшинд (35.6 хувь) байна. Засгийн газрын гадаад өрийн хэмжээ мөнгөн дүнгээрээ нэмэгдэж байгаа ч ДНБ-д эзлэх хувь нь сүүлийн 4 жил дараалан буурч байгаа нь өрийн тогтвортой байдал сайжирч байгааг харуулна. Ялангуяа 2025 оны төсөөлөл болох 35.6 хувь нь сүүлийн 10 жилийн хамгийн бага үзүүлэлтүүдийн нэг (2015 оныхтой ойролцоо) болж байна.

Төсвийн зардалд эзлэх гадаад зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн зардлын хувийн жинг 2015-2025 оноор харьцуулан төсвийн өрийн дарамтыг үнэлж үзлээ. Үндсэн өрийн төлбөр/Төсвийн нийт зарлага гэсэн үзүүлэлт нь улсын төсвөөс гарч буй 100 төгрөг тутамд хэд нь өмнөх өрөө дарахад зарцуулагдаж байгааг харуулдаг бөгөөд **2015-2020 оны хооронд 1.43-4.97 хувь** буюу харьцангуй бага ачаалалтай байсан. Харин 2021 онд 7.11 хувь байснаа **2023 онд 19.18 хувь** болж огцом өссөн нь 2023 онд төсвийн нийт зарлагын бараг **5 төгрөг тутмын 1-ийг** зөвхөн өрийн үндсэн төлбөрт зарцуулсан гэсэн үг. Энэ нь тухайн жилийн төсөвт маш том дарамт болж байсан.

Засгийн газрын гадаад үйлчилгээний төлбөр 2024 онд 7.01 хувь, 2025 онд 9.95 хувь болж тус тус буурсан нь үйлчилгээний төлбөрийн дарамт харьцангуй саарч байгааг харуулж байна. Хүүгийн зардал/Урсгал зардал нь улсын өдөр тутмын үйл ажиллагааны зардалд (цалин, халамж г.м) эзлэх хүүгийн ачааллыг харуулдаг. Хүүгийн зардал нь 2019 онд урсгал зардлын **8.6 хувьд** хүрч, хамгийн өндөр ачаалалтай байсан. **Хүүгийн зардал** 2020 оноос

хойш 7.0 хувиар тогтмол буурсаар 2025 онд **4.9 хувь болсон**. Энэ нь өрийн бүтцэд өөрчлөлт орж, арай бага хүүтэй зээлээр солих, эсвэл урсгал зардал нь хүүгийн зардлаасаа хурдтай өсөж байгааг харуулж байна.

**Зураг 37. Мөнгөл Улсын Засгийн газрын гадаад зээлийн үндсэн өрийн төлбөр төсвийн зардалтай харьцуулсан хувь болон хүүгийн төлбөр урсгал зардалтай харьцуулсан хувь 2015-2025 оны байдлаар**



Эх сурвалж: Сангийн яам, 2026

Гадаад зээлийн үндсэн төлбөр 2023 онд 19.18 хувь болж түүхэн дээд хэмжээндээ хүрсэн ч хүүгийн зардал 5.9 хувь болж харьцангуй тогтвортой байсан нь тухайн жил "их хэмжээний үндсэн өрийг нэг дор төлж барагдуулсан" болохыг баталж байна. Хэдийгээр гадаад зээлийн хүүгийн дарамт 4.9-5.0 хувь хүртэл багасаж байгаа ч үндсэн өрийн төлөлт 9.95 хувьд хүрч 2015-2020 оны түвшнээс даруй 2-3 дахин өндөр хэвээр байгаа нь **өрийн дахин санхүүжилт** чухал хэвээр байгааг илтгэж байна.

## ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН 2027-2029 ОНЫ ТААМАГЛАЛ, ЗАГВАРЫН ҮР ДҮНГҮҮД

### 3.1. Экспортын гол нэрийн түүхий эдийн үнэ, биет хэмжээ

Уул уурхайн салбарын экспортын голлох түүхий эд болох нүүрс, төмрийн хүдэр, алт, зэсийн баяжмалын үнэ болон биет хэмжээний 2026-2029 оны төсөөллийг ҮСХ-ны улирлын давтамжтай тоон өгөгдөлд тулгуурлан эконометрик загваруудын тусламжтайгаар хийж гүйцэтгэлээ.

#### *Биет хэмжээ*

Биет хэмжээний төсөөллийг бүтээгдэхүүн тус бүрээр нэг хувьсагчийн ARIMA загвар болон олон хувьсагчийн VAR загвар ашиглан үнэлэв. ARIMA загвар нь тухайн цувааны өнгөрсөн үеийн утгууд болон үлдэгдлийн өнгөрсөн үеийн утгуудаас хамааруулан ирээдүйн утгыг таамагладаг.

Нэг хувьсагчийн ARIMA загварын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд үнэлсэн тэгшитгэл:

$$D(COAL)_t = \sum_{i=1}^4 \beta_i D(COAL)_{t-i} + \sum_{j=1}^4 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

$$D(IRON)_t = c + \sum_{i=1}^1 \beta_i D(IRON)_{t-i} + \sum_{j=1}^1 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

$$D(COPPER)_t = c + \sum_{i=1}^1 \beta_i D(COPPER)_{t-i} + \sum_{j=1}^1 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

$$D(GOLD)_t = c + \sum_{i=1}^2 \beta_i COAL_{t-i} + \sum_{j=1}^3 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

Олон хувьсагчийн VAR загварыг бүтээгдэхүүн бүрийн хувьд дараах байдлаар үнэллээ. Үүнд:

- Нүүрсний биет хэмжээ (DL\_COAL)-ний төсөөллийг боловсруулахдаа ОУВС-аас гаргадаг Австрали болон Өмнөд Африкийн нүүрсний үнийн индекс (DL\_COAL\_PI), аж үйлдвэрлэлийн өсөлт (DL\_IP\_CN)-ийн цувааг ашиглав.
- Зэсийн баяжмал (DL\_COPPER), Төмрийн хүдэр (DL\_IRON)-ийн төсөөллийг боловсруулахдаа дэлхийн зах зээл дээрх металл болон минералын үнийн индекс (DL\_MI), БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн өсөлт (DL\_IP\_CN)-ийн цувааг ашиглав.
- Алт (DL\_GOLD)-ны төсөөллийг боловсруулахдаа дэлхийн зах зээл дээрх үнэт металлын үнийн индекс (DL\_PMI) болон АНУ-ын бодлогын хүү (DL\_FED\_RATE)-ний цувааг тус тус ашиглалаа.

Дараах хэсэгт бүтээгдэхүүн тус бүрийн хувьд үнэлсэн VAR, BVAR загварын тэгшитгэлийн үр дүнг харуулж байна<sup>8</sup>:

**Нүүрс:**

$$DL\_COAL\_TN = -0.33*DL\_COAL\_TN(-1) - 0.009*DL\_COAL\_INDEX(-1) - 0.012*INDUSTRIAL\_PROD(-1) + 0.105$$

$$DL\_COAL\_TN = 0.52*DL\_COAL\_TN(-1) + 0.046*DL\_COAL\_TN(-2) + 0.059*DL\_COAL\_INDEX(-1) + 0.018*DL\_COAL\_INDEX(-2) - 0.004*INDUSTRIAL\_PROD(-1) + 1.37*INDUSTRIAL\_PROD(-2) + 0.034$$

**Төмрийн хүдэр:**

$$DL\_IRON\_TN = -0.54*DL\_IRON\_TN(-1) - 0.38*DL\_IRON\_TN(-2) - 0.53*DL\_IRON\_TN(-3) + 0.18*DL\_IRON\_TN(-4) - 0.47*DL\_METAL\_MIN(-1) - 0.60*DL\_METAL\_MIN(-2) - 0.18*DL\_METAL\_MIN(-3) - 0.22*DL\_METAL\_MIN(-4) + 0.0035*INDUSTRIAL\_PROD(-1) + 0.0019*INDUSTRIAL\_PROD(-2) - 0.0035*INDUSTRIAL\_PROD(-3) - 0.011*INDUSTRIAL\_PROD(-4) + 0.069$$

$$DL\_IRON\_TN = 0.39*DL\_IRON\_TN(-1) + 0.076*DL\_IRON\_TN(-2) + 0.25*DL\_METAL\_MIN(-1) - 0.013*DL\_METAL\_MIN(-2) + 0.0005*INDUSTRIAL\_PROD(-1) - 0.0004*INDUSTRIAL\_PROD(-2) + 0.0008$$

**Зэсийн баяжмал:**

$$DL\_COP\_TN = -0.22*DL\_COP\_TN(-1) - 0.007*DL\_COP\_TN(-2) + 0.011*DL\_COP\_TN(-3) - 0.046*DL\_COP\_TN(-4) - 0.16*DL\_METAL\_MIN(-1) - 0.10*DL\_METAL\_MIN(-2) - 0.14*DL\_METAL\_MIN(-3) + 0.009*DL\_METAL\_MIN(-4) - 0.0005*INDUSTRIAL\_PROD(-1) + 0.0046*INDUSTRIAL\_PROD(-2) - 0.005*INDUSTRIAL\_PROD(-3) + 0.0033*INDUSTRIAL\_PROD(-4) - 0.0022$$

$$DL\_COP\_TN = 0.53*DL\_COP\_TN(-1) + 0.035*DL\_COP\_TN(-2) + 0.005*DL\_METAL\_MIN(-1) - 0.029*DL\_METAL\_MIN(-2) - 0.000005*INDUSTRIAL\_PROD(-1) + 0.31457424*INDUSTRIAL\_PROD(-2) + 0.003$$

**Алт:**

$$GOLD\_TN = 0.24*GOLD\_TN(-1) - 0.026*GOLD\_TN(-2) - 0.031*GOLD\_TN(-3) + 0.31*GOLD\_TN(-4) + 19.12*DL\_PRECIOUS\_METALS(-1) + 2.87*DL\_PRECIOUS\_METALS(-2) + 10.05*DL\_PRECIOUS\_METALS(-3) - 4.56*DL\_PRECIOUS\_METALS(-4) - 1.41*L\_FED\_RATE(-1) - 1.73*L\_FED\_RATE(-2) + 4.58*L\_FED\_RATE(-3) - 2.26*L\_FED\_RATE(-4) + 1.39$$

$$GOLD\_TN = 0.76*GOLD\_TN(-1) - 0.007*GOLD\_TN(-2) - 0.007*GOLD\_TN(-3) + 0.48*GOLD\_TN(-4) + 4.08*DL\_PRECIOUS\_METALS(-1) - 0.85*DL\_PRECIOUS\_METALS(-2) + 0.41*DL\_PRECIOUS\_METALS(-3) - 0.12*DL\_PRECIOUS\_METALS(-4) - 0.03*L\_FED\_RATE(-1) - 0.025*L\_FED\_RATE(-2) + 0.083*L\_FED\_RATE(-3) - 0.047*L\_FED\_RATE(-4) + 0.83$$

<sup>8</sup> VAR загварын үнэлгээг боловсруулахдаа хувьсагчдаас лог-ялгавар хувиргалт авч суурин процесс болгон ашиглав. Хувьсагчдын лагийн тоог сонгохдоо мэдээллийн шалгуурын аргаар сонгов. Үнэлсэн тэгшитгэлүүдийн үлдэгдлүүдийн хооронд сериал корреляц байхгүй гэсэн тэг таамаглалыг хүлээн авсан болно.

### Түүхий эдийн үнэ.

Үнийн төсөөллийг ARIMA болон VAR загвар ашиглан олон улсын байгууллагуудын төсөөллүүдтэй харьцуулан үнэлэв.

- Нүүрсний үнэ 2026 онд өмнөх оноос бага зэргийн өсөлттэй, цаашид тогтворжих хандлагатай байна. 2025 оны Австралийн нөөц, эрчим хүчний тайлан болон Дэлхийн банкны тайланд нүүрсний үнэ 2027 он хүртэл бага зэрэг өссөн төсөөлөл гаргасан.<sup>9</sup>
- Төмрийн хүдрийн үнэ төсөөллийн хугацаанд 2025 оны хэмжээнд тогтворжихоор байна. Олон улсын байгууллагуудын төсөөлөл 2027 он хүртэл бага зэрэг буурахаар төсөөлөгдөж байна.
- Зэсийн баяжмалын үнэ 2025 оны өсөлттэй адил үргэлжлүүлэн өсөх хандлагатай байгаа бол 2026 оноос өсөлтийн хурд буурахаар байна. Олон улсын байгууллагуудын төсөөллөөр зэсийн үнэ 2026 онд үргэлжлэн өсөж, 2027 оноос тогтворжих хүлээлттэй байна.
- Алтны үнийн хувьд энэ онд түүхэн өндөр түвшиндээ хүрсэн ч энэ өсөлт үргэлжлэх төлөвтэй байна. Харин Австрали болон Дэлхийн банкны тайланд алтны үнэ 2026 онд үргэлжлэн өсөх хэдий ч 2027 онд буурах төсөөллийг гаргасан байна.

Нэг хувьсагчийн ARIMA загварын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд үнэлсэн тэгшитгэл:

$$D(COAL)_t = \sum_{i=1}^1 \beta_i D(COAL)_{t-i} + \sum_{j=1}^2 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

$$D(IRON)_t = c + \sum_{i=1}^2 \beta_i D(IRON)_{t-i} + \sum_{j=1}^5 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

$$D(COPPER)_t = c + \sum_{i=1}^2 \beta_i D(COPPER)_{t-i} + \sum_{j=1}^2 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

$$D(GOLD)_t = c + \sum_{i=1}^2 \beta_i COAL_{t-i} + \sum_{j=1}^4 \theta_j \epsilon_{t-j} + \epsilon_t$$

Олон хувьсагчийн VAR загварыг үнэлэхдээ бүтээгдэхүүн бүрийн хувьд дараах байдлаар үнэлсэн. Үүнд:

- Нүүрсний биет хэмжээ (DL\_COAL)-ний төсөөллийг боловсруулахдаа ОУВС-аас гаргадаг Австрали болон Өмнөд Африкийн нүүрсний үнийн индекс (DL\_COAL\_PI), аж үйлдвэрлэлийн өсөлт (DL\_IP\_CN)-ийн цувааг ашиглав.
- Зэсийн баяжмал (DL\_COPPER), Төмрийн хүдэр (DL\_IRON)-ийн төсөөллийг боловсруулахдаа дэлхийн зах зээл дээрх металл болон минералын үнийн индекс (DL\_MI), БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн өсөлт (DL\_IP\_CN)-ийн цувааг ашиглав.

<sup>9</sup> Resources and energy quarterly: December 2025, Australian Government; Commodity markets outlook, october 2025, World bank.

- Алт (DL\_GOLD)-ны төсөөллийг боловсруулахдаа дэлхийн зах зээл дээрх үнэт металлын үнийн индекс (DL\_PMI) болон АНУ-ын бодлогын хүү (DL\_FED\_RATE)-ний цувааг тус тус ашиглалаа.

Дараах хэсэгт бүтээгдэхүүн тус бүрийн хувьд үнэлсэн VAR, BVAR загварын тэгшитгэлийн үр дүнг харуулж байна<sup>10</sup>:

#### Нүүрс:

$$D(L\_COAL\_PRICE) = 0.21*D(L\_COAL\_PRICE(-1)) - 0.05*D(L\_COAL\_PRICE(-2)) - 0.11*D(L\_COAL\_PRICE(-3)) - 0.12*D(L\_COAL\_PRICE(-4)) + 0.79*D(L\_COAL\_INDEX(-1)) - 0.43*D(L\_COAL\_INDEX(-2)) + 0.39*D(L\_COAL\_INDEX(-3)) - 0.21*D(L\_COAL\_INDEX(-4)) - 0.002*INDUSTRIAL\_PROD(-1) + 0.002*INDUSTRIAL\_PROD(-2) + 0.003*INDUSTRIAL\_PROD(-3) - 0.005*INDUSTRIAL\_PROD(-4) + 0.007$$

$$DL\_COAL\_PRICE = 0.72*DL\_COAL\_PRICE(-1) - 0.004*DL\_COAL\_PRICE(-2) + 0.17*DL\_COAL\_INDEX(-1) - 0.06*DL\_COAL\_INDEX(-2) - 0.0002*INDUSTRIAL\_PROD(-1) + 0.0003*INDUSTRIAL\_PROD(-2) - 0.002$$

#### Төмрийн хүдэр:

$$DL\_IRON\_PRICE = -0.25*DL\_IRON\_PRICE(-1) + 0.08*DL\_IRON\_PRICE(-2) + 0.39*DL\_IRON\_PRICE(-3) + 0.06*DL\_IRON\_PRICE(-4) + 0.4081455155*DL\_METAL\_MIN(-1) - 0.200330910906*DL\_METAL\_MIN(-2) - 0.99*DL\_METAL\_MIN(-3) + 0.02*DL\_METAL\_MIN(-4) + 0.004*INDUSTRIAL\_PROD(-1) - 0.51*INDUSTRIAL\_PROD(-2) - 0.003*INDUSTRIAL\_PROD(-3) - 0.002*INDUSTRIAL\_PROD(-4) + 0.02$$

$$DL\_IRON\_PRICE = 0.63*DL\_IRON\_PRICE(-1) - 0.01*DL\_IRON\_PRICE(-2) + 0.23*DL\_METAL\_MIN(-1) - 0.12*DL\_METAL\_MIN(-2) + 0.0002*INDUSTRIAL\_PROD(-1) - 0.0003*INDUSTRIAL\_PROD(-2) + 0.001$$

#### Зэсийн баяжмал:

$$D(L\_COP\_PRICE) = -0.04*D(L\_COP\_PRICE(-1)) + 0.50*D(L\_COP\_PRICE(-2)) - 0.06*D(L\_COP\_PRICE(-3)) - 0.34*D(L\_COP\_PRICE(-4)) + 0.47*D(L\_METALS\_MIN(-1)) - 0.36*D(L\_METALS\_MIN(-2)) - 0.11*D(L\_METALS\_MIN(-3)) + 0.49*D(L\_METALS\_MIN(-4)) + 0.002*INDUSTRIAL\_PROD(-1) - 0.0004*INDUSTRIAL\_PROD(-2) - 0.001*INDUSTRIAL\_PROD(-3) - 0.002*INDUSTRIAL\_PROD(-4) + 0.013$$

$$DL\_COP\_PRICE = 0.71*DL\_COP\_PRICE(-1) + 0.02*DL\_COP\_PRICE(-2) - 0.006*DL\_METAL\_MIN(-1) - 0.04*DL\_METAL\_MIN(-2) + 0.0004*INDUSTRIAL\_PROD(-1) - 0.0003*INDUSTRIAL\_PROD(-2) + 0.001$$

#### Алт:

$$DL\_GOLD\_PRICE = -0.38*DL\_GOLD\_PRICE(-1) - 0.40*DL\_GOLD\_PRICE(-2) - 0.09*DL\_GOLD\_PRICE(-3) + 0.07*DL\_PRECIOUS\_METALS(-1) +$$

<sup>10</sup> VAR загварын үнэлгээг боловсруулахдаа хувьсагчдаас лог-ялгавар хувиргалт авч суурин процесс болгон ашиглав. Хувьсагчдын лагийн тоог сонгохдоо мэдээллийн шалгуурын аргаар сонгов. Үнэлсэн тэгшитгэлүүдийн үлдэгдлүүдийн хооронд сериал корреляц байхгүй гэсэн тэг таамаглалыг хүлээн авсан болно.

$$\begin{aligned}
& 0.28*DL\_PRECIOUS\_METALS(-2) - 0.15*DL\_PRECIOUS\_METALS(-3) - \\
& 0.02*L\_FED\_RATE(-1) + 0.02*L\_FED\_RATE(-2) + 0.03*L\_FED\_RATE(-3) + 0.02 \\
DL\_GOLD\_PRICE = & 0.71*DL\_GOLD\_PRICE(-1) + 0.01*DL\_GOLD\_PRICE(-2) - \\
& 0.18*DL\_PRECIOUS\_METALS(-1) + 0.01*DL\_PRECIOUS\_METALS(-2) + \\
& 0.01*L\_FED\_RATE(-1) + 0.003*L\_FED\_RATE(-2) + 0.01
\end{aligned}$$

Нүүрсний үнийн төсөөллийг загваруудын дунджаар, биет хэмжээний төсөөллийг ARIMA загварын үр дүнгээр авлаа. Алт, зэсийн баяжмалын биет хэмжээ, төмрийн хүдрийн үнэ болон биет хэмжээг загваруудын дундаж үр дүнгээр авсан бол алт, зэсийн баяжмалын үнийн хувьд дэлхийн геополитикийн нөхцөл байдлын нөлөөгөөр огцом өсөлттэй байгааг харгалзан загваруудын төсөөллийн дундаж дүнгээс 10% доогуур байхаар сонгов (Хүснэгт 18).

Загваруудын үнэлгээний үр дүнгээс харахад алт болон нүүрсний биет хэмжээний төсөөллөөс бусад үзүүлэлтүүдийн хувьд ихэнх загварууд ижил чиглэлд, ойролцоо түвшний үр дүн гаргасан байна. Иймээс нийт экспортын төсөөллийн тодорхойгүй байдал голчлон алт, нүүрсний биет хэмжээн дээр төвлөрч байна гэж дүгнэв.

Хүснэгт 18. Түүхий эдийн үнэ болон биет хэмжээний таамаглалын үр дүн

Төрөл	Үнэ/биет хэмжээ	Загвар	Нэгж	2025	2026*	2027*	2028*	2029*
Нүүрс	Үнэ	COAL_PRICE_F	ам.доллар/тн	64.91	72.77	83.86	87.26	88.37
		VAR	ам.доллар/тн	64.91	66.93	71.14	68.72	68.05
		BVAR	ам.доллар/тн	64.91	68.44	70.86	69.08	66.05
		Average	ам.доллар/тн	64.91	69.10	74.67	74.41	73.60
		2025_forecast	ам.доллар/тн	85.00	88.00	92.00	96.00	
	Биет хэмжээ	COAL_TNFEQ2	мян.тн	90,018.27	100,232.53	100,387.73	102,028.58	104,712.40
		COAL_TN_F	мян.тн	90,018.27	86,927.92	84,748.75	89,638.85	97,734.54
		VAR	мян.тн	90,018.27	115,481.26	129,736.19	149,297.86	175,967.49
		BVAR	мян.тн	90,018.27	134,646.07	163,289.66	187,031.29	215,039.82
		ARIMA_(3,2,4)	мян.тн	90,018.27	106,122.37	115,003.79	123,881.23	134,595.05
Зэсийн хүдэр, баясгал	Үнэ	Average	мян.тн	90,018.27	108,682.03	118,633.23	130,375.56	145,609.86
		2025_forecast	мян.тн	86,437.72	91,230.10	95,433.03	99,635.94	
		ARIMA_EQ4_EQ5	ам.доллар/тн	2,505.59	3,053.34	3,015.86	2,982.64	2,980.03
		VAR	ам.доллар/тн	2,505.59	3,184.15	3,265.96	3,584.66	3,822.53
		BVAR	ам.доллар/тн	2,505.59	3,348.34	3,738.82	3,965.37	4,153.66
	Биет хэмжээ	Average	ам.доллар/тн	2,505.59	3,195.28	3,340.21	3,510.89	3,652.07
		2025_forecast	ам.доллар/тн	1,963.00	2,028.00	2,098.00	2,160.00	
		COP_TNFEQ5	мян.тн	2,289.82	2,516.50	2,520.00	2,520.21	2,520.22
		COP_TN_F	мян.тн	2,289.82	2,603.42	2,740.16	2,873.93	3,007.63
		VAR	мян.тн	2,289.82	2,596.56	2,775.53	2,995.96	3,251.72
		BVAR	мян.тн	2,289.82	2,860.44	3,193.83	3,514.03	3,857.06


	Average	мян.тн	2,289.82	2,379.80	2,526.64	2,678.42	2,843.24
	2025_forecast	мян.тн	2,140.28	2,261.74	2,402.23	2,538.09	
Үнэ	IRON_PRICEFEQ6	ам.доллар/тн	72.04	76.37	76.09	76.13	76.13
	IRON_PRICE_F	ам.доллар/тн	72.04	72.23	71.51	71.15	70.97
	VAR	ам.доллар/тн	72.04	75.22	70.66	70.81	71.42
	BVAR	ам.доллар/тн	72.04	77.12	80.74	82.35	83.62
	Average	ам.доллар/тн	72.04	75.23	74.75	75.11	75.54
Төмрийн хүдэр, баяжмал	2025_forecast	ам.доллар/тн	70.00	64.00	62.00	61.00	
	IRON_TNFEQ8	мян.тн	8,846.40	10,103.13	10,982.67	11,789.12	12,528.54
	IRON_TNFEQ7	мян.тн	8,846.40	9,568.08	9,567.96	9,567.86	9,567.76
	VAR	мян.тн	8,846.40	8,424.27	8,285.78	8,622.84	8,818.84
	BVAR	мян.тн	8,846.40	9,585.22	10,072.82	10,516.90	10,925.59
Биет хэмжээ	Average	мян.тн	8,846.40	9,420.17	9,727.31	10,124.18	10,460.18
	2025_forecast	мян.тн	8,212.83	8,552.86	8,952.10	9,351.32	
	GOLD_PRICEFEQ1	ам.доллар/унц	3,431.58	4,914.54	6,049.36	6,901.30	7,734.55
	GOLD_PRICEFEQ2	ам.доллар/унц	3,431.58	4,811.72	5,594.89	5,831.63	5,895.44
	GOLD_PRICEFEQ3	ам.доллар/унц	3,431.58	4,843.87	5,743.36	6,190.78	6,519.16
Үнэ	VAR	ам.доллар/унц	3,431.58	4,583.53	5,519.66	6,295.42	7,048.01
	BVAR	ам.доллар/унц	3,431.58	5,312.75	6,402.12	7,361.61	8,450.54
	Average	ам.доллар/унц	3,431.58	4,403.95	5,275.69	5,864.53	6,416.58
	2025_forecast	ам.доллар/унц	2,324.00	2,198.00	2,078.00	1,965.00	
	GOLD_TROY_OZ_F	тн	10.79	18.10	19.07	19.86	20.61
Биет хэмжээ	GOLD_TROY_FEQ5	тн	10.79	11.60	12.26	11.90	11.90
	Gold_VAR	тн	10.79	16.57	16.02	15.18	14.80

	Gold_BVAR	тн	10.79	16.74	16.26	16.33	16.06
	Average	тн	10.79	15.75	15.90	15.82	15.84
	2025_forecast	тн	12.15	12.76	13.49	13.23	


Хүснэгт 19. Экспортын гол нэрийн барааны төсөөлөлд анигласан хувьсагчид, тэдгээрийн эх сурвалж

Нэр	Эх сурвалж
Нүүрсний биет хэмжээ, үнэ	ҮСХ
Төмрийн хүдэр, баяжмалын биет хэмжээ, үнэ	ҮСХ
Зэсийн хүдэр, баяжмалын биет хэмжээ, үнэ	ҮСХ
Алтны биет хэмжээ, үнэ	ҮСХ
БНХАУ-ын аж үйлдвэрийн өсөлт	National Bureau of Statistics of China/Trading economics
Өмнөд Африк болон Австралийн нүүрсний үнийн индекс	World bank commodity markets (pink sheet data)
Металл болон минералын үнийн индекс	World bank commodity markets (pink sheet data)
Үнэт металлын үнийн индекс	World bank commodity markets (pink sheet data)
АНУ-ын Холбооны нөөцийн бодлогын хүү	Federal Reserve bank of ST.LOUIS FRED


Зураг 38. Алтны биет хэмжээний төсөөлөл




Зураг 39. Алтны биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)




Зураг 40. Алтны үнийн төсөөлөл




**Зураг 41. Алтны үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)**




**Зураг 42. Нүүрсний биет хэмжээний төсөөлөл**




**Зураг 43. Нүүрсний биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)**




Зураг 44. Нүүрсний үнийн төсөөлөл




Зураг 45. Нүүрсний үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)




Зураг 46. Зэсийн үнийн төсөөлөл




Зураг 47. Зэсийн үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)




Зураг 48. Зэсийн биет хэмжээний төсөөлөл




Зураг 49. Зэсийн биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)




**Зураг 50. Төмрийн хүдэр, баяжмалын үнийн төсөөлөл**




**Зураг 51. Төмрийн үнийн төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)**



**Зураг 52. Төмрийн хүдэр, баяжмалын биет хэмжээний төсөөлөл**



Зураг 53. Төмрийн биет хэмжээний төсөөллийн итгэх завсрын төсөөлөл (30%, 60%, 90%)



### 3.2. DIGNAR19 загварын төсөөлөл

#### Дигнар загварын тухай

DIGNAR (Debt, Investment, Growth, and Natural Resources) нь Динамик статистик ерөнхий тэнцвэрийн (Dynamic Stochastic General Equilibrium-DSGE) загвар бөгөөд ОУВС-аас байгалийн баялаг бүхий хөгжиж буй орнуудын макро эдийн засгийн төлөв байдал, бодлогын үр нөлөөг шинжлэх зорилгоор хөгжүүлж байна. Загвар хоёр төрлийн өрхийн аж ахуй, арилжааны ба арилжааны бус бүтээгдэхүүн (фирмүүд), байгалийн баялаг, Засгийн газар гэсэн бүтэцтэй, эдийн засгийн агентууд ирээдүйг харж, ашгаа хамгийн их байлгах рационал сонголт хийдэг гэж үздэг. Өрхүүдийг санхүүгийн зах зээлд оролцоогүй (Rot), фирм эзэмшдэг буюу санхүүгийн зах зээлд оролцоотой (Opt) гэж хоёр ангилсан. Засгийн газрын гадаад өрийг хөнгөлөлтэй ба арилжааны гэж хуваах ба Засгийн газар төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг санхүүжүүлэхэд ашиглаж болох баялгийн сантай байхаар тооцдог. Загвар эдийн засгийн бүх агентын оролцоо, харилцан үйлчлэлийг илэрхийлэх, тэдгээрийн зааглалт, оновчлол, нэгдүгээр эрэмбийн нөхцөлүүд (FOC), тэнцвэрийн нөхцөлүүд зэрэг нийт 172 тэгшитгэлийг агуулна<sup>11</sup>.


Загварт бүтээгдэхүүнийг

1. Арилжааны бус (N)
2. Байгалийн баялгийн бус арилжааны (T)
3. Байгалийн баялаг (O) гэж багцлан авч үздэг.

Загварын агентуудын харилцан үйлчлэлийг дараах схемээр үзүүлэв.

<sup>11</sup> Илүү дэлгэрэнгүйг <https://www.imf.org/en/Publications/WP/Issues/2016/12/31/Debt-Sustainability-Public-Investment-and-Natural-Resources-in-Developing-Countries-the-41455> судалгаанаас харна уу.

Зураг 54. Системийн бүтэц, агентуудын харилцан үйлчлэл




Бидний ашиглаж буй DIGNAR загварын тооцоолол Dynare<sup>12</sup> программ хангамжийн платформ дээр хийгдсэн. Dynare нь эдийн засгийн DSGE ба OLG загваруудад илүү нийцтэй бөгөөд Матлаб болон C++ хэл дээр бичигдсэн, түүнчлэн Матлабын бусад хэрэгслийг (toolbox) ашигладаг, нээлттэй, лицензтэй платформ юм. DIGNAR нь Dynare version 4.5.6 дээр бичигдсэн бөгөөд Матлаб<sup>13</sup> (MATLAB)-ын Optimization Toolbox, Statistics Toolbox, Control System Toolbox-уудын дотоод функцүүдийг дуудаж ажиллуулдаг. Dynare программ хангамжийн тухайд загварыг .mod эсвэл .dyn файл дээр зохиож, матлабын filename/dynamic.m filename/static.m файлуудыг үүсгэж ажиллана. DIGNAR загварын хэрэглэгчийн орчныг доорх зурагт үзүүлээ.

Эхлээд өгөгдлүүдийг input.xlsx файлд бэлтгэн оруулна (нэрийг өөрчилбөл бусад функцүүд дээр бас өөрчлөх шаардлагатай болно). input.xlsx файлын Calibration, Exogenous, Scenarios, Customized graphs, External baseline гэсэн 5 хуудсанд (sheet) өгөгдлүүдийг оруулна (Зураг 55). Жишээлбэл, Calibration хуудсанд 7 бүлгийн 90 орчим параметрийн тохируулгыг оруулна. DIGNAR загварын simulatescenarios.m файл нь Зураг 56-д үзүүлсэнчлэн үндсэн симуляц тооцооллыг хийж буй матлаб файл юм. Энд input.xlsx файлын "Exogenous series" хуудсанд экзоген хувьсагчийн угуудын цувааг гурван өөр сонголтоор оруулж болно (дэд функцүүдийн хоорондын уялдааг Зураг 56-аас харна уу!)


<sup>12</sup> <https://www.dynare.org/about/>

<sup>13</sup> <https://www.mathworks.com>

Зураг 55. DIGNAR загварын хэрэглэгчийн орчин



Зураг 56. DIGNAR загварын схем



Үндсэн `simulatescenarios.m` симуляцын Матлаб файлд


1. `input.xlsx` файлын өгөгдлийг хуудас тус бүрээр импортолно.
2. Параметруудийг тохируулгын хуудас (`Calibration sheet`)-аас уншина.
3. Дараа нь `DSFNR.mod`, `LALIB.mod`, `EBASELINE.mod` Dynare моделийг дуудаж ажиллуулна.
4. Тооцооллын үр дүнгээс сонирхсон хувьсагчийн утгыг `output.xlsx` файлд бичиж графикаар дүрсэлнэ.

`DSFNR.mod` нь Dynare-ийн загварын гол файл бөгөөд өөртөө дараах гадаад `.mod` файлуудыг `@#include` командаар дуудаж холбоно. Үүнд:

1. Тэгшитгэлүүд `@#include "model_eqs.mod"`

2. Эндоген хувьсагчид @#include “end\_vars.mod”
3. Параметрууд @#include “params.mod”
4. Параметруудийн утга @#include “param\_val.mod”

Зураг 57. input.xlsx файлыг оруулах



Зураг 58. Загварын хувьсагчид

Variables in the model			
Variable	Description	Variable	Description
$c_i^j$	Total consumption by household's type $i$	$y_i$	Total output
$c_{i,j}^j$	Consumption of good $j$ by household's type $i$	$g^j$	Foreign grants
$p_{i,j}^j$	Relative price of nontradables	$r_{OZ}$	Value of natural resource revenue
$s_i$	Real exchange rate	$b_i$	Domestic government debt
$L_{i,j}^j$	Labor supply by household's type $i$ to sector $j$	$d_i$	Concessional government debt
$L_i^j$	Total labor supply by household's type $i$	$d_{i,j}$	Commercial foreign government debt
$w_i$	Average real wage	$g_i^j$	Government consumption
$w_{i,j}^j$	Real wage paid in sector $j$	$g_i^j$	Government investment
$b_i^{GDP}$	Government bonds (held by optimizers)	$g_i$	Total government expenditures
$b_i^{DFP}$	Foreign domestic debt (held by optimizers)	$g_{i,j}$	Government expenditures in sector $j$
$\tau_i^j$	Consumption tax rate	$p_i^j$	Relative price of government expenditures
$\tau_i^l$	Labor income tax rate	$\tau_i^j$	Share of tradables in government expenditures
$R_i$	Domestic real interest rate	$g_i^j$	Effective government investment
$R_i^*$	Foreign real interest rate	$\gamma_i^j$	Growth rate of government investment
$R_{i,j}^*$	Concessional real interest rate	$\delta_i^j$	Depreciation rate of public capital
$\pi_{i,j}^j$	Profits in sector $j$	$f_i$	Resource fund
$r_{i,j}^j$	Real return of capital in sector $j$	$f_{i,j}$	Inflows in the resource fund
$k_{i,j}^j$	Private capital in sector $j$	$f_{i,j}$	Outflows from the resource fund
$\tau_{i,j}^j$	Remittances	$g_{i,j}$	Fiscal gap
$z_i$	Government transfers	$\tau_{i,j}^j$	Target consumption tax rate
$k_{i,j}^j$	Public capital	$\tau_{i,j}^l$	Target labor income tax rate
$\theta_i^{GDP}$	Portfolio adjustment costs	$g_{i,j}^j$	Target government consumption
$y_i^j$	Output in sector $j$	$z_{i,j}^j$	Target government transfers
$L_{i,j}^j$	Labor in sector $j$	$\tau_{i,j}^j$	Rule-based consumption tax rate
$I_{i,j}^j$	Private investment in sector $j$	$\tau_{i,j}^l$	Rule-based labor income tax rate
$z_{i,j}^j$	TFP in tradables	$g_{i,j}^j$	Rule-based government consumption
$Y_{OZ}$	Value of resource production	$z_{i,j}^j$	Rule-based government transfers
$P_{OZ}$	Relative price of natural resources	$x_i$	Total government debt to GDP ratio
$Y_{OZ}$	Production of natural resources	$ca_i^j$	Current account deficit

$i = OPT, ROT,$   
 $j = T, N.$

**Тохиргоо (Калибрац)**

Энэхүү загварын калибрац нь үндэсний тооцоо, хүү, бүтцийн параметр, байгалийн нөөц, төсөв гэсэн үндсэн таван хэсгээс бүрдэнэ. Загварын тохируулга хийх суурь оноор 2025 оныг сонгож доорх хүснэгтэд үндэсний тооцооны хэсгийн калибрацын утгуудыг харуулсан болно. Тус хэсгийн тохируулгыг хийхдээ Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, Монголбанкны тоон мэдээллийн сан болон Bin Grace Li (2016) судалгааны өгөгдлийг ашигласан.<sup>14</sup>

**Хүснэгт 20. Үндэсний тооцооны хэсгийн калибрац**

Хувьсагчид	Калибрацын утга (хувиар)	Эх сурвалж
1. Эдийн засгийн өсөлт	6.8	ҮСХ
2. Экспортын ДНБ-д эзлэх хувь	68.07	ҮСХ
3. Импортын ДНБ-д эзлэх хувь	62.64	ҮСХ
4. Засгийн газрын хэрэглээний ДНБ-д эзлэх хувь	14.62	ҮСХ
5. Засгийн газрын хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь	7.88	ҮСХ
6. Хувийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь	23.53	ҮСХ
7. Байгалийн нөөцийн нэмэгдсэн өртгийн ДНБ-д эзлэх хувь	25.29	ҮСХ
8. Засгийн газрын дотоод өрийн ДНБ-д эзлэх хувь	1.53	ҮСХ

<sup>14</sup> "Current Account Norms for Resource Rich and Capital Scarce Countries", (joint with Araujo, Poplawski-Ribeiro, Zanna), "Journal of Development Economics", Volume 120, May 2016, Pages 144–156.

9. Хувийн гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь	82.68	ҮСХ
10. Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн ДНБ-д эзлэх хувь	1.57	Сангийн яам
11. Засгийн газрын гадаад арилжааны зээлийн ДНБ-д эзлэх хувь	36.40	Сангийн яам
12. Гадаад буцалтгүй тусламжийн ДНБ-д эзлэх хувь	0.38	Монголбанк
13. Улсын төсвийн нийт орлогын ДНБ-д эзлэх хувь	33.42	Сангийн яам
14. Гадаад тусламжийн ДНБ-д эзлэх хувь	0.38	Сангийн яам
15. Засгийн газрын нийт зардалд эзлэх худалдааны салбарын хувь	50	Bin Grace Li et al., (2016)
16. Өрхийн хэрэглээнд эзлэх худалдааны салбарын хувь	50	Bin Grace Li et al., (2016)
17. Худалдааны салбарын засгийн газрын зардалд эзлэх байгалийн баялгийн бус худалдааны эзлэх хувь	50	Bin Grace Li et al., (2016)
18. Худалдааны салбарын өрхийн хэрэглээнд эзлэх байгалийн баялгийн бус худалдааны эзлэх хувь	20	Bin Grace Li et al., (2016)

Дараах хүснэгт бодит хүүгийн хэсгийн калибрацын утгуудыг харуулав. Тус хэсгийн тохируулгын хийхдээ Үндэсний статистикийн хороо, Олон улсын trading economics мэдээллийн сан, Дэлхийн банк болон Олон улсын валютын сангийн тоо мэдээллийг ашиглав.

#### Хүснэгт 21. Бодит хүүгийн хэсгийн калибрац

Хувьсагчид	Калибрацын утга утга (хувиар)	Эх сурвалж
1. Дотоодын бодит хүү	8.6	Монголбанк, Үндэсний статистикийн хороо
2. Хөнгөлөлттэй зээлд төлж буй бодит хүү	1.01	Сангийн яам
3. Гадаадын эрсдэлгүй хөрөнгийн өгөөж (Америкийн засгийн газрын бондын бодит хүү)	1.5	Trading economics, Дэлхийн банк, Morningstar
4. Засгийн газрын гадаад зээлд төлж буй бодит хүү	3.2	Сангийн яам

Бүтцийн параметр болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн калибрацыг Bin Grace Li (2016), Сангийн яам болон Үндэсний статистикийн хорооны тоо мэдээллийг ашигласан бөгөөд дараах хүснэгтэд харуулав. Хөдөлмөрийн зах зээлийн ирээдүйн хэрэглээгээ

оновчилдог иргэдийн эзлэх хувийг дундаж, боломжийн болон чинээлэг иргэдийн эзлэх хувийн нийлбэрээр тооцсон.

**Хүснэгт 22. Бүтцийн параметрийн хэсгийн калибрац**

Хувьсагчид	Калибрацын утга утга	Эх сурвалж
1. Засгийн газрын хөрөнгө оруулалтын үр өгөөж	81.51	Сангийн яам
2. Хөдөлмөрийн зах зээлийн баян иргэдийн эзлэх хувь	39.8	Үндэсний статистикийн хороо
3. Хөдөлмөрийн орлуулалтын мэдрэмж	0.5	Үндэсний статистикийн хороо
4. Худалдааны болон худалдааны бус салбарын орлуулалтын мэдрэмж	0.46	Үндэсний статистикийн хороо
5. Худалдааны бус салбарын хөрөнгө оруулалтын тохируулгын зардлын параметр	25	Bin Grace Li et al., (2016)
6. Худалдааны салбарын хөрөнгө оруулалтын тохируулгын зардлын параметр	25	Bin Grace Li et al., (2016)
7. Худалдааны салбарын капиталын элэгдэл	10	Bin Grace Li et al., (2016)
8. Засгийн газрын капиталын элэгдэл	7	Bin Grace Li et al., (2016)

Дараах хүснэгтэд Төсвийн болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн калибрацын утгуудыг харуулав. Тус хэсгийн тохируулгын хийхдээ Сангийн яамны тоо мэдээллийг ашиглав. Засгийн газрын дэд бүтцийг ашигласны төлбөрийг татварын орлогын бусад төлбөр хураамж хэсгийг нийт урсгалд зардалд хувааж тооцов.

**Хүснэгт 23. Төсвийн болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн калибрац**

Хувьсагчид	Калибрацын утга утга	Эх сурвалж
1. Засгийн газрын нийт орлогод эзлэх байгалийн нөөцийн орлогын хувь	12.47	Сангийн яам
2. Улсын төсвийн нийт орлогод эзлэх Хүн амын орлогын албан татварын хувь	9.56	Сангийн яам
3. Улсын төсвийн нийт орлогод эзлэх Нэмэгдсэн өртгийн албан татварын хувь	20.71	Сангийн яам
4. Засгийн газрын дэд бүтцийг ашигласны төлбөр	10.7	Сангийн яам

Дээр дурдсанаас бусад энэхүү загварт ашигласан улаан болон цэнхэр өнгөөр тэмдэглэсэн калибрацын утгуудыг загварын анхны утгаар үлдээсэн болно.

### *Загварын гадаад (экзоген) хувьсагчдын төсөөлөл*

DIGNAR загварт байгалийн нөөцийн салбар, төсөв, нийтийн салбарын санхүүжилт, төлбөрийн баланс болон хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой нийт 5 бүлгийн 14 экзоген хувьсагч орц болж ашиглагдах бөгөөд үүнээс засгийн газрын хөрөнгө оруулалт, хэрэглээ, шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл, ажилчдын гуйвуулга, экспортын ДНБ-д эзлэх хувь, хөдөлмөрийн нийлүүлэлт, буцалтгүй тусламжийн орлого зэрэг 8 хувьсагчийн 2026-2029 оны утгуудыг E-views программ ашиглан дараах AR болон ARMA, ARIMA зэрэг нэг хувьсагчийн хугацаан цуваан загваруудыг ашиглан таамагласан.

AR(p) загварын тэгшитгэл:

$$y_t = \mu + \varphi_1 y_{t-1} + \varphi_2 y_{t-2} + \dots + \varphi_p y_{t-p} + u_t$$

ARMA(p,q) загварыг тэгшитгэл:

$$y_t = \mu + \varphi_1 y_{t-1} + \varphi_2 y_{t-2} + \dots + \varphi_p y_{t-p} + \theta_1 u_{t-1} + \theta_2 u_{t-2} + \dots + \theta_q u_{t-q} + u_t$$

Харин  $d$  удаагийн ялгавар авсан хувьсагч дээр босгосон ARMA(p,q) загварыг оригинал (ямар нэгэн хувиргалт хийгээгүй) хугацаан цувааны хувьд үнэлснийг ARIMA(p,d,q) загвар гэнэ. Мөн хувьсагчдын суурин эсэхийг өргөтгөсөн Дики Фуллер тест ашиглан шалгаж суурин бус хувьсагчдыг хувиргасан бөгөөд үнэлгээний хийсний дараа үлдэгдлийн шинжилгээг хийсэн болно.

**1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:** Энэхүү загварын калибрац болон экзоген хувьсагчдын ихэнх нь ДНБ-д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Иймээс ДНБ-ий өсөлтийг Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сангийн таамаглалын<sup>15</sup> дунджаар 2026 онд 6.2 хувь, 2027 онд 6.0 хувь, 2028 онд 5.5 хувь, 2029 онд 5.5 хувь харин инфляцыг тус 3 байгууллагын дундаж таамаглалаар 2026 онд 6.9, 2027 онд 6.7 хувь, 2028 онд 7.2 хувь, 2029 онд 7.2 хувь байна хэмээн төсөөлж нэрлэсэн ДНБ-ий 2026-2029 оны утгуудыг тооцоолсон.

### **2. Байгалийн нөөцийн салбар**


Байгалийн нөөцийн гарцын өсөлт: Байгалийн нөөцийн гаралтыг экспортын гол бүтээгдэхүүнүүд болох алт, зэс, төмрийн хүдэр, нүүрс гэсэн 4 гол бүтээгдэхүүний гарцын өсөлтөөр тооцсон. 2026-2029 оны тоон утгуудыг САЕМ загварт ашигласан төсөөллөөр авсан.

Нөөцийн үнэ: Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүний үнийн индекс болон САЕМ загварт ашигласан 4 гол түүхий эдийн үнийн төсөөллийг ашиглан нөөцийн үнийн индексийг тооцсон. Цаашлаад загварын мэдрэг байдлаас хамааран Ходрик-Прескоттын филтер ашиглан харьцангуй үнийн индексээс шокийг салгаж тренд утгыг загвартаа оруулсан.

<sup>15</sup> 3 байгууллагын төсөөллийн дундаж

### 3. Төсвийн үзүүлэлтүүд

Зураг 59. Засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөөлөл /2026-2029 он/




Засгийн газрын хөрөнгө оруулалт: Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон 1 удаагийн ялгавар авч суурин болгож AR(3) MA(3) загвараар үнэлсэн. Энэхүү загварын таамаглалын sMAPE=11.96 байна. Засгийн газрын хөрөнгө оруулалт 2026-2029 онд өсөх төлөвтэй байна.

Засгийн газрын хөрөнгө оруулалтын өгөөж: Засгийн газрын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг барилга болон тоног төхөөрөмжид оруулсан засгийн газрын хөрөнгө оруулалтыг Засгийн газрын нийт хөрөнгө оруулалтад хувааж тооцсон.


Засгийн газрын хэрэглээ: Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон 1 удаагийн ялгавар авч суурин болгож AR(2) загвараар үнэлсэн. Энэхүү загварын таамаглалын sMAPE=5.87 байна. Засгийн газрын хэрэглээ нь 2026-2029 онд өсөх төлөвтэй байна.

Зураг 60. Засгийн газрын хэрэглээний төсөөлөл /2026-2029 он/



Засгийн газрын шилжүүлэг: Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон 1 удаагийн ялгавар авч суурин болгож AR(3) MA(1) загвараар үнэлсэн ба таамаглалын sMAPE=8.4 байна. Засгийн газрын шилжүүлэгт тэтгэврээс бусад нийгмийн шилжүүлгийг оруулсан. Ахмад настны тэтгэвр нь DIGNAR моделийн хөдөлмөрийн зах зээлд загварчлагдаагүй болно.

**Зураг 61. Засгийн газрын шилжүүлэг (халамж)-ийн төсөөлөл /2026-2029 он/**




Нэмэгдсэн өртгийн албан татварын өөрчлөлтийн хувь: Татварын багц шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн барьсан. Дээр дурдсанчлан уг бодлого 2027 оноос эхлэн хэрэгжиж эхлэх ба бодлогын нөлөөг нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг 10 хувиас 6.5 хувь болгон бууруулсантай дүйцэхүйц нөлөө үзүүлнэ хэмээн тооцож, тус өөрчлөлтийг загварт тусгасан.

Хүн амын орлогын албан татварын өөрчлөлтийн хувь: Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан татварын бодлогын нөлөөг тус албан татварын хувь хэмжээг 11 хувиас 8.07 хувь болгон бууруулсантай дүйцэхүйц гэж тооцож, загварт оруулсан.


#### **4. Нийтийн салбарын санхүүжилттэй холбоотой үзүүлэлтүүд**

Буцалтгүй тусламжийн орлого: Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон 1 удаагийн ялгавар авч суурин болгож AR(2) MA(1) загвараар үнэлсэн. Энэхүү загварын таамаглалын sMAPE=14.8 байна. Буцалтгүй тусламжийн орлого нь 2026-2029 онд бага зэргийн хэлбэлзэлтэй байна.

**Зураг 62. Буцалтгүй тусламжийн орлогын төсөөлөл /2026-2029 он/**



**Зураг 63. Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн төсөөлөл /2026-2029 он/**




Засгийн газрын хөнгөлөлттэй зээл: Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон 2 удаагийн ялгавар авч суурин болгож AR(4) MA(1) загвараар үнэлсэн ба таамаглалын sMAPE=6.58 байна. Засгийн газрын хөнгөлөлттэй зээл нь 2025 онд өсөөд 2026 оноос буурах төлөвтэй байна.

Эрсдэлийн урамшуулал: Энэхүү үзүүлэлтийг Монгол Улсын засгийн газрын өрийн статистик болон АНУ-ын бондын хүүгийн 2026-2029 оны төсөөллийг ашиглан тооцсон.

### 5. Төлбөрийн баланстай хамааралтай хувьсагчид

Ажилчдын гуйвуулга: Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон 1 удаагийн ялгавар авч суурин болгож AR(4) загвараар үнэлсэн. Энэхүү загварын таамаглалын sMAPE=0.65 байна. Ажилчдын гуйвуулга нь 2026 он хүртэл өсөж түүнээс хойш аажмаар бууран тогтворжих хандлагатай байна.


**Зураг 64. Ажилчдын мөнгөн гуйвуулгын төсөөлөл /2026-2029 он/**



Экспортын ДНБ-д эзлэх хувь: Энэхүү үзүүлэлтийг 2010-2025 оны бодит утгуудыг ашиглан төсөөлж мэдрэг байдлаас хамааран Ходрик-Прескоттын филтер ашиглан харьцангуй үнийн индексээс шокийг салгаж тренд утгыг загварт оруулсан.

## 6. Хөдөлмөрийн зах зээл

Зураг 65. Ажиллах хүчний оролцооны түвшний төсөөлөл /2026-2029 он/



Хөдөлмөрийн нийлүүлэлт буюу ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний оролцооны түвшнийг ARIMA загвараар үнэлсэн ба тус үзүүлэлт 2026-2029 онд өсөх төлөвтэй байна.

### Тооцооллын үр дүн

Дээр дурдсан 5 бүлгийн калибрацийн утгууд, 5 бүлгийн экзоген хувьсагчдыг ашиглан тооцоолол хийхэд DIGNAR загварын төсөөлөл дараах байдалтай гарсан.

### Хүснэгт 24. DIGNAR загварын төсөөлөл

Хувьсагч	2026		2027		2028		2029	
	Бодлогын нөлөөгүй	Бодлогын нөлөөтэй	Бодлогын нөлөөгүй	Бодлогын нөлөөтэй	Бодлогын нөлөөгүй	Бодлогын нөлөөтэй	Бодлогын нөлөөгүй	Бодлогын нөлөөтэй
Бодит ДНБ-ний төсөөлөл (өсөлт) <sup>a</sup>	5.0	5.0	5.6	6.7	5.5	5.9	5.8	6.0
Нэрлэсэн ДНБ <sup>b</sup> /сая төг./	99,738,872.3		108,380,260.0		117,073,013.8		126,609,201.6	
Гадаад валютын ханшийн төсөөлөл <sup>a</sup> (бодит ханш, 2025 онтой харьцуулсан хувийн өөрчлөлт)	6.7	6.4	8.7	7.0	10.3	8.1	5.6	3.9
Уул уурхайн орлого (Төсвийн орлогод эзлэх хувь) <sup>a</sup>	13.7	13.7	14.2	14.2	14.6	14.6	13.9	13.9
Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсвийн орлогод эзлэх хувь <sup>a</sup>	8.1	8.1	8.5	8.6	8.9	8.7	9.0	9.0
Засгийн газрын хөрөнгө оруулалтын үр өгөөж <sup>a</sup>	78.3	78.2	78.2	78.1	79.2	79.7	78.5	78.4
Буцалтгүй тусламжийн ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	0.5	0.4	0.4	0.4	0.6	0.4	0.5	0.4


Улсын нийт өрийн ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	43.7	43.6	46.8	46.6	50.6	51.2	52.5	54.8
Засгийн газрын дотоод өрийн ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	2.1	2.1	3.1	3.5	4.4	5.5	6.2	8.0
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	1.3	1.2	1.2	1.1	1.1	1.1	1.0	1.0
Засгийн газрын гадаад арилжааны зээлийн ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	40.1	40.0	42.3	41.7	44.8	44.5	45.1	45.6
Ажилчдын гуйвуулгын ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	1.1	1.1	0.9	0.9	0.9	0.9	0.8	0.8
Экспортын ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	65.8	65.7	64.5	64.3	63.2	63.0	62.0	61.7
Ажиллах хүчний оролцооны түвшин <sup>b</sup>	62.9		63.5		64.2		64.9	
Улсын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь <sup>a</sup>	21.1	21.1	21.1	20.1	21.1	20.0	21.5	20.4

*DIGNAR* загварын төсөөлөл. Тайлбар а) загвар өөрөө тооцсон, б) загварт тооцож оруулсан.

### 3.3. CAEM загварын төсөөлөл

Эдийн засгийн онол, бодлогын шинжилгээнд зах зээлийн оролцогчдын ирээдүйн талаарх хүлээлт нь эдийн засгийн хувьсагчдын динамикт чухал нөлөө үзүүлдэг. Иймд эдгээр хүлээлт хэрхэн бүрэлдэн тогтож, цаг хугацааны явцад хэрхэн шинэчлэгддэгийг тайлбарлах онолын загварууд өргөн хэрэглэгддэг. Тэдгээрийн нэг нь **Comprehensive Adaptive Expectation Model (CAEM)** буюу дасан зохицох хүлээлтийн цогц загвар юм.

Зураг 66. САЕМ-ийн бүрэлдэхүүн хэсгүүд



САЕМ нь эдийн засгийн агентууд (өрх, аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагч гэх мэт) өөрсдийн ирээдүйн талаарх хүлээлтийг зөвхөн өнгөрсөн мэдээлэлд бус, харин шинэ мэдээлэл, бодлогын өөрчлөлт, зах зээлийн орчны өөрчлөлт зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан шат дараатайгаар шинэчилж байдаг гэсэн зарчимд тулгуурладаг ба Бодит сектор, Төсвийн сектор, Гадаад Сектор, Мөнгөний сектор гэсэн эдийн засгийн гол салбаруудын төсөөлөлд суурилдаг хагас бүтцийн загвар юм. Эдгээр салбарууд нь макро эдийн засгийн хувьсагчид, тэдний хоорондын хамаарлаар холбогдон эдийн засгийг бүрдүүлнэ. Түүнчлэн тус загварын голлох давуу тал нь эдийн засгийн нийт эрэлт, нийлүүлэлт тэнцвэрт оршино хэмээх онолын талыг тусгадаг давуу талтай.

Уг загварыг ОУВС-ийн Санхүүгийн програмчлал, бодлого сургалтын хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан, эксел суурьтай, Дэлхийн эдийн засгийн төлөв (World Economic Outlook, WEO)-ийн суурь төсөөлөл болон ОУВС-ийн өгөгдлийн сантай холбогдсон байдаг. Загварыг Монгол орны онцлогт тохируулан өгөгдлүүдийг шинэчилж, төсвийн секторыг өргөсөн байдлаар төсөөллийг гүйцэтгэв.

САЕМ загварт ашиглагдаж буй дээрх эдийн засгийн хоорондын харилцаа холбоог авч үзвэл дараах байна.

Ерөнхий бүтэц нь макро эдийн засгийн үндсэн блокуудаас бөгөөд дотоод эдийн засаг, гадаад сектор, мөн төсөв-мөнгөний бодлогын сувгуудын хоорондын харилцан хамаарлаас бүрдэнэ. Загварын гол хэсэг нь үндсэн макро блок бөгөөд үүнд бодит нийлүүлэлт, үнэ, бодит эрэлт зэрэг дотоод эдийн засгийн гол үзүүлэлтүүд тодорхойлогдоно. Эдгээр хувьсагчид нь мөнгөний бодлого, гадаад орчин болон төсвийн бодлогын нөлөөгөөр динамик байдлаар өөрчлөгдөнө.

Нэгдүгээрт, бодит нийлүүлэлтийн блок нь эдийн засгийн потенциал үйлдвэрлэл болон бодит үйлдвэрлэлийн хоорондын зөрүү болох үйлдвэрлэлийн зөрүүгээр тодорхойлогддог. Энэ зөрүү нь инфляцын динамикт чухал нөлөө үзүүлдэг бөгөөд инфляцын түвшин нь Филлипсийн муруйгаар тодорхойлогдоно. Мөн мөнгөний бодлогын хүү нь инфляц болон эдийн засгийн идэвхжилд хариу үйлдэл үзүүлэх Тейлорын дүрмээр илэрхийлэгдэнэ. Эдгээр

бодлогын өөрчлөлт нь валютын ханшид нөлөөлөх бөгөөд ханшийн динамик нь мөн тэгшитгэлээр тодорхойлогддог болно.

Хоёрдугаарт, бодит эрэлтийн блок нь дотоодын нийт эрэлтийг бүрдүүлэх үндсэн бүрэлдэхүүнүүд болох хэрэглээ, хөрөнгө оруулалт, экспорт, импортоос бүрдэнэ. Тус хэсэг нь бодит хүү, валютын ханш болон гадаад эрэлтийн өөрчлөлтөөс шууд хамаарна. Улмаар эдгээр бүрэлдэхүүнүүд нийлж бодит дотоодын нийт бүтээгдэхүүний төсөөллийг гаргах суурь хэсэг болдог.

Үнийн болон дефляторын блок нь эдийн засгийн нэрлэсэн болон бодит үзүүлэлтүүдийн хоорондын холбоог илэрхийлдэг. Үнийн индексүүд (дотоодын үнэ, импортын үнэ, экспортын үнэ зэрэг)-ийн өөрчлөлт нь ДНБ-ий дефляторыг бүрдүүлж, улмаар бодит болон нэрлэсэн ДНБ-ий хоорондын уялдаа холбоог тогтооно.


Түүнчлэн гадаад сектор нь гадаад эрэлт, гадаад инфляц, харилцагч орнуудын хүү зэрэг гадаад орчны хүчин зүйлсийг тусгаж, экспорт, импорт, санхүүгийн урсгал болон валютын нөөцөд нөлөөлнө. Гадаад секторын өөрчлөлт нь төлбөрийн тэнцэл, гадаад өр болон валютын ханшийн хөдөлгөөнөөр дамжин дотоод эдийн засагт нөлөөлөх байдлаар загвар ажилладаг.

Төсөв болон мөнгөний сектор нь засгийн газрын орлого-зарлага, төсвийн алдагдал, мөн төв банкны баланс, мөнгөний нийт үзүүлэлтүүд, дотоод зээлийн өөрчлөлтийг хамарна. Эдгээр бодлогын хувьсагчид нь дотоод эрэлт, инфляц, санхүүгийн нөхцөлд нөлөөлж, улмаар нийт эдийн засгийн идэвхжилд нөлөөлдөг. Энд нэг анхаарах асуудал байгаа нь тус загварын төсвийн төсөөллийн хэсэг нь хэтэрхий тоймчлох шинжтэй байсан тул нэмэлт тооцооллуудыг ашиглан өргөтгөсөн.

### Суурь төсөөлөл

**Үйлдвэрлэлийн зөрүү.** Загварын суурь төсөөлөлд үйлдвэрлэлийн зөрүү онцгой нөлөөтэй. Үйлдвэрлэлийн зөрүү нь мөнгөний бодлого, валютын ханш болон төсвийн бодлогод шууд болон дам нөлөөтэй. Загварын суурь таамаглалаар үйлдвэрлэлийн зөрүү 2026 онд потенциал ДНБ-ий 0.8 хувь, 2027 онд 0.5 хувь байна.

Зураг 67. Үйлдвэрлэлийн зөрүү



**Хувийн хэрэглээ.** Загварт хувийн хэрэглээ нь дараах тэгшитгэлээр тодорхойлогдох бөгөөд үүнд өмнөх үеийн хэрэглээ ( $C_{t-1}$ ), тухайн жилийн орлого ( $ydt$ ), бодит зээлийн хүү ( $rt$ ), урт хугацааны дунджид дөхөх хандлага зэрэг багтана.

$$\Delta c_t = \beta_0^c + \beta_1^c \Delta c_{t-1} + \beta_2^c \Delta ydt_t - \beta_3^c \hat{r}_t^L - \lambda^c [c_{t-1} - \bar{y}_{t-1} - \gamma_0^c] + \varepsilon_t^c$$

**Ашигласан коэффициент**


	Ашигласан коэффициент	OLS - Coeff
Constant ( $\beta_0$ )	0.05	0.05
<b>Богино хугацааны</b>		
Өмнөх үеийн хэрэглээ ( $\beta_1$ )	0.09	0.14
Орлого ( $\beta_2$ )	0.24	0.27
Бодит хүүгийн түвшин ( $\beta_3$ )	0.22	0.4
<b>Урт хугацааны</b>		
$\gamma_0$	-0.42	-0.52
$\lambda$ (Speed of adjustment )	0.30	0.08

**Хувийн хөрөнгө оруулалт.** Загварт хувийн хөрөнгө оруулалт нь дараах тэгшитгэлээр тодорхойлогдох бөгөөд үүнд өмнөх үеийн хөрөнгө оруулалт ( $C_{t-1}$ ), тухайн жилийн ДНБ ( $ydt$ ), зээлийн бодит хүү ( $rt$ ), урт хугацааны дунджид дөхөх хандлага зэрэг багтана.


	Ашигласан коэффициент	OLS - Coeff
Constant ( $\beta_0$ )	-0.13	-0.13
<b>Богино хугацааны</b>		
Өмнөх үеийн хөрөнгө оруулалт ( $\beta_1$ )	0.10	0.31
Бодит ДНБ ( $\beta_2$ )	2.71	2.71
Зээлийн бодит хүү ( $\beta_3$ )	1.91	1.91
<b>Урт хугацааны</b>		
$\gamma_0$	-1.51	-1.56
$\lambda$ (Speed of adjustment )	0.85	0.85

**Өсөлт болон нэрлэсэн ДНБ.** Бодит эдийн засгийн өсөлт 2027 онд 5.6 хувийн өсөлттэй байх төсөөлөлтэй байна. Өсөлт өмнөх жилүүдээс буурахад экспортын орлогоос төсөвт төвлөрөх дүн буурахтай холбоотойгоор төсвийн хөрөнгө оруулалт багасах эрсдэлтэй байгаа нь чухал нөлөө үзүүлэх хандлагатай байна. Түүнчлэн бусад хувийн хэрэглээний эерэг нөлөө өмнөх онуудаас саарах хүлээлттэй байгаа нь нөлөөлөх үр дүнтэй байна.


**Зураг 68. Бодит ДНБ-ий өсөлт**



Зураг 69. ДНБ-ий өсөлтөд салбарын оролцоо



Зураг 70. Нэрлэсэн ДНБ



Нэрлэсэн ДНБ жил дараалан 11% орчим өсөх бөгөөд үүнд дээрх эдийн засгийн өсөлт, инфляц болон ханшийн өсөлт нөлөөлж байна.

**Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого.** Төсвийн орлогын өсөлтийн хурд өмнөх жилүүдтэй харьцуулахад харьцангуй буурах буюу 10 орчим хувьд хадгалах үр дүнтэй байна. 2022-2024 онд төсвийн орлого 32.7 хувиар өссөн бөгөөд энэ нь нүүрсний үнийн хөөсрөл, цар тахлын дараах эдийн засгийн огцом идэвхжил, Ирээдүй өв сангийн хуваарилалтыг хуулийн дагуу хийгээгүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалсан. Тэгвэл цар тахлын дараах эдийн засгийн идэвхжил нэгэнтээ дуусаж, нүүрсний үнийн хөөсрөл хагарсныг 2025 оны төсвийн орлогын өсөлт харуулсан. Улмаар төсвийн орлогын өсөлтийн сааралтын чиг хандлага хадгалагдахын сацуу Ирээдүй өв санд төвлөрөх дүн хуулиар

тогтоосон хэмжээнд<sup>16</sup> байна гэсэн сахилга бат бүхий таамаглалыг дэвшүүлсэн нь төсвийн орлогын өсөлт 10 хувь орчимд гарахад голчлон нөлөөлөв.

САЕМ загварын хүрээнд төсвийн орлогыг зөвхөн том дүнгээр эдийн засгийн өсөлтөөс хамаатуулан төсөөлөлгүйгээр Татварын мэдрэмжийн арга (Tax buoyancy approach) болон Бодит үйлчилж буй татварын хувь хэмжээний аргачлал (Effective tax rate approach)-уудыг татварын ангилал тус бүрийн хувьд гүйцэтгэв. Улмаар татварын шинэчлэлтэй холбоотой нөлөөг тусгах боломж олгосон болно.

**Татварын орлогын эдийн засгийн үзүүлэлтээс хамаарах мэдрэмж.** Төсвийн секторын гол төсөөлөл нь татварын орлогын мэдрэмж дээр үндэслэнэ. Төсвийн орлогын төсөөллийг гүйцэтгэхэд татварын орлогын урт богино хугацааны мэдрэмжийг тооцох замаар төсвийн голлох орлогуудын төсөөллийг хийв.<sup>17</sup>

$$\Delta \ln Tax_t = \lambda \ln Tax_{t-1} + \gamma \Delta \ln GDP_t + \delta \ln GDP_{t-1} + \varepsilon_t$$

Энд  $Tax_t$  нь t үеийн төсвийн орлого,  $GDP_t$  нь ДНБ (эсвэл харгалзах орлогын суурь хувьсагч),  $\varepsilon_t$  нь алдааны хэсэг болно.  $\gamma$  нь суурь хувьсагчийн 1 хувийн өөрчлөлтөд үзүүлэх харгалзах төсвийн орлогын өөрчлөлтийн утга (богино хугацааны нөлөө)-ыг илтгэнэ. Харин  $\theta = -\frac{\delta}{\lambda}$  нь суурь хувьсагчийн 1 хувийн өөрчлөлтөд үзүүлэх харгалзах төсвийн орлогын урт хугацааны нөлөө болно. Төсвийн орлогын тооцоололд богино хугацааны мэдрэмжийг ашигласан бөгөөд орлого, харгалзах суурь хувьсагчдын хамаарлын коэффициент, урт, богино хугацааны орлогын мэдрэмжийг дараах хүснэгт харуулав.

**Хүснэгт 25. Төсвийн орлого болон суурь хувьсагчдын хамаарал**

Төсвийн орлого	Мэдрэмж тооцсон суурь хувьсагч	Урт хугацааны мэдрэмж ( $\theta$ )	Богино хугацааны мэдрэмж ( $\theta$ )
ХХОАТ	Дундаж цалингийн өсөлт	1.3	0.68*
ААНОАТ	Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлт	1.12	0.55*
НӨАТ	Импортын өсөлт	1.06*	0.9
Гаалийн албан татвар	Импортын өсөлт	1.06	0.7*
АМНАТ	Уул уурхайн салбарын экспорт	0.65	0.79*
Нийгмийн даатгалын орлого	Дундаж цалингийн өсөлт	1.24	0.79*
Бусад орлого	ДНБ	0.76*	1.8

\*Мэдрэмжийн тооцоололд ашиглагдсан коэффициент

**Бодит үйлчилж буй татварын хувь хэмжээ.** Бодит үйлчилж буй татварын хувь хэмжээ буюу Effective Tax Rate нь зөвхөн аж ахуйн нэгжийн түвшинд төдийгүй улс орны макро эдийн засгийн түвшинд татварын бодит ачааллыг үнэлэхэд ашиглагддаг чухал аргачлал юм. Тус аргачлал нь макро

<sup>16</sup> Үндэсний баялгийн сангийн тухай хууль, 11.1.1.a - ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь;

<sup>17</sup> (Antoine Cornevin, Mr. Juan C Flores and Juan Pablo Angel, 2023)-ын үзнэ үү.

түвшинд нь эдийн засгийн тодорхой төрлийн татварын орлогыг тухайн татвар ногдох суурьтай харьцуулан тооцдог.

ОУВС тэргүүтэй олон улсын байгууллагууд татварын бодлогын үр нөлөөг үнэлэх, татварын суурь, татварын хөнгөлөлтийн нөлөөг тодорхойлох, мөн улс орнуудын татварын тогтолцоог харьцуулахад ETR үзүүлэлтийг өргөнөөр ашигладаг.

$$r_t^{tax} = Tax_t / GDP_t$$

$$Tax_{t+1} = r_t^{tax} * GDP_{t+1}$$

Энд  $r$  нь ETR буюу бодит үйлчлэх татварын хувь хэмжээг илтгэх бөгөөд  $GDP_t$  нь харгалзах эдийн засгийн суурь хувьсагчийг илтгэнэ. Энэ нь татварын ангилал тус бүрийн хувьд харилцан адилгүй хувьсагч байх бөгөөд АМНАТ-ын хувьд экспортын орлого, Гаалийн албан татварын хувьд импорт зэрэг байна.


Татвар шууд ногдох суурь үзүүлэлтийн тоон өгөгдөл нээлттэй биш байх асуудал бий. Уг тохиолдолд эдийн засгийн харгалзах, ойролцоо үзүүлэлтийг ашиглах замаар дээрх асуудлыг шийддэг. Энэхүү аргачлалын хүрээнд татварын мэдрэмж тооцоход ашигласан үзүүлэлтүүдийг суурь хувьсагч болгон ашигласан бөгөөд үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 26. Суурь хувьсагчдаас хамааран татвар ногдох хувь хэмжээ**

Төсвийн орлого	Хувь тооцсон суурь хувьсагч	ETR
ААНОАТ	Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт	8.60%
ХХОАТ	Дундаж цалингийн өсөлт	1
НӨАТ	Импорт	11%
Гаалийн албан татвар	Импорт	3.30%
АМНАТ	Уул уурхайн салбарын экспорт	2.50%
Бусад орлого	ДНБ	4.50%


**Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл.** Дээрх загвар, аргачлал, суурь таамаглалуудын хүрээнд төсвийн орлого 2026 онд 33.0 их наяд төгрөг, 2027 онд 36.4 их наяд төгрөгт хүрэх төлөвтэй байна. Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ харьцангуй зохистой, бодит түвшинд хүрч буурах буюу 30% орчимд хүрэхээр байгаа хэдий ч 2015-2021 оны дунджаас өндөр байх үр дүнд хүрэв.

Зураг 71. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл




2022-2024 онд төсвийн орлого 32.7 хувиар өссөн бөгөөд энэ нь нүүрсний үнийн хөөсрөл, цар тахлын дараах эдийн засгийн огцом идэвхжил, Ирээдүй өв сангийн хуваарилалтыг хуулийн дагуу хийгээгүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалсан. Тэгвэл цар тахлын дараах эдийн засгийн идэвхжил нэгэнтээ дуусаж, нүүрсний үнийн хөөсрөл хагарсныг 2025 оны төсвийн орлогын өсөлт харуулсан. Улмаар төсвийн орлогын өсөлтийн сааралтын чиг хандлага хадгалагдахын сацуу Ирээдүй өв санд төвлөрөх дүн хуулиар тогтоосон хэмжээнд<sup>18</sup> байна гэсэн сахилга бат бүхий таамаглалыг дэвшүүлсэн нь төсвийн орлогын өсөлт 10 хувь орчимд гарахад голчлон нөлөөлөв.

Зураг 72. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ




<sup>18</sup> Үндэсний баялгийн сангийн тухай хууль, 11.1.1.а - ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь;

Зураг 73. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын өсөлтийн оролцоо, төсвийн орлогын ангиллаар



**Нэгдсэн төсвийн зарлага.** Нэгдсэн төсвийн зарлагыг тооцохдоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9 дүгээр заалтад тусгагдсан тэнцвэржүүлсэн тэнцлийн хуулийн хязгаарыг мөрдлөг болгов. Ингэхдээ ирэх жилүүдэд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2 хувийн алдагдалтай байхаар тооцлоо.

Зураг 74. Төсвийн урсгал зардал



Нэгдсэн төсвийн урсгал зардлын нийт зардалд эзлэх хувь өмнөх 10 жилийн орчимд буюу 78%-тай байх тохируулга хийв. Нэгэнт өссөн урсгал зардлыг танах нь улс төрийн сахилга бат шаардах асуудал тул төсвийн орлого тасалдах тохиолдолд эдийн засгийн чухал үзүүлэлт болох хөрөнгийн зардал үлэмж хэмжээгээр танагдах эрсдэлтэй.

**Хүснэгт 27. Нэгдсэн төсвийн урсгал зардал**

	2022	2023	2024	2025	2026	2027	2028
Үндсэн урсгал зардал (тэрбум төгрөг)	13,558	16,171	21,384	22,641	26,378	29,119	32,038
Өсөлтийн хувь	13.5	19.3	32.2	5.9	16.5	10.4	10.0

**Хүүгийн зардал.** Хүүгийн зардал нь дотоод болон гадаад хүүгийн зардлын нийлбэрээр буюу дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$Int_t = e_t^{avg} i_t^f D_{t-1}^f + i_t^d D_{t-1}^d \quad (2)$$

Энд  $e_t^{avg}$  нь  $t$  үеийн ам.доллартой харьцах төгрөгийн ханш,  $i_t^f$  нь ам.доллаар илэрхийлэгдэх өрийн дундаж хүүгийн түвшин,  $D_{t-1}^f$  нь өмнөх үеийн гадаад өр. Түүнчлэн  $i_t^d$  нь төгрөгөөр илэрхийлэгдэх өрийн дундаж хүүгийн түвшин,  $D_{t-1}^d$  нь өмнөх үеийн дотоод өр болно. Дотоод болон гадаад валютаар илэрхийлэгдэх өрийн хүүгийн түвшин өмнөх 3 жилийн дундажтай ижил түвшинд байна хэмээн үзэв.

**Хөрөнгийн зардал** (Net acquisition of nonfinancial assets). Загварын хүрээнд хөрөнгийн зардал нь тэнцвэржүүлсэн тэнцэл хуулийн хүрээнд байхад зайлшгүй зардлыг (Цалин хөлс, урсгал зардал) хассан дүн байхаар тооцлоо. Тухайлбал төсвийн орлого нэмэгдэж төсөвт орон зай гарах үед хөрөнгийн зардал нэмэгдэх бол аливаа гадаад шокийн нөлөөгөөр орлого буурч, төсвийн орон зай хумигдсан үед хөрөнгийн зардал тус хэмжээнд буурна (Үүнд эдийн засгийн уналттай холбоотойгоор нэрлэсэн ДНБ-ий өсөлт буурч, урсгал зардал буурах нөлөөг хамруулахгүй). Улмаар хөрөнгийн зардал 2026- 2029 онд харгалзан 7.3 их наяд, 8.1 их наяд, 8.9 их наяд, 9.9 их наяд төгрөг байхаар байна.

**Хүснэгт 28. Төсвийн үзүүлэлтүүдийн төсөөлөл /2026-2029 он/**

	2026	2027	2028	2029
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого, их наяд ₮	32.96	36.38	40.04	44.32
ДНБ-д эзлэх хувь	30.0%	29.8%	30.3%	30.9%
Төсвийн нийт зарлага, их наяд ₮	35.16	38.82	42.68	47.19
ДНБ-д эзлэх хувь	32.0%	31.8%	32.3%	32.9%
Хөрөнгийн зардал, их наяд ₮	7.4	8.1	9.0	9.9
ДНБ-д эзлэх хувь	6.7%	6.7%	6.8%	6.9%
Хүүгийн зардал, их наяд ₮	1.4	1.6	1.7	1.9
ДНБ-д эзлэх хувь	1.3%	1.3%	1.3%	1.3%

Дээрх тооцооллын үр дүн нь гадаад шок, сценарын нөлөөг тусгаагүй буюу гадаад шокийн нөлөө үүссэн тохиолдолд нэгэнт өссөн зардлын хэт тэлэлтээс шалтгаалан төсвийн тэнцэл хуулийн хүрээнд багтахгүй байх эрсдэлтэйг анхаарах нь зүйтэй.

**Татварын реформын нөлөө.** Татварын багц шинэчлэлийн хүрээнд Засгийн газраас Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн барьсан. Дээр дурдсанчлан уг бодлого 2027 оноос эхлэн хэрэгжиж эхлэх ба бодлогын нөлөөг нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээг 10 хувиас 6.5 хувь болгон бууруулсантай дүйцэхүйц нөлөө үзүүлнэ хэмээн тооцож, тус өөрчлөлтийг загварт тусгасан. Хувь хүний орлогын албан татварын өөрчлөлтийн хувь: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан татварын бодлогын нөлөөг тус албан татварын хувь хэмжээг 11 хувиас 8.07 хувь болгон бууруулсантай дүйцэхүйц гэж тооцож, загварт оруулсан.

Ингэхдээ төсөвт үзүүлэх нөлөө тогтмол хувиар саарна гэсэн таамаглалыг дэвшүүллээ. Татварын реформын нөлөө нь төсвийн орлогыг бууруулах шууд нөлөө үзүүлэхээс гадна ДНБ-ий бүрэлдэхүүн хэсэг болох төсвийн хөрөнгийн зардал, төрийн хэрэглээг бууруулах замаар эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлнэ. Эсрэг талд татварын орлогыг бууруулснаар эдийн засаг дах хувийн хэрэглээ, хувийн хөрөнгө оруулалт өсөх хөшүүрэг болно. Ийнхүү татварын реформ нь төсөв, хэрэглээ, хөрөнгө оруулалт гэх мэт олон сувгаар дамжин нийт эдийн засагт нөлөө үзүүлнэ.

**Хүснэгт 29. Загварт тусгасан татварын реформын төсөвт үзүүлэх шууд нөлөө, тэрбум төгрөг**


	2027	2028	2029
ХХОАТ	-483.6	-319.18	-159.59
ААНОАТ	-719.5	-474.87	-237.44
НӨАТ	-2500	-1650	-825
<b>Нийт</b>	<b>3,703.1</b>	<b>2,444.0</b>	<b>1,222.0</b>

Улмаар төсөвт үзүүлэх татварын реформын эцсийн нөлөө нь (шууд болон шууд бус нөлөөллийн дараа) төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2027 онд 4.1 их наяд төгрөг, 2028 онд 2.5 их наяд төгрөг, 2029 онд 1.2 их наяд төгрөгөөр бууруулахаар байна. Эсрэг талд төсвийн зардлыг тус хэмжээнд бууруулсны эцэст тэнцвэржүүлсэн тэнцлийн хуулийн шаардлагыг хангах боломж үүсэхийг санах хэрэгтэй.


**Зураг 75. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төсөөлөл, татварын реформын нийт нөлөө**



**Зураг 76. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь, татварын реформын нөлөө**



**Зураг 77. Татварын реформын бодит ДНБ-д үзүүлэх нөлөө, өсөлтийн хувь**



Татварын реформын нийт эдийн засагт үзүүлэх нөлөө 2027 онд 1.2 нэгж хувьтай тэнцэх сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай байгаа бол 2028-2029 онуудад хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт өсөх нөлөөгөөр эдийн засгийн өсөлт илүү өндөр байх төсөөлөлтэй байна.

**Хүснэгт 30. Татварын реформын бодит ДНБ-ий бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөө, тэрбум төгрөг**

	Суурь төсөөлөл			Татварын реформ			Өөрчлөлт		
	2027	2028	2029	2027	2028	2029	2027	2028	2029
Хувийн хэрэглээ	27,293	28,375	29,657	27,483	28,443	29,606.4	190	67	-51
Хувийн хөрөнгө оруулалт	8,060	8,269	8,773	7,818	8,289	8,849.8	-242	19	77
Экспорт	25,534	26,904	28,387	25,534	26,904	28,388.5	0	1	1
Импорт	35,921	37,175	39,066	35,021	36,834	39,067.4	-900	-341	1

Татварын реформын нөлөөгөөр хувийн хэрэглээ 2027-2028 онуудад харгалзан 190, 67 тэрбум төгрөгөөр өсгөх үр дүнтэй байна. Харин хувийн хөрөнгө оруулалт жилийн

хоцрогдолтой буюу 2028 оноос эерэг болох хүлээлттэй гарав. Хувийн хэрэглээ өсөж буй хэдий ч Засгийн газрын хэрэглээ буурах нөлөөгөөр импорт 2027, 2028 онд нийт 1.2 их наяд төгрөгөөр буурах нөлөөтэй байна.

**Экспорт, импорт, төлбөрийн тэнцэл.** Загварын экспортын тэгшитгэл нь төсөөллийн алдаа өндөр, тайлбар багатай байгааг харгалзан экспортыг төсөөллийг гол эрдэс бүтээгдэхүүний экспортын үнэ болон биет хэмжээний төсөөллөөс хамааруулан төсөөллөө. Үүнд,

- Экспортын гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн буюу нүүрс, зэс, алт, төмрийн хүдрийн үнэ болон тоо хэмжээг ашиглан эдгээр бүтээгдэхүүний экспортын орлогыг төсөөлөв (Хүснэгт 32). Энд, түүхэн гүйцэтгэл, геополитикийн нөхцөл байдал, тодорхой бус байдал, цаашдын хандлага зэргийг харгалзан зэс, алтны үнийг эконометрик загварын үр дүнгээс 2026 онд 10%, 2027-2029 онд 5%-аар бага байхаар авч үзлээ.
- Харин бусад уул уурхайн бүтээгдэхүүний экспорт болон уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг сүүлийн онд 10 жилийн дундаж өсөлтөөр өснө гэж үзэв.

**Хүснэгт 31. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний таамаглал**


	2026	2027	2028	2029
Зэсийн хүдэр /мян.тонн/	2,603	2,740	2,874	3,008
Нүүрс /мян.тонн/	86,928	84,749	89,639	97,735
Төмрийн хүдэр /мян.тонн/	9,420	9,727	10,124	10,460
Алт /тонн/	15.8	15.9	15.8	15.8

**Хүснэгт 32. Гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын үнийн таамаглал, сая ам доллар**

	2026	2027	2028	2029
Зэсийн хүдэр (ам.доллар/тн)	2,748	2,865	2,834	2,831
Нүүрс (ам.доллар/тн)	68	71	69	66
Төмрийн хүдэр (ам.доллар/тн)	75	75	75	76
Алт (ам.доллар/унц)	4,331	5,315	5,540	5,601

Барааны экспортын орлогын нийт бараа, үйлчилгээний экспортын орлогод эзлэх хувь нь сүүлийн 3 жилийн дундажтай тэнцүү байна гэж үзэн нийт бараа, үйлчилгээний экспортыг төсөөллөө. Ийнхүү экспортын дүн жил бүр өсөх, төлбөрийн тэнцлийн төсөөлөлтэй нийцтэй байдлаар бодит экспорт 2026-2029 онуудад 5-9 хувийн орчимд өсөхөөр байна.

Зураг 78. Бараа, үйлчилгээний экспортын өсөлт, бодит секторт



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Тайлбар: Экспортыг загварын тэгшитгэлээр төсөөлөөгүй тул 2026-2029 онд төсөөлөл болон загварын таамаглал хэсэг ялгаатай байна.

Импортын хувьд загварын тэгшитгэлийн дагуу төсөөлөл боловсруулав. Загварт бодит импорт нь дараах байдлаар тодорхойлогдоно. Үүнд,

$$\Delta m_t = \beta_0^m + \beta_1^m \Delta m_{t-1} + \beta_2^m \Delta y_t - \beta_3^m \Delta r_{pim} - \lambda^m [m_{t-1} - \bar{y}_{t-1} - \gamma_1^m \overline{r_{pim}}_{t-1} - \gamma_0^m] + \varepsilon_t^m$$

Энд,  $\beta_0^m$  нь тогтмол,  $\beta_1^m$  нь импортын өсөлтийн хөшүүн байдал,  $\beta_2^m$  нь эдийн засгийн өсөлтөөс хамаарах хамаарал,  $\beta_3^m$  нь импортын харьцангуй үнээс хамаарах хамаарал,  $\lambda^m$  нь урт хугацааны тренд рүүгээ хэр хурдан дөхөж байгааг илэрхийлнэ.


	Ашигласан коэффициент	OLS - Coeff
Тогтмол ( $\beta_0$ )	-0.02	-0.02
<b>Богино хугацааны</b>		
Өмнөх үеийн импорт ( $\beta_1$ )	0.14	0.14
Эдийн засгийн өсөлт ( $\beta_2$ )	2.23	2.23
Импортын харьцангуй үнэ ( $\beta_3$ )	0.04	0.04
<b>Урт хугацааны</b>		
$\gamma_0$	5.56	5.58
$\gamma_1$	-1.26	-1.26
$\lambda$ (Speed of adjustment)	0.51	0.67

Импортын тэгшитгэлийн коэффициентүүдийг 2008-2025 оны түүхэн өгөгдөлд суурилан тооцсон бөгөөд манай улсын эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг харгалзан урт хугацааны хувьсагчуудын сүүлийн 10 жилийн төсөөллийн алдааг илүү бага байлгах коэффициентүүдийг ашигласан болно.

Тооцоололд импортын төсөөлөлд ямар нэгэн нэмэлт тохируулга хийгээгүй бөгөөд бүрэн загвараар тодорхойлогдсон. Ийнхүү 2026-2029 онуудад эдийн засгийн өсөлт саарах хандлагатай байх, улмаар бодит импортын өсөлт нам түвшинд байхаар байна. Бодит секторын импортын өсөлт, импортын дефлятор болон ханшийн төсөөлөлтэй нийцтэйгээр төлбөрийн тэнцлийн бараа, үйлчилгээний импорт тодорхойлогдоно. Улмаар, 2027 онд 17.9

тэрбум ам.доллар, 2028 онд 19.2 тэрбум ам.доллар, 2029 онд 20.9 сая ам.долларт тус тус хүрэхээр байна.

Зураг 79. Бараа, үйлчилгээний импортын өсөлт, бодит секторт



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Цаашлаад, төлбөрийн тэнцлийн бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрхэн төсөөлсөн талаар дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 33. Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн бүрэлдэхүүн	Төсөөллийн арга
Урсгал тэнцэл	
Бараа үйлчилгээний тэнцэл	
Бараа, үйлчилгээний экспорт	Өмнө дурдсанчлан, түүхий эдийн үнэ болон биет хэмжээний төсөөллийг ашиглан тооцоолсон.
Бараа, үйлчилгээний импорт	Өмнө дурдсанчлан, загварын импортын тэгшитгэлийн дагуу тооцож, сая ам.долларт хөрвүүлсэн.
Анхдагч орлого	
Үүнээс: Хүүгийн төлбөр	
Үүнээс: Засгийн газар	Засгийн газрын гадаад өрийн хүүгийн төлбөртэй тэнцүү
Үүнээс: Бусад сектор	Сүүлийн 3 жилийн дундаж
Бусад	Сүүлийн жилтэй тэнцүү
Хоёрдогч орлого	
Үүнээс: Тусламжийн орлого	Төсвийн тусламжийн орлоготой тэнцүү, сүүлийн 3 жилийн дундаж
Бусад	Сүүлийн 3 жилийн дундаж
Хөрөнгийн данс	Сүүлийн 3 жилийн дундаж
Санхүүгийн данс	
ШХО	ОТ-н хүүгийн аккруэль, бусад хэсэг нь сүүлийн 3 жилийн дундаж
Багцын ХО	
Үүнээс: Засгийн газар	Засгийн газрын төлөгдөх бондуудын 90 хувийг дахин санхүүжүүлэх
Үүнээс: Бусад	Сүүлийн 3 жилийн дунджаар цэвэр дүнгээр бонд гаргасан бол ирэх жилүүдэд дунджаар тэр хэмжээний эргэн төлөлт хийх
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	Сүүлийн 3 жилийн дундаж

Бусад хөрөнгө оруулалт	
Үүнээс: Засгийн газар	Засгийн газрын гадаад санхүүжилтээс гадаад бондоор санхүүжүүлэх дүнг цэвэрлэж, Засгийн газрын гадаад зээлийн санхүүжилтийг тооцов
Үүнээс: Бусад	Сүүлийн 3 жилийн дундаж
Алдаа болон орхигдуулаг	Сүүлийн 3 жилийн дундаж

Багцын хөрөнгө оруулалт болон ГШХО-ын төсөөллийг дараах таамаглалуудад үндэслэн боловсруулав. Багцын хөрөнгө оруулалтын хувьд, Засгийн газраас бондын эргэн төлөлтийн дийлэнх хэсгийг буюу 90 хувийг бондоор дахин санхүүжүүлнэ гэж үзэв (Хүснэгт 34). Түүнчлэн, Засгийн газрын 2026 онд гаргасан 500 сая ам.долларын бондыг төсөөлөлдөө тусгалаа. Засгийн газраас бусад секторуудын хувьд, гаргасан бонд болон бондын эргэн төлөлтийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй тул сүүлийн 5 жилийн дундаж дүнгээрээ бонд гаргаж, эргэн төлөлт хийнэ гэж үзэв.

#### Хүснэгт 34. Бонд

Засгийн газрын бондын таамаглал	2026	2027	2028	2029
Номад	174.3			
Сэнчүри Г'27		413.1		
Сэнчүри Г'31				
Сэнчүри II			541.7	
Сэнчүри III				350
Сэнчүри IV				
Нийслэлийн бонд		500		
Нийт эргэн төлөлт	174	913	542	350
Дахин санхүүжүүлэх бонд (90%)	157	822	488	315
Шинээр гаргах бондын мэдээлэл	500			
БХО цэвэр нөлөө	483	-91	-54	-35

*Тайлбар: Сүүлийн мөрөнд эерэг дүн нь Засгийн газраас цэвэр дүнгээр санхүүжилт татсан, сөрөг дүн нь бондын эргэн төлөлт хийсэн болохыг илэрхийлнэ.*

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хувьд Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалт дууссан тул түүнтэй холбоотой хөрөнгө оруулалт ирэх жилүүдэд орж ирэхгүй, зөвхөн хүүний аккруэль бичилт нь орно гэж үзэв. Гэхдээ, уг хүүгийн төлбөрийг нэг талдаа анхдагч орлогын хүүгийн төлбөр, нөгөө талдаа гадаадын шууд хөрөнгө оруулалтад бичигдэх тул төлбөрийн тэнцлийн нийт дүнд нөлөөгүй.

Хүснэгт 35. Гадаадын шууд хөрөнгө оруулалт


Төсөөллийн хугацаанд	
ГШХО	Гаднаас хийсэн ХО - Гадаадад хийсэн ХО
Гаднаас хийсэн ХО /цэвэр/	Орох урсгал - Гарах урсгал
Орох урсгал	Уул уурхайн салбар болон бусад салбарын ХО-н нийлбэр
Үүнээс: Уул уурхай	ОТ болон бусад уул уурхайн компаниудын ХО-н нийлбэр
Оюу Толгой (ОТ)	ОТ-н зөвхөн хүүний аккруэль бичигдэх (Анхдагч орлогод бичигдэх бусад секторын хүүний төлбөрийн 73%)
Бусад уул уурхай	Сүүлийн 3 жилийн дундаж
Бусад	Сүүлийн 3 жилийн дундаж
Гарах урсгал	Сүүлийн 3 жилийн дундаж
Гадаадад хийсэн ШХО	Сүүлийн 3 жилийн дундаж

Тэмдэглэл: Сүүлийн 14 жилд Монголд орж ирж буй хөрөнгө оруулалтын урсгалын 73 хувийг уул уурхайн салбар бүрдүүлж байна.

Бусад хэсэгт сүүлийн 3 жилийн дундаж түвшинд хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын гарах урсгал явагдана гэсэн таамаглалд үндэслэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр дүнг гаргасан.

Ирэх онуудад экспортын өсөлт өндөр байгаагаас урсгал тэнцэл 2026, 2027 онуудад ДНБ-ий 0.6%, 1.3% хүрэх, 2028, 2029 онуудад ДНБ-ий -0.1%, -2.1% хүрэхээр байна. Ийнхүү урсгал тэнцэл ашигтай гарах нь тус хэмжээгээр гадаад санхүүжилтийн шаардлага бага байгааг илэрхийлнэ.

Зураг 80. Урсгал дансны тэнцэл ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Санхүүгийн дансны хувьд, ААН, байгууллагуудын нарийн мэдээлэл, нэгдсэн мэдээллийн сан байхгүй тул харьцангуй энгийн байдлаар төсөөллийн аргачлалуудыг ашигласан. Ийнхүү экспортын орлого өндөр байх, Засгийн газраас төсвийн алдагдлыг санхүүжүүлэхээр гадаад эх үүсвэр татах зэргээс шалтгаалан ирэх онуудад төлбөрийн тэнцэл ашигтай гарахаар байна. Тухайлбал, 2027-2029 онд төлбөрийн тэнцэл 1 тэрбум ам.доллар давсан ашигтай байхаар байна. Төлбөрийн тэнцэл энэ хэмжээний ашигтай байх гол нөхцөл нь экспортын гол эрдэс бүтээгдэхүүнүүдийн экспортын үнэ болон биет хэмжээ таамаглалд авч үзсэн түвшинд хүрэх юм.

Ирэх онуудад гадаад худалдааны төлөв, экспортын орлогын зарцуулалт, ханшийн өөрчлөлт, Засгийн газар, ААН-үүдийн гадаад эх үүсвэрээс санхүүжилт татах шийдвэр, олон улсын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх нь төлбөрийн тэнцлийн нөхцөл байдалд нөлөөтэй.

**Мөнгөний сектор.** Мөнгөний секторын гол үзүүлэлт болох мөнгөний нийлүүлэлт нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн болон мөнгөний эргэлтийн хурдаар тодорхойлогдох бөгөөд, мөнгөний эргэлтийн хурд нь загварт дараах байдлаар тодорхойлогдож байна.

$$M2\ money_t = \frac{NGDP_t}{MV_t}$$

$$\Delta MV_t = average\ \Delta MV_t + \mu(\pi_t - \pi_{t-1}) + \varepsilon_t^{\Delta MV}$$

Энд, *M2 money* нь мөнгөний нийлүүлэлт, *MV* нь мөнгөний эргэлтийн хурд,  $\mu$  нь мөнгөний эргэлтийн хурдын инфляцаас хамаарах хамаарлыг илэрхийлнэ. Гэвч эдгээр тэгшитгэлүүдийн дагуу төсөөлөл бусад секторуудтай нийцгүй байгааг харгалзан дараах байдлаар төсөөллөө. Үүнд, төсөөлөл хийсэн хугацаанд хувийн секторын зээл болон ДНБ-ий харьцаа өмнөх онуудын дундажтай нийцтэй түвшинд байхаар үзэв. Улмаар зээлийн өсөлт болон бусад секторуудын төсөөллөөс шалтгаалан мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2027 онд 25.0%, 2028 онд 19.5%, 2029 онд 17.1% -д тус тус хүрэхээр байна.

## ДУГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын эдийн засгийн өсөлт урьдчилсан гүйцэтгэлээр өндөр гарсан, валютын нөөц, төлбөрийн тэнцлийн хувьд эерэг өөрчлөлтүүдтэй байгаа ч нөгөө талд гадаад худалдаа, экспорт, төсөв, татварын орлого буурсан зэрэг анхаарах асуудлууд их байна.

Иймд ТТБЗ-өөс ДХТХМ-ийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал боловсруулахад зориулан хийсэн судалгаа, загварын үр дүнг нэгтгэн дараах дүгнэлтүүдийг өгч байна.

1. Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал эрсдэлтэй хэвээр байна. Судалгаанаас харахад а) Дэлхийн болон хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарах эрсдэл, б) Эдийн засгийн бүтэц, өсөлтийн тогтвортой байдлаас хамаарах эрсдэл, в) Гадаад худалдаа, нүүрсний үнэтэй холбоотой эрсдэл, г) Төсөв, төсвийн тогтвортой байдал зэрэг эрсдэл байгааг анхаарах шаардлагатай байна.
2. Гадаад орчны нөхцөл байдал, БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдлаас хамаарах эрсдэл өндөр байна. Ялангуяа дэлхийн геополитикийн нөхцөл байдал, дайн байлдааны эрсдэлтэй холбоотой БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарах, түүний эсрэг хэрэгжүүлэх бодлогын нөлөөллийг харгалзах шаардлага улам нэмэгдэж байна.
3. Монгол Улсын эдийн засаг тогтворгүй бөгөөд хэврэг, хүртээмжтэй бус байна. Эдийн засгийн урьдчилсан гүйцэтгэлээр өсөлт 6.8 хувь буюу ТТБЗ-ийн болон Олон улсын байгууллагуудын таамаглалаас өндөр гарсан ч энэхүү өсөлт нь дунд хугацаанд үргэлжлэх баталгаа багатай байна. Учир нь тухайн жилийн өсөлтөд өмнө дараалсан уналттай ХАА-н салбарын сэргэлтээс бий болох нөлөөлөл давамгайлж байгаа нь дараа жилүүдэд энэхүү өсөлт үргэлжлэх магадлалыг бууруулж байна.
4. Дээрх шалтгаанаар дунд хугацаанд эдийн засгийн өсөлт уул уурхайн салбараас хамаарах хамаарал өндөр байна. Уул уурхайн салбар нь эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хэмжээний хувьд сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байгаа нь баримтаас харагдаж байгаа. Иймд дараа жилүүдэд бид уул уурхайн бүтээгдэхүүний гарц, үнийн асуудлаас ихээхэн хамааралтай болж байна.
5. Гадаад худалдааны хувьд эрс бууралт ажиглагдаагүй, бүтцийн хувьд сайжирсан эерэг тал байна. Таамаглалаас харахад уул уурхайн салбарт дунд хугацаанд эерэг нөлөөлөл гарахаар байгаа нь гадаад худалдааны үзүүлэлтэд сайнаар нөлөөлөхөөр байна. Гэсэн хэдий ч олон улсын байгууллагууд нүүрсний үнийн хувьд өөдрөг таамаглал дэвшүүлэхгүй байгаа нь бас нэг харгалзах үзүүлэлт юм.
6. Төсвийн хувьд 2025 оны төсвийн тодотгол, 2026 оны төсвийн төлөвлөлт, 2026-2028 оны ДХТХМ-ийн хувьд төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувийн жин, алдагдлыг бууруулах бодлого баримталж, дунд хугацаанд үргэлжлүүлэхээр төлөвлөсөн нь бодлогын зөв сонголт бөгөөд үргэлжлүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Учир нь дунд хугацаанд эдийн засгийн эрсдэл өндөр байгаа үед зарлагын тэлэлт нь төсвийн эрсдэлийг улам нэмэгдүүлэх нөлөөлөлтэй хэмээн үзэж байна.
7. Дээрхтэй холбоотойгоор төсөвт эрсдэл учруулж байгаа гол хүчин зүйлсээр макро эдийн засгийн тогтворгүй байдал, уул уурхайн салбараас хамаарах өндөр хамаарал, төсвийн зарлагын өсөлт зэргийг онцолж байна.

**Төсвийн төлөвлөлтийг гадаад, дотоод орчны хүчин зүйлсийг харгалзан хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдаатай оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх чиглэлээр өгөх бодлогын зөвлөмж**

Судалгааны үр дүнд үндэслэн ТТБЗ-ийн зүгээс өмнөх жилийн нэгэн адил дунд хугацаанд төсвийн зарлагыг хэт өсгөхгүй, алдагдлыг бууруулах төсвийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж, төсвийн бодлогыг макро эдийн засгийн нөхцөл байдалд нийцтэй хэрэгжүүлэх шаардлагатай гэх үзэл баримтлалд чиглэсэн дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна.

1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн бодлогын ач холбогдлыг нэмэгдүүлэх. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн нөхцөл байдалд нийцтэй, эрсдэлийг харгалзсан төсвийн бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай.
2. Дунд хугацааны төсвийн бодлогыг хөгжлийн урт хугацааны бодлоготой уялдуулан тодорхойлох. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд төсвийн нийт зарлага, урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг тодорхой зааж өгсөн бөгөөд түүнийг баримталж ажиллах нь эдийн засгийн өнөөгийн, дунд хугацааны нөхцөл байдалд нийцэх төдийгүй төсвийн тогтвортой байдалд эергээр нөлөөлөх ач холбогдолтой юм.
3. Монгол Улс эдийн засгийн хувьд эмзэг бүтэцтэй, эрсдэл өндөртэй гэдгийг хүлээн зөвшөөрч түүнийг төсвийн дунд хугацааны төлөвлөлтөд харгалзах шаардлагатай. Уул уурхайн бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай байдал нь гадаад орчны эрсдэлийг нэмэгдүүлж байгааг төсвийн бодлого, төлөвлөлтөд анхаарах нь зүйтэй.
4. Уул уурхайн салбарын нөхцөл байдалтай холбоотойгоор зарим экспортын бүтээгдэхүүний үнийн таамаглал, тэнцвэржүүлсэн үнэ зэрэг нь зах зээлийн бодит үнээс зөрүүтэй байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлэх нөлөөтэй гэдгийг судалгааны үр дүн харуулж буй тул анхаарч ажиллахыг зөвлөж байна.
5. *Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.7, 6.8, 6.9, 6.10-д заасан хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг нэн тодорхой, харилцан уялдаатай боловсруулж баталсан байх, тэдгээр бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтууд, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, төсвийн эх үүсвэрийн тооцооллыг урьдчилан хийсэн байх учиртай гэсэн шаардлагыг хангах хэрэгтэй гэсэн өмнөх жилийн зөвлөмжийг хэвээр үлдээж байна.*

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6.2.7-ийн “төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх”; 9.1.2-д “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, ЭМД-ийн сангийн төсөв, тэдгээрийн тодотголыг хэлэлцэж батлах” гэсэн заалтуудын дагуу салбар тус бүрд болон аймаг, нийслэлд хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр нь үндэслэл бүхий, нарийн тооцоо, судалгаанд үндэслэн хийгдэж байж шаардагдах төсөв, хөрөнгө нь төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсвийн төсөлд тусгагдах ёстой гэж үзэж байна.

## ХАВСРАЛТ

### Хавсралт 1. Эдийн засгийн өсөлт, салбарын өрөлдөө (2016-2025)

	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Бүгд	1.49	5.64	7.75	5.6	-4.56	1.64	5.03	7.42	5.12	6.84
ХАА, ойн аж ахуй, загас барилг, ан агнуур	0.76	-0.04	0.9	0.72	0.79	-0.83	1.68	-1.33	-3.64	2.86
Уул уурхай, олборлолт	-0.29	-0.68	0.86	-0.25	-1.44	0.12	-2.08	2.58	1.36	1.41
Боловруулах үйлдвэрлэл	-0.51	1.05	1.38	0.3	0.27	-0.07	0.5	0.42	-0.34	0.74
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.08	0.09	0.16	0.15	0.05	0.22	0.08	0.12	0.11	0.22
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	-0.01	0.01	0	0	-0.01	0.01	0.01	0.02	0.01	0.02
Барилга	-0.02	-0.05	0.07	0.71	-0.13	-0.92	0.25	0.1	0.42	0.52
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	-0.02	0.93	0.02	1.19	-1.43	0.61	1.1	0.77	1.35	-0.55
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.34	0.05	0.77	0.25	-1.01	-0.35	0.4	1.78	0.96	0.31
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	0.16	0.05	0.19	0.11	-0.29	0.06	0.26	0.3	0.26	0.04
Мэдээлэл, холбоо	0.02	-0.09	0.23	0.24	0.11	0.47	0.18	0.47	0.52	0.24
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.28	0.75	0.59	0.26	0.06	0.47	0.14	0.56	1.38	0.67
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.19	0.77	0.23	-0.21	-0.1	-0.13	0.14	0.14	0.11	0.03
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	-0.11	0.03	0.01	0.26	-0.09	0.12	0.15	0.05	0.32	0.05
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.12	0.01	0	0.06	-0.05	0.05	0.15	0.11	0.12	0.05
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.27	0.56	0.1	0.33	-0.14	0.25	0.05	0.29	0.01	0.03
Боловсрол	0	0.13	0.15	0.25	-0.13	0	0.46	0.11	0.11	0.12
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	-0.07	0.05	0.13	0.21	0.11	0.19	0.11	0.05	0.12	0.02
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0	0.04	0.01	0.02	-0.01	0.01	0.09	0.04	0.05	0.03
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.08	0.04	-0.02	-0.02	-0.09	0.03	0	0.02	0.05	-0.01
Бүтээгдэхүүний цэвэр гатвар	0.21	1.94	1.98	1.04	-1.06	1.31	1.36	0.83	1.83	0.04



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,  
2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2027 он	2028 он	2029 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	5.8	6.0	6.3
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	7.0	6.0	5.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ /тэрбум төгрөг/	34,780.0	37,371.8	39,737.5
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	30.4	29.4	28.1
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	36,493.4	38,644.0	40,444.7
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.9	30.4	28.6
5	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,713.4	-1,272.2	-707.2
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-1.5	-1.0	-0.5
6	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	32,495.4	34,827.4	36,908.5
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	28.4	27.4	26.1
7	Нэгдсэн төсвийн суурь тэнцэл /тэрбум төгрөг/	2,284.6	2,544.4	2,828.9
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.0	2.0
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ /тэрбум төгрөг/	57,114.9	63,610.1	63,651.0
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	50.0	50.0	45.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс хуваарилах зардлын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	2,823.0	2,998.2	3,173.0
	- Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.5	2.4	2.2

## ТАНИЛЦУУЛГА

*Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл” гэж заасан бөгөөд энэ хүрээнд татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлэх, бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, хариуцлагатай татвар төлөгчийг дэмжих зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Энэ хүрээнд татварын шинэчлэлийг үе шаттай хийхээр төлөвлөсөн ба эхний үе шат болох Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Их Хурлаар 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр батлагдсан. Уг хуулийн төсөлд иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулж, орлогын тэгш бус байдлыг бууруулах, татварын хамрагдалтыг сайжруулах, далд эдийн засгийг бууруулах зорилгоор нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ын урамшууллын буцаан олголтын 20 хувийг шаталсан хэлбэрээр нэмэгдүүлж 100 хүртэл хувьд хүргэх зохицуулалтыг тусгаж, 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөөд байсан.

Гэвч тус хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсанаас хойших хугацаанд Ойрх Дорнодод үүссэн геополитикийн нөхцөл байдлаас шалтгаалан дэлхий даяарх газрын тосны үнийн тогтворгүй байдлаас үүдэн инфляцын түвшин нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөх нөхцөл бүрдээд байна. Энэ нь макро эдийн засгийн болон бизнесийн үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн бодит орлого, худалдан авах чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул гадаад орчноос үүдэлтэй эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах, инфляцын гэнэтийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Түүнчлэн Олон улсын валютын сан (ОУВС)-ийн Дүрмийн IV заалтын дагуу Монгол Улсад хийгдсэн 2025 оны зөвлөлдөх хэлэлцүүлгээр НӨАТ-ын урамшууллын буцаан олголтыг огцом нэмэгдүүлэх, татварын хувь хэмжээ, суурийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх нь татварын орлогыг бууруулж, төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ зайлшгүй шаардлагатай хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх төсвийн боломжийг хумих эрсдэлтэй гэж дүгнэсэн байна. Мөн төсвийн орлого буурч буй энэ үед дээрх татварын арга хэмжээ нь уул уурхайн орлогын хэлбэлзлээс хамааралтай төсвийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх сөрөг үр дагавартай гэж үзсэн. Иймд төсвийн тогтвортой байдал, олон улсын сайн туршлага зэргийг харгалзан төсвийн орлогыг огцом бууруулах татварын арга хэмжээг энэ цаг үед авч хэрэгжүүлэх нь оновчтой эсэхийг дахин нягтлахыг ОУВС-аас зөвлөсөн.

Иймд гадаад орчинд үүсээд буй нөхцөл байдал, олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмж зэргийг харгалзан үзсэний үндсэнд НӨАТ-ын урамшууллын буцаан олголтыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хүчингүй болгохоор хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөл батлагдсанаар төсвийн орлого их хэмжээгээр буурах, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ өсөж, инфляцын түвшин нэмэгдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэх юм.

---oOo---

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Төрийн ордон  
Улаанбаатар хот

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай  
хуульд өөрчлөлт оруулах тухай

**1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“15.2.1.энэ хуулийн 15.3-т заасан нөхцөл, шаардлага хангасан албан татвар төлөгчийн тухайн улиралд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэл хувийг буцаан олгох;”

**2 дугаар зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17<sup>1</sup> дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

### *Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

Сүүлийн жилүүдэд олон улсын эдийн засгийн орчин тогтворгүй, өндөр хэлбэлзэлтэй байж, тодорхойгүй байдал нэмэгдсээр байна. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн огцом өөрчлөлт, геополитикийн нөхцөл байдал, инфляцын дарамт, мөнгөний бодлогын чангаруулалт зэрэг хүчин зүйлс нь улс орнуудын макро эдийн засгийн орчинд шууд болон шууд бус байдлаар нөлөөлж байна. Үүний улмаас төсвийн бодлогыг богино хугацаанд нөхцөл байдалд нийцүүлэн оновчтой өөрчлөх шаардлагыг бий болгож байна.

Гэвч Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, түүний нэмэлт, өөрчлөлтийг баталснаас хойш гурваас доошгүй сарын хугацаанд харгалзах тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлэх, батлахыг хориглоно” гэж заасан нь дээрх шаардлагад нийцэхгүй бөгөөд төсвийн бодлогын хариу арга хэмжээг цаг хугацааны хувьд удаашруулах сөрөг үр дагавартай байна.

Энэхүү зохицуулалт нь төсвийн төлөвлөлтийн сахилга бат, тогтвортой байдлыг хангах зорилготой боловч практикт дараах хүндрэлүүдийг үүсгэж байна. Үүнд:

- Эдийн засгийн нөхцөл байдал богино хугацаанд өөрчлөгдөх үед төсвийн бодлогыг шуурхай тохируулах боломжийг хязгаарлаж байна;
- Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлд үүссэн зөрүүг богино хугацаанд зохицуулах боломжийг хойшлуулж байна;
- Онцгой нөхцөл байдалд төсвийн бодлогын уян хатан байдлыг бууруулж байна.

Энэ хүрээнд хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “төсвийн тодотголын” гэснийг хасахаар тусгасан болно.

Уг өөрчлөлтийг баталснаар төсвийн тодотголын төслийг 3 сарын хугацааны хязгаарлалтгүйгээр өргөн мэдүүлэх эрх зүйн боломж бүрдэх бөгөөд төсвийн бодлого, шийдвэрийг эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн цаг алдалгүй хэрэгжүүлэх нөхцөл сайжирна. Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дүн гарна гэж үзэж байна. Үүнд:

- Төсвийн бодлого макро эдийн засгийн гэнэтийн өөрчлөлтөд шуурхай, уян хатан хариу үзүүлэх боломжтой болно;
- Төсвийн орлого, зарлагад үүссэн хүндрэлтэй байдлыг цаг алдалгүй зохицуулах нөхцөл бүрдэнэ;
- Төсвийн тодотгол болон төлөвлөлтийн үйл явцыг эдийн засгийн бодит нөхцөлтэй уялдуулан хэрэгжүүлэх эрх зүйн орчин сайжирна;

- Төсвийн бодлогын хэрэгжилтийн үр нөлөө нэмэгдэнэ.

Иймд Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “түүний нэмэлт, өөрчлөлтийг”, “төсвийн тодотголын” гэснийг тус тус хасах нь төсвийн бодлогын уян хатан, шуурхай байдлыг хангах, гадаад болон дотоод эдийн засгийн өөрчлөлтөд оновчтой хариу үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Төрийн ордон  
Улаанбаатар хот

**ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “түүний нэмэлт, өөрчлөлтийг”, “төсвийн тодотголын” гэснийг тус тус хассугай.

Гарын үсэг

**“МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2027 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2028-2029 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ”-ИЙН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛЫН ТОВЬЁГ**

Монгол Улсын "Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл"-ийн төсөл боловсруулах хүрээнд Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль, журамд заасны дагуу төсвийн төлөвлөлтөд төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллага, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоог хангах, иргэдийн санал, санаачилгыг төсөвт тусгах зорилгоор 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдөр олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Мөн түүнчлэн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх “Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах төв”-өөр дамжуулан санал авах үйл ажиллагааг зохион байгуулж, цахим орчинд нээлттэй санал, асуулга явуулсны үр дүнд нийт 1,030 гаруй хариулт, 42 задгай санал хүлээн авсан байна. Олон нийтээс ирүүлсэн санал, зөвлөмжийг нэгтгэн дүн шинжилгээ хийж, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгасан болно.

**Нэг. Хэлэлцүүлэх арга хэмжээнд төрийн болон эрдэм шинжилгээний байгууллага, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон иргэдийн төлөөллөөс ирүүлсэн задгай саналын товьёг**

*Хүснэгт 1. Эрдэм шинжилгээ, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил болон иргэдийн төлөөллөөс ирүүлсэн задгай санал*

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага	1	Хөдөө аж ахуйн салбарын нэмүү нэмэгдүүлэх дэмжих.	Саналыг хүлээн авч, хөдөө аж ахуйн салбарын цаашид баримтлах бодлого, стратегид тусгасан. Дэлгэрэнгүй танилцуулгын 3.1. дэх хэсгээс харах боломжтой. Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2.0 хувиас илүүгүй ашиг, алдагдалтай байх зорилтот түвшнийг хангаж байхаар хуулийн хүрээнд тусгасан.
	2	Төсвийн хязгаарыг баримт уялдуулан баримтлах.	алдагдлын бодлогын бичгүүдтэй чанд тэнцлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19.9-д заасан тухайн төсвийн жилийн ДНБ-ий 2.0 хувиас илүүгүй ашиг, алдагдалтай байх зорилтот түвшнийг хангаж байхаар хуулийн хүрээнд тусгасан.
	3	Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх.	Дэлгэрэнгүй танилцуулгын 2.2.6 дахь хэсгээс харах боломжтой. Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага	4	Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлын нөлөөллийг бодлогын түвшинд тусгах.	<p>Манай улс сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлт болон макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг харьцангуй тогтвортой түвшинд хадгалж ирсэн хэдий ч гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, шинэ сорилтууд нэмэгдсээр байна.</p> <p>Геополитикийн нөхцөл байдал хурцдаж, ялангуяа Ойрх Дорнодын бүс нутаг дахь тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь олон улсын санхүүгийн зах зээл, тээвэр, логистик, хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж, нийлүүлэлтийн сүлжээ, импортын үнийн дарамт, экспортын орлого, валютын ханш, инфляцад эрсдэл үүсгэх нөхцөлийг бүрдүүлж байна.</p> <p>Эдгээр хүчин зүйлсийг харгалзан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028–2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулсан болно.</p>
	5	Төсвийн хуваарилалтыг илүү оновчтой болгох.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
	6	Шинжлэх ухаанд чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	7	Төсвийн нийт хэмжээг оновчтой түвшинд барих.	<p>Хөгжиж буй улс орнуудын төсвийн орлого, зарлагын ДНБ-д эзлэх хувь хэмжээг Монгол Улстай харьцуулсан байдлаар шигтгээ мэдээлэл бэлтгэн боловсруулсан. Дэлгэрэнгүй танилцуулгын Шигтгээ 2.1 дэх хэсгээс харах боломжтой.</p> <p>Мөн түүнчлэн Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.</p>
	8	Шинжлэх салбарт оруулалт шаардлагатай. ухааны хөрөнгө хийх	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
	9	Төсвийн зардлыг бууруулах бодлогыг тууштай хэрэгжүүлэх.	<p>Дунд хугацаанд Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан бодлогын хүрээнд эдийн засаг дахь төрийн оролцоо, төсвийн зардлын тэлэлтийг хязгаарлах, урсгал зардлын өсөлтөд зайлшгүй шаардлагатай нийгмийн халамж, тэтгэвэр тэтгэмж, цалин хөлсийг инфляцтай уялдуулан нэмэгдүүлэх, үр ашиггүй төсвийн зардлыг бууруулж, төсвийн сахилга батыг сахих бодлогыг баримтлан төсвийн зарлагын ДНБ-нд эзлэх хэмжээг үе шаттай бууруулах бодлогыг баримталсан болно.</p> <p>Төсвийн зардлын 2027-2029 оны төсөөллийн талаар дэлгэрэнгүй танилцуулгын 2.2.2 дахь хэсгээс харах боломжтой.</p>
Мандах Их Сургууль	10	Хөрөнгө оруулалтын төслүүдийг эдийн засгийн өгөөжөөр нь эрэмбэлж, төрийн байгууллагуудыг KPI-д суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжүүлэх. Мөн зардал-үр ашгийн (cost-benefit) шинжилгээг тогтмол хийж, төсвийн алдагдлыг бууруулах.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
Монгол Улсын Их Сургууль	11	ААНОАТ-ын тухай хуулийн 22.9-д заасан борлуулалтын 1%-ийн татварын хөнгөлөлтийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаж, хэрэгжилт болон тайлагналын журмыг тодорхой болгох шаардлагатай.	Саналыг хүлээн авч, Сангийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах татварын бодлогыг холбогдох хууль тогтоомж болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулан тусгах чиглэлээр анхаарч ажиллана.
Иргэний нийгмийн байгууллага	12	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, чанарыг сайжруулах.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	13	Орон нутаг болон хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих.	Саналыг хүлээн авч, хөдөө аж ахуйн салбарын цаашид баримтлах бодлого, стратегид тусгасан. Дэлгэрэнгүй танилцуулгын 3.1. дэх хэсгээс харах боломжтой.

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
Хувийн хэвшил	14	Боловсролын төсвийг ДНБ-ий 6%-д хүргэж тогтвортой хадгалах.	Саналыг хүлээн авч, боловсролын салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд судалж, үе шаттай хэрэгжүүлнэ.
	15	Төсвийн сахилга батыг чанд мөрдүүлэх.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
	16	Төсвийн орлого нэмэгдэх бүрд зардлыг дагуулан тэлэх бодлогыг хязгаарлаж, санхүүгийн сахилга батыг сайжруулах.	Саналыг хүлээн авч, төсвийн сахилга батыг сайжруулах, зардлын өсөлтийг хязгаарлах чиглэлээр ДХТХМ-д тусгасан.
	17	Төсвийн орлогын бүтцэд уул уурхайгаас хамаарах хамаарлыг бууруулж, бусад салбарыг дэмжих.	Дунд хугацаанд салбаруудын үйл ажиллагааг зах зээлийн механизм руу чиглүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих бодлогыг баримтална. Эдийн засгийн төрөлжилтийг дэмжих салбаруудын бодлогын талаар дэлгэрэнгүй танилцуулгын 3.1. дэх хэсгээс харах боломжтой.
	18	Төсвийн зардлын үр ашиг, зарцуулалтад хяналтын тогтолцоог сайжруулах.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
	19	Хөдөлмөрийн зах зээлд хиймэл оюун ухааны нөлөөллийг бодлогод тусгах.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	20	Дэд бүтцийг тэргүүнд хөгжүүлж байж томоохон төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх.	Саналыг хүлээн авч, томоохон авто замын төслүүд болон эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлэхээр салбарт бүрд баримтлах стратегид тусгасан болно
	21	Геополитикийн эрсдэлийг тооцож, урьдчилан сэргийлэх механизм болон хяналтын тогтолцоог сайжруулах.	Ойрх Дорнодын бус нутагт үүсээд буй геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дэх тодорхой бус байдал нэмэгдэж байна.

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
			Иймд олон улсын шинжээчдийн дүгнэлт, зөвлөмжийг харгалзан үзэж манай улсын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсрууллаа.
	22	Гадаадын зээл, тусламжийн ил тод байдал болон үр ашигт хяналтыг сайжруулах.	Саналыг хүлээн авсан.
	23	Төсвийн зардлыг таных бодлого хэрэгжүүлэх.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална. Дунд хугацаанд экспортыг нэмэгдүүлэх хүрээнд Засгийн газраас баяжуулах болон боловсруулах үйлдвэрүүдийг дэмжих, хил, гааль, тээврийн зохион байгуулалтыг сайжруулах, мөн ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж зэсийн салбарт орох хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан.
	24	Экспортыг санхүүжилтийг нэмэгдүүлэх. дэмжих	
	25	Төсвийн зардлыг бууруулах бодлого баримтлах.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
	26	Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг суурь, өөдрөг, гутранги зэрэг олон хувилбараар тооцож, эрсдэлийг бодлогын түвшинд тусгах.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
Иргэн	27	Эрчим хүч, боловсрол, эрүүл мэндийн салбарт анхаарч, ТЭЗҮ болон БОҮ-гүй төслүүдийг санхүүжүүлэхгүй байх, төсөл хөтөлбөрийг ач холбогдлоор нь эрэмбэлэх.	Саналын хүлээн авч, холбогдох ТЭЗ-ын саналтай уялдуулан, төсөл хөтөлбөрийн эрэмбэлэх, санхүүжилтийн шалгуурыг сайжруулах чиглэлээр анхаарч ажиллана.

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
	28	Хэрэгцээгүй, давхардсан зардлыг бүрэн зогсоох.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
	29	Ашигт боловсруулах үйлдвэрийг төсвийн нэмэгдүүлэх.	Саналыг хүлээн авч бодлогын чиглэлд холбогдох агуулгыг тусгалаа. Уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн салбарын бодлогын чиглэлийн талаар дэлгэрэнгүй танилцуулгын 3.1. дэх хэсгээс харах боломжтой.

## Хоёр. Төрийн байгууллагын төлөөллөөс ирүүлсэн задгай саналын товьёг

### Хүснэгт 2 Төрийн байгууллагын төлөөллөөс ирүүлсэн задгай санал

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
Төрийн Байгууллага	1	Гадаад зах зээлийн савлагаа, эрсдэлийг бодитой тооцож төсвийн төлөвлөлтөд тусгах.	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсруулахад дэлхийн зах зээл дээрх тодорхой бус байдал, геополитикийн нөхцөл байдлын талаарх олон улсын шинжээчдийн дүгнэлтийг харгалзан үзэж, олон улсын байгууллагуудын төсөөлөлд үндэслэн боловсруулсан болно.
	2	Бүсчилсэн хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх.	Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан.
	3	Төсвийн зардлын бүтцийг оновчтой болгож, шаардлагагүй зардлыг танах замаар үе шаттай бууруулах.	Дунд хугацаанд нийт зардлын ДНБ-д эзлэх хувь хэмжээг үе шаттай бууруулж, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэг рүү чиглүүлэх, үр ашиггүй төсвийн зарцуулалтыг багасгаж төсвийн сахилга батыг сайжруулах бодлого баримтална.
	4	Үр ашиггүй зардлыг бууруулж, төсөл, арга хэмжээний эдийн засгийн өгөөжийг үнэлж шийдвэр гаргах.	
	5	Инфляцыг бууруулж, иргэдийн бодит орлогыг хамгаалах бодлого хэрэгжүүлэхийн зэрэгцээ нийгмийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлэх.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав. Засгийн газрын 2025 оны "Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 224-р тогтоол батлагдаж, зарим салбарын албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлсэн.
	6	Төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх.	Уг шийдвэртэй холбоотойгоор ДХТХМ-д эдгээр нөлөөллийг тооцож, боловсруулсан бөгөөд цалингийн зардлын төсөөллийн талаар дэлгэрэнгүй танилцуулгын 2.2.2 дахь хэсгээс харах боломжтой.
	7	Төсвийн тооцооллыг бодит нөхцөлд нийцүүлэн илүү нарийвчлалтай хийх.	Саналыг хүлээн авч, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн

Байгууллага, иргэн	№	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх тайлбар
			төсөөллийн тухай хуулийн төсөлд тусгав.
	8	Үндэсний баялгийн сангийн зарцуулалтыг хязгаарлаж, төсвийн алдагдлыг салбараар ангилан тооцох.	Саналыг хүлээн авч, цаашид төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад анхаарч ажиллана.
	9	Уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх.	Дунд хугацаанд салбаруудын үйл ажиллагааг зах зээлийн механизм руу чиглүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих бодлогыг баримтална.  Эдийн засгийн төрөлжилтийг дэмжих салбаруудын бодлогын талаар дэлгэрэнгүй танилцуулгын 3.1. дэх хэсгээс харах боломжтой.
	10	Нийслэлийн төсвийг улсын төсөвтэй уялдуулах.	Нийслэлийн төсвийг улсын төсөвтэй уялдуулах асуудал нь Төсвийн тухай хуулиар Сангийн яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарна.
	11	Төсвийг алдагдалгүй батлах бодлого баримтлах.	Саналыг хүлээн авч, төсвийг алдагдалгүй батлах бодлогыг эдийн засгийн мөчлөгтэй уялдуулан, төсвийн тогтвортой байдлыг хангах чиглэлд үе шаттай хэрэгжүүлэхээр тусгасан.
	12	Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлэх.	Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан.
	13	Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, эдийн засгийн идэвхжилийг дэмжих.	Улсын хөгжлийн 2027 оны төлөвлөгөөний төсөлд тусгагдсан.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД  
ОРОЛЦОХ АЖЛЫН ХЭСГИЙН НЭРС**

Хэлэлцэх асуудал: Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Улсын Их хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбоотой ажлын хэсгийн нэрс:

<b>№</b>	<b>Нэр</b>	<b>Албан тушаал</b>	<b>Утас</b>
1	Ж.Энхбаяр	Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	99117928
2	З.Мэндсайхан	Сангийн сайд	-
3	С.Даваасүрэн	Эдийн засаг, хөгжлийн Дэд сайд	99109165
4	И.Батхүү	Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99113569
5	Б.Анар	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	99078437
6	Л.Энх-Амгалан	Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга	80770972
7	Б.Мөнгөнсүх	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99119675
8	Б.Мөнх-Эрдэнэ	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын дарга	88886495
9	Д.Эрдэнэтуяа	Эдийн засаг, хөгжлийн Эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдааны нэгдсэн бодлогын газрын дарга	94005933
10	М.Санжаадорж	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга	99190219
12	Ж.Дэлгэржаргал	Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга	99100568
13	О.Мягмардорж	Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга	88886106
14	Ц.Мөнхдэлгэр	Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн эрх чөлөө, өрсөлдөх чадварын судалгааны хэлтсийн дарга	99199307
15	Б.Төгөлдөр	Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн төсөл, хөрөнгө оруулалтын удирдлагын хэлтсийн дарга	94092818
16	З.Райымбек	Эдийн засаг, хөгжлийн яамны Салбар дундын бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга	88061520
17	П.Чандмань	Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга	99099122